



СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ  
モンゴル文化教育大学  
学術論文集シリーズ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
БИЧИГ

№5 (2026 №1)

Улаанбаатар  
2026 он

СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ  
モンゴル文化教育大学  
学術論文集シリーズ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ  
БИЧИГ

№5 (2026 №1)

Улаанбаатар  
2026

ISBN: 978-9919-0-6677-2  
МОНГОЛ УЛС  
СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ  
БОТЬ 5 (2026 №1)

# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

## №5 (2026 №1)

Редакцын зөвлөл:

Эрхлэгч, Ерөнхий редактор: Д.Эрдэнэчимэг доктор (Ph.D),  
профессор

Гишүүд:      Б.Мөнхбаяр              доктор (Ph.D)  
                 Ц.Пүрэвсүрэн            доктор (Ph.D), профессор  
                 Д.Энхчимэг                доктор (Ph.D), дэд профессор  
                 Б.Дэнсмаа                 доктор (Ph.D), дэд профессор  
                 Д.Бямбадорж            доктор (Ph.D)

Цувралын нарийн бичгийн дарга:      Б.Мөнхбаяр  
Ботийг эрхэлсэн:                              Б.Мөнхбаяр

Улаанбаатар  
2026



**Соёл Эрдэм дээд сургуулийн Эрдмийн зөвлөлийн  
2026 оны 3-р сарын 2-ны өдрийн хурлаар хэвлэхийг  
зөвшөөрөв.**

Соёл Эрдэм дээд сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг –V боть (2026 №1)-  
д орсон эрдэм шинжилгээний өгүүллүүд нь нэг талаар тус сургуулийн  
Хөгжлийн бодлого [2025-2030], Стратеги төлөвлөгөө [2022-2027]-д заасан  
эрдэм шинжилгээний үйл ажиллагааны бодлогын хэрэгжилтийн бодит үр дүн  
болохын сацуу нөгөө талаар СЭДС-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх  
чиглэлийн дагуу, тус сургуулийн профессорын багийн гишүүд болох Монгол,  
Япон, БНХАУ, ОХУ-ын эрдэмтэн судлаачдын бичсэн Монгол-Япон  
харьцуулсан хэл шинжлэл, орчуулга зүй, Утга зохиол судлал болон  
Мэдээллийн технологи, Боловсрол судлалын эрдэм шинжилгээний  
өгүүллүүдийг нийтлэв.

**Эрдэм шинжилгээний бичиг [SCIENTIFIC JOURNAL]**

Соёл Эрдэм дээд сургуулийн эрдэм шинжилгээний цуврал. Уб., 2026, 15,4 хх

**Өсөх пресс ХХК-д хэвлэв.**

**ISBN: 978-9919-0-6677-2**

**ННА- 72**

**ДАА- 378.121**

**С- 525**

**ХАЯГ:**

Монгол Улс, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, I хороо, Олимпын гудамж,  
Соёл эрдэм дээд сургууль.  
Шуудангийн хайрцаг 48/88

И мэйл хаяг: [info@soyolderdem.edu.mn](mailto:info@soyolderdem.edu.mn)

Веб сайт: [www.soyolderdem.edu.mn](http://www.soyolderdem.edu.mn)

Page: <https://www.facebook.com/soyolderdemedu>

Утас: +976 70116947, 70118584

Факс: 11-328584, 11-326947

“Эрдэм шинжилгээний бичиг”- V боть (2026 №1)  
-ийн хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Өсөх пресс ХХК

Цаасны хэмжээ: B5, 17,6 х 25,0

Хэвлэлийн хуудас: 15,4 хх

Хэвлэсэн тоо: 200 ш

**copyright©Соёл Эрдэм дээд сургууль, 2026**

## ГАРЧИГ

### ХЭЛ ШИНЖЛЭЛ, МОНГОЛ ЯПОН ХЭЛНИЙ ХАРЬЦУУЛСАН ХЭЛ ШИНЖЛЭЛ

<b>Fasc 1.</b> Ц.Пүрэвсүрэн	Соёлын антропологи ба “МОНГОЛ ХҮН” судлал .....	7
<b>Fasc 2.</b> Г.Н.Чимитдоржиева	Монгол хэлнүүд дэх <i>bur-/pur-</i> язгуур бүтээврийн утга зүй .....	13
<b>Fasc 3.</b> Д.Энхчимэг	Монгол хэлэн дэх үнэлэмж гэдэг үгийн хэрэглээ, онцлог .....	21
<b>Fasc 4.</b> Илч	Хэл шинжлэлийн сургалтын хөтөлбөрийн тохируулалт [дизайн] ба төгсөгчдийн ажлын байрны талаар .....	27
<b>Fasc 5.</b> М.Мөнхцэцэг	Япон хэлний дуу авиа дүрс дуурайсан үгийн тухай .....	33
<b>Fasc 6.</b> Жаргал	Япон хэлний тусах ба эс тусах үйл үгийн тухай .....	51

### УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ:

<b>Fasc 7.</b> Дулаан	“Учиртай гурван толгой” ба “Бээжин ший” .....	57
<b>Fasc 8.</b> Л.Ц.Халхарова	Ц.Жамцараногийн “Аяллын өдрийн тэмдэглэл” [1903–1907]-ийн орон зай - цаг хугацааны архитектуроник бүтэц .....	63
<b>Fasc 9.</b> Н.Галиймаа	XX-XXI зууны үргэлжилсэн үгийн зохиолд монгол эмэгтэй дүрийн хувьслыг харуулсан нь: (Д. Нацагдорж, С.Эрдэнэ, Ч.Лодойдамба болон орчин үеийн зохиолчдын бүтээлээс жишээлэн) .....	69
<b>Fasc 10.</b> Намиа	Сайнцогтыг эргэн дурсахын ач холбогдол ба соёлын утга чанар .....	75
<b>Fasc 11.</b> Б.Мөнхбаяр	Өрнө ба дорнын соёлыг холбон, өнгөрсөн үеэс орчин үеийг зааглаж, шинэ хэл, шинэ сэтгэлгээний хэв маягийг бий болгосон Д.Нацагдорж .....	78
<b>Fasc 12.</b> Чүү И	Шарайд Дүүрэнжаргалын шүлгийн санаа дүрийн дэлгэр хараа, гүн цээл уран илрүүлэл .....	85
<b>Fasc 13.</b> Хасгоо	“Гарын таван хуруу” кино ба жүжгийн зохиолын бүтцийн харьцуулал .....	95
<b>Fasc 14.</b> Jiu Yue	БНХАУ-ын орчин үе [одоо үе]-ийн шилдэг романы монгол орчуулгын судлал -I [Зян рун "Чонон сүлд" романы жишээн дээр] .....	106
<b>Fasc 15.</b> Liu Yue	В.Инжаннаши (1837-1892) бол XIX зууны Монголын сонгодог зохиолч мөн .....	113

### МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ:

<b>Fasc 16.</b> Д.Бямбадорж	Монгол Улсын кибер аюулгүй байдлын цаашдын чиг хандлага эрсдэл, бууруулах боломж.....	128
<b>Fasc 17.</b> Н.Чулуунбаатар	Тархмал байршил бүхий мэдрүүрийн сүлжээг (USN) хүний зүрхний алсын оношлогоонд хэрэглэх нь .....	131

<b>Fasc 18.</b> Б.Мөнхчимэг	Дээд боловсрол дахь хиймэл оюуны нөлөө ба Moodle системд хиймэл оюуныг нэгтгэх боломж .....136
-----------------------------	--

### БОЛОВСРОЛ СУДЛАЛ:

<b>Fasc 19.</b> Асами Кооичиро	Соёл Эрдэм дээд сургуулийн Япон хэлний орчуулагчийн ангийн оюутнуудад Япон судлалын хичээлийг заах арга .....150
<b>Fasc 20.</b> Ц.Отгон	Сургалтын арга, хэлбэрүүдийн тухай асуудалд .....156
<b>Fasc 21.</b> Ватанабэ Марина	Монгол Улс дахь япон хэл суралцагчдын ханз үсгийн сургалтын тулгамдсан асуудал ба заах аргын судалгаа .....163
<b>Fasc 22.</b> Макихара Аяако	Монгол Улс дахь Япон хэлний сургалтын өнөөгийн байдал ба тулгамдсан асуудлууд: Сургалтын материал болгон япон анимэ ашиглах боломжийн талаарх судалгаа .....171

### ШҮҮМЖ ӨГҮҮЛЭЛ:

<b>Fasc 23.</b> Б.Мөнхбаяр	Харьцуулсан уран зохиол судлалын тавцан дахь Эдгар Аллан По ба Д.Нацагдорж ( <i>ӨМБИС-ийн багш, доктор Манухуарын “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” бүтээлийн тухай</i> ) .....176
<b>Fasc 24.</b> Макихара Соичи	Соёл Эрдэм дээд сургуулийн зохион байгуулсан 2025 оны зуны Морин аяллын хөтөлбөрийн тухай .....184



**ХЭЛ ШИНЖЛЭЛ,  
МОНГОЛ ЯПОН ХЭЛНИЙ  
ХАРЬЦУУЛСАН ХЭЛ  
ШИНЖЛЭЛ**



СОЁЛЫН АНТРОПОЛОГИ БА “МОНГОЛ ХҮН”  
СУДЛАЛ

*Ц.Пүрэвсүрэн*  
(Соёл Эрдэм дээд сургууль,  
Япон судлалын тэнхим. Ph.D, профессор)

*Агуулгын товч:* Монгол улсад нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаан орчин үеийн шинэ парадигмуудын хүрээнд эрчимтэй хөгжиж буй өнөө үед “Монгол хүн гэж хэн бэ?” гэдгийг Соёлын хүн судлалын хүрээнд, байгаль, нийгмийн олон хүчин зүйлийн нөлөөлөл дунд судлах зайлиггүй шаардлага тавигдаж байна гэж үзэж байна. Монгол хүний сэтгэл зүйн хийгээд бихевиор онцлог, зөв зан үйл, ёс суртахууны төлөвшилийг хэрхэн төгөлдөржүүлэх вэ? гэдэгт Соёлын хүн судлал, Монгол хүн судлалын судалгаа хариулт өгөх болно. Тус өгүүлэлд эл чухал асуудлыг задлан шинжилж, үнэлэн дүгнэсэн байна.

*Түлхүүр үг:* хүн судлал, соёлын хүн судлал, нийгмийн хүн судлал, хэлний соёл судлал, хүн төвт судалгаа.

“Хүн судлал” хэмээх өргөн хүрээтэй шинжлэх ухааны ойлголтыг онол арга зүйн хувьд зөв ойлгох явдал эн тэргүүний асуудал болж байна. Манай улсад Антропологи хэмээх ерөнхий ойлголтод бүхнийг тоймлон хамруулснаар шинжлэх ухаан хоорондын зааг дээрх “Хүн судлал”-ыг бүрхэгдүүлэх хандлага түгээмэл байсаар ирсэн. Нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухаан, ялангуяа хэл шинжлэлийн Хэлний соёл судлал зэрэг шинэ парадигмууд нь бүгд Соёлын хүн судлалд хамааралтай юм.

Чөлөөт нэвтэрхий толь-д дурдсанаар **Хүн судлал** буюу **Антропологи** гэдэг нь хүн, хүн төрөлхтнийг судлах байгалийн болон нийгмийн шинжлэх ухаан аж. 1501 онд Германы гүн ухаанч Магнус Хундт Антропологи (эртний Грек хэлний *антропос* хэмээх *ἄνθρωπος*, "хүн", *-логиа* хэмээх *λογία*, "судлал") гэдэг нэр томъёог анх хэрэглэжээ. Антропологийн үүслийн тухайд бол XIX зуунд Францын их сэтгэгч Аугусте Комте (Auguste Comte 1798-1857) хүний нийгмийг судлах шаардлага байгааг дурдаад, ийм судалгааг анх социологи (sociology) буюу “Нийгэм судлал” гэж нэрлэснээр, нийгмийн шинжлэх ухаан бусад шинжлэх ухааны адил хөгжлийн алхмаа эхэлсэн байна.

XIX зууны төгсгөл XX зууны эхэн үеэс энэ санаа улам гүнзгийрэн “Нийгэм судлалаас” гадна бас түүнтэй төстэй “Нийгэм-соёлын антропологи” (social-cultural anthropology), этнологи (ethnology), этнографи (ethnography) зэрэг хүний нийгэм, соёлыг судалдаг бусад салбар ухаанууд дор дороо Европын улс орнуудад гарч ирсэн байна.

1799-1804 оны хооронд Францад дэлхийн үндэстэн, угсаатнуудыг судлах “Хүмүүнийг ажиглан шинжих нийгэмлэг” байгуулагдаж, түүний дараахан Францын хувьсгалаас дүрвэсэн санваартан Дүбуа (Dubois) өмнөд Энэтхэгт очиж суурьшин, Энэтхэгчүүдийн ёс заншлын тухай бичиж үлдээснээр, тухайн үеийн Европын антропологи, этнологи, этнографийн

судалгааны гол арга болох “биечлэн дагах” арга зүй үүсэх үндэс болжээ. Ингээд XIX зууны дунд үеэс Францчууд энэ салбар ухаанаа этнологи гэж нэрлэж энэ нь үндэстэн угсаатнуудыг хэл, соёлоор нь дамжуулан судалдаг ухаан болсон байна .

Оросын Цагаан хааны үед, тэд өөрсдийн мэдэлд байсан Сибирийн ард түмнүүдийг судлан, бүртгэн тоочих ажил хийж, түүндээ Германы судлаачдыг оролцуулж байсан түүх байдаг байна. Эндээс өнөөг хүртэлх Оросын этнографийг хөгжлийн түүхийг гурван үе авч үздэг байна. Эхнийх нь хувьсгалаас өмнөх Хаант засгийн үед харьяалалдаа буй угсаатнуудыг бүртгэн баримтжуулах ажил байсан бөгөөд хоёр дахь шат нь хувьсгалаас хойших үе юм. Энэ нь Марксист онолд тулгуурлаж, Ленинист бодлого баримталсан этнографийн судалгааны үе байжээ. Гурав дахь шат нь одоо дөнгөж эхэлж байгаа бөгөөд 1990-ээд оноос хойших этнологи, антропологийн олон онолын чиг баримжаа бүхий үе юм. Тэд этнографи гэдэг нэр томъёоны агуулга, хамрах хүрээг өөрчлөн өргөжүүлэх зорилгоор этнологи, антропологи гэсэн нэр томъёонуудыг авч хэрэглэж эхэлсэн байна.

Харин Англи, Америкт янз бүрийн үндэстэн угсаатны нийгэм, соёлын олон зүйлийг салангид тусад нь бус түүнийг бүтээгч болох хүн дээр нь төвлөн судална гэсэн чиг хандлагыг баримталж, уг шинжлэх ухааны салбараа антропологи буюу “Хүн судлал” гэж нэрлэжээ. Ингэхдээ Англид “Нийгмийн хүн судлал” (social anthropology) гэх болж харин Америкт “Соёлын хүн судлал” (cultural anthropology) хэмээн нэрлэж заншсан байна. Америкийн хүн судлалын эцэг гэгдэх Германы Еврей гаралтай цагаач Франц Боас (Franz Boas 1858-1942) 1890-ээд оноос Америкийн уугуул иргэдийн соёлыг судалж, өөрийн судалгаагаа соёлын судалгаа гэж тодорхойлж байсан бөгөөд соёл гэдэг бол аливаа судлагдахууны дотоод мөн чанар мэтээр үзэж байжээ (Kroeber and Kluckhohn 1952). Энэ нь цаашлаад тэдний “Хүн судлал”-ыг “Соёлын хүн судлал” хэмээн нэрийдэхэд хүргэсэн байна.

Түүхийн энэ шатанд хүн судлалын энэ хоёр дэг сургууль (школ)-ийг ихэд ялгаатай мэтээр маргаж, 1930-аад онд уг маргаан ихэд хурцадсан байна. Нийгмийн хүн судлаачид соёлын хүн судлаачдыг “соёл ба хүний зан төлөвийг” л судалдаг хэмээн буруу ойлгож байсан бол, соёлын хүн судлаачид нийгмийн хүн судлаачдыг соёлын хүн судлалын нэгэн жижигхэн хэсэг буюу бүхэл цогц зүйлийн жаахан хэсгийг тасалж аван цогц байдлыг нь алдуулан судалдаг мэтээр буруу ойлгож байжээ (Wood 1997: 18). Америкийн хүн судлаачид Английн хүн судлаачдыг нийгмийн бүтэц тогтолцоо, үйл ажиллагаа гэсэн өнгөц, энгийн, амар хялбар зүйл судалдаг хэмээн тохуурхаж, харин өөрсдийн “соёлын хүн судлал”-аа аливаа зүйлийн гүн гүнзгий утга мөн чанарыг судалдаг мэтээр ойлгоцгоож байсан гэдэг. Харин 1970 оноос хойш тэдний хоорондын ялгаа зөрөө арилж, одоо бол харин ийм далд, өнгөцийн эсвэл бүхэл, тусгайн ялгаагүй гэдэг нь тодорхой болон нотлогдож эвлэрсэн байна. Хэдий тийм боловч өнөө хэр нь хэрэв энэ хоёр хандлагыг ялгаатай гэж үзвэл “соёлын хүн судлал” хүмүүсийн мэдлэг, зан заншил, байгууллыг бүрэн цогц байдлаар судалдаг байхад “нийгмийн хүн судлал” бол харин нийгмийн харилцааны аль нэгэн тодорхой хэсгийг тухайлбал, шашныг, улс төрийг, эдийн засгийг, ураг төрлийг ч юм уу судалдаг (Wood 1997: 17) гэж ялгадаг байна.

Антропологи, этнологи, этнографи гэхчлэн харилцан адилгүй нэршиж тогтсон салбар ухаан Орос, Англи, Герман, Францад зэрэгцэн хөгжиж эхэлсэн бол ХХ зууны эхнээс харь улс, үндэстний нийгэм, соёлыг судалдаг ухаан маань утга хэлбэр, чиг хандлагаа тогтоож эхлэн анхны хүн судлаачид, угсаатан судлаачид төрж эхэлжээ. Ийнхүү Өрнөд Европ, Америкт үүсэж, хөгжсөн “соёлын хүн судлал”-ын ачаар дэлхийн үндэстэн угсаатнууд өөрсдийн түүх соёлоо “Хүн төв”-тэй судалж ирснийхээ үр дүнд өөрсдийгөө чухам “хэн” болохыг мэддэг, түүндээ тулгуурлан хүнээ хөгжүүлж, улмаар улс орноо үсрэнгүй хөгжлийн зам дээр гаргаад байна. Улс орны хөгжил дэвшлийн язгуур үндэс нь “Хүний хүчин зүйл” байдаг гэдгийг дэлхийг тэргүүлэгч орнуудын туршлага нотолж байна. Гэтэл монголчууд бид хүн судлал, тэр дундаа “соёлын хүн судлал”-ын альхан талд нь явна вэ?.

1950-аад оноос Монголд Оросын шинжлэх ухаанаар дамжин дэлгэрч тэдний этнографи гэдэг нэр томъёог “Угсаатны зүй” гэж орчуулан хэрэглэх болсон байна. Харьцангуй түүхийн богино хугацаанд хөгжсөн монголын угсаатны зүйн салбар нь, монголын зарим нэг угсаатны цөөнхийн зан заншил, зан үйлийг голчлон судалсан. Соёл судлалын шинжлэх ухаан манайд 1990-ээд оноос хойш сонгодог утгаараа хөгжих сууриа тавиад байна. Гэхдээ соёл судлалыг өнөө хэр нь “Урлаг судлал “хэмээх утгаар ойлгох явдал түгээмэл байсаар байна. Монгол судлал хэмээх шинжлэх ухааны нэг том бөгөөд чухал салбар манайд бий боловч, үзэл суртлын хүлээс, системийн ялгаанаас болоод гадаад орнуудын эрдэмтдийн хийсэн монголын түүх, монгол хэл шинжлэлийн судалгаанаас төдийлөн хэтэрч чадаагүй юм. Монгол судлал бол гаднынхан хийдэг монголын тухай судалгаа гэж ойлгодог хүмүүс цөөнгүй байгаа нь ч нууц биш. Монгол хүнийг судлах ёстой энэ олон шинжлэх ухаанууд харамсалтай нь монгол ёс заншил, монголын түүх, хэл соёлыг түүнийг бүтээгч “Монгол хүн”-ээс нь саланги байдлаар судалж ирсэн гэж хэлж болно. Учир нь бид өнөөдөр монгол хүн гэж хэн болох, ямар зан чанартай, Азийн болоод дэлхийн бусад үндэстнээс юугаараа ялгаатай хийгээд төстэй болохыгоо сайн мэдэхгүй байна. Бид өөрсдийгөө Чингисийн үр сад, нүүдлийн соёл иргэншилтэй, мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлалтай гэх мэт хэдхэн ерөнхий томъёоллоор л тодорхойлдог. Түүнээс гадна жуулчид голдуу гаднынхны дүгнэснээр “найрсаг зочломтгой, гэнэн цайлган, толгой сайтай” гэх юм уу эсвэл “залхуу, хэнэггүй, цаг барьдаггүй, багаар ажиллах чадваргүй, эв түнжингүй” гэж ойлгохоос хэтрэхгүй байна. Энэ бол хүмүүнлэг, ардчилсан нийгэмд маш том судалгааны орон зай бий болсныг харуулж байгаа бөгөөд Монгол хүн “хэн” болохыг шинжлэх ухааны үндэстэй судлах нь нийгэм, хүмүүнлэгийн олон шинжлэх ухааны тодорхойгүй асуудлыг шийдэх гарц болох юм. Бид өөрсдийн бихевиор шинж, темпераментын зонхилох хэв маяг, танин мэдэхүйн онцлог, сэтгэлгээний хэв маягаа огт мэдэхгүй байгаа. Санамсаргүй тохиолдлын хүрээнд өнгөц дүгнэлт хийсээр ирсэн нь бодит байдал.

Монголчууд бид залхуу, хариуцлагагүй гэж өөрсдийгөө тодорхойлж, ажил олгогчид ч “монголчууд залхуу, ажил хийдэггүй” гэх шалтгаанаар гаднын ажилчдыг олноор оруулж ирж, хөдөлмөрийн зах зээл дээр ойлгомжгүй байдал үүсээд байгаа нь нууц биш. Гэтэл яагаад гадаадад ажилладаг монголчууд япон, солонгосын ажил олгогчдоос өндөр үнэлгээ авдаг, хөдөлмөрийн зах зээлийн



эрэлттэй хүн хүч болоод байна вэ. Монгол менежмент хөгжихгүй, монгол хүнийг ажиллуулж чадахгүй байгаа нь монгол хүнийг мэдэхгүй байгаатай холбоотой юм. Бидэнд өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий хэл, түүх, шашин, соёлын асар их баялаг өв уламжлал бий. Түүнийг бүтээж, хадгалж, уламжлуулж ирсэн эзэн нь монгол хүн. Хэлээр нь, түүхээр нь, соёлоор нь дамжуулан монгол хүнийг судалж тодорхойлох бүрэн боломж бий. Үүнийг зөвхөн хэлний жишээн дээр авч үзье.

Монгол хүн юм үзэгдэл, цаг хугацаа, орон зайн маш өргөн төсөөлөлтэй. Жишээ нь монгол хэлэнд “хоногийн газар”, “саахалтын зайтай”, “алд, дэлэм, тохой” гэх мэт үг хэллэг бий. Гаднынхан бидний “үдээс хойш уулзъя”, “12 гээд ярья” гэх мэт цаг товлохыг ойлгодоггүй. Японы нэгэн бизнесмен монгол хүнтэй ажил хэргийн яриа хийснийхээ дараа тодорхой хүсэлт тавиад хариуд нь “тэгж байгаад болно оо” гэж сонсоод, ойлгоогүй тухайгаа ярьсан удаа бий. Энэ бол бидний сэтгэлгээ ерөнхийгөөс тусгай руу чиглэсэн, синтетик хэв маягтай байж болохыг харуулж байгаа юм. Монголчуудыг “бардам, омогтой” гэдэг. Бид эх газрын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд, нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдарч ирсэн соёлын өвөрмөц уламжлалтай. Өргөн уудам нутаг дэвсгэрт, цаг улирлын янз байдал, малын бэлчээрийн гарцаас хамааралтайгаар бие биеэсээ алс зайдуу хоёр гурван гэрээр нутаглаж, бусдаас төдийлөн хамааралгүйгээр өөрийн хүчээр бүхий л амьдралаа залгуулж ирсэн тэрхүү амьдралын хэв маяг нь монголчуудыг өөртөө итгэлтэй, омог бардам болгосон нь гарцаагүй. Багаар ажиллах чадвар сул байдаг нь бидний соёлоос үүдэлтэй индивидуал соёлтой холбоотой ч байж болох юм. Монголчууд

“Эрхэм баян эрдэм ном  
Дунд баян үр хүүхэд  
Адаг баян эд хөрөнгө”

гэж ярьдаг. Эндээс монголчуудын үнэлэмжийг таньж болох бөгөөд үүнийг ч нүүдлийн соёлоор л тайлбарлана. Эндээс дараах хялбархан схем үүснэ. Доктор, профессор Ж.Батсуурь “Хөх толбот монгол хүмүүсийн бусдаас ялгарах чанар” нийтлэлдээ: “...Хүнд ерөөсөө хоёр л төрлийн удамшил байдаг. Нэг нь биологийнх. Энэ нь эцэг эхээс удамшдаг. Монхор хамар, бүлтгэр нүд, өндөр нуруу, өргөн шанаа гэх мэт бие галбир, оюун ухааны шинжүүд энэ удамшлынх. Нөгөө нь нийгмийн удамшил. Эцэг эхээс заяасан сайханд биед байгаа оюун ухаан, араншны хөрсөн дээр хүний сэтгэл, сэтгэлгээ, ёс зүй төлөвшдөг. Сэтгэл, ёс зүй төлөвшиж байж тэр хүн хүн төрхөө олдог...” хэмээсэн байдаг. Судлаачийн өгүүлснээр монгол хүний бүхий л онцлог бол дээрх биологийн хийгээд нийгмийн удамшилтайгаа л холбоотой. Монгол хүнийг таньж болох нэг түлхүүр бол МОНГОЛ ХЭЛ. Орчин үеийн хэл шинжлэлийн шинэ хандлагаар авч үзвэл хэл бол байгаль-нийгмийн үзэгдэл. Өөрөөр хэлбэл монгол хүний соёлын удамшлын зааг бол монгол хэл. Монгол хэлийг хэл шинжлэлийн

шинэ парадигм болох хэлний соёл судлалын өнцгөөс хүн төвтэйгөөр судалж чадвал монгол хүнийг таньж мэдэх нэг бодит гаргалгаа болно.

Э.Сепирийн тодорхойлсоор “Хэл бол соёлтой маш нягт холбоотой. Хэл бол соёлын явцад өөрөө бүрэлдэн хөгжиж, мөн соёлыг илэрхийлж байдаг бөгөөд бүхэлдээ хэл нь соёлын зайлшгүй урьдач нөхцөл болж байдаг. Хэл нь соёлоос гадуур, өөрөөр хэлбэл бидний амьдралын хэв маягаар тодорхойлогдож байдаг практик зан үйл, ёс суртахуун, оюун санааны нэгдмэл өвөөс гадуур оршин тогтнох боломжгүй” ажээ. Эдүгээ эх хэлний хэрэглээний мэдлэг, зөв бичгийн дүрэм, найруулга зүйн стандарт эвдэрч байгаа талаар хэл шинжээчид, эрдэмтэн мэргэд, олон нийт байнга шүүмжилсээр ирсэн. Энэ асуудлыг зөвхөн эх хэлний сургалтыг сайжруулах төдийгөөр шийдвэрлэх боломжгүй бөгөөд монгол хэлээр хэлэлцэж буй монгол хүний соёлын өөрчлөлттэй холбоотой юм.

Хэл, соёл хоёр хоорондоо салшгүй холбоотой, нэг зүйлийн хоёр тал гэж зүйрлэн хэлж болно. Нэг нь нөгөөгөө тодорхойлж, бас харилцан бие биедээ нөлөөлж байдаг. Хэлээр илэрдэг сэтгэлгээний онцлог гэдэг бол хүний танин мэдэхүйн эх үүсвэр юм. Суурьшмал ба нүүдэлч түмний танихуй нь ахуйгаасаа үүдэлтэй ажээ. Танихуй нь сэтгэлгээг бүрдүүлэх бөгөөд ард түмнүүдийн сэтгэлгээний хэв маяг нь соёлын онцлогоор тайлбарлагдана. Тухайлбал монголчууд ба япончуудыг харьцуулан авч үзье. Япончууд цагаан будааны тариалан эрхэлж амьдарч ирсэн *お米の文化* буюу “Цагаан будааны соёл”-той. Тэд хамтарч хөдөлмөрлөж, бие биеэ дэмжин тусалж байж, арвин ургац авч, амьдралаа залгуулна. Ганц өөрийн хүчээр, зөвхөн өөрийнхөө талбайг арчлан, өндөр ургац авч, сайн сайхан амьдрах боломж байхгүй. Тэгэхээр тэд бие биеэ гомдоохгүй, үргэлж зөөлөн эелдэг, халуун дулаан харьцаж байж, харилцан бие биеийнхээ тус дэмийг авч амьдарна гэсэн үг. Тиймээс ч өөрөөсөө илүү хамт олноо дээдэлж “хамт олон байвал би байна” гэж үзэж иржээ. Энэ сэтгэхүй нь хэлээрээ илэрч, үгийн санд нь хангалттай байдаг эрс шууд татгалзсан, үгүйсгэсэн, хориглосон үг хэллэгийг хэрэглэхээс зайлсхийж, зориуд зөөлрүүлж хэлдэг байна. Энэ нь ахуй, соёлын онцлогтойгоо уялдаатай бүрэлдэн тогтсон хамт олонч буюу коллективный соёлтойгоо холбоотой.

“Соёлын хүн судлал”, “Нийгмийн хүн судлал” хоёрт ялгаа зөрөө бараг үгүй болон нэгэн салбар ухаан болохыг ихэнх судлаачид зөвшөөрсөн байхад харин “Хүн судлал”, “Угсаатны зүй” хоёр ингэтлээ ойртон нэгдэж чадаагүй гэж үзэж болно. Антропологи, этнологи, этнографи анх ерөнхий чиг хандлага нь янз бүрийн үндэстэн угсаатнуудын нийгэм соёлыг судлах нэгэн зорилготой, нэгэн арга зүйтэй байсан хэдий ч сүүл рүүгээ зарим орнуудын уламжлал холдон хөндийрч, тус тусдаа бие даасан шинжлэх ухаанууд болон хөгжжээ. Энэ нь магадгүй хэлний ялгаа зөрөөнөөс болсон байх магадлал өндөр гэж судлаачид үздэг юм байна. Үнэхээр ч Англи, Америкийн антропологи нэгэн хэлээр зангилагдаж байхад Европын этнологи, этнографид ийм боломж байгаагүй нь тодорхой юм. Хэл бол “соёлын хүн судлал”, “нийгмийн хүн судлал”-ын аль алинд нь чухал үүрэгтэй байгаль - нийгмийн үзэгдэл болох юм. Эндээс үзсэн ч монгол хэлний “Хүн төвт” судалгаа нь “Монгол хүн судлал”-ын гарааны цэг болох ёстой.

Монгол хүн судлалыг хөгжүүлэх нь боловсрол судлал, бизнесийн удирдлага, хүний нөөцийн менежмент, анагаах ухаан, улс төр судлал гэх мэт

хүн төвтэй олон шинжлэх ухааны суурь судалгаа болох ёстой. Монгол хүнийг соёлын хүн судлалын үүднээс сайтар судалж байж түүнийг удирдах, сургах “түлхүүр”-ийг олно.

## ДҮГНЭЛТ

Монгол улсад нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаан орчин үеийн шинэ парадигмуудын хүрээнд эрчимтэй хөгжиж буй өнөө үед “монгол хүн гэж хэн бэ?” гэдгийг соёлын хүн судлалын хүрээнд, байгаль, нийгмийн олон хүчин зүйлийн нөлөөлөл дунд судлах зайлшгүй шаардлага тавигдаж байна гэж үзэж байна. Монгол хүний сэтгэл зүйн хийгээд бихевиор онцлог, зөв зан үйл, ёс суртахууны төлөвшлийг хэрхэн төгөлдөржүүлэх вэ гэдэгт соёлын хүн судлал, монгол хүн судлалын судалгаа хариулт өгөх болно. Нийгэм, эдийн засаг, улс төрийн систем тогтолцоонд гарч буй хурдтай өөрчлөлтийн нөлөөгөөр нийгмийн амьтан болох хүн нь сэтгэл зүй, бие бялдрын хувьд зохих хэмжээнд өөрчлөгдсөөр байна.

- Манай нийгэм, хүмүүнлэгийн салбарын эрдэмтэн судлаачид “Монгол хүн” судлалд анхаарлаа хандуулах цаг нэгэнт болсон бөгөөд энэ чиглэлд төр засаг, судалгааны байгууллага, хүрээлэн, салбарын яамд анхаарлаа хандуулж бодлогын шинжтэй арга хэмжээ авах зайлшгүй шаардлага тулгарч байна.
- Манайд нийгэм, соёлын антропологийн тулгуур онол, арга зүй, судалгааны бүтээлүүдийг танилцуулсан орчуулгын ажил, эмхлэн хэвлүүлсэн сурах бичиг, гарын авлага хомс байгаа нь энэ чиглэлийн судалгаа хөгжихөд бэрхшээл учруулж буйг анхаарах шаардлагатай.
- Монголд өдий болтол хөгжиж ирсэн этнографи дээр суурилан этнологи, антропологийг цэгцтэй хөгжүүлнэ гэдэг бол соёлыг судалдаг шинжлэх ухаануудын зааг дээр судалгаа хийгдэнэ гэсэн үг юм.
- Соёлын хүн судлал түлхүү хөгжсөн орнуудын судалгааны онол, арга зүйгээс тодорхой хэмжээнд суралцах боломжийг бүтээлчээр ашиглах нь зүйтэй.

### Ном зүй:

- Бадамхатан С. 2005. Эрдэм шинжилгээний бүтээлүүд, 3-р боть, Улаанбаатар: Монголын үндэсний түүхийн музей.
- Бум-Очир .Д Улс төрийн хүн судлалын онолын үүд. УБ., 2008.
- Лурье С.В. 1999. Историческая Этнология. Москва: Аспент Пресс.
- *Маслова В.А. - Лингвокультурология М.,2001*
- Садохин А. П., Грушевицкая Т.Г. 2000. Этнология. Москва: Высшая Школа.
- Wood P. W. 1997. Ethnography and Ethnology. Т. Barfield-ийн эмхэтгэсэн The Dictionary of Anthropology (Хүн судлалын толь). Oxford: Blackwell Publishing.
- 文化人類学入門。中公新書 1 9 8 2 年
- 人類学 1 9 9 3 年

МОНГОЛ ХЭЛНҮҮД ДЭХ *bur-/pur-* ЯЗГУУР БҮТЭЭВРИЙН  
УТГА ЗҮЙ

Г.Н.Чимитдоржиева  
(ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын  
Монгол Төвөд Будда судлалын хүрээлэн,  
Хэл шинжлэлийн секторын ЭШТэрА,  
Candidate of Sciences (Philology))

**Abstract.** This paper is concerned with the reconstruction of the primary motivation of imitative words with the root morpheme *bur- / pur-* in the Mongolian languages. In the examples, trill sound *r* in the final acts as a generalizing semantic element (the main motivating sound). To reconstruct the ways of semantic development of the Mongolian roots *bur-*, *pur-*, *bor-*, *por-* two lexical-semantic groups and their correlation with each other are determined: 1) sounds and images of animated nature and 2) sounds and images of inanimate nature. The *first* group contains lexical units denoting loud sounds (to growl – to roar – to scream – to grumble) and hoarse sounds (to snort – to croak // snub-nosed // stupid). The *second* group is more complicated. A broad range of meanings represents it: to bobble – to seethe – to boil – to curl – to spin // to bristle (to flurry, to fuss) // to babble // a flurry // to rain or snow – blizzard, snowstorm. This chain of meanings acts as the main one when denoting other phenomena, figurative rethinking, and nomination of various actions.

**Keywords:** the Mongolian languages, phonosemantics, lexis, root morpheme, reduplication, etymology.

Үгсийн анхдагч хэлбэр, утга хоёрын холбоо түүхэн өөрчлөлтийн улмаас ойлгомжгүй, бүрхэг болсон байдаг. Үгийн гарлыг задлан шинжлэх явцад үгийн утгыг тайлбарлах, үгийн анхдагч утгыг сэргээх, түүхэн хөгжлийг нь илрүүлэх асуудалтай тулгардаг. Өнөөдөр үгийн гарал судлаачид үгсийн авиа дууриах язгуур шинжийн (гарлын) тухай таамаглалын үндэс болсон авиа ба утга хоорондын шууд холбоог цуваа цагт тогтоох аргыг санал болгож байна. Хэл шинжлэлд “*үгийн гарлын авианы утга зүй*” гэсэн нэр томъёо бий болжээ. Зорилго нь бол тухайн үгээр нэрлэгдэх авиа дууриах сэдлийг олж тогтоох, дуу авианы дүрслэлийн үндэслэлийг гаргах, язгуур утга хийгээд авианы дуурьсал хооронд ямар шинжтэй холбоо буйг олж тогтооход оршиж байна. Энэхүү өгүүлэлдээ бид монгол хэлнүүдийн *bur- / pur-* гэсэн язгуур бүтээвэр бүхий үгсийн сан-утгын нэгэн ай савын бүлэг үгсийн авиа дууриах гарлын талаарх таамаглалыг хэлбэр зүйн болон утга зүйн хүрээнд дэвшүүлж байна. Нийтлэг цөм утгатай, нийтлэг бүтээврүүдээс бүтсэн бүлэг үгсийг задлан шинжилснээр эдгээр үгсийн гарлыг тодруулах, үгсийн сан-утгын нэгэн холимог бүлгийн харилцан ялдаа бүхий үгсийн эгнээг тогтоох боломж олгож байгаа юм.

*Bur- / pur-* язгуур бүтээвэр нь гурван авиалбараар /фонемоор/ илрэнэ. Тэдгээрийн акустик /дуурьсах/ шинж чанар нь оноох явцад тухайн фонемыг сонгох үндсэн нөхцөл болсныг илтгэнэ. Фонем тус бүр нь дохионы тусдаа бүрэлдэхүүнтэй бөгөөд харин тухайн язгуур бүтээврийн дуурьсах, өгүүлэх шинжүүдийн зохицол нь авианы утга зүйн холбоос үүсгэнээр тодорхой шинж,

тодорхой дүрслэл гаргаж байна. “Авианы утга зүй” судлаачдын үзэж байгаагаар үгийн язгуур утга хэлбэршихэд гол үүргийг үгийн эхний гийгүүлэгч авиа юмуу “фонестем” гэж нэрлэгддэг хэд хэдэн гийгүүлэгчийн нийлбэр гүйцэтгэдэг байна.

Байгалийн дуу чимээний аливаа параметрийг гаргаж ирэхэд ашигладаг янз бүрийн шинжүүд нь утгыг илтгэгч элементүүд болж, тэдгээр нь нэгэн нийтлэг бүлэг үүсгэж байвал И.Г. Рузин “фонемотип” - авиалбарын төрөл гэж тодорхойлж байна [Рузин, 1993. х. 19]. Энэ бол тухайн авиалбарын тодорхой нэг авиа дууриах үүрэг хувирахгүй байх нэгээхэн хил хязгаарын үүрэг гүйцэтгэгч тогтмол үзүүлэлт юм. Тухайн хэлний, тодорхой нэг лексемтэй /үгийн сангийн утгатай/ нэгэн “авиалбарын төрөл” нь хэд хэдэн харилцан адилгүй хэлбэртэй байж болно. Тухайлбал, “тэсрэл”-тэй авиалбарын төрөлд *b, d, g, k* гэх мэт авиалбарууд тохирч болох юм.

Б.В. Журковскийн тэмдэглэсэнээр хамгийн их сонирхол татаж байгаа зүйл бол утга илэрхийлэгч авианы орчин, тодруулбал үгсийн сангийн тодорхой утга бүхий “ижил төстэй” гийгүүлэгчийн бүлэг (жишээ нь *b/p/f/h; z/s; m/n; d/g* гэх мэт.) нь “ижил төстэй” элементүүдийг сэлгэхэд авианы ямар өөрчлөлт гарах нь тодорхойгүй байдаг явдал юм [Журковский, 1969. х. 54]. Бидний сонирхож буй *b, p, f, d, g, k, h* авиалбарууд нь дуурьсал-өгүүлэхүйн хэмжүүрээр тэсрэх (буюу хамжих - *b, p, d, g, k*) болон шүргэх (завсрын - *f, h*) гийгүүлэгчүүдэд хамаардаг. Түүний дотор *b, p* – уруулын, *g, k, h* – тагнайн арын, *d* – хэлний үзүүрийн гэж ангилагдана. Ийм байдлаар тухайн язгуур бүтээврийг *bur-, pur-, fur-, dur-, hur-, gur-, kur-* хүртэл өргөжүүлж болно. Үгсийн сангийн үндсийг судлан шинжлэх үед судлаач Михалев А.Б. авианы утгын шинжийг дараах байдлаар тайлбарлав. Үүнд: тэсрэх маягийн авиа гаргадаг *b, p* нь янз бүрийн дуу чимээг (голдуу хүчтэй тэсрэх дуу чимээ) дууриадагаас гадна өгүүлэхийн бүх эрхтэн оролцож гардаг онцлогтой байна [Михалев, 2007. х.28]. Доргих “*r*”- нь удаан үргэлжлэх чимээг дууриан, өгүүлэхүйн эрхтний хоолойн үйл ажиллагааг бэлгэдэж байдаг. С.В. Воронин “*r*”-ийг “*цэвэр фреквентатив*” дуу авианы бүрэлдэхүүн гэж үзэж байна. *C + V + r*- ийн дуу авиа дууриах загварын бүрэлдэхүүн болох чичэрхийлсэн “*r*” авиалбар нь цохилт хэмнэлтэй хирнээ удаан үргэлжлэх чимээ гаргаснаар чихэнд нилээд чийртэй сонсогддог. Ихэнх хэлэнд энэ загвар нь хөдөлгөөн, эргэлт, шавьжны гаргадаг авиа, хоржигнох чимээ, тас няс хийх чимээ, цохих чимээ зэргийг илэрхийлдэг байна [Воронин, 2009. х. 55-56]. Энэхүү өгүүлэлд бид *bur- / pur-, bor- / por-* язгуур бүтээвэртэй бүлэг үгсийн авиа дууриах/дүрслэх утгыг системтэй авч үзэх болно. Ингэхдээ *hur-, fur-, gur-, kur-* язгуурыг ч хамруулах бөгөөд сүүлийн авиалбар доргих “*r*”, харин эхэнд нь *b / p* гийгүүлэгчүүд орсноор дүрслэх хүрээг нь өргөжүүлж байгаа юм. Бидний судалсан лексемийн “*r*” элемент нь үл нийцэл, доргио чичиргээ, хүчтэй огцом байдал, тасалдал зэргийг хүчтэй дүрслэдэг үндсэн гол авиа нь болж байна. **ЭХНИЙ БҮЛЭГТ** бид амьд байгалийн дуу чимээг илэрхийлэгч, өгүүлэхүйн эрхтнээр дамжин гардаг, хүний биеийн бусад хэсэг бараг оролцдоггүй хэлэгддэг үгсийг орууллаа. Үүнд:

1) **архирах - орилох - хашгирах - бувтнах** гэсэн үндсэн утгатай бөгөөд дуу авиагаараа огцом чанга дуу гаргадаг. Ан амьтны гаргадаг авиаг

дамжуулахдаа хүмүүс адилхан болох гэж дууриадаг. Энэхүү хэд хэдэн утга санаа нь аялга үг болон дуу авиаг дууриан дүрслэх үгсээр илэрэх бөгөөд язгуур бүтээвэр нь *bar-* / *bur-* байна. Үндсэндээ энэ нь даган дууриах хэлбэрээр эсвэл давтах ёсоор илэрхийлэгддэг: Мо. *бар-бар дуугар-*, Бур. *бар-бар дуугар-*, *бар-бар байса гэмэрэн хэлэ-*; *бар-бар гэ-*; *бүр-бар гэ-*; *бард байса/байтар*; *бүрд гэ-*.

-*xip-* хэмээх үйл үгийн дагавартай *bur-* / *pur-* гэсэн язгуур бүтээврийн хувилбар нь энэхүү утгыг бас илэрхийлнэ: Мо. *borkira-*, *борхиро-*, Бур. *бүрхир-*, *борхир-*, *бурхир-*; *бүрхир-*, Калм. *боркл-*, *боркр-*; Мо. *barkira-*, *бархир-*, Бур. *бархир-*, Калм. *бэркр-*; Бур. *ори-бархи*. Үйл үгийн авианы хэлбэр нь өгүүлэхүйн эрхтэний үйл ажиллагааны утгын ачааллыг давхар агуулж байдаг: Мо. *barda-*, Бур. *боро-*.

Дараах лексемүүд нь Мо. *bars*, *бар*, *барс*, Бур. *бар*, *барас*, Калм. *барс* (< перс.: *pārs* ‘леопард; барс, пантера’ [ЭСТЯ, 1978, х. 69]), *арсалан*, *эрсэлэн*, *арьяатан* гэх жишээнд (*бар*), (*бар*) гэвэл хурц шүдтэй архирч буй махчин амьтны дүр зураг бидний нүдэнд бууна. Энэхүү хэсэгт бас гадна байдлыг тооцож үзсэн ижил утгатай үгсийг Мо. *baraqai*, *барахай*, Мо. *barmadai*, *бармаадай* хамруулж байна. Энд бид EDAL-ийн харьцуулан тавьсан “жишээ”-г оруулж байна Мо. *\*ber* ‘волчонок’ (*borte čino* [SH], *beltereg*, *belterge* [Less., p. 98]; *berte činua*, *bortu* [Less., p. 128]; Мо. *бэлтрэг*, Бур. *бэлтэргэ*, Калм. *белтрэ*).

Мо. *bortu* (*berte*) *činua* нь *\*beltereg* хэмээх үгийн язгуураас үүссэн бололтой. Энэ нь < *\*berteleg* [Ramstedt, 1935, p. 42] авиа сэлгэх ёсны үр дүнг харуулж байна. Мо. *bertegčün*, *бэртэгчин*, бур. *бэртэгшэн* гэдэг жишээнд *\*bert* хэмээх ижил төстэй язгуур байна. Э.В.Севортян Мо. *bürü-e*, *бүрээ*, Бур. *бүрээ*, Калм. *бүрэ*, Ойр. *бүрээ* үгийг халмигийн *bör* хэмээх авиа дууриах/дүрслэх язгууртай харьцуулан үзсэн байна (хангинан дуугарах дуу авиа): *bör-bör ge-* ‘треть; рычать’ [ЭСТЯ, 1978, х. 195].

2) **хиржигнэх - пир хийх // шантгар хамартай // тэнэг** зэрэг утгатай үгнүүд нь огцом хэржигнэх дуудлагыг үндсэн утгын хажуугаар гаргадаг.

Пир хийх дуу авиаг дууриан гаргах болон шувууд нисэж буухдаа далавчаараа гаргадаг дуу чимээг *per-/pür-* хэмээх үндсээр дамжуулан давтах ёсоор илэрхийлдэг: Мо. *per per*, *pür*, Мо., Бур. *пэр пэр*, *пүр*, Мо. *pürki-*, *пүрхий-*, *пүр хий-*; бур. *паар-паар дуугар-*; *пэр-пэр байса ханяа-*; *пүр-пүр*, *пүр-пар*; *пүр-пүр гэ-*; Мо. *пүрд*; *пүрд хий-*, *пүрдхий-*, *пүрд гэ-*, Бур. *пүрд байса ниидэ-*. Мөн -*чигна-/жигна-/шагана-* үйл үгийн дагавартай *par-/per-* язгуур бүтээврийн хувилбарууд: Мо. *парчигна-*, *паржигна-*, Бур. *паршагана-*; *пэршэгэнэ-*.

Тухайн дуу авиаг гаргахад дагалдан гарах дүр төрхийг илэрхийлэхэд хэлэнд хоёрдагч элемент байдаг бөгөөд энэ нь цаашдын дүр төрхийг дүрслэн гаргахад тусалдаг. Жишээлбэл, Бур. *парнагар*, *пирнагар*, *порногор*, *порхогор* хэлэхэд амьсгаа авахад хамрын салстаар дуу чимээтэй авиа болон гарахдаа хамрын нүхийг үлээх тэр дүр төрхийн холбоосоор илэрхийлдэг. Үүнээс үүдээд өргөн хамартай дүр төрхийг “тэнэг” гэж үзсэн бололтой.

Мо. *qur* [*qurquul*], *хур* [*gurquul*], Бур. *хура*, Калм. *хур* зэрэг нь бувтнах эсвэл шалчигнах дуу авиаг гарган илэрхийлж бөгөөд заримдаа нэгдсэн чичэрхийлсэн дуу авиа болдог. Ганц эм хурганы бувтнасан дуу авианаас ‘*кАрру-кукАрру-курррррррр*’ [<http://onbird.ru/golosa-ptic>] хэмээх нэг л авиагаа давтаж байгааг ялгаж болох юм. Үүнтэй зэрэгцээд тус утгатай т.-ма. хэлнүүдийн –

эвенк. *пуртакан*; *хороки*, эвен. *хорики*, нег. *хојохи*, орооч., ульч., орок. *поро*, ма. *хорки*; эвенк. *хурки*, нег. *хурки* [\**хурки*], орооч. *окина* [\**хоркина*] жишээнд нь *q/r* тодорхой дэс дараатай сэлгэсэн авиа сонсогдоно.

**ХОЁРДАХЬ БҮЛЭГТ** амьд бус байгалийн дуу авиа болон дүр зургийг илэрхийлэх үгнүүд орно. Энэ бол **бургилах - поржигнох - буцлах - уугих баагих, бургих - уурлах - чалчих - үймээн шуугиан - цасан шуурга** зэрэг дуу авиаг илэрхийлж буй утгатай үгнүүдийн гол шинж тэмдэг нь “*r*” авиалбараар чичэргээг харуулдаг. Үндсэндээ эдгээр үгс нь ус буцалхад гарах усны хөдөлгөөнийг илэрхийлж буй эрчимтэй дуу шуугианы авиаг илэрхийлж байгаа юм. Зөвхөн усны дуу авиаг илэрхийлэхээс гадна бас утаа тоосны уугих байдал, ус буцалж байхад магадгүй гарч байгаа жижигхэн бөмбөлгүүд зэргийг дүрслэх утга санааг агуулж байдаг. Энэхүү бүлэг үгсийн бусдаас ялгарах шинж тэмдэг нь гэвэл нүдэнд харагдах дүр зураг байна. 1. Буцалж буй усны бөөрөнхий хэлбэртэй жижиг бөмбөлгүүд болон утааны уугих хэлбэр. 2. Олон удаа давтагдах эргэж хуулирах хөдөлгөөн. 3. Дээшээ хийх хөдөлгөөн буюу хажуу талаараа өргөсөх байдал зэрэг нь хэмжээнийхээ хувьд томорч байгаа сэтгэгдэл төрүүлнэ. Дээрх шинжүүдийг товойлгон харуулсан **уурлах – буужигнуулах – чалчих – үймэх - үймээн шуугианд байх** үйл хөдлөлийг заан нэрлэсэн утгыг ухаарахад хүргэсэн байна.

Авиа дууриах: Мо. *bur bur*, *бур бур хий-*, *бар бур*; Бур. *бур бур гэ-*, Калм. *бур бур ги-*; Мо. *пор пор хий-*, *пор пор гэ-*, Бур. *пор пор гэ-*; Мо. *пур, пур пур, пур пур хий-*, *пур пур гэ-*, *утаа пур пур хий-*, *пур хий-*, *пурхий-*, *пурги-*, Бур. *пур пур бусал-*; Мо. *pürdki-*, *пүрдхий-*, Бур. *пүрд гэ-*; Калм. *пард*, Ойр. *пард-пард ге-*.

Дараа, *bur-* / *pur-* язгуур бүтээврийн хувилбарууд: - Мо. *бура-*, *бураа*, Калм. *бур-*, *бура*, Ойр. *бура-*, *бураа*, Бур. *хөөһэ бура-*, *буры-*;

- Мо. *borgi-*, *борги-*; Мо. *burgi-*, *бурги-*, Бур. *бурья-*; Мо. *бургила-*, Бур. *бурьял-*;

- Мо. *burgira-*, *бургира-*, *бурхира-*; Калм. *буркл-*, Мо. *bürge-*, *бүргэ-*, Калм. *бүрг-*; Ойр. *бүрге-*; Мо. *бүргэлэ-*; Калм. *буржң-*,

- Мо. *purgi-*, *пурги-*, Бур. *пүрье-*, Ойр. *пурга-*; Калм. *пүрг-*, Бур. *парья-*; *хүрье-*; *хүрил-*.

-*чигна-* үйл үгийн дагавартай *bur-* / *pur-* язгуур бүтээврийн хувилбарууд: Мо. *burčigina-*, *бурчигна-*; Бур. *буришагана-*; Мо. *porčigina-*, *порчигно-*, *пурчигна-*, Бур. *поршогоно-*, *пуришагана-*; Мо. *parčigina-*, *парчигна-*, Бур. *паршагана-*, *пүришэгэнэ-*.

Үймээн шуугианыг илэрхийлсэн утгатай дараах үгс байна. Үүнд: Мо. *bürki-*, *бүргэ-*, *бар бур хийж*, *бургин баргин*.

**Оргилох, дээшлэх хэмээх утгатай үйл үгийг эсгэх - ялзрах - хөгц мөөгөнцөр үүсэх - муухай үнэртэй болох - муухай заваан** гэсэн утгатай үгсийн сан-семантикийн бүлэгт дүн шинжилгээ хийж утга санааг цааш нь өргөжүүлэх боломжтой. Эдгээр үгсүүд нь зарим талаараа хэмжээний хувьд томруулсан, дээш чиглэлтэй үйлдэлийг илэрхийлдэг. Хөгц мөөгөнцөр нь тааламжтай нөхцөлд орсон үед ихээхэн идэвхтэй үржиж, хамаг зүйлийг устгаж байдаг мөөгөн хэлбэртэй бичил организмын төрөл зүйл юм. Тэд хортой учраас муухай үнэр ялгаруулж байдаг. Эсгэх үйл явц ашигтай бактерийн тусламжтайгаар эсгэлтийн үйл явц явагддаг. Ингэснээр бүтээгдэхүүн

булинггартаж, хөөсөрч эхэлдэг. Жишээ нь: Мо. *buri*, *buriva* [Less., p. 138], *буриваа*, Бур. *бури* [ЭСТЯ, 2003, х. 124], Мо. *burita-*; *burtay*, Мо., Бур., Ойр. *буртаг*, Бур. *бурхи*, *бүртэг*; Мо. *burjayı-*, Мо., Бур. *бурзай-*, Калм. *бурза-*, Бур. *бурзагар*, Калм. *борзн*; Мо., Калм. *бүр-*, Бур. *бүрэ-*, *бүри-*, *бүрилгэ*, *бүрилтэ*, Калм. *бүрлн*.

Дараах үгсийн бүлэгт нь хур тунадас гэх мэт агаар мандлын үзэгдлийг илэрхийлдэг. Агаар мандлын үзэгдэл болох “бороо”-г дуу авиан болон харааны хүлээн авах байдлаар заан нэрлэж болох авч хүлээн авч буй ойлголтуудын аль альных нь давамгайлах үүргийг тодорхойлоход хүндрэлтэй юм: Мо. *borıy-a*, Мо., Бур. *бороо*, Калм. *боран*, Ойр. *бораан*, Бур. *хиш бараан*; Калм. *борал*, *борат*.

Дуу авианы (сонсголын) ойлгоц. Борооны дуу чимээ нь усан дээр эсвэл хатуу гадаргуу дээр олон тооны дуслууд бууж ойн, эрчимтэй доошоо дусаж байгаа нь ихээхэн хэмжээний дуу чимээ гаргаж байдаг (жишээ, Ойр. *баржинна*). Энэхүү борооны дуу шуугианыг нээлттэй “а” эгшигээр илэрхийлж, энэ нь “ж” гэсэн чанга хүчтэй авиагаар эрчимжүүлэн өгч холбосон байдаг). Харин удаан хугацааны шивэрсэн борооны дуу авиаг “бувтнах” гэсэн үгтэй холбон тайлбарладаг (харьцуулвал, *бормотать* буюу *бърмътать* гэх эртний орос үг нь *бър* болон *мотати* гэсэн үгнээс үүсэлтэй. Өөрөөр хэлбэл, “шал хэрэггүй юм ярих, ойлгомжгүй ярих” гэсэн утгыг агуулна. Эртний славяны *бърбътати* нийтлэг славяны *бърбър* буюу хоёр дахин *бър*-аас үүсэлтэй).

Харааны хүлээн авах чадвар. Судлаач Сундуева Е.В. үйл үгийн хэлбэр дээр үндэслэж Птунг. *\*pur-* ‘бороо шиврэх; цас орох’, Пяп. *\*pür-* ‘цас/бороо орох’ [EDAL, p. 1105–1106]; орок. *пурэ-* ‘бороо шиврэх’, ойр. *буржицна-*, Мо. *bürelje-*, мо. *бүрэлзэ-* борооны талаарх харааны хүлээн авах уялдаа холбоосыг нотлохдоо “эрээлжлэх” гэсэн шинж тэмдгийн утга орсоньг үгүйсгэхгүй байгаа бөгөөд үүнийгээ лексем дахь *\*mor* гэсэн үндэс нь “ямар нэгэн эрээлжлэх зүйл” буюу агаарт байгаа жижигхэн борооны дуслуудыг илэрхийлж байгаагаар нотлож байна [Сундуева, 2011. х. 201-202].

*Bur-* язгуур нь урьд өмнөхийн адил “алаг эрээн” хэмээх шинжийг агуулж байгаа бөгөөд үйл үгний хувьд (жишээ: *бургана-*, *бургина-*, *бургалиг цас*) харааны ойлголтон дээр тайлбарлаж болох юм. Хярмаг цас (*пороша*) бол жижигхэн цасыг илэрхийлдэг бөгөөд үгийн гарлаараа бол славян хэлэн дэх “тоос, дарь, үнсэн товрог, шиврээ бороо” зэрэг утгыг агуулдаг байна. Буриад хэлэнд “цасан шуурга” гэсэн ойлголтыг (*саһа бордоһон* хэмээх лексемээр илэрхийлсэн байдаг. Энэхүү семантикийн бүлгийг үргэлжлүүлэн бусад жишээг авч үзье: Птюрк. *\*bora-*; Пкор. *\*pora* [EDAL, p. 1105–1106], кар. *purgu*, фин. *purku*, вепс. *purg*, коми *purga* [Мызников, х. 57] > орос *пурга*, *буран* > тюрк.: *buran*, *boran*, *porān*, *borayan*, *burayan* [Фасмер, 1986. х. 243]; т.-ма. - эвенк. *бүрга*, нан. *борқали*, нан. *бора*, ма. *буран*, эвенк. *бургал-*, нан. *бора*. Эдгээр жишээнээс харахад, бид *\*bury-* / *burg-* үндэстэй үгнүүд харааны ойлголтын хувьд давамгайлж байна гэж үзэж байна. **Уугих баагих - эргэлдэх - салхитай үед цас орох - цасан шуурга** зэрэг эдгээр гинжин хэлхээ бүхий үгсийн утга агуулга нь салхитай үед агаарт цас эргэлдэн орж буй дүр зургийг илэрхийлдэг бол харин “цасан шуурга” нь цасыг хүчтэй салхи авч явахыг илүү эрчимжүүлэн илэрхийлж байна. Хэрвээ дээр дурдсан жишээнүүдэд эргэлдэн тойрох гэсэн

элементүүдийг дүрслэн харуулсан бол, дараах бүлэг үгэнд **эргэлдэх - тойрох - өрөмдөх - буржийх, ороонго** зэрэг нь утгын гинжин хэлхээний гол утгыг илэрхийлж байна:

- Мо. *ergi-*, *эргэ-*, Бур. *эрье-*, Калм. *эрг-*, Даг. *ergi-*, *xergi-*, *xorgi-* [EDAL, p. 1137]; Мо. *burγui*, *бурγуй*, Бур. *бургы*, Калм. *бурһу*, Мо. *burγuida-*, *бурγуйда-*, Бур. *бургыда-*.

\**borγ* хэмээх язгуур нь Мо. *borγuyusu*, *борγуус*, Бур. *боргоохон*, *боргоодоон* олон тооны жижигхэн шавьжийг бэлэгддэг ба тэдгээр нь агаарт уугих утаа шиг байдаг.

Буржгар хэмээх утгыг агуулсан шинж нь \**bor / bur / burq* Мо. *burjγar* [Less., p. 140], *буржгар*, Бур. *буржагар*, Калм. *буржһр*, Мо. *буржий-*; Бур. *буржы-*, Калм. *буржи-*, Мо. *бурзай-*; Бур. *аржай-* үндсээс бүтсэн ургамлын нэрэнд агуулагдаж байдаг: Мо. *burγasu*, *бургас*, *бургаас*, Калм. *бурһсн*, Бур. *бургааһан*; Мо. *burγan-a*, *бургана*; Мо. *burγaγa*, *бура*, Калм. *бура*; Мо. *borulji*, *боролз*; Мо. *boruljin* [Less., p. 121], *боролж(ин)*, Бур. *боролжо*; Мо. *boruljiγan-a*, *боролзгоно*. Севортян Э.В. тюрк. *бурчақ* ‘буурцаг, вандуй; эрдэнэ шиш; мөндөр; хөлсний том дусал; буржгар’ *бур-* хэмээх үйл үгнээс “нугарах, дээс томох” [ЭСТЯ, х. 276] Мо. *burčay*, *буурцаг*, Бур. *буурсаг*, Калм. *бурчг*; Мо. *burčayai*, *буурцай*; Мо. *burčayan-a*, *буурцана* гарал үүслийг тогтоож байна. Эдгээр нэрнүүд нь мушгирсан ургамлын гаднах байдлаар нь дүгнэж гаргасан байна.

*Bur-* хэмээх үгийн язгуур нь бас **харуй бүрий – бүрэг - бүрхэг - харалган - бүрхэх, бүдгэрсэн** хэмээх утгуудтай холбоотой байна. Жишээ нь:

- Мо. *barui*, *bürüi barui*, *харуй бүрий*, *бүрий баруй*, *бүрэнхий*, Бур. *бүрэнхы*, Калм. *бүрң*, *бүрңкэ*, *барң-бүрң ги-*.

- Мо. *bürüg*, *bürüger*, *бүрэг*, *бүргэр*, Бур. *бүрэгэр*; Калм. *бүрг*, *бүргр*, Ойр. *бүрег-бараг*; Мо. *bürkeg*, *bürküg*, *бүрхгэр*, Бур. *бүрхэг*, Калм. *бүркг*; Мо. *bürjüger*, *бүрзгэр*; Мо. *bürügül*, Бур. *бүрүүл*, *бүрүүр*, Калм. *бүрүл*; Мо. *bürs*, *бүрс барс*, Бур. *бүрһэгэр*; Мо. *börtüger*, *бөртгөр*, Бур. *бүртэгэр*; Мо. *börügsi-*, *börüyi-*, *бүрий-*, Бур. *бүры-*, Калм. *бүри-*; Бур. *бүрылгэ-*, *бүрүүлтэ-*.

Энэхүү бүлэгт бас дараахь үгийн утгыг оруулж болох юм: Мо. *büri-*, Мо., Калм. *бүр-*, Бур. *бүри-*, Мо. *bürke-*, *бүрхэ-*, Калм. *бүрк-*, Бур. *бүрхэ-*; Мо. *bürkeg*, *bürkü*, *бүрх*; Мо. *bürkügül*, *бүрхүүл*, Калм. *бүркэ*, Бур. *бүрхөөг*, *бүрхөөлтэ*, *бүрхөөсэ* г.м. Сундуева Е.В. “Харуй бүрийд гэрлийн үзэгдэл намсах явдал нь гэрэл ба харанхуйн хоорондын заагт гэрлийн цацрагийн мөч бүр нь нарийсаж байдагтай холбоотой” [Сундуева, 2011. х. 198] гэж тэмдэглэжээ. Энэ бүлэг дотор бодит байдлын шинжүүд, үзэгдлийн шинж чанарыг илэрхийлсэн үгс байна. Мо. *börülje-*, Мо., Бур. *бүрэлзэ-*, Калм. *бүрлз-*; Мо. *bürilgene*, *бүрэлгэнэ*; Мо. *büriljegene*, *бүрэлзгэнэ*, Мо. *börtü*, *бөрт*.

*Bur-* язгуурын дүрслэх болон хүртэн мэдрэхүүд буух авианы шинж нь **олон хуниастай дүрс** буугаад, **хүрэхэд шаржигнаж, ширчигнэсэн мэдрэмж өгнө**. Авианы дуурьсал-өгүүлэхийн эрхтний оролцооны хувьд бол “*r*” гийгүүлэгчээс шалтгаалаад овон товонтой, хурц ирмэгтэй зүйлд хүрмэгцээ агдасхийж цочих байдал бие болоод нүүрэнд илрэх дүрийг авиагаар буулгах юм.

- Мо. *barbayar*, *барбагар*, Бур. *барбагар*, Калм. *барвһр*, Ойр. *барваһар*; Бур. *нэрхигэр*; Мо. *barčayar*, *barjayar* [Less., p. 84, 90], *barčigir*, *barsayar*, *баржгар*, *барчгар*, *барзгар*, *барсгар*, Бур. *баржагар*, *барсагар*, Калм. *барзһр*, *барчһр*; Мо. *barkiyar*, *бархигар*,

- Мо. *berjigir*, *berčigir*, *бэржгэр*, *бэрчгэр*, Бур. *бэржэгэр*; Мо. *birjigir*, *birčigir*, *биржгэр*, *бирчгэр*, Бур. *бирзагар*, Калм. *бирзһр*, *бирчһр*; Мо. *bersegüü*, *бэрсүү*, Калм. *берсү*;

- Мо. *burjayar*, *бурзгар*, Бур. *бурзагар*; *буриагар*, Калм. *бурчгэр*;

- Мо. *borčii-*, *борчий-*, Бур. *буришы-*, Калм. *бурчи-*; Ойр. *борчии-*, Бур. *борсогор*; *бордигор*; *боржогор*, *борзогор*, *борьёгор*; Мо. *borkiyar*, *борхигор*, Бур. *борхогор*, *борхигор*; Мо. *borča*, *борц*, Бур. *борсо*, Калм. *борц*.

- Мо. *borγuγu*, *борγуγи*, *боргонцог*, *боргоцой*, Бур. *борбоосгой*.

**Оргилох – поржигнох – буцлах - уугих баагих, тойрох** зэрэг дээр дурдсан үгсийн сан-семантикийн бүлгийн үгсүүдийн *bur-* / *pur-* үндэстэйгээс гадна олон дахин давтагдах үйл ажиллагааг илэрхийлж, бөөрөнхий хэлбэрийн утгыг агуулдаг гэж үзсэн бөгөөд мөн түүнчлэн объёмынхоо хувьд есдөг ялгаатайг онцолж үзсэн билээ. Энэхүү бүлгийн үгэнд дараах утгатай үгнүүдийг ялган үзэж болох юм. Үүнд: **бордох - том болох- бөөрөнхий- булцгар:**

- Мо. *bortuyu* [Less., p. 121], *бортого*, Бур. *бортого*, Калм. *бортх*, Ойр. *бортмог*; Калм. *борта-*; Бур. *пүрды-*;

- Мо. *bordu-*, *борд-*, Бур. *бордо-*, Калм. *борд-*, Мо. *borq-a*, *борх*, Калм. *бард*, *бардай*;

- Мо. *boruu*, *бороо*, Бур. *бордигор*, *боори*;

- Мо. *borbi*, *борви*, Калм. *бөрв*, Бур. *борьбо*, Калм. *борва-*, Ойр. *борваа-*

Эрдэмтэн Сундуева Е.В. ‘penis’ гэсэн утгатай бур. *баргуз*. *хүртэбэй* хэлбэртэй \**bört* хэмээх үндсийг “ямар нэгэн юм цухуйх бултайх” гэж үзсэн бөгөөд үүнийгээ тува хэлний *бөртек* буюу “эрэгтэй хүүхдийн бэлгийн эрхтэн” гэж үзэн жишээ авчээ. Үүнийг судлаач Б.И.Татаринцев *бөрүт-* ~ *бөрт-* хэмээх түркийн үйл үгийн үндсээс үүссэн гэж үзсэн (хавдах, томрох, таргалах) бөгөөд мөн түүнчлэн энэ нь буриадын аг. *борбоо*, баргуз. *бобоо* зэрэгтэй синоним юм (харьц., *борбой-*, *борболзо-*) [Сундуева, 2011. х. 126].

Бидний зүгээс гарлыг нь тодорхойлоход хүндрэлтэй байгаа бусад үгийг хараахан тайлбарлаагүй байна. Бур. *буриша-*, *бури-*, Мо. *буримд-*, Мо., Бур. *буруу*, Калм. *буру* **эргэх - өрөмдөх - эргэж харах (өөр тал руугаа)** зэрэг нь дээрх утгуудаас салбарлан хөгжсөн бололтой.

Өгүүлэлдээ бид дээрх үгсийг бүгдийг нь авч үзээгүй болно. Учир нь орчин цагийн бүх үгийн гарлыг авианы утга зүй, авианы сэдлийн зарчмаар тэр бүр тайлбарлаж болохгүй. Тайлбарлахад төвөгтэй олон тооны бүтэцтэй тулгарах бөгөөд тэр бүр авианы шинжээр утга гарч ирэхгүй юм. Ийнхүү *bur-* / *pur-* язгуур бүтээврийн дуурьсал/өгүүлэхүйн шинж төлөвийг тодорхойлсноор тухайн үгийн авиа, утга хоёрын холбоог мөшгих боломж бүрдэж байна. Үгсийн сан-утгын нэгэн бүлгийн үгсийг энэ аргаар шинжлэх нь нэг үгийг тайлбарласнаар утгын хамааралтай хэсэг үгсийг тайлбарлах боломж олгодог онцлогтой. Монгол хэлэнд *bur-* / *pur-* гэсэн язгуур бүтээвэр нь утгын баялаг талбайтай, олон хувилбартай боловч ихэнх нь хоорондоо утгын уялдаа холбоотой байна.

## Ном зүй

- Ramstedt G. J.* Kalmukisches Wörterbuch / G. J. Ramstedt. – Helsinki, 1935.
- Воронин С. В.* Основы фоносемантики / С. В. Воронин. – М.: ЛЕНАНД, 2009. – 248 с.
- Журковский Б.В.* Звуковая символика в идеофонах (на материале языка хауса и некоторых других африканских языков) / Б. В. Журковский // Материалы семинара по проблеме мотивированности языкового знака / Отв. ред. В.М. Павлов. – Л., 1969. – С. 54-55.
- Михалев А.Б.* [Инициаль и финаль как смыслообразующие компоненты корня](#) // Мир на Северном Кавказе через языки, образование, культуру. Материалы V Международного конгресса. Симпозиум X «Теоретические и прикладные аспекты исследования языков». Пятигорск, 2007. С.28-30.
- Мызников С. А.* Лексика финно-угорского происхождения в русских говорах северо-запада: этимологический и лингвогеографический анализ / С. А. Мызников. – СПб.: Наука, 2004. – 482 с.
- Ружин И. Г.* Природные звуки в семантике языка (Когнитивные стратегии именования). – Вопросы языкознания. – 1993. - № 6. – С. 17-27.
- Сундуева Е. В.* Звуки и образы: фоносемантическое исследование лексем с корневыми согласными [r/m] в монгольских языках. Улан-Удэ: Издательство бурятского научного центра СО РАН, 2011. 344 с.
- EDAL** – Starostin, S. Etymological Dictionary of the Altaic Languages – Part I. A–K; Part II. L–Z; Part III. Indices. / S. Starostin, A. Dybo, O. Mudrak (with assistance of Ilya Gruntov and Vladimir Glumov). – Leiden; Boston: Brill, 2003. – 2096 p.
- Less.** – Lessing, F. D. Mongolian-English dictionary / F. D. Lessing. – Berkeley – Los Angeles: University of California Press, 1960. – 1217 p.
- SH** – Haenisch E. Wörterbuch zu Manghol-un Niuča Tobčaan (Yüan-ch’ao pi-shi), Geheime Geschichte der Mongolen / E. Haenisch. – Leipzig, 1939.
- БАМРС** – Большой академический монгольско-русский словарь / Отв. ред. Г. Ц. Пюрбеев. – В 4-х тт. – М.: Academia, 2001–2002.
- КРС** – Калмыцко-русский словарь / Под ред. Б. Д. Муниева. – М.: Изд-во «Русский язык», 1977. – 765 с.
- МА** – Поппе, Н. Н. Монгольский словарь Мукаддимат ал-Адаб. – Ч. I–II // Тр. Института востоковедения [АН СССР], XIV / Н. Н. Поппе. – М.; Л.: Изд-во Акад. наук СССР, 1938. – 453 с.
- ССТМЯ** – Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков. – В 2-х тт. – Л.: Наука, 1975, 1977.
- Татаринцев, 2000** – Татаринцев, Б. И. Этимологический словарь тувинского языка. – Т. I. А, Б / Б. И. Татаринцев. – Новосибирск: Наука, 2000. – 440 с.
- Тодаева, 2001** – Тодаева, Б. Х. Словарь языка ойратов Синьцзяна (По версиям песен «Джангара» и полевым записям автора) / Б. Х. Тодаева. – Элиста: Калм. кн. изд-во, 2001. – 493 с.
- Фасмер, 1986** – Фасмер, М. Этимологический словарь русского языка. – В 4-х т. / М. Фасмер; пер. с нем. – М.: Прогресс, 1986, 1987.
- Шагдаров, 2006** – Шагдаров, Л. Д. Бурятско-русский словарь. – В 2-х тт. / Л. Д. Шагдаров, К. М. Черемисов – Улан-Удэ: Изд-во ОАО «Республиканская типография», 2006, 2008.
- ЭСМЯ, 2015** – Этимологический словарь монгольских языков. Т. 1. А-Е / Г. Д. Санжиев, М. Н. Орловская, З. В. Шевернина. – М.: ИВ РАН, 2015. – 224 с.
- ЭСТЯ, 1978** – Этимологический словарь тюркских языков: Общетюркские и межтюркские основы на букву «Б» / Авт. сл. ст. Э. В. Севортян. – М.: Наука, 1978. – 349 с.

МОНГОЛ ХЭЛЭН ДЭХ “ҮНЭЛЭМЖ” ГЭДЭГ  
ҮГИЙН ХЭРЭГЛЭЭ, ОНЦЛОГ

*Д.Энхчимэг  
(Соёл Эрдэм дээд сургууль  
Хэл шинжлэлийн доктор (Ph.D))*

Зах зээлийн эдийн засагт шилжсэн өнөөгийн нийгмийн нөхцөлд хүний үйл ажиллагаа, нийгмийн харилцаа, соёлын үзэгдлийг үнэ цэн, ач холбогдлын үүднээс авч үзэх хандлага улам бүр нэмэгдэж, үүний үр дүнд үнэлэмжийн тухай асуудал судалгааны олон салбарт өргөн хүрээнд хэрэглэгдэж байна. Энэ нь монгол хэлний хэрэглээний соёлд ч бас нөлөөлж, “үнэлэмж” хэмээх үг шинэ ойлголтыг илэрхийлэгч хэлний нэгж болон идэвхтэй хэрэглэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Үнэлэмжийн асуудлыг философийн шинжлэх ухаанд бие даасан судлагдахуун болгон авч үздэг бөгөөд уг ойлголт нь зөвхөн философийн хүрээнд бус ёс зүй, гоо зүй, сэтгэл судлал, соёл судлал, хэл шинжлэл зэрэг олон салбар шинжлэх ухаантай уялдан өнөөг хүртэл судлагдсаар ирсэн.

Манай улсад үнэлэмж судлал нь бие даасан шинжлэх ухааны салбар болон бүрэн төлөвшөөгүй боловч нийгмийн ухааны судлаачид өөрсдийн бүтээлдээ үнэлэмжийн талаар авч үзэн, тодорхой үнэлэлт дүгнэлт өгсөөр байна. Тухайлбал, Ц.Баатартогтох, Ц.Гомбосүрэн, Ч.Жүгдэр, Д.Бямбасүрэн, Х.Гүндсамбуу, Л.Дагдан, Г.Чулуунбаатар, Д.Мандах, Ц.Цэцэнбилэг, Н.Эрдэнэтунгалаг, Л.Одонтуяа, Г.Сайнхишиг зэрэг эрдэмтдийн судалгаанд уг асуудал тодорхой хэмжээнд тусгалаа олсон байна. Эдгээр судлаачид үнэлэмжийг ихэвчлэн объект–субъектийн харилцааны хүрээнд тайлбарласан нь нийтлэг ажиглагдаж байна.

Ц.Цэцэнбилэг “Үнэлэмж бол хувь хүн өөртэйгөө адилтгадаг (харьцуулдаг) нийгэмлэгт болон өөрт нь ач холбогдол (утга)бүхий зан үйлийн эрхэмлэх зорилго хийгээд аргын тухай түүний төсөөллүүд юм” гэж тодорхойлсон. Ц.Баатартогтох “Үнэлэмж бол тодорхой объектоор тэмдэглэн илэрхийлдэг, боловсруулан бүтээгдэж, түүнд субъектээс өгөгдсөн, иймээс зөвхөн түүнийг өвөр хоорондоо хэрэглэгчдэд ойлгомжтой байдаг субьектив утга юм” гэж тодорхойлсон. Г.Чулуунбаатар “Байгаль, нийгэм, хүний амьдралын үй түмэн үзэгдэлд сэтгэн үйлдэгч субъектийн зүгээс хандаж буй хандлага, үзэл бодол, үйл ажиллагааны нийлбэр цогцыг хамгийн ерөнхий байдлаар нь үнэлэмж хэмээх ойлголтоор илэрхийлж болно” гэж тодорхойлсон. Д.Мандах “Үнэлэмж бол субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн” хэмээсэн. Г.Сайнхишиг “Үнэлэмж бол монголчуудын хувьд эрхэмлэдэг, цээрлэдэг зүйлс юм” гэжээ. Л.Одонтуяа “Үнэлэмж нь субъектийн оюуны үйл ажиллагаа мөн бөгөөд түүний хүсэл хийгээд үл хүсэхүйн утгыг илэрхийлэх үнэлгээ мөн” хэмээн тодорхойлсон. Эдгээр судлаачид үнэлэмжийг:

- субъектийн ухамсар, оюуны үйл ажиллагаанд суурилсан
- объекттой харьцах харилцааны үр дүнд бий болдог
- нийгэм, соёлын орчинд төлөвшдөг
- хувьсан өөрчлөгдөх шинжтэй

гэж нийтлэг шинжээр нь тайлбарласан байна. Судлаачид үнэлэмжийг оюун санааны, нийгэм-соёлын болон үйл ажиллагааны түвшинд авч үзсэнээрээ өөр хоорондоо ялгарч байна. Хэл шинжлэлийн талаас авч үзвэл дээрх тодорхойлолтуудад “үнэлэмж” гэдэг үг нь ихэвчлэн **хийсвэр утгатай нэр үг** байдлаар хэрэглэгдэж, оюуны үйл ажиллагаа, хандлага, төсөөлөл, утга, харилцаа зэрэг ухагдахуунтай холбогдож байна. Энэ нь “үнэлэмж” хэмээх үг бодит зүйлээс илүүтэйгээр **ухамсар, танин мэдэхүйн түвшинд орших** ойлголтыг илэрхийлдэгийг харуулж байна. Мөн дээрх тодорхойлолтуудад “утга”, “төсөөлөл”, “хандлага”, “оюуны үйл ажиллагаа”, “хүсэл” зэрэг үгс давтамжтай хэрэглэгдэж байгаа нь “үнэлэмж” гэдэг үгийн семантик цөм нь **субъектив шинж** болохыг илтгэнэ. Үүнээс үзвэл, “үнэлэмж” нь монгол хэлэнд зөвхөн “үнэ цэн”-ийг илэрхийлэх бус, түүнийг **үнэлж, утга оноож буй сэтгэхүйн үйл явцыг** хамтад нь илэрхийлдэг хэлний нэгж болж байна. Түүнчлэн дээрх тодорхойлолтод “үнэлэмж” гэдэг үг нь ихэвчлэн **нэр томьёоны шинжтэй**, онолын тайлбар бүхий байдлаар хэрэглэгдэж байгаа нь уг үг орчин цагийн монгол хэлэнд **шинжлэх ухааны хэллэгийн түвшинд** тогтвортой суурьшиж байгааг харуулж байна.

Сүүлийн үед монгол хэлний хэрэглээнд нэлээд түгээмэл болж буй “үнэлэмж” хэмээх үг нь уламжлалт тайлбар толь бичгүүдэд хэрхэн тусгагдсан нь сонирхол татаж байна. Энэ үүднээс Я.Цэвэлийн *Монгол хэлний товч тайлбар толь*-ийг сөхөн үзэхэд “үнэлэмж” гэх нэгж үг бүртгэгдээгүй бөгөөд харин “үнэ”, “үнэ бүхий”, “үнэлэлт”, “үнэлэх” зэрэг утгаар тэмдэглэгдсэн байна. Энэ нь “үнэлэмж” гэх ойлголт харьцангуй сүүлийн үед үг хэллэгийн хэрэглээнд нэвтэрч, идэвхтэй хэрэглэгдэх болсныг илтгэж байна. Харин *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*-д “үнэ цэн” хэмээх хоршоо үгийг “юмны чухал хэрэгцээт чанар” хэмээн тайлбарласан нь үнэлэмжийн ухагдахууны утга агуулгыг дам байдлаар илэрхийлж буй хэрэг гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, “үнэлэмж” гэдэг үг шууд нэр томьёо хэлбэрээр тайлбар тольд бүрэн төлөвшиж амжаагүй боловч түүний утга агуулга нь “үнэ”, “үнэлэх”, “үнэ цэн” зэрэг үгсээр дамжин илэрхийлэгдэж иржээ. Эдгээр баримтад тулгуурлан “үнэлэмж” хэмээх үг монгол хэлэнд ямар утга агуулгаар, ямар үгзүйн хэлбэрээр хэрэглэгдэж буйг тодруулах шаардлага урган гарч байна. Иймд энэхүү судалгаанд “үнэлэмж” гэх үгийн хэрэглээ, түүний үгзүйн онцлог, мөн орчин цагийн монгол хэлний хэрэглээнд эзлэх байр суурийг авч үзлээ. Үүнд:

### 1. Холбон нийлэх байдлаар:

А/ тийн ялгал+ үнэлэмж: Монголчуудын үнэлэмж, монгол хүний үнэлэмж, хувь хүний үнэлэмж, үгийн үнэлэмж, эдийн засгийн үнэлэмж, өөрийн үнэлэмж, бусдын үнэлэмж, хөдөлмөрийн үнэлэмж, өгүүлэгчийн үнэлэмж, урлагийн үнэлэмж, нийгмийн үнэлэмж, улс төрийн үнэлэмж, сүсэг бишрэлийн үнэлэмж, шашны үнэлэмж, хэлний үнэлэмж, монгол хэлний үнэлэмж, боловсролын үнэлэмж, эрчүүдийн үнэлэмж, шударга ёсны үнэлэмж, стратегийн үнэлэмж, хэрэглэгчийн үнэлэмж, засгийн газрын үнэлэмж, хөрөнгийн биржийн

үнэлэмж, олон нийтийн үнэлэмж, бүх нийтийн үнэлэмж, сул талын үнэлэмж, таны үнэлэмж, зүйр үгийн үнэлэмж, дээд боловсролын үнэлэмж, хүний эрхийн үнэлэмж, төрийн үнэлэмж, ёс суртахууны үнэлэмж, гоо сайхны үнэлэмж, байгууллагын үнэлэмж, зах зээлийн үнэлэмж, уран зохиолын үнэлэмж, байгалийн нөөцийн үнэлэмж, мэргэжлийн үнэлэмж, ардчиллын үнэлэмж, уран бүтээлчдийн үнэлэмж, нийгмийн үнэлэмж, дагалдах мэргэжлүүдийн үнэлэмж, багшийн үнэлэмж, гадаад хэлний үнэлэмж, бусдын үнэлэмж, рашааны үнэлэмж, хүн амын үнэлэмж, ажиллагсдын үнэлэмж, байгууллагын үнэлэмж, мөнгөний үнэлэмж, урлагийн үнэлэмж, аз жаргалын үнэлэмж, хувьцааны үнэлэмж, гэр бүлийн үнэлэмж, хөдөлмөрийн хүний үнэлэмж, үйл ажиллагааны үнэлэмж, үзэл суртлын үнэлэмж, үзэл баримтлалын үнэлэмж, роликийн үнэлэмж, сав баглаа боодлын үнэлэмж, сувилагчийн мэргэжлийн үнэлэмж, оюутны үнэлэмж, сургуулийн үнэлэмж, эмэгтэй хүний үнэлэмж, эхийн үнэлэмж, төрийн албан хаагчийн үнэлэмж, компанийн үнэлэмж, байгууллагын гишүүн бүрийн үнэлэмж, сайхны үнэлэмж, хэрэглэгчийн үнэлэмж, хүмүүсийн үнэлэмж, зохиолчийн үнэлэмж, малчин өвгөний үнэлэмж, баатруудын үнэлэмж, таваарын үнэлэмж, үйлчлүүлэгчдийн үнэлэмж, төрийн үнэлэмж, брэндийн үнэлэмж, ажлын байрны үнэлэмж, удирдах ажилтны үнэлэмж, сэтгэл судлалын үнэлэмж, оюуны үнэлэмж, мэдлэгийн үнэлэмж, амь насны үнэлэмж, соёлын үнэлэмж, хүмүүсийн үнэлэмж, сэтгүүлчдийн үнэлэмж, эрх чөлөөний үнэлэмж, эмийн үнэлэмж, мэдээллийн үнэлэмж, үнэт зүйлийн үнэлэмж, барааны үнэлэмж, удирдлагын хувийн үнэлэмж, сургалтын үнэлэмж, дэлхийн үнэлэмж, чанарын үнэлэмж, баримжаалсан үнэлэмж, цагийн үнэлэмж, мэргэжилтний үнэлэмж, цэргийн үнэлэмж, хоршоодын үнэлэмж, багшийн үнэлэмж, багшийн ажлын үнэлэмж, ажлын үнэлэмж, ажлын байрны үнэлэмж, хайр сэтгэлийн үнэлэмж, таван одны үнэлэмж. Эдгээрээс монголчуудын үнэлэмж, монгол хүний үнэлэмж, өөрийн үнэлэмж гэдэг үгс зонхилж байгаа бол рашааны үнэлэмж, брэндийн үнэлэмж гэдэг үгс нь содон байна.

- *Рашааны үнэлэмж*:...Нийт 429 рашаан хамруулж усны дээж авчран холбогдох мэргэжлийн байгууллагуудаар судлуулснаар рашааны үнэлэмж хангахуйц 265 рашааныг усны мэдээллийн санд бүртгэсэн байна./undesten.mn, Улсын хэмжээнд нуур тойрмын тоо эрс багасжээ. Л.Алтангэрэл/
- *Брэндийн үнэлэмж*: Тайванийн Олон Улсын брэндийн үнэлэмж судалгаа нь Тайванийн улам олон брэндүүдийг олон улсад танилцуулж, шилдэг компани, аж ахуйн нэгжүүдийг хөхүүлэн урамшуулах үүднээс энэ жилийн шалгаруулалтын тоог дахин 10аар нэмэгдүүлжээ./roc-taiwan.org, Тайванийн топ брэндүүд/

*Б/ тодотгол+үнэлэмж*: Эрхэм үнэлэмж, үнэгүй үнэлэмж, доод үнэлэмж, нэмүү үнэлэмж, ардчилсан үнэлэмж, монгол үнэлэмж, ахиуц үнэлэмж, таван толгойн үнэлэмж, түүхэн үнэлэмж, мөнгөн үнэлэмж, эерэг үнэлэмж, сөрөг үнэлэмж, дээд үнэлэмж, шинэ үнэлэмж, хэлшгүй үнэлэмж, солбисон үнэлэмж, нийтлэг үнэлэмж, их үнэлэмж, өндөр үнэлэмж, шалгуурт үнэлэмж, тэгш бус үнэлэмж, сайн үнэлэмж, доогуур үнэлэмж, сэтгэхүйн үнэлэмж, зөв үнэлэмж, буруу үнэлэмж, солбисон үнэлэмж, шууд үнэлэмж, өөрийгөө үнэлэх үнэлэмж, анхдагч үнэлэмж, бага үнэлэмж, хөгжингүй

үнэлэмж, бодит үнэлэмж, хийсвэр үнэлэмж. Үнэгүй үнэлэмж, ахиуц үнэлэмж, хэлшгүй үнэлэмж, солбисон үнэлэмж гэх үгс содон байна.

- *Үнэгүй үнэлэмж*: Монголд хүн болсноос Америкт үхэр юм уу гахай болоод төрчихсөн нь дээр ч санагдах үе байх юм. Учир нь “Монгол үнэлэмж” гэж дэлхийд байхгүй шилдэг нэршил нэгэнт үүсжээ. Монголд 100 даага уралдуулаад эхний таван байранд орсныг нь 40-100 хүртэл сая төгрөгөөр урамшуулж байх жишээтэй. Гэтэл нөгөө морь унаж хурдлуулсан жаахан хүүхдийг нэг гутал, 100 мянган төгрөгөөр урамшуулж байх жишээтэй. /gogo.mn. Нийтлэлч Нийслэлхүү, 2011.09.28/
- *Ахиуц үнэлэмж*: Ахиуц үнэлэмж гэдэг нь тухайн ажилтны ур чадварыг мэргэжлийн ханшаар нь үнэлэх дээр нэмэгдээд мэргэшсэн ур чадварынх нь үнэлгээг нэмж тооцсон хувь хүний үнэ цэнийг хэлж байгаа юм./mhri.mn” Та ямар ангилалд ажилламаар байна”./
- *Хэвшгүй үнэлэмж*: Өнгөрсөн бүх дурсамжууд үгээр хэлшгүй үнэлэмж болно./love\_gb.blog.gogo.mn/
- *Солбисон үнэлэмж*: Ингэснээр эцэст нь “бүрэн” солбисон үнэлэмж гарна. /ikecult.wordpress.com “Уургийн моделийн боловсруулалтад В-факторын хязгаарлан баригчийг хэрэглэх”/

В/ үнэлэмж+тодотгол: Үнэлэмж нь өндөр, үнэлэмж өндөртэй, үнэлэмж доогуур, үнэлэмж маш доогуур, үнэлэмж дорой, үнэлэмж бага, үнэлэмж муу, үнэлэмж дээгүүр.

- *Үнэлэмж дорой*: Үнэлэмж дорой эхнэрийн хаягдах вий гэсэн мэдрэмж, ээжийн ганцаардана гэсэн ухамсартай бус айдас архидалтыг даамжруулах нь бий. /103 mn.”Архидалт бол мафи”/
- *Үнэлэмж нь өндөр*: Багш хүн үнэ цэнтэй, үнэлэмж нь өндөр байх ёстой./chimgee\_bayr.blog.gogo.mn/

Г/ үнэлэмж+ үйл үг Үнэлэмж дээшлэх, үнэлэмж буурах, үнэлэмж өсөх, үнэлэмж төлөвших, үнэлэмж алдагдах, үнэлэмж нэмэгдэх, үнэлэмж унах, үнэлэмж хангахуйц, үнэлэмж хангах, үнэлэмж судлах, үнэлэмж авах.

- *Үнэлэмж буурах*: Олон улсад Монгол улсын нэр хүнд, үнэлэмж буурах зэрэг олно урхагтай асуудал дагуулсаар ирсэн юм./oloo.mn, Б.Батжаргал “Гэрээг цуцлаагүй бол жилд 1-2 их наяд төгрөгийн татвараа алдах байсан”/
- *Үнэлэмж төлөвших*: “Иргэний танхим” түүний ажиллах журмын талаар мэдээлж ардчиллын үнэлэмж төлөвших үйл явц, авлигын шалтгаан нөхцөл хор хөнөөл, нутгийн өөрөө удирдах байгууллагын явцад.../news.mn “Шийдвэр гаргагчдад иргэний танхим нөлөөлнө”/

**2. Хоршин нийлэх байдлаар**: Үнэлэмж баримтлал, үнэлэмж сонирхол, үнэлгээ үнэлэмж, хандлага үнэлэмж, ойлголт үнэлэмж, үнэлэмж баримжаалал, баймж үнэлэмж, тэрслэл үнэлэмж, шалгуур үнэлэмж, зарчим үнэлэмж, үнэлэмж хандлага, үнэлэмж агуулга, үнэлэмж чадавх, мэдрэмж үнэлэмж,

- *Мэдрэмж үнэлэмж*: ...Хичээлийн үед нөхцөл байдалд хувиран өөрчлөгдөх чадвар сайтай, мэдрэмж үнэлэмж сайн, асуудлыг

оновчтой тодорхой шийдвэрлэх.../.blogmn.net, Я.Шийлэгмаа “Багш хүн гэж хэн бэ?”/

➤ *Тэрслэл үнэлэмж*: ... Абсурд ба урлаач, абсурд туршлага ба тэрслэл, тэрслэл үнэлэмж, тэрслэл трансцендент урлагийн философийн талаасаа имиж ба бодит байдал.../mihh.mn,”Экзистенциалист философи ба абсурдын тухай”/

3. **Зүйчлэн хуваавал**: “Үнэлэмж” хэмээх үгийг утга илтгэх байдлаар эдийн засгийн, улс төрийн, анагаах ухааны, урлаг, гоо зүй, гоо сайхны, оюуны, нийгмийн, уул уурхайн гэх мэтээр ангилан үзэх боломж байна.

#### Дүгнэлт

1. “Монгол хүний үнэлэмж” гэх ойлголт нь монгол хэлний өдөр тутмын болон судалгааны хэрэглээнд зонхилох байр суурь эзэлж байна. Энэ нь хүний нийгэмд эзлэх байр суурь, боловсрол, ёс суртахуун, аж амьдралын үнэлэмж зэрэг олон хүчин зүйлсийг нэгтгэн авч үзэх үзэл санааг илэрхийлдэг. Өнөөгийн нийгэмд хүн амын үнэлэмжийг зөвхөн эдийн засгийн үзүүлэлтээр хэмжих биш, харилцаа, ёс зүй, хувь хүний хөгжил зэрэг олон талт хэмжүүрээр дүгнэх хандлага ажиглагдаж байна.
2. “Үнэлэмж” гэдэг үг монгол хэлний үгийн сангийн шинэ орон зайд орсон бөгөөд ихэнхдээ зах зээлийн болон нийгмийн харилцаатай холбогдон хэрэглэгдэх болсон нь сонирхол татна. Судалгаанаас үзэхэд, уг үг нь монгол хэлэнд хожуу нэвтэрсэн бөгөөд бизнес, менежмент, боловсрол, соёлын хүрээнд түгээмэл хэрэглэгдэж байна. Энэ нь хэлний хөгжил, шинэ үг бий болох динамикийг харуулж байна.
3. “Үнэлэмж” гэдэг нь заримдаа холбон нийлэх, хоршин нийлэх зэрэг үйл үгстэй хамт хэрэглэгддэг бөгөөд хэмжих, дүгнэх утгатай. Гэхдээ сайн, муу үйлдэл, хувь хүний чанар, эдийн засгийн үзүүлэлт гэх мэт олон талт ойлголтуудтай холбоотой хэрэглээтэй байдаг. Жишээлбэл, “энэ хүний ажлын үнэлэмж өндөр байна” гэх мэтээр хувь хүний бүтээмж, үнэлэгдэхүйц чанарыг тодорхойлдог.
4. Өнөөгийн нийгэмд, ялангуяа эдийн засаг, улс төр, боловсролын салбарт “үнэлэмж” гэдэг ойлголт нь шинэ үгийн хэрэглээг бий болгосон. Энэ нь монгол хэлэнд шинэ утга, үзэл санааг нэвтрүүлэх замаар хэлний баялгийг нэмэгдүүлж, ойлголтын өргөн цар хүрээг бий болгож байна. Үүний нэг тод жишээ нь хувь хүний боловсрол, ажил мэргэжлийн үнэлэмжийг дүгнэх явдал юм.
5. Зарим тохиолдолд “үнэлэмж” гэдэг үгийг англи хэлний “value” эсвэл “evaluation” гэх ойлголтоос шууд орчуулсан байх магадлал ажиглагдаж байна. Энэ нь хэлний шинэчлэл, гадаад нөлөө, орчин үеийн боловсрол, эдийн засгийн үзэл санаатай холбоотой бөгөөд орчуулгын явцад шинэ утга болон хэрэглээ бий болсон байж болно. Нийтэд нь авч үзвэл, “үнэлэмж” гэдэг үг нь зөвхөн хүний чадвар, ёс суртахуун, ажлын бүтээмжийг хэмжихээс гадна, нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд хэрэглэгдэх болсон нь хэлний хөгжил, шинэ ойлголт бий болохын тод жишээ юм. Энэ нь монгол хэлний уламжлалт үгийн санг баяжуулж, шинэ ойлголт, үзэл санааг нэвтрүүлж байна.

### Ном зүй

1. Ц.Баатартогтох “Монголчуудын үнэлэмжийн судалгааны философи асуудал”, Дисс, УБ.,2000, 30-р тал
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”, УБ., 2008, дэд дэвтэр, 2318-р тал
3. Л.Одонтуяа “Монгол зүйр цэцэн үгэнд үнэлэмж илрэх онцлог” Дисс, Уб.,2004, 96-р тал
4. Ц.Цэцэнбилэг “Монголын залуусын уламжлалт ба орчин үеийн үнэлэмжүүд”, Дисс, УБ.,1998,13-р тал
5. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ., 1966, 622-623-р тал
6. Г.Чулуунбаатар “Нийгмийн ардчилсан үнэлэмжийн тогтолцоо”/Шинэ толь, УБ.,1998. №23, 16-р тал/
7. Философский энциклопедический словарь, М.,1983, 533-р, 829-р тал
8. undesten.mn Л.Алтангэрэл “Улсын хэмжээнд нуур тойрмын тоо эрс багасжээ”.
9. ikcult.wordpress.com “Уургийн моделийн боловсруулалтанд В-факторын хязгаарлан баригчийг хэрэглэх”
10. news.mn “Шийдвэр гаргагчдад иргэний танхим нөлөөлнө”
11. mihh.mn “Экзистенциалист философи ба абсурдын тухай”
12. olooo.mn Б.Батжаргал “Гэрээг цуцлаагүй бол жилд 1-2 их наяд төгрөгийн татвараа алдах байсан”

**ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН  
ТОХИРУУЛАЛТ [ДИЗАЙН] БА ТӨГСӨГЧДИЙН  
АЖЛЫН БАЙРНЫ ТАЛААР**

*Илч*

*(БНХАУ, Өвөр Монголын Багийн их сургуулийн  
Монгол судлалын сургуулийн багш, доктор)*

*Агуулгын товч: Энэхүү өгүүлэл<sup>1</sup>д хэл шинжлэлийн тусгай мэргэжлийн хийчээлийн сургалтын хөтөлбөрийн тохируулалт [дизайн] ба ажил эрхлэлтийн хоорондын хамаарлыг судалсан болно. ОВЕ (Үр дүнд суурилсан боловсрол) боловсролын философид үндэслэн хэл шинжлэлийн үндсэн хичээлүүд болон төгсөлтийн дараах ажлын байрны өнөөгийн шинэчлэлийн дүн шинжилгээгээр сургалтын хөтөлбөрийн дизайн ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний хооронд нягт холбоо байгааг олж тогтоосон. Өгүүлэлд хичээлийн агуулга, заах арга зүйг оновчтой болгох, практик сургалтыг бэхжүүлэх, ажил мэргэжлийн төлөвлөлтийн удирдамж өгөх нь хэл шинжлэлийн төгсөгчдийн ажлын байрны өрсөлдөх чадварыг сайжруулах гол түлхүүр болохыг онцолсон.*

*Түлхүүр үг: Дээд боловсрол, Хэл шинжлэлийн сургалтын хөтөлбөрийн дизайн, Ажил эрхлэлт*

Дэлхийн даяаршил хурдацтай хөгжиж, өдөр бүр шинэчлэгдэж байгаа мэдээллийн технологийн хөгжлийн ач, үр дүнд хэл шинжлэлийн ухааны ач холбогдол улам бүр тод болж байна. Гэсэн хэдий ч байнга өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээл, нийгмийн эрэлт хэрэгцээтэй тулгарч буй хэл шинжлэлийн сургалтын хөтөлбөрүүд нь төгсөгчдийн ажлын байрны өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд тэдгээрийг хэрхэн шинэчлэн боловсруулах сорилттой тулгарч байгаа нь дээд боловсролд шийдвэрлэх ёстой яаралтай асуудал болж байна. Энэхүү өгүүлэл нь хэл шинжлэлийн сургалтын хөтөлбөрийн загвар болон ажлын байрны хэтийн төлөвийн хоорондын хамаарлыг шинжлэх, одоогийн сургалтын хөтөлбөрийн дизайны давуу болон сул талуудыг харьцуулах, ОВЕ боловсролын философид үндэслэн сайжруулах саналуудыг санал болгох, их сургуулиудын хэл шинжлэлийн оюутнуудын мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн загвар болон карьерын хөгжлийн лавлагаа өгөх зорилготой юм.

---

<sup>1</sup>Энэхүү өгүүлэл нь Өвөр Монголын Өөртөө Засах Орон, Боловсролын Шинжлэх Ухааны “14-р таван жилийн төлөвлөгөө”-ний хүрээнд “Хэл шинжлэлийн мэргэжлийн гол сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх нь ОВЕ боловсролын үзэл баримтлалд суурилсан” (Баталгаажуулах дугаар: NGJGH2023413) судалгааны төслийн үе шатны үр дүн юм.

## I. OBE боловсролын философийн тухай

OBE нь Үр дүнд суурилсан Боловсролын товчлол юм. Үр дүнд суурилсан Боловсрол гэдэг нэр томъёог "Үр дүнд чиглэсэн Боловсрол" гэж орчуулж болох боловч энэ өгүүлэлд OBE боловсрол гэсэн товчлолыг ашигласан болно.

OBE боловсролын концепцийг анх 1980-аад онд АНУ-д санал болгож, 1990-ээд онд онолын систем болгон хөгжүүлсэн. OBE боловсролын концепцийг Америкийн эрдэмтэн Уильям Г. Спади санал болгосон. 1981 онд Спади "Үр дүнд суурилсан сургалтын менежмент: Социологийн хэтийн төлөв" нэртэй ном хэвлүүлж, анх "үр дүнд чиглэсэн боловсрол" гэсэн концепцийг танилцуулсан. 1994 онд Спади "Үр дүнд суурилсан боловсрол: Чухал асуудлууд ба хариултууд" хэмээх монографаа хэвлүүлсэн бөгөөд энэ нь OBE боловсролын концепцийн үүслийг тэмдэглэсэн түүхэн бүтээл гэж тооцогддог. "Үр дүнд суурилсан боловсрол: Чухал асуудлууд ба хариултууд" номын гол агуулга нь үр дүнд чиглэсэн сургалтын шинэчлэлийн ач холбогдол, хэрхэн үүссэн, түүний практик нь сургууль, сурагчдад хэрхэн нөлөөлж байгаа зэрэг асуудлуудаас бүрдэнэ.

Спади OBE-г "тодорхой хугацааны сургалтын дараа сурагчид эцэст нь ямар чадварыг хөгжүүлдэгт анхаарлаа хандуулдаг боловсролын систем" гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, OBE нь сурагчдын суралцах үр ашгийг дээшлүүлэх, эцсийн дүндээ тодорхой чадвар, чанарыг хөгжүүлэх зорилготой сурагч төвтэй систем юм. Энэ нь сурах бичгийн агуулгад ихээхэн найддаг уламжлалт сургалтын аргуудаас үндсэндээ өөр бөгөөд сурагчдын гүйцэтгэлийг бараг зөвхөн сурах бичгийн материалд суурилсан шалгалтаар үнэлдэг.

Энэхүү философийг хэрэгжүүлэх нь хоёр үндсэн үйл явцыг хамардаг: "дахин төлөвлөх" ба "хэрэгжүүлэх". Нийгэм болон цаг үеийн шаардлагыг ойлгох нь OBE (Үр дүнд суурилсан боловсрол)-ийн боловсролын философийн үндсэн үүрэг юм. Энэ нь нийгэм болон цаг үе ямар байр суурь, авьяас чадварыг шаарддагийг бүрэн ойлгох гэсэн үг юм. Энэхүү ойлголт дээр үндэслэн "сургалтын зорилтууд"-ыг илүү шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой, үнэн зөв, нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн томъёолж болно.

Эдгээр "сургалтын зорилтууд"-ыг удирдамж болгон хөгжүүлсэн авьяас чадвар нь нийгэм, цаг үеийн шаардлагыг хангах ёстой. "Сургалтын зорилтууд" тодорхой болсны дараа "төгсөлтийн шаардлага"-ыг томъёолно. "Төгсөлтийн шаардлага" нь "сургалтын зорилго"-д үйлчлэх ёстой. "Төгсөлтийн шаардлага" нь илүү нарийвчилсан, тодорхой байх тусам "сургалтын зорилго"-д илүү сайн үйлчилж, нийт зорилгод хүрэх магадлалыг нэмэгдүүлдэг. "Төгсөлтийн шаардлага"-ыг тодорхойлсны дараа "сургалтын хөтөлбөрийн систем"-ийг тэдгээр дээр үндэслэн бий болгоно. Өөрөөр хэлбэл, тогтоосон "төгсөлтийн шаардлагыг" хангахын тулд тухайн мэргэжлийн онцлог, шинж чанарт үндэслэн зохих салбаруудыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох ёстой. Боловсруулсан салбарын систем нь "төгсөлтийн шаардлагыг" дэмжих ёстой. "Сургалтын хөтөлбөрийн систем" нь сургалтын зорилго, сургалтын агуулга, сургалтын арга зүй, хэлэлцүүлэгт зориулсан үнэлгээний стандартыг багтааж болно. "Сургалтын хөтөлбөрийн систем"-ийг тодорхой тодорхойлсны дараа

салбар бүрийн багш нар тус тусын "заах зорилтууд"-аа тодорхойлно. "Загварын зорилтууд"-ыг тодорхойлсны дараа "заах агуулга"-г тогтоох хэрэгтэй. Сургалтын агуулга нь сургалтын зорилгод хүрэхэд үйлчлэх ёстой. "Заах агуулгыг" оноосны дараа "заах аргууд"-ыг сургах хэрэгтэй. Заах аргууд нь олон янз байж болно.

## **II. Хэл шинжлэлийн мөн чанар, сургалтын зорилго, сургалтын хөтөлбөрийн бүтэц**

Хэл шинжлэлийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь үндсэн хичээлүүд болон хэрэглээний хичээлүүд гэсэн хоёр үндсэн ангилалд хуваагддаг. Үндсэн хичээлүүд нь голчлон авиа зүй, дүрэм, үг зүй, семантик зэрэг үндсэн онолын агуулгыг хамардаг бөгөөд оюутнуудад хэл шинжлэлийн онолын үндэс суурийг тавих гол зорилго нь юм. Эдгээр хичээлүүд нь оюутнуудад хэл шинжлэлийн мөн чанар, хөгжлийн хуулийг гүнзгий ойлгох, логик сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх боломжийг олгодог. Энэхүү онолын мэдлэг нь хэрэглээний хэл шинжлэл зэрэг практик болон салбар дундын хичээлүүдийн чухал онолын үндэс суурь болж, үүнийг чухал хичээл болгодог.

Тиймээс хичээлийн сургалтын зорилгыг дараах байдлаар төсөөлж болно. Үүнд:

Нэгдүгээрт, орчин үеийн монгол хэлний авиа зүй, үг зүй, дүрмийн онцлогийг сурч эзэмших, үндсэн мэдлэг хуримтлуулах.

Хоёрдугаарт, орчин үеийн монгол хэлний онол, аргуудыг ашиглан өдөр тутмын амьдралд тулгардаг хэлний тодорхой асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах, эдгээр онолын үндсийг хэлний судалгаанд хэрэгжүүлэх.

Гуравдугаарт, бусадтай үр дүнтэй харилцах, өөрийн санаагаа тодорхой илэрхийлэх, бусдын яриаг анхааралтай, бодлоготой сонсох, бусдаас хэрэгтэй санал, зөвлөгөө авснаар хүлээн зөвшөөрөгдөх, үр дүнтэй хамтран ажиллах чадвартай байх.

Дөрөвдүгээрт, асуудалд шүүмжлэлтэй хандаж, өөрийн үзэл бодлыг санал болгох чадвартай байх.

Тавдугаарт, энэ хичээлээр дамжуулан оюутнууд хэл шинжлэлийн мэдлэг эзэмшиж, практик ур чадварыг хөгжүүлэхээс гадна асуудлыг олон өнцгөөс харах, оновчтой ойлголтоо баяжуулах, ажил, амьдралд тулгардаг хүнд хэцүү асуудлуудыг тайван судалж, шийдвэрлэхийн тулд диалектик сэтгэлгээг ашиглах боломжтой болно.

Дараагийн алхам бол агуулгыг сургалтын зорилгод нийцүүлэн боловсруулсан эсэхийг баталгаажуулах явдал юм. Уламжлалт заах аргууд нь голчлон багш төвтэй бөгөөд сурагчид анхааралтай сонсдог. Гэсэн хэдий ч Үр дүнд суурилсан боловсрол (ОВЕ)-ын философи нь сурагч, шавь, оюутан төвтэй сургалтыг онцолж, туршлагад суурилсан сургалт, сурагчийн амжилтад анхаарлаа хандуулдаг. Энэ нь багшийн үүргийг сургалтын үйл явцын туршид төвлөрсөн байдлаас хамтын ажиллагаа руу шилжүүлдэг. Эдгээр сургалтын зорилгод хэрхэн хүрэхийг авч үзье.

1-р зорилго буюу суурь мэдлэг хуримтлуулахыг багш нар онолын мэдлэг заахад харьцангуй илүү оролцдог тул лекцээр дамжуулан хэрэгжүүлж болно.

2-р зорилго нь холбогдох хэл шинжлэлийн бүтээлүүдийг уншиж, ойлгох, аялга, аялга дахь хэл шинжлэлийн онцлогийг тодорхойлж, тайлбарлах гэх мэтийг заах зорилгод хүрэхийг хамардаг.

3-р зорилгод дээр дурдсан асуудлуудыг тойрсон хамтын ажиллагааны тусламжтайгаар хүрч болно. Хөдөлмөрийн хуваарилалт, даалгаврыг хичээнгүйлэн гүйцэтгэх, хамтын ажиллагааны тусламжтайгаар асуудлыг шийдвэрлэх нь багийн ажиллах чадварыг хөгжүүлдэг.

4-р зорилгод дээр дурдсан хамтын ажиллагааны тусламжтайгаар хүрч болно. Түүний үзэл бодлыг олон тооны судалгааны өгүүлэл, эрдэмтдийн санал бодолд үндэслэн шинжилж, боловсруулаад зогсохгүй, үзүүлэн эсвэл илтгэлийн хэлбэрээр системтэйгээр, оновчтой танилцуулж болно.

5-р зорилгод тайлан сонсох замаар хүрч болно. Тайлан нь оюутнуудад дотоод болон гадаадад хийсэн судалгааны өнөөгийн байдал, ямар асуудлууд шийдэгдсэн, ямар асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа, ирээдүйд ямар ажил хийх шаардлагатай байгааг ойлгоход тусалдаг бөгөөд ингэснээр асуудлыг хөгжлийн үүднээс авч үздэг диалектик сэтгэлгээний хэлбэрийг бий болгодог.

### **III. Хэл шинжлэлийн мэргэжлээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн өнөөгийн байдал**

Хэл шинжлэлийн мэргэжлээр төгссөн хүмүүс хэлний боловсрол, хэвлэл, эрдэм шинжилгээний чиглэлээр олон төрлийн ажлын байрны боломжуудыг эдэлдэг. Боловсролын салбарт төгсөгчид хэлний багшлах, сурах бичиг бичих, хэлний сургалтанд хамрагдаж, мэргэжлийн мэдлэгээ ашиглан хэлний авьяас чадвараа хөгжүүлэх боломжтой. Хэвлэлийн салбар нь хэл шинжлэлийн төгсөгчдөд, ялангуяа компьютерийн хэл шинжлэлийн чиглэлээр мэргэшсэн хүмүүст хөгжлийн өргөн боломжийг олгодог. Тэд байгалийн хэлний боловсруулалт, яриа таних, машин орчуулга зэрэг чиглэлээр ажиллах боломжтой. Хэвлэл мэдээлэл, хэвлэлийн салбарт оюутнууд контент засварлах, хянан засварлах чиглэлээр өвөрмөц давуу талтай бөгөөд энэ нь номын чанарыг хангах, мэдээлэл түгээх үр ашгийг дээшлүүлэхийн тулд хэл шинжлэлийн мэдлэгээ ашиглах боломжийг олгодог. Цаашилбал, зарим төгсөгчид хэл шинжлэл эсвэл холбогдох чиглэлээр судалгаа хийсээр байгаа нь салбарын хөгжилд хувь нэмэр оруулдаг. Гэсэн хэдий ч одоогийн хөдөлмөрийн зах зээлийг харахад хэл шинжлэлийн төгсөгчид ажил эрхлэлтийн ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Энэ байдал нь хэл шинжлэлийн төгсөгчдөд онцгой биш боловч ихэнх төгсөгчдийн тулгардаг асуудал юм. Үүний шалтгаан нь дараах байдалтай байна.

Одоогийн байдлаар дээд боловсрол болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний хооронд тодорхой хэмжээний зөрүү байна. Уламжлалт сургалтын загварууд нь мэдлэг дамжуулахыг чухалчилж, оюутнуудын практик чадвар, цогц чанарыг хөгжүүлэхийг үл тоомсорлодог бөгөөд үүний үр дүнд төгсөгчид ажил олгогчдын хэрэгцээг хангаж чадахгүй байна. Үүний зэрэгцээ

хөдөлмөрийн зах зээлийн авьяастнуудад тавигдах шаардлага улам бүр олон янз болж, зөвхөн мэргэжлийн мэдлэг төдийгүй инноваци, багийн ажиллагаа, насан туршийн суралцах чадварыг шаардаж байна. Энэхүү нийлүүлэлт ба эрэлтийн тэнцвэргүй байдал нь дээд боловсролын сургалтын шинэчлэлийн ач холбогдол, яаралтай байдлыг харуулж байна.

#### **IV. Хичээлийн хөтөлбөрийн дизайны ажлын зах зээлтэй холбоотой байдал**

Хичээлийн хөтөлбөрийн дизайн болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний хооронд нягт холбоо байдаг. Одоогийн байдлаар олон их сургуулийн хэл шинжлэлийн хөтөлбөрүүд сургалтын хөтөлбөрийн дизайн болон хөдөлмөрийн зах зээлийн шаардлагын хоорондын зөрүү, онол, практикийн нэгдэл хангалтгүй байгаагаас болж төгсөгчдийн ажлын байранд хурдан дасан зохицоход хүндрэлтэй байна.

Үүнийг шийдвэрлэхийн тулд их сургуулиуд аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагаагаа бэхжүүлж, салбарын хэрэгцээг ойлгож, сургалтын хөтөлбөрийн дизайн болон заах арга барилыг зохих ёсоор нь тохируулах хэрэгтэй.

Хичээлийн агуулга, заах арга барилыг оновчтой болгох, практик сургалтыг бэхжүүлэх нь төгсөгчдийн ажлын байрны өрсөлдөх чадварыг сайжруулах гол түлхүүр юм. Их сургуулиуд хэрэглэнд чиглэсэн сургалтын тоог нэмэгдүүлж, дадлага, практик сургалтыг бэхжүүлж, оюутнуудыг бодит ертөнцийн салбарт ажиллаж, асуудлыг шийдвэрлэх чадвараа сайжруулахыг дэмжих хэрэгтэй. Цаашилбал, ажил мэргэжлийн төлөвлөлтийн удирдамж өгөх нь чухал юм. Их сургуулиуд салбарын мэргэжилтнүүдийг урьж, лекц уншиж, ажил мэргэжлийн төлөвлөлтийн семинар зохион байгуулж болно. Энэ нь оюутнуудад янз бүрийн ажлын байрны салбарын шаардлага, хөгжлийн хэтийн төлөвийг ойлгож, боломжийн ажил мэргэжлийн төлөвлөгөө боловсруулахад тусална.

#### **Дүгнэлт**

ОВЕ (Үр дүнд суурилсан боловсрол) боловсролын философи нь суралцагчдын суралцах үр дүнд анхаарлаа төвлөрүүлж, бүх сурагчдын хөгжлийг онцолж, сурсан мэдлэгээ практик асуудлыг шийдвэрлэхэд ашиглахыг дэмжиж, боловсролын зорилгодоо хүрэхийн тулд хувь хүнд чиглэсэн сургалтыг уриалсан сурагч төвтэй боловсролын систем юм. Нөгөөтэйгүүр, ОВЕ нь уламжлалт сургалтаас ялгаатай нь багш нар юу заадагт бус, харин сурагчид юу сурч, ямар ур чадвар эзэмшдэгт анхаарлаа хандуулдаг. Энэ нь сурагчдын ололт амжилтад илүү их ач холбогдол өгч, цаг үеийн хөгжилд дасан зохицож, төгсөгчдийн ажлын байранд шууд үйлчилдэг.

Энэхүү өгүүлэлд хэлний сургалтын хөтөлбөрийн дизайн болон ажлын байрны хоорондын хамаарлыг ОВЕ боловсролын философийн үүднээс авч үзэхийг оролдсон болно. Мэдээжийн хэрэг, цаашид судлах, сайжруулах шаардлагатай олон чиглэл бий. Багш нар сургалтын үр ашгийг дээшлүүлэх,

төгсөгчдийн ажлын байрыг дэмжих зорилгоор ОВЕ философид үндэслэн өвөрмөц сургалтын хөтөлбөрийн дизайн болон сургалтын зорилгыг боловсруулж болно.

#### **Ном зүй**

1. Уильям Г. Спади, Үр дүнд суурилсан боловсрол: Чухал асуудлууд ба хариултууд, Америкийн сургуулийн захиргааны ажилтнуудын холбоо, Арлингтон, Виржиниа муж, 1994.
2. Уильям Г. Спади, Үр дүнд суурилсан сургалтын менежмент: Социологийн хэтийн төлөв, Америкийн сургуулийн захиргааны ажилтнуудын холбоо, Арлингтон, Виржиниа муж, 1981.

## ЯПОН ХЭЛНИЙ ДУУ АВИА ДҮРС ДУУРАЙСАН ҮГИЙН ТУХАЙ

*М.Мөнхцэцэг*

*(Соёл Эрдэм дээд сургууль,*

*Япон судлалын тэнхим, докторант)*

Өнөө үед хүн төрөлхтөн зөвхөн өөрийн улсын төрөлх хэлээрээ яриад зогсохгүй бусад үндэстний хэл, ёс заншлыг нь судлах болжээ. Иймээс бид япон хэлний дуу авиа болон дүрс дуурайсан үгийн талаар судалгаа хийж төрөлх хэл рүүгээ хөрвүүлэхийг хичээлээ. Бид энэхүү судалгааны ажлаа Япон хэлний дуу авиа болон дүрс дуурайсан үг нь Монгол хэлнээ хэрхэн орчуулагдах тал дээр түлхүү ажиллаа. Ингэхийн тулд, Япон хэлний дуу авиа дүрс дуурайсан үгийн тухай номыг орчуулсан. Бид судалгааны ажлынхаа хэрэглэгдэхүүн болгож Р.Гүрбазар "Орчуулгын онол дадлагын үндэс", Д.Бадамдорж "Монгол хэлний үгийн сангийн утга зүй", Д.Бадамдорж "Монгол хэлний утга зүйн шинжилгээ", Н.Нансалмаа "Үгийн сан судлал", 日本語単語ドリル擬音語、擬態語 “Япон хэлний үгийн дасгал, дуу авиа болон дүрс дуурайсан үг” зэрэг эдгээр ном товхимлыг ашигласан болно.

### **I. Япон хэлний дуу авиа болон дүрс дуурайсан үгийн тухай**

Япон хэлний 擬音語гионго, 擬態語гисэйго нь аливаа зүйлсийн дуу чимээ дуурайсан үгийг хэлнэ. Харин гитайго гэдэг нь хүн амьтан болон юмсын байр байдлыг заасан үгийг хэлнэ. Япон хэлэнд гитайгог түлхүү хэрэглэдэг. Гионго нь Япон хүнд сонсогдож байгаа дуу чимээг тэр чигээр нь илэрхийлсэн байдаг бол гитайго нь дуу чимээгээр биш аливаа юмны байр байдлыг төлөөлүүлэн хэлдэг үг учир тэр байдлыг нь сайн мэдэхгүй хүний хувьд хэцүү асуудалын нэг байдаг. Гитайгогийн үндэс болох үгнүүд энгийн үгийн санд их орсон байдаг. Япон хүмүүс эдгээр хэллэгүүдээ их хэрэглэж заншсан байдаг учир тухайн хэлийг сонгон суралцаж буй оюутан залуус дээрх хэллэгийг сайтар эзэмшин хэрэглэж заншвал Япон хүнтэй харилцахад илүү хялбар байх төдийгүй Япон юм.

#### **I.1. Дуу чимээ болон дүрс дуурайсан үгийн төрлүүд**

Дуу чимээг илэрхийлэх үгс нь дотроо хүн болон амьтаны дуу авиаг илэрхийлэх Гисэйго, байгалийн юмс үзэгдлийн дуу чимээг заадаг Гионго гэж ангилдаг байна. Харин аливаа юмсын дуу чимээг бус ямар нэг зүйлийн үйл хөдлөл болон байр байдлыг заасан үгс дотроо амьтай зүйлсийн байр байдлыг заах гитайго, амьгүй зүйлсийн байдлыг заах гиёого болон хүний сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг канжёого хэмээн хуваан авч үздэг байна. Япон хэлэнд

Гионго, гитайго нь ойролцоогоор 2000 орчим байдаг гэсэн судалгаа байдаг бөгөөд тэдгээр нь бүгд өөр өөрийн онцлогтой үгс байдаг.

Судалгаанаас үзвэл хэлбэр талаасаа хамгийн их байдаг нь [いやいや] [えんえん] гэх мэт дахин давтагдах үетэй үгс бөгөөд энэ загвараар бүтсэн үг 419 байдаг. Дараагийнх нь [きらっ] гэх зэрэг үгс 212, гуравдугаарт [うんざり] [ずばり] гэсэн хэлбэрийн 141 үг, дөрөвдүгээрт [すっかり] [かっかり] хэлбэрийн үгс 103 байдаг байна. Дээрх хэлбэрүүдээс өөр хэлбэрийн Гионго гитайго байна. Үүнээс дурдвал эгшиг уртсаж дуудагдах хэлбэр, нэг авиа дээр тулгуурлан бүтсэн үгс гэх мэтчилэн маш олон төрлийн гионго болон гитайго байдаг. Ингэж олон янзаар үг бүтэх нь 擬音語гионго 擬態語гитайгогийн гол онцлог нь юм.

### Дуу чимээ болон дүрс дуурайсан үгийг Монгол хэлнээ орчуулах нь

会う-ぶつかる-ぶつける

#### 1. ばったり гэнэт, санамсаргүй

予定していなかったのに、思いがけなく人と出会う様子。驚きの気持ちを含んでいる。Жишээ өгүүлбэр: きのう新宿で昔の恋人にばったりであった。Өнөөдөр Шинжюүд эртний найз залуутайгаа санамсаргүй таарсан.

#### 2. こっそり сэмээрхэн, сэмхэн, нууцаар

他人に知られないように何かをすること。Жишээ өгүүлбэр: 二人は親から交際を反対されていたが、時々こっそりと会っていた。Тэр хоёрын үерхлийг эцэг эх нь зөвшөөрдөггүй учраас, тэр хоёр нууцаар уулздаг.

#### 3. ごつんと

硬くて重たい物と物が、激しくぶつかる音を表す。ほかに、[がちん] [がん][がん] [ごん] などよく使う。

→ Маш хатуу хүнд зүйл хүнд юмтай мөргөлдөхийг илэрхийлдэг. Үүнээс гадна, [がちん] [がつん] [がん] [ごん] зэргийг их хэрэглэдэг. Жишээ өгүүлбэр: 消しゴムを捨てたとき、机の角にごつんと頭をぶつけた。Баллуураа авах гэж байгаад ширээний буланд толгойгоо цохичихлоо.

#### 4. こつんと Түгхийтэл цохих

小さくて硬いものが軽くぶつかる音。[こつん、かつん]などもよく使う。Жижиг хатуу зүйл аливаа юмыг хөнгөн мөргөх чимээ。[こつん、かつん] зэргийг мөн адил хэрэглэдэг. Жишээ өгүүлбэр: 窓がガラスに、こつんと小さな虫がぶつかっている。Цонхны шилийг жижигхэн хорхой түгхийтэл мөргөчихсөн.

洗う-磨く-汚れる Угаах – зүлгэх – бохирдох

#### ごしごし үрэх, шир шур хийх, үрэгдэх

強くこすって洗う様子。股、その音。Жишээ өгүүлбэр: ひどい汚れてです。でも、ごしごし洗えばおちますよ。よ Их бохирдсон байна шүү. Гэхдээ, сайтар үрж угаавал үр дүн нь гарна байх аа.

#### 2. じゃぶじゃぶ үсчүүлэх, цалгитал хийх

水をかき回したり、水をながしながらあらったりする音。また、水の中を歩いたりする音。Жишээ өгүүлбэр: この服を洗濯機がつかえないから、手でじゃぶじゃぶ洗うしかない。Энэ хувцасыг угаалгын машинаар угаалгүйгээр, гараараа угаахгүй юу

### 3.びかびか Гял цал, гялалзах, гялехийх

つやがあつて、光が反射するほどじれいな様子。また、新しいものを形容するときも使う。Жишээ өгүүлбэр: お客さんが来る前に、グラスをびかびかに磨いておこう。

### 言う-しゃべる-話す Хэлэх -чалчих – ярих

くどくど дахин дахин

く かえ  
しつこく何度も ;繰り返して言うこと。Жишээ өгүүлбэр: 同じことを何度もくどくど言わないで。 Яг адилхан зүйлийг дахин дахин битгий хэл.

### ぺちやくちゃ юм ярих элдвийг ярих

友達同士などが、軽い話題を中心に、休みなくおしゃべりをしている様子。Жишээ өгүүлбэр: このカフェには近所のおばさんがよく集まって、ぺちやくちゃとおしゃべりを楽しんでいる。Энэ кафе хөрш эмээ нар цуглаарад, элдвийг ярин хөгжилдөж байна。

### ぶつぶつ Янших, үглэх, гонгинох

小さい声ではっきりしない話し方をする様子。特に、独り言を言っている人の様子を表すことが多い。股、はっきりしない言い方で不満を言うこと。Жишээ өгүүлбэр: あの人、さっきから一人で何かぶつぶつ言ってる。気持ち悪いなあ。Энэ хүн саяхнаас ганцаараа үглэдэг болсон。 Сэтгэл санаа нь таагүй байгаа бололтой。

### そひそ Шивгэнэх, шивнэх

ほかの人に聞こえないように、小さな声で話す様子。ひそひそと話すことを[ひそひそ話し]と言うことも多い。Жишээ өгүүлбэр: さっきからあの二人、私の方を見ながらひそひそ話していて、気になる。Саяхнаас, энэ хоёр над руу хараад шивнэж ярьдаг болсон。

### ぺらぺら Чөлөөтэй ярих, сайн чанарын даавуу, цаас

あまりよく考えずに、話してはいけないことでも何でも、よくしゃべる様子。また、外国語をとてもし上手に話す様子。Жишээ өгүүлбэр: あの方は、人の秘密をぺらぺらとしゃべるから、信用できません。Энэ хүн, хүний нууцыг ярьчихдаг учраас, итгэж чадахгүй。

### 歩く-行く-進む Алхах -явах-урагшлах

### のろのろ Удаан, аажуу, алгуур

動きがゆっくりしている様子。好ましくないと思う気持ちが込められている。Жишээ өгүүлбэр: のろのろ歩かないでください。授業におくれますよ。Битгий удаан алхаад бай хичээлээсээ хоцорлоо。

### よろよろ гуйвах, гуйвалзах, найгах

しっかり立つこと、歩くことができず、倒れそうな様子。見ていて危ない、という気持ちが含まれている。Жишээ өгүүлбэр: 酒に酔った人がよろよろと歩いていた。Архинд согтсон хүн гуйваад алхаж байна。

**ぶらぶら юу ч хийхгүй дэмий хоосон тайван алхах, алгуур удаан**  
目的がないまま、ただ歩いている様子。ぶらぶら歩くときは、はやくではなく、ゆっくり股仕事などの予定がなくて、特に何もしない様子も表す。Ямар ч зорилгогүйгээр зөвхөн алхаж байгаа байдал。Алгуурхан хурдан биш, тайван алхах。Бас ажлын зорилгогүй, ихэвчлэн юу ч хийхгүй байгаа байдлыг илэрхийлдэг。Жишээ өгүүлбэр: その川沿いの道は、犬を散歩にちょうどいいです。Энэ голын эргээр нохойгоо салхилуулахад яг тохирно。

**よちよち Тэнтэр тунтар**  
赤ちゃんが頼りない歩く様子。かわいさを表す。Жишээ өгүүлбэр: 赤ちゃんがよちよち歩くのはかわいい。Нялх хүүхэд тэнтэр тунтар алхаж байгаа нь хөөрхөн。

**痛む-Өвдөх**  
ちくちく  
針のように先の細いものが、浅く何度も刺すような痛みのことを表す。それほど強い痛み出はない。体の痛みのほかに、何か悪いことをして心が痛むときにも使う。Жишээ өгүүлбэр: このセータは首のあたりがちくちくする。Энэ хүзүүтэй цамц хүзүүний ойр хавийг хатгаад байна。

**ずきずき Янгинах, чимчигнэх**  
脈を打つように続けて、強く痛む様子。歯が痛いときや頭つうがするときなどによく使う。Жишээ өгүүлбэр: 風を引いて、ずきずきする。Салхи салхилсанаас болоод толгой янгинаж өвдсөн。

**きりきり шархирах**  
胃や頭が痛いときなどに使う。Жишээ өгүүлбэр: 突然、胃がきりきりと痛んで、歩けなくなった。Гэнэт ходоод шархирч өвдөөд алхаж чадахгүй болсон。

**ひりひり хорсох, хорсч өвдөх**  
皮膚や喉に、しびれるような軽い痛みを感じる様子。日焼けしたとき、辛いものべたとき、軽い火傷をしたときなどに使う表現。Жишээ өгүүлбэр: このカレーは、すごく辛い。唇がひりひりするよ。Энэ карэний халуун ногоо нь их юм аа, уруул хорсом。

**しくしく базлаж өвдөх, мэгшиж уйлах**  
あまり強くない痛む様子。おなかや歯が強いときによく使う。Жишээ өгүүлбэр: 風でおなかの調子が悪くて、ずっとしくしく痛むんです。Салхинд байхаар гэдэс базалж өвдөх гээд байх юм。

**起きる босох**  
**ぱっと гэв гэнэт, хурдан**  
動作や変化が、非常に短い時間でおこる様子。Жишээ өгүүлбэр 私は朝に強いので、時計が鳴るとぱっと起きます。Би өглөө их сэргэг байдаг учраас цаг дугарахаар л хурдан босдог。

## のそのそ

動きが遅く、にぶい様子。[ゆっくり] [のんびり]などはいい意味でつかわれるが、[のそのそ]は悪い意味で使われることが多い。Жишээ өгүүлбэр: みんなが朝食を食べ終わった頃、愛顧がのそのそとおきてきた。Бүгд өглөөний цайгаа ууж дуусах үед Аико дөнгөж босож ирсэн.

## 置く-押す-押さえる Тавих -дарах-барих

**そっと** аяархан, сэмхэн, зөөлхөн, хулгайгаар нууцхан

乱暴にならずに、静かに、丁寧にする様子。[そーっと] [そろりと]などとも。Жишээ өгүүлбэр: ワインがこぼれないように、グラスをそっと置いた。Виногоо асгахгүйн тулд стаканаа аяархан тавьсан。

## どんと гарах, орох

音がするぐらい、勢いよく、力を入れて何かをする様子。少し乱暴な感じ。股、力強い様子を表すこともある。Жишээ өгүүлбэр: その不愛想な店員は、水の入ったコップをテーブルにドんと置いた。Тэр соёлгүй харьцаа муутай худалдагч устай аягийг ширээн дээр тавьсан。

## どさっと

重いものや大きいものが、落ちたり、倒れたり、投げだされたりする音や様子。Жишээ өгүүлбэр: 旅行から帰ってきた兄は、大きな荷物をどさっと床に置いた。Ах аяллаас ирээд, том ачаагаа түгхийтэл коридорт тавьсан。

## ぎゅっと Чав чанга

強い力で握ったり、押さえたりすり様子。Жишээ өгүүлбэр: クロちゃんの写真を撮るから、暴れないようにぎゅっと押さえて。Күрогийн зургийг авах болохоор агсан тавиулахгүйн тулд чанга барьж байгаарай。

## ぐいぐい

力を入れて、押したり、引いたりする様子。強いがある感じ。また、酒などを何杯も強いよく飲む様子を表す。Жишээ өгүүлбэр: 上からぐいぐい押さえたが、ケースに全部は入らなかった。Дээрээс нь хүчтэй түлхсэн ч, чемоданд бүгд орохгүй нь ээ

## 怒る – 騒ぐ уурлах – шуугилдах

**ぶんぶん** маш их уурлах, үнэр үнэртэх

怒って、機嫌が悪い様子。あまり深刻ではなく、一時的な場合が多い。かわい感じを表すことも多い。Жишээ өгүүлбэр: 姉は、彼氏に"太ったね"と言われて、ぶんぶん怒っていた。Эгч найз залуудаа бүдүүн юм аа гэж хэлүүлээд маш их уурласан。

**かんかん** Дүрэлзэх, шатах

とても怒る様子 Жишээ өгүүлбэр: 新しいラバイトの子が三日続けて遅刻をしたので、店長はかんかんにおこった。Шинэ цагийн ажилтан 3 хоног дараалан хоцорсон учраас, дэлгүүрийн эзэн уурласан。

わあわあ

やかましく騒ぐ音や様子。また、世間で話題になっている状態を表すこともある。Жишээ өгүүлбэр: 電車の中で若者の集団がわあわあ騒いで、うるさかった。Галт тэргэнд залуучууд бөөнөөрөө шуугилдаад, төвөгтэй юм аа.

### **わいわい шуугиантай үймээнтэй**

多くの人が、それぞれで大きな声で話している様子。花見の様子を表すときによく使う。Жишээ өгүүлбэр: 同窓会では久しぶりに懐かしい友達に会って皆でわいわい話しました。Хамт суралцагчдын уулзалт болон удаан уулзаагүй дотнын найзтайгаа уулзахаар бүгд чанга ярьдаг.

### **落ちる-折れる унах -хугарах**

#### **1 どすんと**

重いものが落ちたり倒れたりする音や様子。また、飛行機の高度や株の値段などが急に大きく下がるようす。Жишээ өгүүлбэр: 今日は、大きな地震がおり棚の上の整理箱おちてきた。Өнөөдөр, хүчтэй газар хөдлөлт болоод тавиур дээр цэгцтэй байсан хайрцаг унасан.

#### **ぱらぱら шир шир, шар шар, пад пад**

雨や小石など、小さくてもものが落ちたりふったりする音や様子。

Бороо хайрга зэргийн жижиг зүйл унах болон орох үед гарах дуу мөн тэр байдал. Жишээ өгүүлбэр: この木は病気みたいだ。はっぱがぱらぱら落ちてしまう。Энэ мод өвдсөн юм шиг. Навчис нь шар шархийн унаж байна.

#### **ぽたぽた Дусал дусах үед под под, тог тог гэж дугарах**

水のしずくが次々に落ちる音や様子。この場合、次のしずくが落ちるまで間隔が長い。Жишээ өгүүлбэр: 彼女の目から涙がぽたぽた落ちた。

Найз охины маань нүднээс нулимс под, под гэж унасан.

#### **ぼきっと**

細くて固いものが折れる音。もろい感じ。Жишээ өгүүлбэр: 彼は枯れた木をぼきっと折れて、火の中に入れた。Тэр хуурай мод хугалаад гал руу хийсэн.

### **書く 読む бичих унших**

#### **1さらさら шар шархийх, сэрчигнэх, харжигнах, хуурайших**

流れるように、途中で止まらないで文字や絵を書く様子。Жишээ өгүүлбэр: 彼は色紙を受け取ると、慣れた様子でさらさらとサインを書いた。Тэр зориулалтын цаасан дээрх хүлээн авсан баримт дээр сурсан байдлаараа сэрчигнүүлж бичсэн.

#### **2.かりかり шаржигнах,пад пад хийх**

固いものを引っかいたり、削ったり、かきったりするときの軽い音。鉛筆や万年筆の先が紙に当たるおとを表すことがある。Жишээ өгүүлбэр: 試験中はカリカリと言う鉛筆の音が聞こえた。Шалгалтын үеэр шар, шархийх харандааны дуу л сонсогдсон.

#### **ざっと Ойролцоо, бараг, барагцаагаар**

細かいところは気にしないで、大まかにすること。多くの場合、急いで何かをするときにつかわれる。いろいろな動詞とともに使われる。 Жишээ

өгүүлбэр: 朝はいつも、朝食をたべながら、新聞にざっと目を通します。Өглөө болгон цайгаа уунгаа сонин товчхон гүйлгэж уншдаг.

**じっくり нягт, ул суурьтай, анхааралтай, хянамгай**

落ち着いて、ゆっくり丁寧になにかをする様子。いろいろな動詞と一緒に使われる。Жишээ өгүүлбэр: 硬い内容だと思っていただけじっくり読むとなかなか面白い本だね。Нэлээд сонирхолтой номын гол санааг нь бодон, нягталж унших.

**すらすら түгдрэлгүй саадгүй**

物事が途中で止まったりせずに進む様子。Жишээ өгүүлбэр: つとむ君は、まだ5歳なのに小学生の算数の問題をすらすら解く。

Цүтомү, хараахан 5 нас хүрээгүй ч бага сургуулийн сурагчийн тооны бодлогыг түгдрэлгүй хариулдаг.

**噛む-かじる Хазах, зуух - мэрэх хэмлэх**

**くちやくちや шал шал, шалир шалир зажлах, үрчийлгэх, шалчийлгах**

ものを噛むときの音や表す。特に、口をあけて、ガムなどを音を立てながら噛むときに使う。Жишээ өгүүлбэр: ご飯食べるときにくちやくちやするのやめて。Хоолоо идэж байх үедээ шалир шалир гэж зажлахаа боль。

**1.かぶっと**

大きな口を開けて、一気に噛みついたり、食べたりする様子。

Жишээ өгүүлбэр: こんな小さな犬でも、突然がぶっと噛むことがあるから気をつけてください。Энэ нохой жижиг боловч, гэнэт хажаж магадгүй учир санаа зовсон。

**がりがり Хяхтнуулах, хяхтнасан дуу гарах**

硬いものをかじったり、削ったり、噛み砕いたりする音。ちょっと荒っぽく噛んでいる感じ。Жишээ өгүүлбэр: 最近は暑くて暑くて、氷をがりがりかじってばかりです。Саяхан маш их халуун байсан болохоор мөс хяхтнуулж идсэн。

**4.ぼりぼり шажигнуулах, шар шар зажлах, хумсаар маажих чимээ**

硬いものを噛み砕く音。Жишээ өгүүлбэр: ちょっとお腹が空いたので、ピーナッツをぼりぼり食べてました。Гэдэс жаахан өлссөн учраас самар шар, шар дугаргаж идсэн。

**覚える-忘れる**

**Цээжлэх, тогтоох, санах - мартах**

**どンドン урагштай, амжилттай, хурдан, тасралтгүй, хүчтэй цохих дуу**

物事が、勢いよく、調子よく進んだり、行われたりする様子。また、迷いや遠慮がない様子。いろいろな動詞と一緒につかわれる。Жишээ өгүүлбэр: 朝は頭が冴えて、どンドン単語を覚えられる。Өглөө толгой сэргэг байдаг болохоор хурдан үгээ цээжилье。

**ぼんやり**

Гөлийсөн, гөлөрсөн, алмайрсан, тодорхой бус, бүдэг бадаг, хоосон дэмий, юу ч хийхгүй, хайхрамжгүй, болгоомжгүй

記憶や事柄の内容がはっきりしないで、あいまいなようす。いろいろな動詞とともにつかわれる。Дурсамж болон хэрэг явдлын талаар тодорхой бус эргэлзээтэй санах байдал。Бүх үйл үгтэй хамт хэрэглэж болно。

Жишээ өгүүлбэр: 幼いころ、父によく遊んでもらったのをぼんやり覚えている。Бага насандаа, аавтайгаа тоглодог байснаа бүдэг бадаг санаж байна。

### **3. きっちり** нарийн яг таг, цэвэр нямбай, пиг

あいまいさがなく、正確、確実に何かを行う様子。いい意味で使われることが多い。Жишээ өгүүлбэр: 借りたものはきっちり返す。それは当然のことです。Өртэй байсан хүн яг буцааж өгсөн。Энэ гэнэтийн зүйл боллоо шүү。

### **すっきり**

一つ残らず全部である様子。いろいろな動詞と一緒につかわれる。

Жишээ өгүүлбэр: 彼女は新しい恋人ができて、僕のことはすっきりわすれてしまったみたいだ。Найз охин маань шинэ найз залуутай болоод, миний тухай бүр мөсөн мартсан юм шиг байна。

### **うっかり** Алмайрах, хайнга, хайш яайш, анхааралгүй

注意するのを忘れていて、何かを失敗する様子。いろいろな動詞といっしょに使う。Жишээ өгүүлбэр: オートロックなのに、うっかり部屋に鍵を忘れた。Автоматаар түгжигдсэн болохоор, өрөөний түлхүүрээ мартчихжээ。

**切る-刺す-刺さる** Огтлох – хатгах, чичих, сүлбэх – хатгуулах, сүлбүүлэх

#### **1. ぱっと** ナイフや包丁などの刃物で、うまく、物を切る様子。

Жишээ өгүүлбэр: その侍は、刀でぱっと竹を切った。Тэр самурай, сэлмэнд чадварлаг бөгөөд хусыг огтолчихсон。

#### **2. ざっくり** Тас, тасар огтлох

力を入れて勢いよく切る様子で、特にひとつのかたまりをいくつかのかтамりに切り分けるときに使う。

#### **ぶすっと** Баргар, дүнсгэр

先のとがったものが、やわらかいものに刺さる様子、音。

Жишээ өгүүлбэр: 時代劇で、忍者が探検をぶすっと畳に突き刺した。

Он цагийн жүжигт, нинжа баргар царай гарган татамиг тас цавчсан。

#### **ちくっと**

針などをちゅっと刺す様子や、そのときに感じる痛み。Жишээ өгүүлбэр:

1. 今ちくっと刺された感じがした。Чүд чүд хатгуулах мэдрэмж төрсөн。

#### **暮らす** амьдрах, аж төрөх

**ゆったり** чөлөөтэй, сэлүүхэн, тайван, налгар, уужим, хэлхгэр

落ち着いていて、空間や気持ちにゆとりがある。ゆっくりと時間を過ごす様子。いい意味で使うことが多い。Жишээ өгүүлбэр: 田舎だのびのびと子育てをし、家族でゆったりと暮らしたい。Хөдөө явахаа хойшлуулаад хүүхдээ өсгөж, тайван амьдармаар байна。

### **のんびり** амар тайван, санаа амар, тайван

忙しくなく、気楽で落ち着いている様子。いい意味に使うことが多い。人の評価に使うとマイナスの意味を含むことが多い。Жишээ өгүүлбэр: 引退した後は、山奥に別荘を買って、愛犬コロと共にのんびり暮らしています。

Огцорсныхоо дараа, уулын бэлд зуслангийн газар худалдаж аваад хайртай нохой Коротойгоо хамт байх нь тайван сайхан байна.

### **あくせく** Ажил хэрэгч, эрч хүчтэй, завгүйдэх, шаргуу ажиллах

心に余裕がなく、細かいことに気をとられたり忙しく仕事をしたようになります。Сэтгэл тавгүй, жижиг зүйлд санаа тавин завгүй ажлаа хийх дүр.

Жишээ өгүүлбэр: **あくせく**暮らす日々の中、季節の変化に気づかなくなる。Завгүй амьдрах өдрүүдийн дунд улирал солигдсоноор сэтгэл санаа тавгүйтсэн.

### **いきいき** сэргэлэн, цовоо

元気がよくて、勢いや活気がある様子。特に、顔の表情や、目や動作の様子を表すときに使う。Жишээ өгүүлбэр: お年寄りが生き生きと暮らせる会社をめざします。Настан, сэргэлэн цовоо амьдруулж чадах компанийг зорьсон.

### **開ける** -**閉める** нээх, онгойлгох, задлах - хаах битүүлэх

#### **がらがら** тачигнах, хоржигнох дуугарах

引き戸などを開けたり閉めたりするときの音。窓など小さいものを瞬間的に開けるときは使う。このほか、箱や器の中で何かが転がるように動いて音を立てるときなどに使う。Жишээ өгүүлбэр: 朝はいつも、近くのパン屋がシャッターをがらがらと開ける音で目が覚める。Өглөө болгон үргэлж, ойролцоох талхны дэлгүүрийн түгжээ дугарахад сэрдэг.

#### **すーっと**

引き戸やふすまなどが、滑らかに、静かに開けいたり閉まったりするようす。Жишээ өгүүлбэр: 入口の戸がすーっと開いて、旅館の主人が部屋に入ってきた。Орох хаалгыг онгойлгон буудлын эзэн өрөөнд орж ирсэн.

#### **ぼんと**

比較的軽くて小さいものが、勢いよく飛び出したり、はじけたり、軽く破裂したりする音。Жишээ өгүүлбэр: ワインのせんを開けるときの、ぼんという音が好きだ。Виноны бөглөөг онгойлгох үед, пан хийх чимээнд дуртай.

#### **ぱたんと** тас хийх, пад хийх

戸などを閉める軽いおと。Жишээ өгүүлбэр: 父はよんでいた本をぱたんと閉めって、昼ねをはじめた。Аавыг дуудахад номоо пад хийтэл хаагаад өдөр унтаж байсан нь анх удаа.

#### **座る** суух

#### **どっかり** Лагхийн, лүгхийн

堂々と座る様子。態度が大きな人に対してなど、いい意味で使わない場合もあります。Жишээ өгүүлбэр: 息子は朝からテレビの前にとっかり座って、何もしない。Хүү өглөөнөөс хойш зурагтын өмнө лаглайтал суучхаад, юу ч хийсэнгүй.

#### **ちょこんと** цэгцтэй, томоотой

小さく動かずに座っている様子。Жишээ өгүүлбэр: 赤い服を着た女の子がちよこんと座っている。Улаан өнгийн цамц өмссөн охин шатан дээр томоотой сууж байна.

**咳をする -鼻水が出る ханиад хүрэх – хамрын нус гоожих**

**こんこん** үнэг чоно улих, хуурай ханиах, хана цохих, цас мөндөр орох чимээ.

風邪をひいたときの音。比較的軽めのときに使われる。Жишээ өгүүлбэр: 1. きのうの昼からこんこん咳が出る。Өнөөдөр өдрөөс хуурай ханиалгаад байна。Ханиалгаад байсан, ханиад хүрчихсэн юм биш байгаа。

**ごほごほ**

風邪をひいたときの咳の音。Жишээ өгүүлбэр: 田中さん、ごほごほ咳してたけど、明日やすんだほうがいいんじゃない。Танака гуай ханиадтай байгаа учраас маргааш амарсан нь дээр бишүү。

**ずるずる** сунжрах, алгуурлах, чирэх, гулгах, халтирах

鼻水がたくさん流れ出る様子。また、音を立てて鼻水をすする音。汚いイメージ。Жишээ өгүүлбэр: 外はずごく寒くて、走っているうちに鼻水がずるずる出てきた。Гадаа хүйтэн байсан учраас гүйж байх үед сунжирч гарсан。

**たらたら** дусаах, гоожуулах, унжуулах, гомдол, дургүйцэл

液体しょうのものが少しずつ続けて下に流れ落ちて行く様子。汗や鼻水について言うことが多い。Жишээ өгүүлбэр: 部屋の中があまりに暑くて汗がたらたら出てきた。Өрөөнд тийм ч халуун биш ч хөлс дусалсан。

**叩く** цохих, алгадах

**ぱしっと**

勢いよく音を立てて、物と物が当たる様子。Жишээ өгүүлбэр: 腹が立ったので、彼の顔をぱしっと叩いた。Гэдэс рүү цохисон учраас түүнийг тас алгасан。

**とんとん** зөөлөн цохих дуу, хэвийн, дүндээ дүн, яв цав, саадгүй

続けて軽く叩く音。Жишээ өгүүлбэр: 外からトントんと、玄関のドアをノックする音がした。Гаднаас зөөлөн цохиод, үүдний өрөөний хаалгыг онгойлгох дуу гарсан。

**どんでん** урагштай, амжилттай, хурдан

続けて強く叩いたりする音。トントんより強くて大きいおと。Жишээ өгүүлбэр: 隣の部屋がうるさいので、壁をどんでん叩いて注意した。Хажуу өрөөнийхөн төвөгтэй байсан учир, ханыг нь болгоомжтой цохисон。

**食べる - 味わう** идэх – амтлах, амсах

**ぱくぱく** амаа томоор ангайлгаж, хамхих

食べ物を元気よく食べる様子。

Жишээ өгүүлбэр: 1.何でもおいしそうにパクパク食べてくれる人と結婚したいです。Юу ч байсан амттай байна шүү гээд иддэг хүнтэй гэрлэмээр байна。

**がつがつ** шунаглан, ховдоглон

食欲が盛んで、食べ物をととてもほしがって、急いで食べる様子。Хоолны дуршил ихтэй, идэх юманд үнэхээр дуртай учир завгүйгээр идэх байдал. Жишээ өгүүлбэр: そんなに急いでがつつ食べると、お腹が痛くなるよ。Ингэж ихээр нь шуналдаж идэхээр гэдэс чинь өвдөхгүй юу

**もぐもぐ** гонгинох, бувтнах, ээрэх, түгдрэх

口をあまり開けないで、また、そのような口の動き。Жишээ өгүүлбэр: 子供が私に隠れて、何がもぐもぐ食べている。Хүүхэд маань надаас нуугаад ямар нэгэн юм бувагнуулан идэж байна.

**もくもく** дув дуугүй, дуугарахгүй

黙って何かを続けてすること。Жишээ өгүүлбэр:

これからどうなるかわからなかったが、みんなもくもくと作業を続けた。

Үүнээс хойш, юу ч болсон гэсэн бүгдээрээ чимээгүй ажлаа үргэлжлүүлье.

**走る** – **はねる**гүйх – үсрэх, харайх, ойх

**のろのろ** удаан, аажуу, алгуур

動きが遅くて、ゆっくりしている様子。車についてよく使われる。

Хөдөлгөөн удаантай, алгуур хийх байдал. Машинд их хэрэглэдэг. Жишээ өгүүлбэр: 前の車がのろのろ走るから、なかなか進めない。Урд байгаа машин хөдлөхгүй байгаа учраас ерөөсөө урагшлахгүй байна.

**びゅんびゅん** салхи хүчтэй салхилах

風を切って勢いよく動く様子。風の音を表している。Жишээ өгүүлбэр: 広い道路を車でびゅんびゅん走るのは、気持ちがいい。Өргөн замаар машинтайгаа салхи зүсэн явах сайхан.

**びよんびよん** дэвхцэх, дэгдэх

軽い感じで繰り返しはねる様子。Жишээ өгүүлбэр: うれしくて、子供がびよんびよんはねている。Баярлаад, хүүхэд маань дэвхцэн үсэрч байна.

**泣く** - уйлах, гонгинох

**えんえん** үргэлжилсэн, сунжирсан

声を出して泣く様子。子供に使う。Жишээ өгүүлбэр: 子供がわがママを言っ  
て、えんえん泣いている。Хүүхэд өөрийнхөөрөө үргэлжлүүлэн уйлж байна.

**しくしく** мэгшин уйлах, базалж өвдөх

小さな声でよわよわしく泣く様子。子供や女性に使う。

Жишээ өгүүлбэр: お母さんに叱られて、子供がしくしく泣いている。Ээждээ загнуулаад, хүүхэд нь мэгшин уйлж байна.

**わんわん** хүүхэд уйлах чимээ, нохой хуцах чимээ

人が大声を出して泣く様子。Жишээ өгүүлбэр: 10年間可愛がっていた猫が死んだときは、わんわんなきました。Арван жилийн туршид хайрласаар ирсэн муураа үхэхэд их уйлсан.

**並ぶ** Эгнэх, жагсах

**ずらっと**

人や物が列になって、たくさん並んでいる様子。Жишээ өгүүлбэр: こっちのケースには、有名メーカーの高級時計がずらっと並んでいる。Энэ чемоданд, алдартай брэндийн сайн чанарын цагнууд олон ширхэг байна.

**ぎっしり нягт, сайн, шигүү, шахцалдан, пиг**

すき間なく、いっぱい詰まっている様子。Завсар зайгүй дүүрэн чихээстэй байх。Жишээ өгүүлбэр: こっちの棚は本がぎっしり入っていて、もう一冊も入らない。Энэ хайрцагт ном дүүрэн байгаа учраас нэг ном ч орох зай алга。

**きっちり нарийн яг таг, цэвэр, пиг**

すき間があつたりずれたりしてなくて、ぴったりしている様子。Жишээ өгүүлбэр: 本がサイズごとにきっちり並んでいると、気持ちがいい。Номууд, яг хэмжээгээрээ эгнээтэй байгаа болохоор сэтгэл санаа сайхан байна。

**寝る-眠る Унтах, нойрсох**

ぐうぐう とてもよく眠っている様子。いびきの音を表す。1.仕事から帰ってきた父は、いつの間にかソファでぐうぐう寝ていた。Ажлаасаа гэртээ харьж ирээд аав, хэсэгхэн зуур буйдан дээр хурхираад унтаж байсан。

**すやすや зөөлөн, намуун, амгалан, тайван**

静かに気持ちよさそうに眠っている様子。寝ているときの息の音を表す。子供や動物に使うことが多い。Жишээ өгүүлбэр: 子供が遊びつかれて、すやすや眠っている。Хүүхэд маань тоглож ядраад, амар тайван нойрсож байна。

ぐっすり нам, таг унтах とても深く眠っている様子。Жишээ өгүүлбэр: 今日 は疲れたでしょう。早く帰ってぐっすり眠ったほうがいい。Өнөөдөр ч ядарлаа шүү。Хурдан хариад нам унтвал сайхан шүү。

**うとうと нойрмог, нойрмоглох, зүүрмэглэх**

寝るつもりはないが、眠くなって、そのままの姿勢で短い時間眠ること。電車で揺られるうち、うとうと眠ってしまった。Галт тэрэгний найгах хөдөлгөөнд зүүрмэглэчихсэн байна。

**飲む - уу, 吸う - сорох, татах****ごくごく**

飲み物を勢いよく飲むときの音を表す。Жишээ өгүүлбэр: すごくのどが渴いていたので、水をごくごく飲んだ。Үнэхээр их ам цангасан учраас, ус зөндөө их уусан。

**ぐいっと огцом татах, залгилан уух**

勢いよく、一気に何かを飲む様子。お酒に使うことが多い。Хүчтэй, нэг амьсгаагаар уух байдал。Архи уух үед түгээмэл хэрэглэнэ。Жишээ өгүүлбэр: 本酒は、小さなウツワでぐいっと飲むのがおいしい。Япон архийг жижиг савнаас залгилж уух амттай。

**ちびちび бага багаар**

少しずつ、時間をかけて何かをする様子。Жишээ өгүүлбэр: 父は毎晩、テレビを見ながらお酒をちびちび飲みます。Аав орой болгон зурагт үзэнгээ архийг бага багаар шимж уудаг。

**ちゅーちゅー**

口を小さくして何かを吸うこと。また、ストローで何かを飲む様子。Жишээ өгүүлбэр: 赤ちゃんは泣きやんで、ミルクをちゅーちゅー吸い始めた。Хүүхэд уйлахаа болиод, сүүгээ сорж эхэлсэн。

## 光る 光る 光る, гэрэлтэх, шалгарсан сайн

1. **ぴかぴか** гял цал, гялалзах, гялсхийх つやがあるものが、ずっと光っている様子。Жишээ өгүүлбэр: お母さんの金の指輪、古いのにぴかぴかひかっているね。Ээжийн алтан бөгж хуучин хэдий ч гялалзаж байна.

## **きらきら** гялалзах, гялтганах (туяа)

美しく光る様子。光などを反射していることも多い。Жишээ өгүүлбэр: 朝の太陽の光を受けて、川の水面がきらきら見えています。Өглөөний нарны цацрагийг сонирхож байхад, голын усны гадаргуу гялтганаж харагдсан.

**てかてか** гэрэлтэх, гялалзах つやがあつて光る様子。Жишээ өгүүлбэр: このズボンはまだ古くて、お尻の部分がてかてか光っている。Энэ өмд хуучраад өгзөгний хэсгээрээ цайрч байна.

## **太る** - тарган/ясер - туранхай, эцэнхий

**ぶくぶく** だらしない感じで太っている様子。マイナスのイメージで使う。Жишээ өгүүлбэр: 田中さんは、不規則な生活を続けているうち、ぶくぶく太ってしまった。Танака гуайн, эмх замбараагүй амьдрал нь үргэлжилсээр байгаа учир таргалсаар байгаа.

## **どんどん** урагштай, амжилттай, хурдан

何かが勢いよく進んでいく様子。プラスの意味で使うことが多い。Жишээ өгүүлбэр: あなたはやせすぎだからどんどんたべて、どんどん太ってね。Та хэт турсан учраас, сайн идвэл, ахицтайгаар жин нэмнэ.

## **まるまる** бамбагар, тарган, бөмбөгөр, дугуйрах, эвхрэх, бүхэл бүтэн, нэг мөсөн

よく太っている様子。大人より赤ちゃんや動物に使うことが多い。プラスの意味で使う。Жишээ өгүүлбэр: あそこにいる豚が、一番まるまる太っているね。Тэнд байгаа гахай хамгийн тарган нь юм байна.

## **がりがりに** хяхтнуулах, хяхтнасан дуу гарах

体がとてもやせている様子。人にも動物にも使う。Жишээ өгүүлбэр: 山田さんはがりがりにやせているので、あまり体力がない。Ямада гуай, үнэхээр туранхай учраас ямар ч чадалгүй.

## **げっそり** сэтгэл санаагаар унах, царай алдах

顔や体などが急にやせる様子。Жишээ өгүүлбэр: 昔、体調を崩して、げっそりやせたことがある。Эртнээс, биеийн байдал нь муу байсан болохоор царай алдаад турсан байна.

## **降る**- орох **落ちる** - унах, буух, ойчих **舞う**- хийсэх, дэврэх, эргэлдэх

### **ざあざあ** шаагих, юүлэх

雨が激しく降る音。**ざあざあ**降りがよくつかわれる。Жишээ өгүүлбэр: 突然、雨が**ざあざあ**降ってきた。Гэнэт бороо шаагин орлоо.

## **ぱらぱら** шир шир, пад пад, под под

小さくて粒状のものが少しだけ降ってくる様子。雨に使うことが多い。

Жишээ өгүүлбэр: 何かがぱらぱら降ってきたと思ったら、木の葉たった。Юу шир шир унаад байгаа юм болоо гэж бодтол, модны навчис байжээ。

**ちらちら** сүүмэлзэх, гялалзах, бага зэрэг, хааяа хааяа

小さくて軽いものが、ゆっくり落ちる様子。雪に使うことが多い。

Жишээ өгүүлбэр: 今年初めての雪が、ちらちらと降ってきた。Энэ жилийн хамгийн анхны цас бага багаар будран орж байна.

**しとしと** шир шир, шивэр шивэр

雨が静かに、音もなく降る様子。Жишээ өгүүлбэр: 朝起きて外を見たら、雨がしとしと降っていた。Өглөө босоод гадаах байдлыг хартал бороо шиврэн орж байлаа。

**曲げる - へこそ** Нугалах, мурийлгах, тахийлгах - хонхойх

**くねくね** мушгиа, муруй

何度も曲がって続いていく様子。道などの長いものに対して使うことが多い。 Жишээ өгүүлбэр: しばらくの間、くねくね曲がる坂道が続いた。Хэсэг хугацаанд, муруй налуу зам үргэлжилж байна。

**ぐにやりと**

外から熱や力を受けて、形が曲がったりゆがんだりする様子。 Жишээ өгүүлбэр: 風がものすごくて、持っていた傘が一瞬でぐにやりと曲がってしまった。Салхи ширүүн салхилаад, тэнд байсан шүхрийг агшин зуурт эвхчихсэн。

**ぐにやぐにや** зөөлөн, сул, үлбэгэр, ноомой

元の形を残さず、波を打つように形が曲がったりゆがんだりする様子。

Жишээ өгүүлбэр 車が突っ込んでガードレールがぐにやぐにやに曲がっていた。Машин дайрч ороод төмөр замын гүүрэн дээгүүр зөөлөн мушгиж гарсан。

**ぼこっと**

あな あ

穴が空いたように大きくへこんでいるようす。 Жишээ өгүүлбэр: 怒って壁を叩いたら、ぼこっとへこんでびっくりした。Уурлаад, ханаа цохитол хонхойхоор нь гайхсан。

**ぺこんと**

ものの表面の一部が、軽くへこむ様子やその音。 Жишээ өгүүлбэр: 親指でちょっとジュースの缶を押したらぺこんとへこんだ。Эрхий хуруугаараа түлхэхэд, пок гээд онгойсон。

**回る-転がる** Эргэлт – өнхрүүлэх, бөмбөрүүлэх, алдах, унагах

**くるくる** эргэлдэх, тойруулан ороох, улайран ажиллах

続けて回る様子。 Жишээ өгүүлбэр: 犬が自分のしっぽを追いかけて、くるくる回っている。Муур өөрийнхөө сүүлийг хөөгөөд тойрон эргэлдэж байна。

**ぐるぐる** тойрон, эргэн勢いよくつづけて回る様子。 Жишээ өгүүлбэр: 何億年も前から、つきは地球の周りをぐるぐる回っています。Хэдэн сая жилийн өмнөөс сар дэлхийн бөмбөрцгийг тойрон эргэлдсээр ирсэн。

**ぐるっと** эргэлдэх, хуйлах, эвхэх, ороох

まわりを回ったり、まわりを見たりすること。また一週したり一回転したりするようす。 Жишээ өгүүлбэр: 今日は天気もいいし、公園をぐるっと一周しましょう。Өнөөдөр тэнгэр сайхан байна。Цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалъя。

**ごろごろ** тас няс, тар няр, зүгээр суух, бөөгнөрөх, нижигнэх, нүргэлэх

大きくて重いものがゆっくり転がる様子。転がる音を表す。Жишээ өгүүлбэр: いま大きな岩がごろごろころがってきたら、逃げられないね。Удахгүй том чулуу тас няс гээд өнхрөөд ирэх нь холдож чадахгүй нь ээ.

**5.ころころ** өнхрөх 小かくて軽いものが転がる様子。Жишээ өгүүлбэр: 駅で100円玉を落としたら、ころころとボールがころがってきた。Галт тэргэнд 100 иений зоосон мөнгөө унагаагаад, тэр нь хол газар өнхрөөд ичмээр юмаа.

**見る** -**見つめる** Үзэх, харах, шалгах, ажиглах - ширтэх, ажиглах, гөлрөх

**1.じっくり** Нягт ул суурьтай, хянамгай, анхааралтай, сайтар 時間をかけて、落ち着いて何かをする様子。Жишээ өгүүлбэр: 答えを書いた後にもう一度じっくり見てください。間違いが見つかるかもしれません。

Хариултаа бичсэнийхээ дараа дахин нэг удаа анхааралтай хараарай.

**ちらっと**

一瞬の短い時間で見ること、あるいは人に会うこと。Жишээ өгүүлбэр: 本屋で最初の2、3ページをちらっと見ただけだから、内容まではよくわかりません。Номын тавиур дээр эхний 2、3-р хуудсыг сайн харсан ч агуулгыг нь ч сайн ойлгосонгүй.

**じろじろ** сонирхон, сониучирхан, цоо, тас

珍しいものを見るように、またそれを評価するように、目を離さすにずっと見る様子。失礼な印象を含む。Жишээ өгүүлбэр: 彼のお母さんに挨拶に行ったら、上から下までじろじろ見られて、嫌だった。Түүний ээжтэй нь мэндлээд, дээрээс нь доош нь хүртэл тас ширтээд, муухай юм боллоо.

**4. きよろきよろ** сониуч, дурламтгай 落ち着かない不安な様子で、周りを何度も見ること。Жишээ өгүүлбэр: 駅を降りて周りをきよろきよろ見ていたら私を呼ぶ声が聞こえた。Галт тэрэгнээс буугаад эргэн тойрноо сонирхон харж байтал, намайг дуудах дуу сонсогдсон.

**じっと** хөдөлгөөнгүй, анир чимээгүй 集中して、動かずに何かを行う様子。Жишээ өгүүлбэр: 何を思っているのか、彼は何も言わずに、ただ私の顔をじっと見つめていた。Ямар нэгэн юм бодоод тэр юу ч дугарахгүй зөвхөн миний царайг хөдөлгөөнгүй харж байна.

**燃える-焼ける** Шатах, гал гарах шатах, түлэгдэх, хуурагдах, шарагдах, борлох

**めらめら** гэнэт, дүрсхийн шатах 炎を立てて、力強く燃えている様子。心の状態を表すこともある。 Жишээ өгүүлбэр:

めらめらと燃える暖炉の火の中に、彼女との思い出の手紙や写真を投げ入れた。Дүрсхийн шатаж байсан зуухан доторх гал руу найз найз охиныхоо дурсамж болох захиа болон зургийг нь шидсэн.

**ぼうぼう** бүрхэгдсэн, хучигдсан 火が強いよく燃えている、燃え広がっている音やその様子。Жишээ өгүүлбэр: A B Cビルの家事は、窓から空気が入

って、さらにぼうぼうと燃やしていたら、火がどんどん大きくなって困った。ABC барилгын гал нь, цонхоор агаар орсны улмаас их талбай шатсан байна.

### 3. ジュージュー

肉や魚などが、フライパンやてっぱんなどの上でよく焼けている音やその様子。Жишээ өгүүлбэр: 肉がジュージュー焼けている音を聞いているうち、お腹が空いてきた。Мах шарж байгаа дууг сонсоод гэдэс өлсчихлөө.

#### こんがり хүрэн өнгө

食べ物などが、こげる程度に、よく焼けている様子。Жишээ өгүүлбэр: さっき、オープンに入れたケーキは、こんがりいい色に焼きあがった。Саяхан, цахилгаан зууханд хийсэн кекс хүрэн өнгөтэй болоод борлочихсон байна.

#### 止まる-止む Зогсох, болих – болих, намдах

1. ぱたっと これまで続いていたことが、突然止まる様子。 Жишээ өгүүлбэр: さっきまで隣の部屋からけんかの声が聞こえていたが、ぱたっと止んだ。Саяхныг хүртэл хажуу өрөөнөөс хэрүүл хийх чимээ гардаг байснаа больчихсон байна.

ぴたっと 時間的, 場所的に、急に止まる様子。

Жишээ өгүүлбэр: さっきまで大泣きしていた子供が、母親におもちゃを買ってもらおうとぴたっと泣き止んだ。Саяхан хүртэл, чанга дуугаар уйлж байсан хүүхэд ээж дээрээ очоод больчихлоо.

3. すーっと 音も立てず、速く静かに止まる様子。 Жишээ өгүүлбэр: 最新式の自動車は性能がいいので、音もなく、すーっと止まる。Шинэ загварын машины хүч нь сайн болохоор дуу гаргаад л хурдан больдог.

#### がたんと

固くて重いものが、大きな音を立てる音を表す。 Жишээ өгүүлбэр: 電車で寝ていたら、突然がたんととまったので、びっくりして起きた。Галт тэргэнд унтаж байтал, гэнэт зогсохоор нь гайхсан.

#### 笑う- 微笑む

Инээх - инээмсэглэх, жуумалзах, мишээх

\\にこにこ инээмсэглэл, мишээл

明るく、やさしく笑う様子。うれしい、楽しい、という気持ちのときによく使う。声は出していない。 Жишээ өгүүлбэр: 空港で久しぶりに会った父は、にこにこわらって出迎えてくれた。Нисэх онгоцны буудал дээрээс, удаан уулзаагүй аав минь инээмсэглэн угтаж авсан.

くすくす жиг жуг, жуумалзах

相手にわからないように、声を抑えて笑う様子。女性に使われる。 Жишээ өгүүлбэр: 司会者が何度も間違えるので、客席からくすくすという笑い声が起こった。Хөтлөгч хэд, хэдэн удаа андуурсан учир, зочдын суудлаас жиг жуг инээлдэх дуу сонсогдсон.

にやにや шүдээ яралзуулан инээх

何かうれしいことや面白いことを思って、一人で声を出さずに笑う様子。  
Жишээ өгүүлбэр: 1. 木村さんは、なにか楽しいことがあるのが、一人でにやにやしている。キムラ、ямар нэгэн хөгжилтэй зүйл байгаа болохоор ганцаараа шүдээ яралзуулан инээж байна.

#### **げらげら тас хийтэл инээх**

何かがおかしくて、大声で笑う様子。少しうるさい感じ。Жишээ өгүүлбэр: 思い切って髪形を変えたら、みんなにげらげら笑われてしまった。

Шийдэмгийгээр, үсний засалтаа өөрчилтөл, бүгд шоолон тас тас хөхрөлдсөн.

#### **にっこり инээвхийлэл, инээмсэглэл**

とてもうれしそうに、ちょっと笑う様子。Жишээ өгүүлбэр: いすに座ってにっこり笑っているのが、私のおばあさんです。

Сандал дээр инээмсэглэж суугаа нь, миний эмээ.

#### **気持ちがよい感じ – Сэтгэл санаа сайхан байх байдал**

##### **Сэтгэл өндөр байдал**

##### **さっぱり огт, бүр, юу ч, ерөөсөө**

汚れなど不快なものが落とされ、残ってなく、さわやかで気持ちよい感じ。  
。 Жишээ өгүүлбэр: 今日は汗かいた。早くシャワーを浴びてさっぱりしたいなあ。Өнөөдөр их хөлөрлөө。Хурдан шүршүүрт орж угаая。

**すっきり бүх, бүгд, цэгцтэй, тодорхой, ил 余計なものがなく、気持ちよい感じ。** Жишээ өгүүлбэр: きのうのことはショックだったうけど、一晩泣いたら**気持ちがすっきりした。** Өчигдөрийн явдалд цочирдсон ч оройжингоо уйлаад сэтгэл санаа цэгцэрсэн。

**すっと хурдан, гэнэт, огцом, гялс, уужим, тэнүүн** 今まで引っかかって不快だったものがない状態で、気持ちよい感じ。 Жишээ өгүүлбэр: これまでの不満を全部課長に言ったら、**すっとした。** Өнөөдрийг хүртэл, сэтгэл дундуур байсан зүйлсээ хэлтсийн даргад хэлээд дотор уужирсан。

**ほっと санаа амар, амсхийх, уртаар амьсгаа авах** 心配なことなど、今までひっかかっていたものが取り除かれ、やっと安心する様子。 Жишээ өгүүлбэр: 入院したって聞いたときは驚いたけど、軽いけがで**ほっとしたよ。** Эмнэлэгт хэвтсэн гэж сонсоод гайхсан ч, ялимгүй зүйл гэхээр нь санаа амарсан шүү。

#### **Дүгнэлт**

Бид энэхүү судалгааны ажлаараа Япон хэлний дуу авиа дуурайсан "гионго" нь аливаа юмсын дуу чимээг нь дуурайсан хэллэг бөгөөд сонсогдож байгаа дуу чимээг тэр хэвээр нь илэрхийлсэн байдаг бол, дүрс дуурайсан "гитайго" нь хүн амьтан болон юмсын байр байдлыг заадаг гэдгийг жишээ өгүүлбэрийн тусламжтайгаар тодорхойлсон. Япон хэлний дуу авиа болон дүрс дуурайсан үгс нь 2000 орчим байдаг гэсэн судалгаа байдаг бөгөөд үг бүтэх аргын хувьд хамгийн их байдаг нь үг нь дахин давтагдсан үетэй үгс байдаг юм байна. "Япон хэлний үг, дүрэм болон дуу авиа дуурайсан болон дүрс дуурайсан үг" гэсэн номыг орчуулан сэдэв тус бүрийн "дуу авиа дуурайсан үг "гионго"

хэлбэр дүрс дуурайсан үг”- г түүн авч, аль үгийн аймгийн үг болох мөн тухайн номыг орчуулан, орчуулгын тал дээр нь судаллаа.

Ингэхэд үйл үг-96, тэмдэг нэр-101, дахин давтагдсан үетэй үгс-13, ойролцоо утгатай үгс- 27 байсан. Япон хэлнээ үг давхардах аргаар бүтсэн үгс монгол хэлнээ буухдаа үйл үг болох нь их байсан. Харин, нийт орчуулгын 60% -г үгчилсэн орчуулгаар, 20%-г нь утгачилсан орчуулгаар, 20%-г нь дүйцүүлсэн орчуулгаар орчуулсан. Харин цаашид улам бүр судлан, монгол хэлний дуу авиа, хэлбэр дүрс дуурайсан үг хэллэгийг япон хэлээр хэрхэн орчуулсныг орчуулгын зохиолын жишээн дээр авч үзвэл шинэлэг ажил болох боломжтой юм.

#### **Ном зүй:**

С.Дэмбэрэл “Япон -монгол” их толь бичиг УБ хот., 2018 он

Р.Гүрбазар “Орчуулгын онол дадлагын үндэс”

Д.Бадамдорж “Монгол хэлний үгийн сангийн утга зүй”

Д.Бадамдорж “Монгол хэлний утга зүйн шинжилгээ”

Н.Нансалмаа “Үгийн сан судлал”

にほんごたんご      ぎおんご      ぎたいご

日本語単語ドリル擬音語、擬態語 2008.01.01

## ЯПОН ХЭЛНИЙ ТУСАХ БА ЭС ТУСАХ ҮЙЛ ҮГИЙН ТУХАЙ

*Жаргал  
(БНХАУ, Соёл Эрдэм дээд сургууль,  
Япон судлалын тэнхимийн зочин профессор)*

*Агуулгын товч:* Зохиогч тус өгүүлэлдээ япон хэлний тусах ба эс тусах үйл үгийг монгол хэлтэйгээ харьцуулан, түүний ухагдахуун, утгын онцлог, ялган таньж хэрэглэх арга, жич үйл үгийн хэв байдлын талаарх онцлог зэрэг хэдэн талаар нарийвчлан шинжилжээ.

*Түлхүүр үг:* Япон хэлний тусах ба эс тусах үйл үг ухагдахууныг ялган тогтоох хэв байдлын онцлог

### Нэг. Ухагдахуун ба утгын онцлог

Япон хэлний үйл үгийг, тусагдахуунтай шууд холбогдох эсэхээр нь тусах үйл үг (他動詞) ба эс тусах үйл үг (自動詞) гэж хоёр төрөлд ангилдаг. Шууд тусагдахуун шаардах буюу шууд тусагдахуун авч чадах үйл үгийг тусах үйл үг гэнэ. Тусах үйл үг нь утгын хувьд үйлийн эзэн биеийн өөр хэрэг бодисыг хөдөлгөж, хувируулах буюу нөлөөлөхийг илтгэдэг. Өгүүлбэрт үйлийн эзэн бие нь тэр болгон илрэхгүй ч, тэр нь үйл үгийн утгаас нь тодорхой мэдэгддэг байна. Үйлийн эзэн биеийг нь нөхцөл ”が”-өөр илтгэн, шууд тусагдахууныг нь “を”-ээр илтгэдэг. Жишээ нь, 田中さんが 窓を開けた。Танака цонхыг нээв。この仕事に時間をかけた。энэ ажилд цаг зарцуулав。子供が コップを割った。Хүүхэд цом [аяга, шилэн аяга] хагалав。

Шууд тусагдахуун шаардахгүй буюу шууд тусагдахуун авч чадахгүй үйл үгийг эс тусах үйл үг гэнэ. Эс тусах үйл үг нь хүн буюу хэрэг бодис, үзэгдлийн өөрөө хөдөлж хувирахыг илтгэдэг. Тэрхүү хөдөлж хувирч байгаа эзэн биеийг нь нөхцөл “が”-өөр илтгэнэ. Мэдээж логикийн хувьд, тэр болгон өөрөө хувирсан биш ч (зарим үед хувируулсан эзэн бие нь тодорхойгүй, зарим үед хувируулсан эзэн биеийг гол болгон өгүүлэхгүй зэрэг найруулгын шаардлагаас болсон тохиолдол зэрэг), хэл зүйн хувьд, эс тусах үйл үгээр илтгэх нь найрлагын өнгийг ондоо болгодог. Жишээ нь, дээр дурдсан гурван өгүүлбэрийн үйл үгийг эс тусох үйл үг болгон найруулбал: 窓が開いた。Цонх онгойв。この仕事に時間がかかった。Энэ ажилд цаг оржээ。コップが割れた。Шилэн аяга хагарав。Тусах үйл үгээр ердөө үйл биелүүлэгчийн бодит, биеч зорилготой үйл хөдөлгөөнийг илтгэж, эс тусах үйл үгээр үйл биелүүлэгчгүй буюу эсхүл хүмүүсийн санаагаар болдоггүй хэрэг учрыг илтгэдэг учраас түүнээр үргэлж байгалийн үзэгдэл зэрэг бодит зориллогүй хэрэг учир, үзэгдлийг зурагладаг, эсвэл бусад хэрэг учрыг ийм хэлбэрээр эерүүлэн илтгэдэг байна. Жишээ нь, ドアを 閉めますよ、早く乗ってください

い。Үүдийг хаалаа шуу, хурдан суугаарай! ドアがが 閉まります。ご注意ください。Үүд хаагдлаа, анхаараарай! гэх мэт.

### Хоёр. Тусах ба эс тусах үйл үгийг ялган таних

Япон хэлэнд ижил язгуурт тусах, эс тусах үйл үг маш олон байхаас гадна нэг бүлэг үг нь хоёрдмол шинжтэй, бас нэг бүлэг үйл үг нь зөвхөн нэг л шинжтэй байдаг болохоор тэдгээрийг зохих төрөл зүйлд нь хувааж шинжих нь тэдгээрийн онцлогийг эзэмшин, зөв ялган танихад маш чухал ач холбогдолтой юм.

1. **Ижил язгуурт тусах, эс тусах үйл үг** – Бид ижил язгууртай, зөвхөн тусах ба эс тусах утгаараа ялгагддаг үгийг ижил язгуурт тусах, эс тусах үйл үг гэжээ. Энэ нь яг монгол хэлний ”хагалах ба хагарах, эвдэх ба эвдрэх, унагах ба унах” гэх зэрэг үзэгдэлтэй адил байдаг. Жишээ нь : 治す(эмнэх, эдгээх) ба 治る(эдгэх, эдгэрэх), 動かす(хөдөлгөх) ба 動く(хөдлөх), 折る(хугалах) ба 折れる(хугарах) гэх мэт маш олон үйл үгийг дурдаж болно. Өгүүлбэр болговол 病気を治す(өвчнийг эдгээх), 病気が治る(өвчин эдгээх) гэх мэт. ижил язгуурт тусах, эс тусах үйл үгийн үгийн сүүлийн ялгаанууд нь доорх мэт жам ёстой байдаг.

1. тусах -ウ эс тусах-ア<sub>る</sub>  
刺す хатгах 刺さる шигдэж орох  
つなぐ холбох つながる холболдох  
つかむ барих つかまる баригдах
2. тусах -ア<sub>す</sub> эс тусах-ウ  
焼く шарах 焼ける шарагдах, шатах  
切る таслах 切れる тасрах  
破る урах 破れる урагдах
3. тусах -す эс тусах-れる  
倒す унагах 倒れる унах  
流す урсгах 流れる урсах  
表す илтгэх 表れる илрэх
4. тусах -す эс тусах-る  
起こす үүсгэх 起こる үүсэх  
残す үлдээх 残る үлдэх  
戻す буцаах 戻る буцах
5. тусах -ア<sub>す</sub> эс тусах-ウ  
動かす хөдөлгөх 動く хөдлөх  
乾かす хатаах 乾く хатах  
鳴らす дуугаргах 鳴る дуугарах
6. тусах -ア<sub>す</sub> эс тусах-イ<sub>る</sub>.  
生かす амьдруулах 生きる амьдрах  
伸ばす сунгах 伸びる сунах

延ばす	сунжруулах	延びる	сунжрах
<u>7. тусах —アす</u>		<u>эс тусах—エる</u>	
慣らす	дасгах	慣れる	дасах
燃やす	шатаах	燃える	шатах
増やす	нэмэх	増える	нэмэгдэх
<u>8. тусах —オす</u>		<u>эс тусах—イる</u>	
起こす	сэрээх, бусах	起きる	сэрэх, босох
落とす	унагах	落ちる	унах
降ろす	буулгах	降りる	буух
<u>9. тусах —エる</u>		<u>эс тусах—アす</u>	
集める	цуглуулах	集まる	цуглах
始める	эхлүүлэх	始まる	эхлэх
止める	зогсоох	止まる	зогсох
<u>10. тусах —エる</u>		<u>эс тусах—ウ</u>	
開ける	нээх,	開く	онгойх
続ける	үргэлжлүүлэх	続く	үргэлжлэх
育てる	бойжуулах	育つ	бойжих
<u>11. тусах —す(る)</u>		<u>эс тусах—える</u>	
消す	унтраах	消える	унтрах
見る	үзэх	見える	үзэгдэх
まじる	холих	まじえる	холилдох
<u>12. тусах —せる</u>		<u>эс тусах—る</u>	
乗せる	онуулах	乗る	онох
載せる	тээх	載る	тээгдэх
寄せる	ойртуулах	寄る	ойртох

Эдгээр нь бол зөвхөн үзэгдлийг жагсаасан төдий болно. Бодитой сурч хэрэглэхэд бол яалт ч үгүй хос хосоор нь цээжилж хэрэглэж дадах хэрэгтэй юм.

**2. Тусах, эс тусах хоёрдмол шинжтэй үйл үг:** Япон хэлэнд зарим үгс нь тусах, эс тусах хоёрдмол шинжтэй байдаг. Ялангуяа サхувирлын үйл үгэнд ийм үзэгдэл арвин байдаг.

人数を 増す(ます)。 хүний тоог нэмнэ.

人口が 増す(ます)。 хүн ам нэмэгдэнэ.

車を 道のそば寄せておく。 машиныг замын хажууд ойртуулж тавих.

大きな波が 寄せてくる。 их давалгаан ойртож ирэх.

研究を 完成した。 судалгаагаа дуусгав.

仕事が 完成した。 ажил дуусав.

写真を 拡大した。 зургийг ихэсгэв.

規模が 拡大した。 хүрээ ихсэв.

木が 根を 張る。 мод үндсээ ургуулах.

根が 張る。 үндэс ургах.

仕事をする。 ажил хийх.

音が する。 чимээ гарах.

夏休みが 終わった。 зуны амралт дуусав.

今日の 授業を 終わった。 өнөөдрийн хичээлийг дуусгав (энэ бол  
終わる гэдэг эс тусах үйл үгийг 終える гэдэг тусах үйл үгтэй адилаар  
хэрэглэсэн жишээ болно.)

Тусах, эс тусах хоёрдмол шинжтэй үйл үгийн нэг хэсэг нь үгийн олон  
утгаас болж, ийм хоёрдмол шинжтэй болсон байдаг. Жишээ нь:

A. 私は喜んで、モンゴルのことを説明してあげます。 Би Монголын  
тухай байдлыг баяртай тайлбарлаж өгдөг.

B. 兄の忠告を 喜ばない。 Ахын сануулгыг хүлээн авах дургүй.

C. 進学を 喜ぶ。 Сургууль дэвшсэнийг бэлэглэх. Дээрх жишээнд “喜  
ぶ” гэдэг үг нь “баярлах, баяртай хүлээн авах, баярлан бэлэглэх” буюу  
“бэлэглэх” зэрэг үндсэн утга ба салбар утгатайгаас болжээ. Энэ үг нэгдүгээр  
утгаараа эс тусах үг, сүүлийн хоёр утгаараа бол тусах үг болно. Ийм үгээс бас  
хэдийг дурдвал, жишээ нь:

笛を 吹く／風が吹く。

人を笑う／人が笑う。

値段を負ける／AがBに負ける。

**3. Тусах буюу эс тусах нэг л шинжтэй үйл үг:** Тусах үйл үг: 読む、食べる  
、着る、投げる、試みる、打つ、殺す... гэх мэт. Эс тусах үйл үг: 行く、来  
る、いる、老いる、死ぬ、痩せる、歩く、泣く、発展する... гэх мэт.

### Гурав. ”を”-тай залгаж хэрэглэдэг эс тусах үйл үг

Дээр бид япон хэлний үйл үгийг шууд тусагдахуун авч чадах эсэхээр нь  
тусах үйл үг мөн эсэхийг нь шинжих чухал үндэслэл болгож болно, ”を” -ээр  
шууд тусагдахууныг илтгэдэг гэж ярьсан билээ. Энэ талаар монгол хэлтэй  
адилхан, гэвч адилгүй тал нь япон хэлэнд доорх мэт хоёр үзэгдэлд “を”-г онцгой  
эс тусах үйл үгтэй холбож, тусгай утгыг илтгэдэг. Тухайлбал:

1. Үйл хөдөлгөөний өнгөрөх орон газрыг “を”-ээр илтгэн, ард нь шилжиж  
хөдлөхийг илтгэх эс тусах үйл үгийг залгаж, ямар нэгэн газраар  
өнгөрөхийг илтгэдэг. Жишээ нь, 道を 歩く。 замаар явах. 空を 飛  
ぶ。 агаараар нисэх. Энд “を” нь монгол хэлний “аар, ээр” нөхцөлийн  
зохих утгатай тохиролцоно. Энэ мэт “орон талбайгаар шилжин хөдлөх  
буюу өнгөрөн гарахыг илтгэх” эс тусах үйл үг олон бий. Жишээ нь: 歩  
く／行く／散歩する／旅行する／走る／泳ぐ／泳いで渡る／這う／  
登る／飛ぶ／滑る／通う／通る／回る／超える／過ぎる／渡る／曲  
がる／通過する／経由する／飛び越える／横切る... гэх мэт.

2. Ямар нэгэн орон чигээс салж гарахыг илтгэх үед тэрхүү орон чигийг “を”-ээр илтгэж, ард нь салж гарахыг илтгэх эс тусах үйл үг залгадаг. Жишээ нь: 電車を降りる。цахилгаан галт тэргээс буух. 自動車を避ける。машин тэргээс зайлах. Энд “を” нь монгол хэлний “аас” нөхцөлийн зохих утгатай тохиролцоно. Энэ мэт “нэгэн орон чигээс салж гарахыг илтгэх”-тэй холбогдох эс тусах үйл үг олон бий. Жишээ нь, 出る／離れる／出発する／卒業する／北京を立つ／故郷を去る... гэх мэт.

#### Дөрөв. Тусах ба эс тусах үйл үгийн хэвийн онцлог

1. Тусах үйл үгэнд үйлдэгдэх хэвийн дагавар залгавал, даруй эс тусах шинжтэй болдог. Жишээ нь: 明ける— ドアを開けた。Үүдийг нээв. 開けられる— ドアがあげられた。Үүд нээгдэв. Сүүлийн өгүүлбэр нь хэлбэр бүтцийн хувьд “ドアが 開いた (үүд онгойв)” гэсэн эс тусах үйл үг өгүүлэхүүнд өгүүлбэртэй адил болно.  
木の枝を 折った。модны мөчрийг хугалав。  
木の枝が 折られた。модны мөчир хугалагдав。  
木の枝が 折れた。модны мөчрийг хугарав。  
機械を 動かした。машиныг хөдөлгөв。  
機械が 動かされた。тамашин хөдөлгөгдөв。  
機械が 動いた。машин хөдлөв.
2. Эс тусах үйл үгэнд үйлдүүлэх хэвийн дагавар залгавал, даруй тусах үйл үгийн шинжтэй болдог. Жишээ нь, 息子が 行った。Хүү явжээ. 息子を 行かせた。Хүүг явуулжээ. Ийм өгүүлбэрээс хоёрыг жишээ нь, 友達が 来た。Найз ирэв. 友達を 来させた。Найзыг ирүүлэв. 馬が 瘦せた。Морь эцэв. 馬を 瘦せさせた。Морийг эцээв гэх мэт.

#### Тав. Тусах ба эс тусах үйл үгийн байдлын талаарх онцлог

Япон хэлний тусах, эс тусах үйл үгийн үргэлжлэн орших байдлын утга ба хэлбэр нь ондоо, онцгой байдаг. Үүнийг зөвхөн жишээгээр үзүүлье. 窓が開いている。Цонх нээлттэй байна. 窓が開けてある。Цонхыг нээгээд тавьчихжээ. Энэ хоёр өгүүлбэр нь цонхны нээлттэй байгаа байдлын үргэлжлэн оршиж байхыг илтгэж байхын хамт, сүүлийн өгүүлбэр нь цаанаа энэ цонхыг ямар нэгэн хүн нээж тавьжээ гэснийг харуулж байна. Хэлбэр нь тусах үйл үг + である, Эс тусах үйл үг + ている . Доорх жишээнүүд мөн адил. 庭に車が 止まっている。Хашаанд машин зогсож байна. 庭に車が 止めてある。Хашаанд машин зогсоочихжээ. 冷蔵庫に肉が 入っている。Хөргөгчинд мах байна. 冷蔵庫に肉が 入れてある。Хөргөгчид мах хийгээд тавьчихсан байна.

Ийнхүү бид япон хэлний тусах, эс тусах үйл үгийн онцлог шинж жич тэдгээрийг зөв сурч хэрэглэхэд холбогдох өдий төдий асуудлуудыг нарийвчлан шинжлэн үзэхэд ийм байна.



# УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ



“УЧИРТАЙ ГУРВАН ТОЛГОЙ” БА “БЭЭЖИН ШИЙ”

Дулаан  
(БНХАУ, Бээжин Их Сургууль,  
доктор, профессор)

*Агуулгын товч:* Өгүүлэлд, хорьдугаар зууны тавь жараад онд шинэ Бээжин ший “Учиртай гурван толгой” нь Хятад - Монголын соёлын харилцааны үйл ажиллагааны дагуу бүтээгдсэн, улмаар хоёр гүрний нөхөрсөг харилцааны үр жимс болж боловсорсон тухай, мөн Хятадын ший жүжгийн шинэчлэлт өөрчлөлтийн түүхэн дээр ч онцгой үүрэг гүйцэтгэсэн тул бусад жүжгийн зохиолууд тодоос ялгарч гарсан талаар задлан шинжилжээ. Хятадын театрт тавигдаж байсан өөрчлөн найруулсан Бээжин ший “Учиртай гурван толгой” нь Д.Нацагдоржийн бичсэн Юндэн, Нансалмаа хоёрын хайр дурлалын гунигт жүжиг биш, харин Ц.Дамдинсүрэнгийн засан найруулсан Юндэн, Нансалмаа нар Балган ноёныг тэмцэн ялсан баярт жүжиг юм. Энэхүү сэдэв нь тухайн үеийн Монгол, Хятадын хоёр гүрний ангийн тэмцлийн үзэл ухамсрын гол урсгалтай яг сайхан нийлэн зохицож байсан бөгөөд дэлхий нийтийн олон улсын харилцааны хоёр лагерийн тэмцлийн байдалтай ч зохицож байснаараа Монгол-Хятадын соёлын харилцааны хамтын ажиллагаанд сонгогдсон хамаг тохиромжтой бэлтгэл болсон нь тодорхой.

*Түлхүүр үг:* Д.Нацагдорже, Учиртай гурван толгой, Ц.Дамдсүрэн Учиртай гурван толгой дуурь, Бээжин ший,

Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой” жүжиг зөвхөн Монгол Улсын театртаа тавигдаж байсан төдийгүй, түүнийг бахархан сонирхсон улс орны үндэсний ший жүжгийн тайзан дээр ч хэдэн жилийн хугацаатайгаар тавигдаж байсны нэг тодорхой жишээ нь гадаадын ард түмний сонгодог урлаг болсон Бээжин ший (Бээжин опера) “Учиртай гурван толгой” болно. Хятад, Монгол хоёр орны соёлын харилцааны үйл ажиллагааны дагуу 1956 оны зургадугаар сард Хятадын Бээжин шийн хоёрдугаар хүрээлэнд (Zhong guo jin ju er yuan) “Учиртай гурван толгой”-г Бээжин ший болгон өөрчлөн найруулж, театрт тавьснаас эхэлж, Бүх Хятадын бараг муж болгоны ший жүжгийн хүрээлэн нь цөм “Учиртай гурван толгой”-г тоглуулж, эгэл ардаас эхлэн төрийн тэргүүн хүртэл сонирхон үзэцгээсэн төдийгүй, шинээр өөрчлөн найруулсан “Учиртай гурван толгой” жүжиг нь уламжлалт Бээжин ший мөн үү? эсвэл гадаадын дуулалт жүжиг мөн? гэдэг асуудал нь их маргаан үүсгэж, Хятад ший жүжгийн хөгжилтийн түүхэн дээрх том үйл хэрэг болсон байна. Гэтэл жаран жилийн дараа эргэн харахад Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой”-г Бээжин ший болгон Бүх Хятадын жүжгийн театруудад тавьж байсан тухай Монгол улсын үзэгчид судлаачдыг битгий хэл, Хятадын ший жүжгийн түүх судалдаг эрдэмтэд ч бараг санаанд орохгүй мартаж орхимоор хэмжээнд хүрсэн байна. Олны цээжинд мартагдаж удсан Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой” жүжгийн Бээжин шийн нэг хувилбарыг олзуурхан судалж, он жилийн тоосыг нь арчиж, орчин үеийн уран зохиол, ший жүжгийн түүхийн хуудсанд

тэмдэглэж үлдээх нь их Нацагдоржийн зохиол бүтээлүүд зөвхөн Монголдоо бус зэргэлдээх том гүрний урлагийн хөгжилтийг ч хүчтэй нөлөөлж байсныг танин мэдэх ач холбогдолтой билээ.

### **НЭГ. “Учиртай гурван толгой”-г Бээжин ший болгон өөрчилж найруулсан өнгөрөлт**

Бээжин ший жүжгийг Хятадын алдарт жүжгийн зохиолч Fan Jun Hong бичиж, урьдаар “Жүжгийн зохиол” сэтгүүлийн 1956 оны долдугаар хугацаанд нийтлүүлээд, дараа нь засан боловсруулж, 1957 онд Хятадын ший жүжгийн хэвлэлийн хорооноос тусгай ном болгон хэвлүүлсэн байна. Бээжин ший “Учиртай гурван толгой”-г Ц.Дамдинсүрэнгийн зассан эхийг үндэслэсэн баярт жүжиг болох бөгөөд уг дуулалт жүжгийг зохиолч Анчинхүү, Номин хойно өмнө хоёр ч удаа Хятад хэлэнд орчуулж хэвлүүлжээ.

Хятадын театрт тавигдаж байсан “Учиртай гурван толгой”-н Бээжин шийн хувилбар нь Д.Нацагдоржийн бичсэн гунигт жүжгийн уг эх биш гэдгийг юуны өмнө тодорхойлж байна. Энэ нь мөн ч тухайн үед Монголын театрт тавигдаж байсан “Учиртай гурван толгой” жүжиг нь Ц.Дамдинсүрэнгийн зассан эх болох бөгөөд энэ тэмцлийн сэдэв нь хорьдугаар зууны тавь жараад оны үеийн олон улсын харилцааны дээр социалист гүрнүүд ба хөрөнгөт улсуудын хоорондох хоёр лагерийн тэмцлийн цаг үеийн дэвсгэр дээр тоглоход яг сайхан тохирсон сэдэв болж байсантай холбогдоно.

Зохиолч Fan Jun Hong -оос юунд “Учиртай гурван толгой” жүжгийг Бээжин ший болгон найруулсан зорилгоо ингэж ярьсан байна: “Бээжин шийн урлагийн арга барилаар орчин үеийн Монгол үндэсний амьдралыг харуулж, онцгойлон гадаадын алдарт бүтээлийг өөрчлөн найруулах ажил нь жүжиг найруулахаас аваад тайзан дээр гаргаж тоглох, хөгжим тааруулах аль талаас нь ярьсан ч цөм яваагүй “ЗАМ ТАМ” гэдэг шинэ туршлага юм. Тэр дотор Бээжин шийгийн урлагийн арга барилыг яаж Монголчуудын үндэсний урлагтай зохицуулах вэ гэдэг асуудал хамаг бэрх асуудал болж байна”

Тэгвэл Бээжин ший болон Монголын дуулалт жүжиг хоёрыг заавал нийлүүлэх гэж зүтгэсэн шалтгаан юу билээ? Энэ талаар Бээжин ший “Учиртай гурван толгой”-д Юндэнгийн дүрд тоглосон алдарт жүжигчин Zhang yun xi-ийн яриа сонирхолтой хариулт өгсөн байна. 1952 оны ес, аравдугаар сард Хятадын зохиолчид урлагчдын төлөөлөгчдийн бүлгэм болон Хятадын Дуу бүжгийн хүрээлэн тухайн үеийн БНМАУ-д нөхөрсөг айлчлалт хийж Улаанбаатар хотноо “Учиртай гурван толгой” жүжигтэй танилцсан байна. Zhang yun xi “Учиртай гурван толгой”-г үзэж дуусаад, буцаж харьсны дараа уг жүжгийг Бээжин ший болгон найруулаад, Хятадын жүжгийн театрт тавих бодол ургасан ажээ. Zhang yun xi: “- Би “Учиртай гурван толгой” жүжгийг учиргүй их тоосны нэг шалтгаан нь Монголчуудын тэрлэг болон Бээжин шийн жүжгийн хувцас нь хоорондоо төстэй, Бээжин шийн жүжигчид Монгол тэрлэг өмсөөд тоглоход Хятад үзэгчид ч хүлээн авч чадна гэж бодсон юм” гэж хожим нь дурсан ярьж байжээ.

Гэтэл хоёр гүрний адил бус соёлыг хооронд нь нэвтрүүлэхэд хувцас төсөөтэй талд л найдаад амжилтанд хүрцгээх биш. Аль ч “Учиртай гурван толгой”-г Бээжин ший болгон тоглож, театрт тавьсны дараа үзэгчдийн дунд адил бус санал гарч, зарим нь: “Бээжин шийг одоочлон өөрчилж Хятадын

уламжлалт жүжиг урлагийн өөрчлөлтийг шинэ амжилтад хүргэлээ” гэж магтан сайшааж байхад зарим нь: “Өөх ч биш, булчирхай ч биш юм болгосон” гэж ширүүн шүүмжилсэн байна. Хятадын алдарт урлагчин Wu zu guang: “Учиртай гурван толгой”-н Бээжин шийн хувилбарыг уламжлалт Бээжин шийгээс ялгаж үзэх хэрэгтэй, хамаг сайн нь шинэ жүжгийн төрөл зүйлд багтааж нэрлэвэл зохино” гэсэн санал дурдсан нь тухайн үеийн Хятадын ший жүжгийн урлагийн хүрээнд нэлээд газар авсан үзэлтэн болж байжээ. Тэгээд энэ маргаан нь эцэстээ Мао Зэдүн тэргүүлэгчийн ганц үгээр шийдвэрлэгдсэн юм.

Тухайн үед “Учиртай гурван толгой”-г Бээжин ший болгон өөрчлөн найруулсан нь Бээжин ший-г цаг үеийн шаардлагад нийцүүлэн одоочлон өөрчлөх үйлдлэг туршлага ба гадаадын жүжиг урлагийг Хятадын театрт тоглуулах соёлын солилцооны үйлдлэг туршлагатай холбогдсон том арга хэмжээ болж байсан тул Мао Зэдүн, Жоу Энх Лай зэрэг нам төрийн удирдлага нарын анхааралд орж байжээ. Ингээд Бээжин шийн хүрээнээс нь Мао Зэдүн тэргүүлэгчийн суудаг хоёр Жен Дан танхимд “Учиртай гурван толгой”-г аваачиж тоглуулах гэж төсөвлөсөн боловч “Учиртай гурван толгой”-н тайзны урлагийн гурван том хиймэл уул нь хэтэрхий том хоёр Жен Дангийн үүдээр оруулахад төвөгтэй тул, арга бус (буюу) Мао Зэдүн тэргүүлэгчийг Бээжингийн өмнө дээрхэд байдаг “Tian qiao ju chang” жүжгийн театрт залж авчраад, тэнд “Учиртай гурван толгой” жүжгийг тоглуулж тэргүүлэгчид сонирхуулсан байна. Мао Зэдүн тэргүүлэгч “Учиртай гурван толгой”-г урамтай үзэж дуусаад, урлагчид жүжигчдийг хүлээн авч уулзаад: “- Өөх ч биш булчирхай ч биш гэлээ, үнэндээ бас зүгээр жүжиг болсон байна” гэж зөв үнэлж магтсан бөгөөд Балганы дүрд тоглосон жүжигчний авьяас билгийг хамгаас илүү тоож сайшаасан гэнэ.

“Учиртай гурван толгой” жүжгийг Бээжин ший болгон найруулан тоглуулахад Монгол улсын оролцооноос халуун гараа сунгаж хүчтэй дэмжсэнийг тэмдэглэх ёстой байна. “Учиртай гурван толгой” жүжгийг Бээжин ший болгон найруулан тоглуулах ажлыг Хятад- Монголын соёлын харилцааны үйл ажиллагааны төсөвт багтааж, 1955 онд Хятадын Бээжин шийн алдарт удирдаач Ма уан хiang-аар Бээжин ший “Учиртай гурван толгой”-г удирдан тоглуулахаар тогтжээ. 1955 оны есдүгээр сард Ма уан хiang Улаанбаатарт айлчилж, Монгол Улсын Төв театрт “Учиртай гурван толгой” жүжгийг дахин нэг удаа үзэн сонирхож, Төв театрын дарга, удирдагч болон “Учиртай гурван толгой”-н дүрд тоглосон жүжигчидтэй уулзан ярилцаж санал зөвлөгөө авчээ. “Учиртай гурван толгой”-г Бээжин ший болгон найруулан тоглуулахаар бэлтгэж байгаа хугацаанд Монголын талаас хүчтэй дэмжиж, жүжгийн зохиол, хөгжмийн найруулга, тайзны засал, хувцас зэрэг олон талын материалаар хангалттай тусалсан байна. Хятадын Бээжин шийн хоёрдугаар хүрээлэн нь “Учиртай гурван толгой”-г өөрчлөн найруулахаар эрчтэй ажиллаж, бараг бүх Хятадын Бээжин шийн хамаг сайн зохиолч, жүжигчдийг урьж Бээжин ший “Учиртай гурван толгой”-г бүтээсэн байна. Үүнд: Удирдаач: Ма уан хiang, тухайн үед Хятадын Соёлын яамны Ший жүжиг өөрчлөн хөгжүүлэх товчоог даргалж байв. Жүжгийн зохиолыг өөрчлөн найруулагч: Фэн Жиюүн Лүн, алдарт жүжгийн Зохиолч Хөгжим- Лиү Яай Тянь, алдарт хөгжмийн зохиолч, Бээжин шийн хүрээлэнгийн хөгжмийн дугуйланг даргалж байв. Бүжиг найруулагч- Жиян Зүй Гуйан, Монгол бүжиг тоглоод нэрд гарсан алдарт

бүжигчин. Нансалмаагийн дүрд Юн Жин Мин “Улаан дэнгийн тэмдэглэл” гэдэг орчин үеийн Бээжин шийг тоглоод улс даяар алдаршсан Бээжин шийн алдарт тоглогч. Юндэнгийн дүрд – Жиян Юн Ши Балганы дүрд- Жиян Рүн Чин Бээжин ший “Учиртай гурван толгой”-д Монгол үндэсний амьдралын зан ааль ба соёлыг зөв харуулж оновчтой тоглохын төлөө Бээжин шийн хүрээлэн нь бас Өвөр Монголоос алдарт хуурч Паажий гуайг Бээжинд сарын хугацаатайгаар урин авчирч, зөвлөгчөөр ажиллуулсан байна.

Өөрчилж найруулсан Бээжин ший “Учиртай гурван толгой” нь уг жүжигтэйгээ нилээд зөрүүтэй болсон тул Ма уан хiang Соёлын яамаар дамжуулан, Монголын элчин сайдын яамтай холбоо барьж, Монголын төв театрын дарга агсан Н.Цэгмид болон Монголын дуулалт жүжгийн ерөнхий удирдаач (найруулагч) Гэндэн гуайг Монголоос урин авчирч, заан жолоодуулж санал зөвлөлгөө авсан байна. Монголын талаас өөрчлөн найруулсан “Учиртай гурван толгой”-н Бээжин шийн амжилтыг баяртай хүлээн авсан бөгөөд бас тодорхой засах санал өгчээ. Фэн Жиүн Лүн, Гэндэн нарын саналыг үндэслэж, шинэ найруулсан жүжиг дотроо зарим шинэ агуулгыг нэмж оруулсан бөгөөд ардын дуучин Буян, Балган ноёны захирагч Баянтай, Юндэнгийн эцэг зэрэг хэдэн дүрийг шинээр нэмж оруулсан байна. Хятадын Бээжин шийн өөрчлөлт одоочлолтын түүхэнд “ХӨШӨӨ” болсон орчин үеийн гурван зохиол байдаг.

Өнөөдөр хүртэл хүмүүс “БУУРАЛ ХҮҮХЭН”, “УЛААН ДЭНГИЙН ТЭМДЭГЛЭЛ” гэдэг хоёр жүжгийг цээжилсээр байгаа бөгөөд, олон хүмүүс түүний доторхи сонгодог бадгуудыг дуулж чаддаг. Харин нөгөө мартагдмаар болсон жүжиг нь харин “Учиртай гурван толгой” байсан билээ. Өнөөдөр бид Хятадын Бээжин ший болон бусад ший жүжгийн түүхэн материалд тулгуурлаж, жаран жилийн өмнө Бээжин ший болгон өөрчлөн найруулж, Хятадын театруудад хэдэн жил дараалан тавигдаж, Хятадын ший жүжгийн өөрчлөлт хөгжилтийг гүнзгий нөлөөлсөн “Учиртай гурван толгой”-г судлан сэргээж, хоёр гүрний хойч үеийнхэнд хэлж мэдүүлэх шаардлагатай байна.

### **ХОЁР. “Учиртай гурван толгой”-оос болсон Бээжин шийн өөрчлөлт хөгжилтийн маргалдаан**

“Учиртай гурван толгой”-г Бээжин ший болгон өөрчлөн найруулж театрт гаргасны дараа Хятадын ший жүжгийн хүрээнд нилээд маргаан үүссэн байна. Маргааны гол цэг нь: Монголын олон үзэгдэлт дуулалт жүжиг “Учиртай гурван толгой”-г Хятадын Бээжин шийн хөрсөн дээр яаж суулгах вэ? гэсэн асуудал болно. “Учиртай гурван толгой”-г Бээжин ший биш гэж үгүйсгэсэн Wu zu guang -ийн үзэхээр, гурван талаар Бээжин Ший урлагийн уламжлалаас зөрчсөн гэж зааж гаргажээ. Нэгд: Шинээр өөрчлөн найруулсан “Учиртай гурван толгой” нь Бээжин шийн жүжигчдийн хоорондох яриаг уламжлалын аргаар гаргаж дийлсэнгүй. Уламжлалт Бээжин ший доторхи жүжигчдийн хоорондох яриаг “Аялгуулан дуулах” болон “Бээжингийн хар яриагаар өгүүлэх” гэж хоёр хуваадаг бөгөөд ахмад настай дүр, хар хормойвчтон, баатар жанжин, залуу эрэгтэй, алаг царайт зэрэг дүрд тоглодог жүжигчид нь аялгуулан дуулж, зарим хундагачин ба эмэгтэй гол дүрд тоглодог жүжигчид нь Бээжин хар яриагаар өгүүлэн ярьдаг ажээ.

Мөн Бээжин шийн доторхи дүрүүд нь хувцас өмсгөлөөрөө тодорхой ялгардаг бөгөөд өмссөн хувцас ба өгүүлж дуулдаг үг яриа нь ч уламжлалаа дагаж ямар аялгуугаар яаж дуулж ярьдаг нь хүртэл олон зуун жилийн турш хэвшиж тогтсон бөгөөд үзэгчид жүжигт тоглодог дүрүүдийг харангуут аялгуулж дуулах буюу Бээжин яриагаар энгийн маягаар ярихыг нь хүртэл мэдэцгээдэг ажээ. Гэтэл өөрчлөн найруулсан “Учиртай гурван толгой”-н дүрүүд нь зөвхөн өмссөн хувцсаа эрэгтэй, эмэгтэй насны зөрөөгөөрөө ялгарахаас биш, дүрдээ тохирсон уламжлалт Бээжин шийн “Аялгуулан дуулах” “Бээжин яриагаар хэлэх” дүрмийг баримталсангүй тул, Бээжин ший үзэж дассан Хятад үзэгчдэд авч хэлбэл энэ уламжлалыг эвдэж, Бээжин шийн хэл ярианы системийг хутгалдуулсан учир болжээ.

Хоёрт: Уламжлалт Бээжин ший бол тайзны засал бараг хэрэглэгддэггүй бөгөөд цөм жүжигчдийн тоглох мэргэжилд түшиж, үлгэр үүсч хөгждөг орон зай, цаг хэмжээгээ төсөөлөн үзүүлдэг. Гэтэл өөрчлөн найруулсан “Учиртай гурван толгой” нь бодит байдлыг дүрсэлсэн тайзны засал (гурван уул, Балган ноёны ордон зэрэг) хэрэглэсэн тул Европын дуулалт жүжигтэй адил болж, уламжлалт Бээжин шийн урлагийн арга барилаар тоглон үзүүлэхэд нөлөөлжээ. Wu zu guang-ийн үзэхээр энэ нь тайзны урлагийн ахуйч үзэл (реалист)-ийн дүрслэх урлагийг Бээжин шийн бэлгэдэн үзүүлэх тоглох урлагтай органикаар нэгтгэн уялдуулж чадаагүйгээс болсон байна.

Гуравт: Өөрчлөн найруулсан “Учиртай гурван толгой”-н, жүжгийн зохиол нь Бээжин шийн жүжгийн зохиолын бүтэц зохиомжийг дагасан биш, уг Монгол зохиолыг баримтлан олон үзэгдэл хуваасан нь мөн чанар дээрээ дуулалт жүжиг л болох ёстой гэж Wu zu guang нар зааж гаргажээ. “Учиртай гурван толгой”-г шинэ Бээжин ший болгон өөрчлөн найруулсан үйл хэрэг нь үнэндээ гадаадын сонгодог ший жүжгийг “Хятад ший жүжгийн хөрсөн дээр суулгах” ба “Бээжин шийг шинэчлэн, одоочлох” хоёр талын утга агуулгатай юм.

Иймээс “Учиртай гурван толгой”-г үйлдэн бүтээсэн Хятадын зохиолчид жүжигчид өөрийн гэсэн тодорхой үзэлтэй байсан байна. “Д.Нацагдоржийн уг зохиол нь өрнөдийн зохиолын хэлбэрээр бичигдсэн боловч европын дуулалт жүжигт уягдан баригдсангүй, харин Монгол үндэстний онцлогоо хадгалж чадсан бөгөөд онцгойлон жүжгийн харилцаа дуу нь Монгол ардын дууны хөгжмийн шилдэг уламжлалыг хадгалж чадсан юм” гэж Хятадын зохиолч, урлагчид “Учиртай гурван толгой”-н уг зохиолын талаар тодорхой ойлголттой байсан юм. Үнэхээр ч Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой”-н уг эхэд олон хүмүүний хамтын дуу байхгүй бөгөөд, харилцаа дуу нь Монгол ардын дууны онцлогийг илүү хадгалсан байсан юм. Харин Ц.Дамдинсүрэнгийн зассан эхэд хүмүүсийн дүр нэмэгдэж, хамтын дуу нэмэгдэж өрнөдийн дуулалт жүжиг рүү нэн илүү хэлбийсэн байна. Онцгойлон Ц.Дамдинсүрэнгийн засалт эх дэх хэд, хэдэн хамтын дуулал нь Д.Нацагдоржийн уг эхэд байсангүй зүйл юм.

Яг эдгээр хамтын дууллыг Бээжин шийн уламжлалт аргаар яаж илтгэж харуулах талаар өөрчилж найруулсан “Учиртай гурван толгой” нь амжилтад хүрч чадсангүй ажээ. Яагаад гэвэл уламжлалт Бээжин шийд олон хүмүүс хамтаар дуулдаггүй юм. Энэчлэн Д.Нацагдоржийн өрнөдийн сонгодог дуулалт жүжгийн урлагаар Монгол амьдралыг харуулсан “Учиртай гурван толгой”

жүжгийг Хятадын урлагчид Бээжин шийн урлагийн хэлбэртэй дахин бүтээх гэсэн оролдлого нь ингэж тал талын олон бэрхшээлд учирсан боловч бүх Хятадын ший жүжгийн шинэчлэлт өөрчлөлтөд үнэтэй цэнтэй туршлага авчирч өгчээ.

### **ГУРАВ. Бээжин ший “Учиртай гурван толгой”-н түүхийн байр суурь**

БНХАУ байгуулагдсаны дараа Монголын орчин үеийн уран зохиолыг орчуулан танилцуулахдаа эн тэргүүнд ший жүжгээс эхэлж танилцуулсан нь сонирхолтой юм. Тэрчлэн хорьдугаар зууны тавиад онд болсон Хятадын ший жүжгийн өөрчлөлт шинэчлэлтийн явцад “Учиртай гурван толгой”-г үргэлж Бээжин ший-г амжилттай өөрчлөн найруулсан шилдэг зохиолд нэр дурдан шүүмжлэн ярилцаж байсан юм. Хятадын хамгийн том сонин болох “Ардын өдрийн сонин” нь ч Wu zu guang зэрэг нэрт хүмүүсийг урьж “Учиртай гурван толгой” жүжгийн талаар тусгай шүүмж бичүүлж байсан билээ. Хорьдугаар зууны тавь жараад онд шинэ Бээжин ший “Учиртай гурван толгой” нь Хятад - Монголын соёлын харилцааны үйл ажиллагааны дагуу бүтээгдсэн шилдэг зохиол бүтээлээрээ хоёр гүрний нөхөрсөг харилцааны үр жимс болж боловсорсны хажуугаар мөн Хятадын ший жүжгийн шинэчлэлт өөрчлөлтийн түүхэн дээр ч онцгой үүрэг гүйцэтгэсэн тул бусад жүжгийн зохиолууд тодоос ялгарч гарсан юм. Гэтэл, Хятадын театрт тавигдаж байсан өөрчлөн найруулсан Бээжин ший “Учиртай гурван толгой” нь Д.Нацагдоржийн бичсэн Юндэн, Нансалмаа хоёрын хайр дурлалын гунигт жүжиг биш, харин Ц.Дамдинсүрэнгийн засан найруулсан Юндэн, Нансалмаа нар Балган ноёныг тэмцэн ялсан баярт жүжиг юм. Энэхүү сэдэв нь тухайн үеийн Монгол, Хятадын хоёр гүрний ангийн тэмцлийн үзэл ухамсрын гол урсгалтай яг сайхан нийлэн зохицож байсан бөгөөд дэлхий нийтийн олон улсын харилцааны хоёр лагерийн тэмцлийн байдалтай ч зохицож байснаараа Монгол-Хятадын соёлын харилцааны хамтын ажиллагаанд сонгогдсон хамаг тохиромжтой бэлтгэл болсон нь тодорхой. Харин Д.Нацагдоржийн судалгааны хараасаас авч хэлбэл, зохиогчийн нэр тодорхой заасан “Учиртай гурван толгой” нь үнэндээ засагдсан эх байсан бөгөөд Д.Нацагдоржийн янаг дурлалын мөнхийн сэдвийг барьж бичсэн агуу гунигт жүжиг “Учиртай гурван толгой” нь Хятадын жүжгийн театрт хэзээ ч тавигдаагүй байсан нь түүхийн тавилан байсан болов уу?

Ц.ЖАМЦАРАНОГИЙН “АЯЛЛЫН ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ”  
[1903–1907]-ИЙН ОРОН ЗАЙ – ЦАГ ХУГАЦААНЫ  
АРХИТЕКТониК БҮТЭЦ

*Л.Ц.Халхарова*  
(ОХУ-ын Д.Банзаровын нэрэмжит  
Буриад Улсын их сургууль  
доктор, дэд профессор)

*Агуулгын товч: Ц. Жамцараногийн өдрийн тэмдэглэл нь зөвхөн аяллын тэмдэглэл бус, нийгэм-түүхэн бодит байдал, угсаатны зүйн баримт, хувь хүний байр суурь, байгаль-циклийн цаг хугацааны огтлолцолд бүрэлдсэн олон давхаргат хронотон бүхий баримтат-уран сайхны үнэт эх сурвалж юм. Ц. Жамцараногийн аян замын өдрийн тэмдэглэлүүдийн орон зайн онцлог нь материаллаг ертөнц, бодит түүхэн үнэн байдлын орон зайг хамарснаараа тодорхойлогдоно. Эдгээр асуудлыг өгүүлэлд нарийвлан тодруулан авч үзсэн байна.*

*Түлхүүр үг: Жамсрангийн Цэвээн, аяллын тэмдэглэл, баримтат уран сайханы зохиол*

XX зууны нэрт монгол судлаач эрдэмтдийн нэг бол буриад ард түмний авьяаслаг хүү **Цыбен Жамцаранович Жамцарано** юм. Тэрээр зөвхөн нэрт хэл шинжлэлийн эрдэмтэн төдийгүй түүхч-угсаатан судлаач, монгол угсаатны ард аман зохиол цуглуулагч байсан бөгөөд мөн гэгээрүүлэгч, нийгэм улс төрийн зүтгэлтэн байв. Түүний шинжлэх ухааны өв маш арвин бөгөөд хэл шинжлэл, аман зохиол, уран зохиол, түүх, монгол угсаатны угсаатан зүйн чиглэлээр олон бүтээл туурвисан юм.

Ц. Жамцараногийн шинжлэх ухааны өвд түүний өдрийн тэмдэглэлүүд онцгой байр суурь эзэлдэг. Эдгээр тэмдэглэл нь эрдэмтэн Ц.П. Ванчикова, И.В. Кульганек, В.Ц. Лыскокова нарын нягт нямбай хөдөлмөрийн үр дүнд 2001 онд анх удаа хэвлэлд бэлтгэгдэн, өргөн уншигчдын хүртээл болсон юм. 2011 онд нэмэлт, засвартай хоёр дахь хэвлэл нь дахин хэвлэгдэн гарсан байна. Тус номын оршилд дурдсанаар, “энэ нь 1903–1907 онд Эрхүү муж, Өвөр Байгал болон Монгол нутгаар хийсэн экспедицийн үеэр хөтөлсөн 9 дэвтэр тэмдэглэл бөгөөд түүний шинжлэх ухааны гавьяа, хувийн золиослол, өөрийн ажлын ач холбогдлыг гүнээ ухамсарлаж, ирээдүйн өмнө хүлээсэн хариуцлагыг нь гэрчлэх баримт мөн” [8, х.6] гэжээ.

1903–1907 оны аян замын өдрийн тэмдэглэлүүд нь янз бүрийн салбарын судлаачдын, тэр дундаа хэл бичгийн ухааны эрдэмтдийн анхаарлыг татдаг. Энэ нь шинжлэх ухааны тодорхойлолт, ажиглалт агуулсан баримт бичиг төдийгүй түүх, угсаатан судлал, аман зохиол судлалын чухал эх сурвалж юм. Гэвч тэдгээр нь зөвхөн шинжлэх ухааны үнэ цэнтэйгээр хязгаарлагдахгүй, харин зохиогчийн хувь хүний өнгө аяс тод шингэсэн байдгаараа онцлог. Түүнчлэн аян

замын өдрийн тэмдэглэлийн төрөл зүйл нь баримтат-уран сайхны зохиолын төрөл зүйлийн тогтолцоонд багтдаг юм.

Аян замын өдрийн тэмдэглэлийн жанрын хил хязгаар өнөөг хүртэл тодорхой бүрэн тогтоогдоогүй бөгөөд маргаан дагуулсаар байна. Энэхүү жанрын онцлог нь материал сонгон авах зарчим, өгүүлэмжийн хэлбэр, хронотопын (орон зай, цаг хугацааны зохион байгуулалт) шинж чанар, зохиогчийн дүр зэрэгт илэрдэг. Аян замын тэмдэглэл нь өөрийн дүрслэх зүйл, жанрын агуулга, хэлбэртэй байдаг. Судлаачдын тэмдэглэснээр, “аяны тэмдэглэлийн үндэс нь аялж буй баатрын орон зайд шилжин хөдөлж буйг дүрслэх, аяллын явцад болсон үйл явдлыг өгүүлэх, аялагчийн сэтгэгдэл, үзсэн харсантай холбоотой эргэцүүлэл болон өргөн мэдээлэл-танин мэдэхүйн төлөвлөгөө юм” [3, х.3] гэжээ. Судлаач В.М. Гуминский аян замын тэмдэглэл нь “тэмдэглэл, бичиглэл, өдрийн тэмдэглэл (журнал), найруулал, дурсамж” зэрэг олон хэлбэрээр илэрч болдгийг онцолж, өгүүлэмжийн бодитой, үнэн баримтад тулгуурласан шинжийг чухалчилсан байна. Мөн тэрээр танин мэдэхүйн зорилго нь гоо зүйн, улс төрийн, нийтлэлзүйн болон философийн шинжтэй нэгдмэл (синкрет) харилцан үйлчлэл дунд давамгайл байр суурь эзэлдгийг тэмдэглэсэн байдаг [2, х.839].

Аян замын зохиолуудын сэдвийн өргөн хүрээ нь уг жанр мөн чанартаа баримтат-уран сайхны шинжтэй болохыг баталдаг. Энэ нь жанрын синкрет (хосмол) шинжийг илтгэх бөгөөд аян замын өдрийн тэмдэглэлүүдэд ихэвчлэн хувь хүний, субъектив өнгө аяс нэлээд хүчтэй илэрдэгтэй холбоотой юм. Аян замын тэмдэглэл буюу өдрийн тэмдэглэлийн жанрт дүрслэх объект нь динамик шинжтэй, өөрөөр хэлбэл “зохиогчийн орон зай, цаг хугацаанд шилжин хөдөлж буй үйл явцыг газарзүйн байршлыг тогтмол тэмдэглэн, тодорхой топографийн эсвэл он цагийн эхлэл цэгтэй харьцуулан хугацааг тэмдэглэх замаар илэрхийлэх” явдал юм [7, х.3].

Орон зай, цаг хугацааг “хронотоп” хэмээх нэгэн цогц ойлголтоор нэрлэсэн М.М. Бахтины үзэж байгаагаар, “уран зохиолын хронотопт орон зайн ба цаг хугацааны шинжүүд утга төгөлдөр, тодорхой бүхэлд нэгдэн нийлэгждэг. Энд цаг хугацаа нягтарч, өтгөрч, уран сайхны хувьд харагдахуйц болдог; харин орон зай нь эрчимжиж, цаг хугацаа, үйл явдал, түүхийн хөдөлгөөнд татагдан ордог” [1, х.235] гэжээ. Иймээс орон зай-цаг хугацааны архитектуроник (хронотоп) нь Ц. Жамцараногийн аян замын өдрийн тэмдэглэлүүдийн зохион байгуулалтын бүтцийн үндсэн зарчим болж, нарийн төвөгтэй тогтолцоог бүрдүүлдэг. Энэхүү бүтцэд юуны өмнө нийгэм-түүхэн цаг хугацаа болон байгаль-циклийн (давтамжит) цаг хугацааг ялган үзэж болох бөгөөд эдгээр хронотопын түвшин бүр өөр өөрийн тодорхой үүргийг гүйцэтгэдэг юм.

Ц. Жамцараногийн 1903–1907 оны аян замын өдрийн тэмдэглэлүүд нь бүтцийн хувьд 5 хэсэгт хуваагдана. Үүнд:

1. **1903 оны 6 дугаар сарын 30 – 7 дугаар сарын 31-ний өдрийн тэмдэглэл**
2. **Дэвтэр №3-ын материал. 1903 оны 7 дугаар сарын 31 – 9 дүгээр сарын 9** (Эрхүү мужид хийсэн экспедици)
3. **1904 оны зуны өдрийн тэмдэглэл** (Өвөр Байгал болон Монголд хийсэн экспедици)

4. **1905 оны зуны өдрийн тэмдэглэл. 4–8 дугаар сар** (Буриадад хийсэн экспедици)
5. **1906–1907 оны өдрийн тэмдэглэл. 1906 оны 5 дугаар сарын 16 – 1907 оны 1 дүгээр сарын 2** (Эрхүү мужид хийсэн шинжлэх ухааны аялал)

Ц. Жамцараногийн өдрийн тэмдэглэлүүдийн агуулга нь бодит байдлыг маш өргөн хүрээтэй хамарсан байдаг. Үүнд ХХ зууны эхэн үеийн Оросын алслагдсан нутгууд болон Монголын тал нутгийн амьдрал, тухайн үеийн хувьсгалт үзэл санаа, буриад ард түмний нөхцөл байдлын талаарх зохиогчийн үнэлгээ, эрх баригчдын дур зорго зэрэг олон асуудал тусгагджээ.

Нийгэм-түүхэн цаг хугацаа нь түүний өдрийн тэмдэглэлүүдэд давамгайлах цаг хугацааны үндсэн төрөл юм. Өгүүлэмжийн цаг хугацаа нь ХХ зууны эхэн үе бөгөөд зохиогчтой хамт бид Өвөр Байгал, Эрхүү муж, Монгол нутгаар сэтгэлдээ аялж буй мэт болдог. Зам зуурын уулзалт учрал, тохиолдлууд, хүмүүс, тухайн цаг үеийн ахуй амьдралын дүр зураг нүдний өмнө тодрон гарч ирнэ. Түүний тэмдэглэлүүд нь шинжлэх ухааны ажиглалтын өвөрмөц нэгэн он цагийн бичиг (хроник) бөгөөд буриад, монгол овог аймгуудын амьдралын онцлогийг харах боломжийг олгодог юм.

Ц.Жамцараногийн аян замын өдрийн тэмдэглэл 1903 оны зунаас эхэлдэг. Тухайн үед тэрээр **Санкт-Петербургийн их сургууль**-ийн оюутан байсан бөгөөд багш нарынхаа эрдэм шинжилгээний даалгавраар Өвөр Байгал болон Эрхүү мужид экспедицид явж, аман зохиол болон түүх-угсаатны зүйн материал цуглуулах зорилготой байв.

“6 дугаар сарын 30. Могойтуйн өртөөнөөс галт тэргэнд сууж, Читад ирэв. 7 дугаар сарын 1. Цэргийн амбан захирагч Надаровт бараалхан, морь дайчлах нээлттэй бичиг авч, зарим зүйл (би – револьвер) худалдан авч, Верхнеудинск хүртэл билет аваад явлаа. Читагаас Верхнеудинск хүртэл саадгүй явсан. Замд хятадын хар ажилчидтай жижигхэн шуугиан болов. Тэд буудлаа унтаж өнгөрөөгөөд сэрмэгцээ уут саваа цонх, хаалгаар шидэж, өөрсдөө явж буй галт тэргнээс үсэрч, өнхрөн унацгаав. Кондукторууд орилж, хятадууд бүр ч их сандарч байлаа” [8, х.9] хэмээн түүний тэмдэглэл эхэлдэг. Өдрийн тэмдэглэлийн бичлэг бүр он сар өдөр, бичигдсэн газрыг нарийвчлан тэмдэглэсэн байдаг. Жишээ нь: “7 дугаар сарын 21. Эрхүүгээс Кударуу Якутын замаар шуудангийн тэргээр гарлаа. Миний танил Михайлов хүртэл 2 өртөө: Хомутовка, Жердовка. Жердовкоос Усть-Орда хүртэл шуудангийн хос морь авч явсан ч хагас замаас улус руу эргэв” [8, х.26]; “7 дугаар сарын 31. Алагуя (Турункинский улус) – Паргасын өвөлжөө хүртэл 35 верст. Орой, нар жаргахаас өмнө, яриа хөөрөөтэй бурят Петроман (Алагуевын родаас)-тай хамт гарлаа” [8, х.38].

Зохиогчийн өгүүлэмжид нутгийн иргэдтэй хийсэн яриа, аман зохиол, угсаатны зүйн баримтууд хааяа хааяа шингэн орж ирдэг. Буриадуудын ахуй амьдрал, шашны зан үйлийн онцлогийг дүрсэлсэн нь угсаатны зүйн түүхийн үнэт эх сурвалж болдог. Тухайлбал:

“7 дугаар сарын 17. Эндхийн бурятууд, Ерхүү мужийн бүх бурятуудын адил, 8 ханатай модон гэрт 20–30 гэрээрээ бөөнөөр амьдарна. Гэрүүдийн ойролцоо тахилгын амьтдын арьс, толгой, хөлтэй нь хус

модонд өлгөсөн байх ба толгой нь тахил өргөсөн бурхны зүг харсан байдаг” [8, х.23]

гэжээ. Буриад улсуудын амьдралын шинж тэмдгээр тухайн цаг үеийн нийгмийн байдал бодитоор сэргэн харагдана.

“7 дугаар сарын 15. Аларскийн дацанд. Дацангийн ширээтгэй, хуучны андтайгаа ярилцав. Тэрээр тайшаатай Думын үед бурятууд эдийн засаг, ёс суртахууны хувьд хавьгүй дээр байсан гэв. ... Овгийн ахлагчид бүхнийг хянан, муу үйлээс сэргийлж чаддаг байжээ. ... Дум, тайшаг устгаснаар архины газар гарч ирсэн. Овгийн байгууллыг устгаснаар ёс суртахууны тулгуур алдагдаж, байдал дордсоор байна гэж бурятууд гомдоллодог” [8, х.19].

Ц. Жамцарано Эрхүү муж, Өвөр Байгалын янз бүрийн улусын буриадуудын аж байдлыг дүрслэхдээ нийтдээ ард түмний амьжиргааны түвшин доогуур байгааг тэмдэглэсэн байдаг. Тэрээр овгийн удирдлагыг Дум, тайшагийн хэлбэрээр халсан засгийн бодлогыг шүүмжилж, “Хэрэв засгийн газар бурятуудын сайн сайхныг зорьсон бол эсрэг үр дүнд хүрчээ. Харин ‘инородец’-уудыг сулруулах, устгах зорилготой байсан бол зорилгодоо хүрч байна” хэмээн асуусан өнгө аястай бичсэн байна [8, х.19]. Өдрийн тэмдэглэлд байгаль-циклийн цаг хугацаа ч мөн тодорхой үүрэг гүйцэтгэнэ, хэдийгээр харьцангуй цөөн дүрслэгдсэн ч утга агуулга гүнтэй.

“7 дугаар сарын 12. Эрхүүгээс төмөр замаар ирж, Кутуликэд үүрээр хүрэв. Нар хараахан мандаагүй байлаа. Нар мандахыг хүлээв. Удалгүй дорно зүг улайж, нар аажуухан мандлаа. Би түүнийг мэндчилэв” [8, х.14]; “7 дугаар сарын 3. Аймшигтай халуун өдөр. Сөрөг салхитай явна, халуунд амьсгаа давчдав” [8, х.101]; “8 дугаар сарын 22. Цас үргэлжлэн орсоор. Уул нуруудад морьдын гэдэс хүрэх хэмжээний цас орсон гэж гэрчүүд ярив” [8, х.123].

Харин түүний тэмдэглэлд судлаачийн ажлын өдөр тутмын үйл ажиллагаа дэлгэрэнгүй тусгагдсан байдаг. Жишээ нь: “8 дугаар сарын 7. Алагуя Хонгоровынд хоноод, өглөө Ольхонд уулзаж байсан Хулхан Далбанов ирэв. Маш эелдэг, яриа хөөрөөтэй хүн. Тэрээр заяаны дууллыг болон бусад мэдээллийг дуртайяа өгч, би хуудсууд, дэвтэртээ тэмдэглэн авлаа” [8, х.69]; “8 дугаар сарын 8. Бараг орой хүртэл заяаны бичлэг хийв. Өвгөн Буту Булдаев, Борсой нар ярив. Бүгд илэн далангүй, тусч байж, мэддэг бүхнээ хэлж өгөхийг хичээв” [8, х.71].

Ийнхүү Ц. Жамцараногийн өдрийн тэмдэглэл нь зөвхөн аяллын тэмдэглэл бус, нийгэм-түүхэн бодит байдал, угсаатны зүйн баримт, хувь хүний байр суурь, байгаль-циклийн цаг хугацааны огтлолцолд бүрэлдсэн олон давхаргат хронотоп бүхий баримтат-уран сайхны үнэт эх сурвалж юм. Ц. Жамцараногийн аян замын өдрийн тэмдэглэлүүдийн орон зайн онцлог нь материаллаг ертөнц, бодит түүхэн үнэн байдлын орон зайг хамарснаараа тодорхойлогдоно. Судлаач Юрий Лотман уран зохиол дахь уран сайхны орон зайг “дүрүүд байрлаж, үйл явдал өрнөх континуум” хэмээн тодорхойлоод, түүнийг “ид шидийн ба ахуйн, гадаад ба дотоод” зэрэг дэд хэв шинжүүдэд ангилсан байдаг. Түүнчлэн “дүрүүдийн зан үйл нь тэдний оршин буй орон

зайтай ихээхэн холбоотой бөгөөд нэг орон зайгаас нөгөөд шилжихэд хүн тухайн орон зайн хуулиар өөрчлөгдөнө” [6, х.264] гэжээ.

Ц. Жамцараногийн өдрийн тэмдэглэлд бодит, гадаад орон зайнаас гадна “дотоод” орон зай ч тод ялгарна. Энэ нь буриад ард түмний хувь заяа, тэдний гэгээрэл, ирээдүйн талаархи өдөр тутмын бодол, санаа зовнил, ардын соёл, зан заншил, уламжлал, туульчид болон тэдний хувь тавиланд хандах зохиогчийн хүндэтгэл, эмзэг хандлагаар илэрхийлэгддэг. Түүний тэмдэглэлүүд динамик шинжтэй, өөрөөр хэлбэл зохиогчийн хөдөлгөөн идэвхтэй, зорилготой байна. Орон зай нь статик бус, байнга өөрчлөгдөж байдаг. Аян замын зохиолд “зам”-ын хронотоп жанрын бүтцийг зохион байгуулах чухал үүрэгтэй. Зам нь орон зайд оршдог ч аль нэг орон зайд хамаарагдахгүй, түүгээр нэвт гардаг. Энэ талаар Юрий Лотман “Зам нь бүх төрлийн орон зайг багтаах боловч аль нэгэнд нь харьяалагдахгүй, тэдгээрийг нэвтлэн өнгөрдөг” [5, х.47] хэмээн оновчтой тодорхойлсон байдаг.

Аян замын тэмдэглэлд орон зай нээлттэй ба хаалттай гэсэн эсрэгцэлтэйгээр илэрч, хөдөлгөөн ба хөдөлгөөнгүй байдал гэсэн тогтвортой оппозиц үүсгэнэ. Зам, аян замын хронотопыг идэвхжүүлэх нь өгүүлэгчийг “нээлттэй орон зайн баатар” болохыг харуулна. Жишээлбэл: “8 дугаар сарын 5. Эцэст нь явж чадна. Морьд бэлэн” [8, х.66] хэмээн тэмдэглэсэн нь хөдөлгөөнд тэмүүлэх эрмэлзлийг илтгэнэ. Харин хаалттай орон зайд тэрээр өөрийгөө хязгаарлагдсан, эрх чөлөөгүй мэт мэдэрдэг: “7 дугаар сарын 16. Надад зориулж өгсөн модон гэрт өдөржин суулаа. Хийх ажилгүй, аймшигтай уйтгар” [8, х.24]; “8 дугаар сарын 3. Өдрийг яаж өнгөрөөхөө ч мэдэхгүй. Эзэн алга, мордох боломжгүй” [8, х.36].

Хаалттай орон зай нь хөдөлгөөний зогсонги байдал, дотоод түгшүүрийг төрүүлдэг. Түүний өгүүлэмжид дотоод хурцадмал байдал, товч, хэмнэлттэй бичлэг анзаарагдана. Тэр өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг дэлгэрүүлэн бичихээс зайлсхийдэг. Ах нь нас барсныг мэдээд ч мэдрэмжээ барьж бичсэн байдаг: “... эхийн хацар даган нулимс урсаж байлаа. Эцэг ч сэрж, уйлав... Энэ цохилт надад хэтэрхий хүнд” [8, х.129]. Дараа нь ахынхаа тухай дурсан, буддын номлолын даруу төлөвөөр үдэж: “Баяртай, хайрт ах минь! Чиний гунигт дэлхийд өнгөрүүлсэн богинохон амьдралын чинь дурсамж үлдэг” хэмээн бичжээ [8, х.129].

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр түүний бичлэгийн өнгө аяс өөрчлөгдөнө. 1903–1904 оны эхний тэмдэглэлүүдэд аман зохиол, угсаатны зүйн материал, захидлын ноорог, зүүд, дурсамж зонхилж байхад, 1905–1907 оны хожуу бичлэгүүдэд нийгэм-ёс суртахууны шинжтэй эргэцүүлэл, нэгтгэл дүгнэлт давамгайлна. Экспедицийн үр дүнгээс гарсан эрдэм шинжилгээний бүтээлүүдээ тэрээр 1905 оноос хэвлүүлж эхэлсэн.

Түүний “Монгол ардын уран зохиолын жишээ” бүтээлийг үнэлсэн академич Борис Владимирцов “Ц. Ж. Жамцараногийн чин үнэнч хөдөлмөрийн ачаар халх, буриад болон бусад монгол овог аймгуудын баатарлаг туульсын нэлээд их өв бидний мэдэлд ирлээ. Цаашид энэ сан улам баяжина гэдэгт найдна” [4, х.127] хэмээн онцлон тэмдэглэжээ. Иймээс Ц. Жамцараногийн аян замын өдрийн тэмдэглэлүүд нь аян замын уран зохиолд түгээмэл тохиолдох орон зай-цаг хугацааны нарийн төвөгтэй архитектурониктой байхаас гадна

эрдэмтний иргэний зориг, ёс суртахууны үүргээ ухамсарлан биелүүлсэн үйл хэрэг, буриад ард түмний түүх, аман зохиол, соёлыг хойч үедээ хадгалан үлдээх гэсэн чин эрмэлзлийн бодит илэрхийлэл болсон юм.

### Ном зүй

1. Бахтин М. М. Формы времени и хронотопа в романе // Вопросы литературы и эстетики. Исследования разных лет. – М.: Худож. лит., 1975. – 504 с.
2. Гуминский В. М. Путешествие // Литературная энциклопедия терминов и понятий / под ред. А. Н. Николюкина. – М., 2001.
3. Иванова Н.В. Жанр путевых записок в русской литературе первой трети XIX века (тематика, поэтика): автореф. дис. ... канд. филол. наук. Улан-Удэ, 2010. – 24 с.
4. История отечественного востоковедения до середины XIX века. – М.: Наука, 1990. – 436 с.
5. Лотман Ю.М. Проблема художественного пространства в прозе Гоголя // Уч. зап. Тартуского ун-та. – Вып.209. – Тарту, 1968.
6. Лотман Ю.М. Текст в тексте // Лотман Ю.М. Статьи по семиотике культуры и искусства. – СПб.: Академический проект, 2002. – 504 с.
7. Травников С.Н. Поэтика художественного пространства в путевой литературе конца XVII – начала XVIII века // Поэтика жанров русской и советской литературы. Межвузовский сборник научных трудов. – Вологда, 1988. – 135с.
8. Цыбен Жамцарано. Путевые дневники. 1903-1907 гг. Сост.: Ц.П. Ванчикова, В.Ц. Кульганек. – Улан-Удэ: Изд-во ОАО «Республиканская типография», 2011. – 264 с.

**XX-XXI ЗУУНЫ ҮРГЭЛЖИЛСЭН ҮГИЙН ЗОХИОЛД МОНГОЛ  
ЭМЭГТЭЙ ДҮРИЙН ХУВЬСЛЫГ ХАРУУЛСАН НЬ:  
(Д. НАЦАГДОРЖ, С.ЭРДЭНЭ, Ч.ЛЮДОЙДАМБА БОЛОН ОРЧИН  
ҮЕИЙН ЗОХИОЛЧДЫН БҮТЭЭЛЭЭС ЖИШЭЭЛЭН)**

*Н.Галиймаа*

*(Соёл Эрдэм дээд сургууль  
Доктор, профессор)*

**Abstract.** *This article explores the transformation of female representation in Mongolian prose from the XX to the XXI century, focusing on works by D.Natsagdorj, Ch. Lodoidamba, S. Erdene, L. Ulziitugs, and B. Shuudertsetseg. The study aims to identify how female characters have shifted in narrative function and symbolic meaning in response to social and cultural changes. Using comparative and textual analysis, the research highlights the evolution of women's roles from collective, socially bound figures to autonomous individuals. In the XX century, realism dominated literary practice, portraying women as patriotic, hardworking, and central to family life, exemplified by Dulmaa in "Tungalag Tamir" and the lyrical female figures in Erdene's "Khoid nasandaa uulziya". By contrast, XXI century prose reflects postmodern tendencies and feminist criticism, emphasizing personal freedom, choice, and emotional sensitivity. Ulziitugs's "Aquarium" depicts women through symbolic introspection, while Shuudertsetseg's "Khulang's Home" presents women as career-oriented and self-determined. The findings suggest that Mongolian literature mirrors broader societal transformations: from collectivist ideals to individual agency and diversity. This shift underscores how literary representation of women not only reflects but also participates in redefining cultural values and gender roles in modern Mongolia.*

**Түлхүүр үг:** *Монголын уран зохиол, эмэгтэй дүрийн төлөөлөл, Реализм, Постмодерн, Феминист шүүмжлэл, соёлын өөрчлөлт, харьцуулсан шинжилгээ*

## ОРШИЛ

XX-XXI зууны Монголын уран зохиолын эмэгтэй дүрийн өөрчлөлтийн талаар өгүүлэхийн өмнө зохиолын дүр гэсэн тодорхойлолтыг авч үзье. “Зохиолын дүр нь ерөнхий нийтлэг утга, чанар ба түүнийг агуулсан хувь чанар гойд хэлбэрийн нэгдэл мөн.” (Ш.Гаадамба, 1980) гэж Ш. Гаадамба тодорхойлжээ. Дэлхийн аливаа уран зохиолын адилаар Монголын уран зохиолд эмэгтэй хүний дүрийг тухайн цаг үеийн нийгмийн үнэлэмж, үзэл суртлын чиг хандлагаар харуулж байлаа. Монгол эмэгтэйн дүрслэл XX зуунаас XXI зуунд шилжихдээ нийгмийн үнэлэмжийн өөрчлөлттэй уялдаж, хувьсан өөрчлөгджээ. Тухайлбал XX зууны Монголын уран зохиолд эмэгтэй хүнийг эх оронч, хөдөлмөрч, гэр бүлийн түшиг тулгуураар, XXI зуунд хувь хүний эрх чөлөө, сонголт, даяаршлын нөлөө хүчтэй нэвтэрч буй хэв маяг бүхийгээр дүрслэх нь давамгайлж байна. XX зууны жишээгээр Монголын нэрт зохиолч Д.

Нацагдорж, Ч. Лодойдамба, С. Эрдэнэ, XXI зууны жишээгээр Л. Өлзийтөгс, Б. Шүүдэрцэцэг нарын бүтээлээс иш татан харьцуулалт хийж, монгол эмэгтэйн дүрийн өөрчлөлтийг харуулахыг хичээлээ. Зохиогч энэхүү өгүүллээрээ уран зохиол дах монгол эмэгтэйн дүрийг цаг хугацааны өөрчлөлттэй уялдуулан шинжлэх зорилго тавилаа. Тус зорилгод хүрэхийн тулд монгол эмэгтэйн дүрийн өөрчлөлтийг харьцуулсан шинжилгээ, контент анализийн аргаар судлаад соёл-нийгмийн үнэлэмжтэй холбон тайлбарлахыг хичээлээ.

## XX–XXI ЗУУНЫ МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН ОНОЛЫН ХАНДЛАГУУД

XX–XXI зууны Монголын уран зохиолд эмэгтэйн дүр нь тухайн цаг үед ноёрхож байсан онолын хандлагатай уялдан өөрчлөгдөж ирсэн. Судалгааны онолын үндэслэлийг дараах гурван чиглэлээр товч тайлбарлалаа. Нийгмийн бодит байдлыг үнэн зөвөөр тусгахыг үндсэн зорилгоо болгосон реализм XX зууны эхэн болон дунд үед **Монголын уран зохиолд ноёрхож байв**. Тэр үеийн зохиолчид эмэгтэй дүрийг эх оронч, шударга, нийгмийн шинэчлэлд идэвхтэй оролцогч байдлаар дүрсэлсэн нь реализмын арга барилын илэрхийлэл юм. Реализм нь “нийгмийн бодит нөхцөл, анги давхаргын харилцааг уран зохиолд тусгах” зорилготой гэсэн Т. Эгилтоны (Eagleton, 2003, хууд. 2) хандлага Монголын уран зохиолд ч илэрч байлаа. 1960–1980-аад онуудад **социалист реализм ноёрхож, эмэгтэй дүрийн гаднах төрхийг онцлох уламжлалт хэв шинжээс дотоод ертөнц, оюун санаа, нийгмийн үнэт зүйлтэй холбон дүрслэхэд анхаарах болов. Өөрөөр хэлбэл эмэгтэй хүнийг зөвхөн “үзэмжийн объект” бус, хөдөлмөрч, оюунлаг, нийгмийн идэвхтэй дүрээр харуулж байлаа**. Энэ нь зөвхөн уран зохиолын арга барил бус, тухайн үеийн үзэл суртлын бодлоготой уялдсан онолын чиглэл байв.

XXI зууны монголын уран зохиолд постмодерн арга барил хүчтэй нэвтэрсэн. Олон өнцөгт үзэл, уламжлалт үнэлэмжийг задлан шинжлэх, дотоод ертөнцийн философийн эргэцүүллийг постмодерн хандлага илэрхийлдэг. Тиймээс постмодерн уран зохиол символик дүрслэл, сэтгэлийн гүн дэх философийн эргэцүүллийг ихээхэн ашигладаг. “Их түүхийн үнэлэмжийг задлан шинжлэх, олон жижиг түүх, олон өнцөгт үзлийг илэрхийлэх” (Lyotard, 1984) хэмээн постмодернизмыг Лотард тодорхойлсон нь Монголын уран зохиолд эмэгтэй дүрийн олон талт байдлыг харуулахад нийцдэг юм.

XXI зууны зохиолд эмэгтэй дүрийг **феминист шүүмжлэлийн (Feminist literary criticism)** өнцгөөс тайлбарлах нь түгээмэл болсон. Амьдралын замаа сонгож, карьер, хайр дурлалын асуудлыг өөрөө шийдвэрлэж буйгаар эмэгтэй хүнийг харуулах нь феминист шүүмжлэлийн хандлагын онцлог билээ. “Эмэгтэй хүний дуу хоолойг уран зохиолд гаргаж ирэх, тэгш эрхийн төлөө тэмцэх нь феминист шүүмжлэлийн зорилго” гэсэн Мойгийн (Moi, 1985) тодорхойлол өнөөгийн Монголын уран зохиолд тодоор илрэх боллоо.

## XX ЗУУНЫ УРАН ЗОХИОЛЫН ЭМЭГТЭЙ ДҮРҮҮД

Д. Нацагдорж “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгээ 1931 онд бичжээ. Энэ нь Монголын шинэ үеийн уран зохиолд байгаль, хөдөө нутгийн уянгын дүрслэлийг тод томруун гаргасан, Д.Нацагдоржийн оргил бүтээлүүдийн нэгэн юм. Тус өгүүллэгт хөдөө нутгийн байгаль, тал нутгийн уянгын өнгө аясыг философи эргэцүүлэлтэй хослуулан дүрсэлсэн нь монгол уран зохиолд шинэчлэл авчирсан гэж судлаачид үздэг. Уг өгүүллэгт эмэгтэй дүрийг тэр үеийн уран зохиолын уламжлалт хандлагаар буюу гадаад үзэмжийг дэлгэрэнгүй дүрсэлдэг. “...*Үзвэл насан арван найм, ёс, шинэ сарны адил хурц тунгалаг гэрэлтэнэ. Урт хар гэзгийг гурваар даран унжуулж, улбар шар дурдан алчуураар толгойгоо ороон, өрөөсөн нүдний дээд тал дээр хэлтгий зангилан үзүүрийг унжуулсан нь залуу бүсгүйн дэгжин байдлыг үзүүлжээ. Цайвар өнгөтэй зөөлөн царай нь зуны наран дор борлоод хоёр хацарт нь эрүүлийн улаан туяа тусчээ. Харах нүдний хар цагаан нь хослоод, хотын залуу хүний дээр эелдгээр хөдлөх тутам дор миний нүдэн эрхгүй дагалдан давхина. Энгэр, нударгыг нь хар торгоор эмжиж, нарийнхан хошмог тавьсан хүрэн ягаан чисчүү дээлийг өмсөн, зүүн ханцуй барин атгаад, баруун ханцуйгаа цухуйлган, зөөлөн цулбуурыг хугас нуун, ташаагаа тулж буулгасан ном нударгыг далбайлган бүрхүүлсэн нь шинэ цагийн хээнцэр байдлыг гайхуулжээ. Хоолойн товчийг задгай тавьсны дотуур бас хар торгоор бөөрөнхийлөн эмжсэн цайвар шар дурдан цамцны зах цухуйж буй түүний дотор нимгэн цагаан хөрстэй гоо хүзүү үзэгдэхүй нь хазаад авмаар. Шар бажгар дурдан бүсийг шавхийтэл ороогоод, угалзтай шөнтгөр гутлыг дөрөөний дунд тасхийтэл жийсэн нь талын идэр махбодыг бахархуулжээ. Харь газрын залуу хүн би түүний замыг хөндөлсөн саатуулж, хэдэн үг асуун хэлэлцэхүй дор тал газрын бага охин тэр жолоог татаж, дуртайгаар түдгэлзэн хариулан очиж, басхүү энэ тэрийг лавлан сонирхоно. Ташаа нь тэвхийж, хавирганы ясан нь зурайсан ялгуун саарал морин нь тогтоож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдах боловч, дээр нь унасан үзэсгэлэнт охин ажиг үгүй сууж өгүүлэлдэх бөгөөд үг хэлэлцэн хичээнгүйлэн аашлахуй нь бага хүүхдийн мэт хөнгөмсөг зөвэрхүү, хасын өнгөтэй дөрвөлжин цагаан шүдээ яралзуулан үе үе инээмсэглэн мишээхүй нь хаврын улирал ирж буй адил бахтай. Эелдэг түүнийг үнсэн шимбээс ханаш үгүй биз ээ”* (Д.Нацагдорж, 2016, хууд. 323) Эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг гаднах төрхөөр (цагаан царай, урт хар үс, гоолиг бие) романтик дүрслэлээр илэрхийлэх нь 1930-аад оны Монголын уран зохиолд түгээмэл байжээ.

**1950-аад оны Монголын үргэлжилсэн үгийн зохиолд эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг дүрслэх арга уламжлалт “нүүрний цагаан, үсний урт” гэх хэмжүүрээс бага зэрэг өөрчлөгдөж, шинэ нийгмийн үнэт зүйлээс шалтгаалан “хөдөлмөрч, эрч хүчтэй, эх оронч” шинж чанараар баяжсан. Энэ нь 1930–1940-өөд оны романтик дүрслэлээс илүүтэйгээр социалист реализмын чиг хандлагад нийцсэн өөрчлөлт юм. Социалист реализмын нөлөөгөөр эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг зөвхөн гаднах төрхөөр бус, ажил хөдөлмөр, нийгмийн үнэт зүйлтэй холбон дүрслэх боллоо.**

Ч. Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд “Дулмаа бол Тамирын хөвөөнд төрж өссөн, цагаахан сэтгэлтэй, нутаг усандаа нэртэй хөөрхөн бүсгүй.” гэж түүний гоо үзэсгэлэн, энгийн боловч үнэнч сэтгэлийг зохиогч өгүүлжээ. “Тэр хайрласан хүнийхээ төлөө зовлонг ч тэвчинэ, жаргалыг ч хуваалцана гэж итгэдэг.” (Ч.Лодойдамба, 1971) гэсэн нь Дулмаагийн хайр дурлалд үнэнч, хайрынхаа төлөө өөрийгөө золиослох чадвартай эмэгтэй хүний дүрийг илэрхийлдэг. “Дулмаа бол хувь тавилангийн салхи шуурганд туугдсан ч сэтгэлдээ ариун хайр, итгэлээ хадгалж үлдсэн нэгэн.” (Ч.Лодойдамба, 1971) гэх өгүүлбэрт түүний дүрийн эмзэг, гэхдээ сэтгэлийн тэнхээтэйг тодотгож байна. “Дулмаагийн гоо үзэсгэлэн нь зөвхөн царай зүсээр бус, шударга зан, эх оронч сэтгэлээр улам тодорч байлаа.” (Ч.Лодойдамба, 1971) Энэ өгүүлбэр Дулмаагийн гоо үзэсгэлэнг царай зүсээр төдийгүй шударга зан, эх оронч сэтгэлээр тодруулсан социалист реализмын арга барилын сонгодог жишээ юм. Дулмаа хувьсгалын үйл хэрэгт идэвхтэй оролцож, эмэгтэй хүний нийгэмд эзлэх байр суурийг бодитойгоор харуулдаг. Тэрээр романтик дүрээс давж, нийгмийн өөрчлөлтөд хувь нэмэр оруулж буй эмэгтэй хүний шинэ төрхийг илэрхийлдэг.

С.Эрдэнийн “Хойд насандаа учирна” романд “Түүний нүдний гүнээс амьдралын итгэл, хүсэл гэрэлтэж, цагаан царай нь салхинд борлон туяарчээ.” (Эрдэнэ, 1989) хэмээн бичсэн нь эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг зөвхөн гаднах үзэмжээр бус, дотоод ертөнц, амьдралын итгэлтэй холбон дүрсэлжээ. “Цэвэлмаа Яндагт сэтгэлээ өгсөн ч түүний эхнэртэй, амьдралтай гэдгийг мэдэхийн зовлонг дотроо тээж явна.” гэдгээр түүний хайр дурлалын эмзэг, нууцлаг шинжийг харуулж, эмэгтэй хүний сэтгэлийн дотоод тэмцлийг илэрхийлдэг. “Тэр хайрласан хүнийхээ төлөө өөрийн хувь тавиланг золиослохдоо ч бэлэн мэт санагдана.” (Эрдэнэ, 1989) гэдэг нь Цэвэлмааг хайр дурлалд бүхнээ зориулдаг, өөрийгөө золиослох чадвартай эмэгтэй болохыг илтгэнэ. Дээрх хоёр ишлэлээс харахад Цэвэлмаа хайр дурлалдаа үнэнч, өөрийгөө золиослох чадвартай, эмзэг хувь тавилан бүхий эмэгтэй хүний ертөнцийг тодотгож өгдөг. Зохиогч Цэвэлмаагийн дүрээр хувь хүний дотоод ертөнц, хайр дурлал, хувь тавилангийн эргэцүүллийг гүнзгий гаргахдаа эмэгтэй хүнийг нийгмийн баатар бус, харин өөрийн сонголт, сэтгэл хөдлөл, хувь тавилангийн эзэн болгон харуулсан. Цаг төр зөөлөрч байсан үед бичигдсэн тус романд 1980-аад оны уянгын өнгө аяс илэрнэ. Өөрөөр хэлбэл уянгын философи, постмодерн өнгө аяс, феминист шүүмжлэлийн эхлэл тавигдаж байжээ хэмээн хэлж болмоор.

## XXI ЗУУНЫ УРАНЗОХИОЛЫН ЭМЭГТЭЙ ДҮР

2000-аад оны дараагаар Монголын уран зохиолд постмодерн өгүүллэгүүд олноор гарч эхэлсэн. Эдгээр өгүүллэгт эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг уламжлалт хэмжүүрээс илүүтэйгээр “учир битүүлэг ертөнц”, “өөрийн дотоод хүч”-тэй холбон дүрсэлдэг. Эмэгтэй хүнийг “домгийн хатадтай адил” эсвэл “учир битүүлэг ертөнц” мэтээр дүрсэлж, гоо үзэсгэлэнг зөвхөн харагдах байдлаар бус соёл, түүх, дотоод ертөнцийн илэрхийлэл болгон харуулж эхэлсэн. Тухайлбал, Л. Өлзийтөгсийн “Аквариум” өгүүллэгт эмэгтэй

дүрийг орчин үеийн хотын амьдрал, дотоод ертөнцийн эмзэг мэдрэмжээр харуулдаг. Нэг хэсэгт: “Тэр аквариумын загас шиг өөрийн орон зайд ганцаардана” гэж дүрсэлсэн нь XXI зууны эмэгтэй хүний дотоодын ганцаардал, нийгмийн өөрчлөлтөд дасан зохицох үйл явцыг философийн өнгө аясаар илэрхийлжээ. “Хүүхэн болгон атаархаж, хүн болгоны магтдаг байсан зөөлөн, булбарай арьс минь одоо хэдийнээ улаан ягаан толботой, хатуу хайрсан бүрхүүл болон хувирчээ.” гэх өгүүлбэрт эмэгтэй хүний гоо үзэсгэлэн цаг хугацааны эрхэнд хэрхэн өөрчлөгдөж, нийгмийн үнэлэмжийн объект болдгийг харуулдаг. (Л.Өлзийтөгс, 2005) “Энэ аквариумыг худалдан авч байхдаа би өөрийнхөө авсыг бэлдэж байна гэдгээ мэдээгүй юм.” гэдгээр эмэгтэй хүний амьдралын орон зайг аквариумтай зүйрлэн, эрх чөлөөний хомсдол, дотоод хоригийг илэрхийлжээ. (Л.Өлзийтөгс, 2005) “Энэ жижигхэн аквариум байтугай дөрвөн өрөө сууц маань, хүн болгон саруулхан, томыг нь бахдан хэлэлцдэг албан тасалгаа маань, цаашилаад дуу шүлэг бүхэнд хязгааргүй хэмээн магтагддаг Монголын өргөн тал... надад багадаад байгаа юм шиг санагдан үргэлж, үргэлж давчдаж явдаг байлаа.” гэдгээр эмэгтэй хүний дотоод ертөнцийн өргөн хүсэл мөрөөдөл нь бодит амьдралын хязгаарлалтад багтаж чадаагүйг харуулна. (Л.Өлзийтөгс, 2005). Л. Өлзийтөгс энэ жижигхэн өгүүллэгтээ постсоциалист нийгмийн эмэгтэй хувийн ба олон нийтийн орон зайд хэрхэн оршин тогтнож буйг, мөн түүний дотоод зөрчлийг гүн гүнзгий харуулсан юм.

Б. Шүүдэрцэцэгийн “Хулангийн гэр” роман нь хамгийн их уншигчдын хүртээл болсон романуудын нэг бөгөөд эмэгтэй хүний хайр дурлал, гэр бүлийн харилцаа, хувь тавилангийн тухай гүн сэтгэгдэл төрүүлсэн зохиол гэж үнэлэгддэг. Түүний энэ зохиолын эмэгтэй дүр нь карьер, хайр дурлал, хотын амьдралын асуудалтай, эрх чөлөөт амьдралын хэв маягтайгаар гардаг. Жишээ нь: “Хулан өөрийн амьдралын замыг сонгохдоо эргэлзээгүй, өөрийн хүсэл мөрөөдлөө дагасан” (Б.Шүүдэрцэцэг, 2007) гэх өгүүлбэр нь XXI зууны эмэгтэйг өөрийгөө илэрхийлэгч, сонголттой, нээлттэй хүнээр харуулж байна.

“Хайр гэдэг хүнийг жаргаахын зэрэгцээ зовлонгийн гүнд ч аваачдаг юм байна.” (Б.Шүүдэрцэцэг, 2007) гэдгээр зохиогч Хулангийн дотоод ертөнцийн хайр дурлалын хоёр талт шинжийг харуулна. *Эмэгтэй хүн гэр бүлээ авч явахын тулд өөрийнхөө мөрөөдлийг золиослох нь олонтаа.*” (Б.Шүүдэрцэцэг, 2007) гэх нь Хулангийн дүрээр дамжуулан эмэгтэй хүний амьдралын золиос, нийгмийн хүлээлтийг илэрхийлжээ. “Аавынхаа архинд живсэн нүдийг харах бүртээ би өөрийн ирээдүйг айдастайгаар төсөөлдөг байлаа.” гэдгээр гэр бүлийн харилцаа, эцэг эхийн нөлөө охины сэтгэлд ямаршуухан гүнзгий ул мөр үлдээснийг тод томруун харуулна. “Хүн болгон намайг гоо үзэсгэлэнгээр хэмжиж, харин би өөрийнхөө дотоод ертөнцийг ойлгуулах гэж тэмцсээр.” (Б.Шүүдэрцэцэг, 2007) гэсэн өгүүлбэрт эмэгтэй хүнийг гадна төрхөөр нь үнэлдэг нийгмийн хандлагыг шүүмжилсэн зохиогчийн санаа шууд харагджээ. Дээрх ишлэлүүд нь “Хулангийн гэр” романы үндсэн шугам буюу эмэгтэй хүний хайр дурлалын зовлон шаналал, гэр бүлийн харилцааны хүндлэл, нийгмийн үнэлэмжийн дарамтыг тодотгож байна.

Л.Өлзийтөгсийн бүтээл философийн бөгөөд бэлгэдлийн шинжтэй бол Б.Шүүдэрцэцэгийн роман бодит амьдралын асуудлыг тод томруун, драматик

байдлаар харуулсан онцлогтой. Дээр дурдсан зохиолчдын зохиолуудаас харахад ХХ зууны эмэгтэй дүр нь нийгмийн үйл явц, эх оронч үзэлд төвлөрсөн бол ХХI зуунд хувь хүний дотоод ертөнц, эрх чөлөө, сонголтод төвлөрч байна. Дүрслэлийн арга барилын хувьд ХХ зуунд реализм, уянгын өнгө аястай байсан бол ХХI зуунд постмодерн, философийн эргэцүүлэл давамгайлж байна. Гэвч Монголын ХХ ба ХХI зууны уран зохиолд доорх зүйлс уламжлагдан үлджээ. Үүнд:

- Эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг онцлон дүрсэлдэг уламжлал
- Хайр дурлал, хувь тавилан, гэр бүлийн харилцаа нь эмэгтэй дүрийн гол сэдэв хэвээр үлдсэн
- Эмэгтэй хүний дотоод ертөнцийн эмзэг байдал, золиос, үнэнч хайр зэрэг билээ.

## ДҮГНЭЛТ

Монголын үргэлжилсэн үгийн зохиолд монгол эмэгтэйн дүрслэл ХХ зуунаас ХХI зуунд шилжихдээ нийгмийн үнэлэмжийн өөрчлөлттэй уялдан өөрчлөгджээ. ХХ зуунд эмэгтэй дүрийг эх оронч, хөдөлмөрч, гэр бүлийн түшиг тулгуур болгон харуулсан бол ХХI зуунд хувь хүний эрх чөлөө, сонголт, олон талт амьдралын хэв маягтайгаар дүрслэх нь давамгайлж байна. Энэ нь монгол эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмжийн өөрчлөлтийг уран зохиолоор дамжуулан харуулж буй хэрэг юм.

ХХ зууны уран зохиолд эмэгтэй дүрийг нийгмийн үнэт зүйл, романтик гоо үзэсгэлэнгээр тодорхойлж байсан бол ХХI зуунд хувь хүний дотоод ертөнц, сонголт, эрх чөлөөний асуудалтай холбон илэрхийлэх болсон. Энэ нь Монголын уран зохиолын эмэгтэй хүний дүрийн хөгжлийн шинэ шат, феминист өнгө аясыг илэрхийлж байна.

### Ном зүй:

- Eagleton, T. (2003). *Literary Theory: An Introduction*. Oxford: Blackwell.
- Lyotard, J.-F. (1984). *The Postmodern Condition: A Report on Knowledge*. Minneapolis: University of Minnesota Press. Minneapolis: Minneapolis: University of Minnesota Press.
- Moi, T. (1985). *Sexual/Textual Politics: Feminist Literary Theory*. London: Routledge. London: London: Routledge.
- Б.Шүүдэрцэцэг. (2007). *Хулангийн гэр*. Улаанбаатар: Хөх Монгол.
- Д.Нацагдорж. (2016). *Хөдөө талын үзэсгэлэн; Бүрэн зохиол, Тэргүүн боть*. Улаанбаатар: ШУА, ХЗХ.
- Л.Өлзийтөгс. (2005 оны 10 22). *Аквариум*. biirben.mn: <https://biirbeh.mn/index-ээс> Гаргасан
- Ч.Лодойдамба. (1971). *Тунгалаг Тамир*. Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр.
- Ш.Гаадамба. (1980). *Уран зохиолын онолын үндэс*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.
- Эрдэнэ, С. (1989). *Хойд насандаа учирна*. Улаанбаатар: Хэвлэх үйлдвэр.

**САЙНЦОГТЫГ ЭРГЭН ДУРСАХЫН АЧ ХОЛБОГДОЛ БА  
СОЁЛЫН УТГА ЧАНАР**

*Намиа  
(БНХАУ, ӨМНШУА-ийн Утга зохиол судлах газар,  
доктор, профессор)*

*Агуулгын товч: Олны мэдээжээр том хэмжээний дурсгах ажиллагаа бол ямар нэгэн бүлэг цогц буюу нийгмийн гишүүийн хамтын ажиллагаа болох юм. Ямар нэг хүн буюу хэрэг учрыг нийгмийн гишүүд хамтдаа дурсгаж байгаа нь дан гагц дурсагдагчийг санагалзахын төлөө ажиллагаа төдий биш, харин энэхүү дурсгах ажиллагаагаар дамжуулан нэн олон зүйлийн нийгмийн үүрэгчлэлийг гүйцэтгэхийн тулд юм. Дурсгах ажиллагаа бол нийгмийн гишүүдээс хамтын адилашлыг цогцлоох бүтэмжтэй арга барил болох бөгөөд ирж байгаа цаг үед өртгийн баримжаа олгох, жолоодлого үзүүлэх чадамжийг ч гүйцэтгэж байдаг. Иймээс дурсгах ажиллагаа нь түүхэн ач холбогдолтой бөгөөд нэн бас гүн гүнзгий бодит ач холбогдол ба соёлын өртөгтэй байдаг. Өгүүлэлд эдгээр асуудлыг БНХАУ-ын алдарт зохиолч На.Сайнцогтын жишээн дээр задлан тайлбарлажээ.*

*Түлхүүр үг: На.Сайнцогт, зохиолч, соёлын утга чанар, гүн ухаан*

**НЭГ. На.Сайнцогтыг дурсгах ажиллагааны  
бодит ач холбогдол**

Дурсагдагчийн нийгмийн байр суурь жич дурсаж байгаа цаг үеийн бололцоо нөхцөл, үзэл санааны шаардлагаас болж дурсгалын ажиллагааны хандлага чиглэл, тайлбарлах цаг нь ч харилцан адилгүй байдаг. Өнөөдрийн түүхэн нөхцөл, цаг үеийн орчинд бид На.Сайнцогтыг дурсаж байгаа нь наад зах нь доорх мэт хэдэн зүйлийн ач холбогдолтой гэж хэлж болно. Юуны өмнө бидэнд сонгодог зохиолыг дахин цогцлохын чухал чанарыг мэдүүлж байна. Энэ асуудлыг бид нийгэм журамт улс орнуудын утга зохиолоор жишээлэн яривал амархан ойлгож болно. БНХАУ-ын байдлаар авч үзэхэд, дээр зууны дөчөөд оноос далаад он болтолх цаг үе бол үндсэндээ хувьсгалт сонгодог бүтээлийг бүтээн байгуулахын тэмцсэн цаг үе болно. Гэтэл 20-р зууны наяд оноос нааш, уншигчид ба судлаачид хувьсгалт үнэр амт бүхий сонгодог бүтээлийн үнэ цэнийг сэжиглэж, өрнө дахины модерн үзлийн өнгө будаг бүхий өөр нэгэн зүйлийн сонгодог бүтээлийг цогцлохоор мэрийж өнгөрөв. Гэвч нүдний өмнө хүмүүс дээрх хоёр зүйлийн сонгодог бүтээл нь бүр манай оршин бүхий цаг үеийн туршлага ба сэтгэлгээг бүрмөсөн илтгэхэд хүчирдэнэ гэж таньж эхлэв. Даруй өнгөрсөнд хөөцөлдөж байсан сонгодог бүтээлийн одоохоч буюу реалист үнэ цэнийг сэжиглэх шатанд ороод буй. Тийм ч учраас зарим эрдэмтэд манай оршин бүхий энэ цаг үе бол сонгодог бүтээлгүй цаг үе буюу “сонгодог бүтээлийн зовуурь шаналлын цаг үе” гэж үзэж байдаг. Яг иймэрхүү сонгодог бүтээлийн тухай зовнилоос болж хүмүүс ондоо нэг зүйлийн ярианы сэдвийг бий болгожээ. Даруй сонгодог бүтээлийг дахин бүтээх гэдэг сэдвийн тухай ярилцах болсон бөгөөд бас манай энэ үеийн сонгодог бүтээлийн гол тусалтын

цэг нь “үндэстэн ба соёл гэдэг дээр бий” гэж чухалчлан дурдаж байна. Үндэстний соёлын онцлогтой сонгодог бүтээлийг дахин бүтээх нь нэг зүйлийн хандлага болсон гэж үзэж болно. Энэхүү хандлага ба нөхцөл доор бид На.Сайнцогтын бүтээлийг судлан шинжилж, дурсган тэмдэглэж байгаа нь ямар нэгэн утга агуулгаас авч хэлбэл “үндэстний сонгодог бүтээлийг дахин бүтээх ажиллагаанд оролцож байна” гэж үзэж болно. Дараа нь На.Сайнцогтыг дурсгах ажиллагаа нь манай өнөөдрийн шинэ соёлыг бүтээн байгуулахад ач тустай гэж хэлж болно. Манай өнөөдрийн бүтээн байгуулж бүхий соёл бол өнгөрснөөс ялгагдах өөрийн гэсэн цаг үеийн онцлогтой байдаг. БНХАУ-ын ойрын жилд санаачилж бүхий тал нутгийн соёл буюу умардын соёл бол нэг төлөөлөгч чанартай жишээ болох юм. Гэхдээ иймэрхүү шинээр санаачилж бүхий соёл нь эд өлгийн соёлыг багтаахын хамт нэн бас оюуны соёлын агуулгатай байх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл оюун санааны дотоод чанар ба зориг санааны уламжлалтай байх байх хэрэгтэй билээ. Ингэмээжин сая манай цогцолж бүхий соёл нь жинхэнэ оюун сүнстэй болж чадна.

На.Сайнцогт бол ХХ зуунд цогцлогдсон монголчуудын оюун санааны соёлын нэг төлөөлөл болно. Иймээс тэр бас заавал өнөөдрийн цогцолж бүхий тал нутгийн соёл буюу умардын соёлын нэг бүрэлдэхүүн буюу эс байх ёстой юм. На.Сайнцогт бол амьдарч агсан тухайн эринийхээ шинэ соёлыг цогцлон байгуулахаар мэрийсэн төлөөлөгч чанартай зохиолч, үзэл санаатан болох бөгөөд түүний хийж бүтээсэн үйлс ба үлдээж өгсөн оюун санааны өв нь өнөөдрийн шинэ соёлыг бүтээн байгуулахад тойрч гарч боломгүй лавлалтын ач тустай байдаг. На.Сайнцогт гуай бидэнд уламжлалыг хүндэтгэхийн хамт шинэ зүйлийг шингээж авах тухай олон арвин үзэлт танилт ба бодит үйлдлэгийн жишээг үлдээснийг түүний зохиолыг уншсан хүмүүс бүр тодорхой мэднэ. Тэрээр дээр зууны эхэнд дэлхийн урагшилсан соёл мэдлэгтэй золгохын улмаас “тавигдан нээгдэхүй нь эрхэм” гэдэг үзлийг дурдаж хувь хүн, айл гэр, улс орон цөм тавигдан нээгдмэээжин сая нийгмийн жинхэнэ урагшилалт давшилт байж чадах тухай маш бүтээлчээр дурдаж, бас бусдын соёлыг оруулах үес “урсган оруулах” ба “халхлан бөглөх”-г уялдуулах тухай хувьсангуйгаар таньж олоод “Тэгээвч” шүлгээрээ дамжуулан илтгэж байсан билээ. Энэ бүхнийг өнөөдөр авч үзэхэд, урьдахи хүмүүсийн ул мөр нь хойнох хүмүүстээ яахын аргагүй толь болдогийг илүү ухаарч чадах ажээ. Дээр ярьсан мэтээр На.Сайнцогт бол нэгэн соёлын солилцоо бас шинжилгээ алсалсан цаг үеийг дохиолсон соёлын хошууч болох юм. Тэр өрнө дорнын соёлын солилцооны ажиллагаанд биечлэн оролцсон бөгөөд бас сурган хүмүүжил, утга зохиол, улс төр зэрэг олон хүрээнд идэвхтэй ажиллаж, нийгмийн бүх талыг харгалзаж, бүрэн бүтэн хүн болохын дүрмийг үзүүлсэн юм. Түүний зохиолд өөрийн ба харийн соёл харилцан уусаж, олон хүрээ царааг хамарсан болохоор адил бус судалгаанд хамаатуулан авч үзэх олон боломжтой байдгийг хүмүүс явах тутам мэдэрч байна. Тэрээр хүнийг босгох тухай олон талаар санаачилж, хүн төрөлхтний соёлжлын чухал чанарыг чангатгасан боловч, байгаль гэдэг хүн төрөлхтөнтэй нөхцөлдөн оршиж бүхий нэг зүйлийн амьд систем байхыг ерөөс мартаагүй. Тэр байгалийг баархаж, байгалиас сэдэв аван, байгалийн тухай шүлэг зохиол олон бичиж, байгальтай харилцан янаг найртай байхын жишээг биечлэн үзүүлсэн байдаг. Эдгээр нь өнөөдрийн хувьд юутай эрхэм нандин өв хөрөнгө болох ажээ.

## **ХОЁР. На.Сайнцогтыг дурсгах ажиллагааны соёлын утга чанар**

Эрдэмтдийн судалгааг үндэслэвэл соёлын өртөг гэдэг энэхүү ухагдахуун нь *“Соёлын шинж чанар бүхий үнэ өртөг ... онцгойлон оюун санааны өртгийг заана”*, *“Нэг үндэстний соёлд агуулагдсан өртгийн систем, эсхүл нэг үндэстний соёлд агуулагдаж байгаа өртөг буюу соёлын системийн илрүүлсэн өртгийн хандлага”*, *“Нэг зүйлийн соёлын системийн илрүүлсэн өртгийн хандлага нь ямар нэгэн текстийн задлалтаар дамжиж илэрсэн”*... гэх зэрэг олон зүйлийн тайлбартай байдаг. Дээрх олон зүйлийн тайлбараас алийг нь сонгосон ч хамаагүй, бүр манай ярилцан бүхий На.Сайнцогтын одоохоч ач холбогдлын тухай бодолхийлолд тусламж болох ач тустай. Өмнө үед хүмүүс На.Сайнцогтын тухай дурдатгалын зохиолыг олон бичжээ. Тэдгээр зохиолоос На.Сайнцогтын тухай дурдатгалын зохиолын нэг онцлогийг амархан олж болно. Энэ бол хүмүүсийн сэтгэлд На.Сайнцогтын хүн чанарын тухай нотлол нь түүний зохиол бүтээлээс илүү чухал байранд орсон байдаг. Буй бүхий хүмүүсийн цээжинд На.Сайнцогт гуай туйлын цагаан, туйлын эелдэг, туйлын багтаамжтай, туйлын ухаан билигтэй бичгийн хүний дүрээр илэрчээ. Онцгойлон хүн чанарын хувьд маш сайхан, бүрэн хүний дүрээр илэрсэн байна. На.Сайнцогтын дүр дээр монгол хүний хамгийн сайн сайхан шилдэг чанар хуримтан нэгдсэн нь монгол хүний өртгийн хандлага, нэг үндэстний хамтлагийн таамаглал хийгээд хөөцөлдлийг илрүүлсэн юм. Хүмүүсийн сэтгэл дахь На.Сайнцогтын дүрээс бид эелдэг, багтаамжтай байх бол нэг зүйлийн оюун санааны охь чанар гэдгийг мэдэж болно. На.Сайнцогтын зориг санаа бол монгол соёл тэрчлэн тал нутгийн соёл буюу нүүдэл соёлын чөмөг болно гэдгийг мэдэж болно. На.Сайнцогт, үндэстний явцуу үзлийг барьдаггүй, эрх зэргийг шүтдэггүй, эрэгтэй эмэгтэй, хөгшин залуу, өөрийн үндэстэн ба бусад улс орнуудын хүнд адилхан адил тэгш ханддаг. Бас хүн төрөлхтний буй бүхий шилдэг соёлыг бахархан, багтааж, бас шингээж авдаг. Тиймээс На.Сайнцогтын дүр бол монгол хүний дүр болох бөгөөд бас ч хүн төрөлхтөн бологсдын хөөцөлдөж бүтээгүүштэй соёллог дүр болох юм. На.Сайнцогтыг дурсгахын хамгийн чухал соёлын утга чанар нь ч үүнд оршино.

**ӨРНӨ БА ДОРНЫН СОЁЛЫГ ХОЛБОН, ӨНГӨРСӨН ҮЕЭС ОРЧИН  
ҮЕИЙГ ЗААГЛАЖ, ШИНЭ ХЭЛ, ШИНЭ СЭТГЭЛГЭЭНИЙ ХЭВ  
МАЯГИЙГ БИЙ БОЛГОСОН Д.НАЦАГДОРЖ**

*(Их зохиолч Д.Нацагдоржийн мэндэлсний 120 жилийн ойд зориулав.)*

**Б.Мөнхбаяр**

*(Хэл бичгийн ухааны доктор)*

*“... Уран зохиол нь цэцэн мэргэн оюунаас гарч, ертөнц дахиныг хайлган чадагч яруу найруулгыг хүндэтгэн, залуу авьяастныг дуудан сэргээж, ... зохиолч нарыг хөгжүүлэн, хурц сэргэлэн ухааны амттай сайхан зохиолоор шинэ дэлхийг дэвтээхэд санаа тавих билээ.”*

*1930 он. Д.Нацагдорж*

Өвөр Монголын нэрт эрдэмтэн доктор, профессор Дорнотэнгэр, монгол уран зохиолын тухай нэгэн ярилцлагдаа “Монгол Улсын алдарт яруу найрагч, Монголын орчин үеийн уран зохиолын суурилагч Д.Нацагдорж бол ховорхон олддог уран зохиолын авьяас билигтэн мөн. Хурмаст тэнгэр түүнд зөвхөн гучин нэгхэн жилийн богино цагийг соёрхсон байхад, тэр харин хурмаст тэнгэрт уран зохиолын өнөдийн вант гүрнийг буцаан өгчээ. Түүний сүрлүүн, борогжуун, чөлөөт шүлэг, зохиолын суртал нь үй олон уран зохиолын залуусыг дайлан дагуулжээ. Миний сэтгэлд Д.Нацагдорж бол мянган уулын шовх оргил нь мөн. Яг л Оросын А.С.Пушкин, Энэтхэгийн Р.Таагүр, Английн У.Шекспир, Томас Эллиот, Чилийн Пабло Неруда, Мексикийн Октавио Пас, Ирландын Уильям Батлер Йейтс, Америкийн У.Уйтмен нарын адил агуу их зохиолч мөн.”<sup>2</sup> хэмээн үнэлсэн байдаг. Чухам яагаад Д.Нацагдорж гуайг “Монголын Их зохиолч”, “Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч” хэмээн хүлээн зөвшөөрөн, үнэлдгийн мөн чанар, утга учир нь эл өгүүллийн нэр хийгээд эрдэмтний өгүүлсэн ярианд оршино. Энэ бол Их зохиолч Д.Нацагдорж шүлэг, найраглал, өгүүллэг, туурь, тууж, жүжиг, орчуулга, эсээ, нийтлэл, найрууллуудаараа өмнөх үеийнхээ танин мэдэхүй, уран сайхны сэтгэлгээг үгүйсгэх бус, харин цааш хөгжихөд саад болж буй ойлголт, уран сайхны сэтгэлгээнд тогтсон байсан хэвшмэл хандлагыг хэрхэн шинэчлэн, яаж даван туулахыг үзүүлж харуулсан гэсэн үг болно. Өөрөөр хэлбэл, 1920-иод оны тэр цаг үеэс Монголын нийгмийн амьдрал өөрчлөгдөн, түүнийг хуучин хэмжүүрээр ойлгох боломжгүй болж, шинэ сэтгэлгээ, шинэ үзэл санаа зайлшгүй шаардлагатай болоход, Д.Нацагдорж уран бүтээлээрээ тэрхүү шинэ сэтгэлгээ ба түүнд тохирсон хэл,

---

<sup>2</sup> “Лэй гүн шан (雷公山, Lei gong shan) шүлэг сэтгүүл”-ийн эрхлэн найруулагч, Миёо (苗族 Miyao) үндэстний яруу найрагч Нан Ван Е (南王爷 Nan Wang Ye) – д Хөх хотноо өгсөн ярилцлага 2015 оны 4-р сарын 17-19.

сэтгэхүйг бий болгоход онцгой үүрэг гүйцэтгэсэн ажээ. Энэ үйл хэрэгт түүний “Миний хэнз хурга”, “Энэтхэгийн бүсгүй”, “Гайхалтай”, “Ааль үгүйгээс хамар үгүй” (“Халдаг балдаг”) “Миний нутаг”, “Сар аа!”, “Нар аа!”, “Миний ээж”, “Дөрвөн цаг”, “Бид хоёр” ... зэрэг шүлэг болон бас шоронд хоригдож байхдаа бичсэн шүлгүүд, “Харанхуй хад”, “Ламбугайн нулимс”, “Хуучин хүү”, “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”, “Уул усны охин”, “Хөдөө талын үзэсгэлэн” (“Амазони”), “Шувуун саарал” ...тэргүүт олон өгүүллэг, “Учиртай гурван толгой”, “Нуугдсан эрдэнэ”, “Их авгай” зэрэг жүжиг, “Бичиг үсэг хэрхэн дэлгэрсний товч түүх”, “Монголын түүхийн товч” зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны зохиол, А.С.Пушкиний болон Э.А.Погийн уран бүтээлийн орчуулгыг нь онцлон тэмдэглэх ёстой. Эдгээр бүтээлүүд нь нийтлэг агуулгаараа тухайн цаг үеийнхээ Монголын нийгмийн бас монгол хүний урагшлан дэвших нөхцөлийг бий болгож, *“Ингээж л зохиож, бичиж ирсэн”* гэдэг сэтгэлгээг эвдсэн юм. Д.Нацагдоржийн хийсэн энэ шинэчлэл нь Монголын ард түмэнд соён гэгээрлийн галт бамбар болохын сацуу *чөлөөт сэтгэлгээ бүхий бичгийн зохиол* хэмээх зүйлийг мэдрүүлсэн жинхэнэ бодит алхам болсон юм. Ялангуяа дээр онцлон дурдсан зохиолууд нь зөвхөн тэр цаг үеийнхээ уншигчдын төдийгүй XXI зууны өнөө цаг үеийнхэнд ч гэсэн эргэлзэх, магадлах, асуух, шүүмжлэх, тунгаах, санагалзах, ухаарах, холбон бодох боломж, чадварыг бий болгодог, нийгмийн танин мэдэхүйн сэтгэлгээнд ямагт ахиц дэвшил, гүнзгийрэл, сонирхлыг бий болгодог байна.

Жишээ нь, “Ламбугайн нулимс”-ын төгсгөлийн өгүүлэмжид *“Нэг өдөр гэвш Лодон гэртээ ирээд, байшингийн хаалгаа татвал дотроос түгэжжээ.”* гэсэн явдал гардаг. Өгүүлэмжийн энэ агшинд, бүх зүйл Лодонгийн өмч гэдэг нь илэрхий. Тэр ондоо хүний, өөр айлын **гэрт нь** ирээгүй, ерөөсөө л өөрийнхөө **гэртээ** ирсэн. Таних танихгүй хэн нэгний **хаалгыг нь** татаагүй, зөвхөн өөрийн гэрийнхээ **хаалгаа** л татсан. Гэвч хаалга түгжээтэйгээр барахгүй, удалгүй Лодонгийн гэрт нь байгсад түүнийг хөөлөө. Ийнхүү хөөгдсөн Лодон юу ч үгүй хоцорсныг “байшингийн **босгыг нь** тэвэрч” гэж дүрслэн илэрхийлжээ. Монгол хэлний хамаатуулах нөхцөл “аа<sup>4</sup>” ба “минь, чинь, тань, нь” зэрэг нь утга санааны ийм нарийн ньюансыг илтгэдэг ажээ. “Хөдөө талын үзэсгэлэн” буюу “Амазони”-доо, тэр мундаг Амазони хүүхнүүдийн дайчин, бурханлаг, гоо үзэсгэлэнтэй, хийморьлог, цог золбоотойгоос гадна тэдний үндсэн имиж, дүр төрх нь болсон эр хүнийг хүлээн зөвшөөрдөггүйг ердөө хоёрхон үгээр *“Харь газрын залуу хүн түүний замыг хөндөлдөн саатуулж, хэдэн үг асуун хэлэлцэхэд тал газрын бага охин тэр жолоог татаж, дуртайгаар түдгэлзэн ...”* гээд л үзүүлсэн байдаг. “Хуучин хүү” хэмээх нэгэн нөхөр *“Гэртээ уулыг өнгөрвөл, айлгүй хэмээн бодож, тэнгэрийн хаяанаас цааш газаргүй гэж сэтгэсээр, түмэн хэргээс хоцорч дэлхий боловсролоос гээгдэнэ.”* гэсэн, энэ танин мэдэхүйн шүүмжлэлт сэтгэлгээнээс асар том ухаарлын орон зай бий болсон байна. Тэгэхээр ингэж урьд өмнө гарч байгаагүй, тухайн цаг үеийнхний мэддэг, ойлгодог, ярьж хөөрдөг байсан ерөөл, магтаал, үлгэр тууж, домог түүхээс нь огт өөр зүйл гарч ирэн, тэдний сонирхол, тэмүүллийг нь татаж, улмаар энэ байдал нь түгээмэлжин дэлгэрч, соёлын шинэ хэл, шинэ үнэт зүйлийг бий болгосон ажээ. Хамгийн чухал дэвшил нь *тэр цагийн монголчууд бэлэн харцунд үл баригдах сэтгэлгээтэй болж байсан нь:*

- үзэл санааны эрх чөлөөг
- урлаг, утга зохиолд шинэ урсгал бий болсныг
- уламжлалт туурвил зүйн сэтгэлгээнээс модерн, постмодерн урсгал руу шилжиж байсныг


нь хүлээн авч байсан явдал нотлон харуулдаг. Өөрөөр хэлбэл хуучин сэтгэлгээгээ халж, шинэ амьдрал, орчин үетэйгээ нийцэхийн төлөө ухамсраа шинэчилэхэд Д.Нацагдоржийн уран бүтээл гойд нөлөөлж байв. Тийм ч учраас доктор, профессор Ч.Билигсайхан Монголын орчин үеийн уран зохиолын түүхэн үечлэлийн тухай өгүүлэлдээ Д.Нацагдорж нараас хойших үеийг “1930-аад оны сүүл үеэс уран зохиолын хэвийн хөгжил алдарч, энэ байдал 1960-аад оны эх хүртэл үргэлжилсэн юм.”<sup>3</sup> хэмээн тэмдэглэсэн байдаг. Ямартаа ч, үүлэн чөлөөний наран мэт тэр хэсэгхэн хугацаа буюу хүн ард нь сэтгэлгээний хувьд эрх чөлөөтэй, утга соёлын хэвийн хөгжил нь алдраагүй, улс төр, үзэл суртлын мөрдөлт, мөшгилт, хашилт хаалт, заавар зөвлөгөө нь хараахан хатуу чанд биш, тийм нэгэн агшин зуурын орчин Д.Нацагдоржийг ИХ ЗОХИОЛЧ болгон гаргаж ирсэн ажээ. Тэгэхээр нэрт эрдэмтэн, академич Х.Сампилдэндэвийн дурдсан “Чухам үнэнийг хэлэх юм бол Д.Нацагдоржийн уран бүтээлээ туурвисан үе нь социалист реализмын социалист гэсэн тодотголтой огтхон ч хамаагүй 1921-1940 онд монгол оронд социализм байгуулах зорилтыг тавьж байгаагүйг бид мэднэ. 1934 онд ЗХУ-ын зохиолчдын их хурлаас Сталины шахалт шаардлагаар уран бүтээлийн аргаа социалист реализм гэж томьёолоход Д.Нацагдорж сонгодог гол бүтээлүүдээ аль хэдийн туурвиж, монголын шинэ үеийн уран зохиолын гол зарчмуудыг үндэслэсэн билээ.” эл дүгнэлттэй холбон үзвэл д.Нацагдорж гуай цаг үедээ л Их зохиолч болсон байжээ.

Д.Нацагдорж гуайн туурвил зүйн сэтгэлгээ маш хүчирхэг. Магадгүй, энэ нь хүүхэд балчир ахуйдаа эрдэмт мэргэн багшийн шавь болж, дорнын утга соёл, гүн ухааныг ухан ойлгож, хүлээж авсантай нь холбоотой байх. Бас, бараг л хүүхэд байхаасаа л төрийн хариуцлагатай алба хашиж ирсэн болохоор, эртнээс хэрсүүжснийх нь ч илрэл мөн байх. Нөгөөтэйгүүр Орос, Германд байхдаа дэлхийн сонгодгуудыг уншин судалж, урлаг, утга зохиолын мөн чанар, өрнөдийн философи сэтгэлгээг ухаарч мэдэрсэнтэй нь ч холбоотой байх. Мөн зорилго нэгт үеийн залуусын уран бүтээлийн цэвэр сайхан өрсөлдөөн ч бас нөлөөлсөн байх. Нэгэнт ийм зүйл хаана ч, хэзээ ч, ямар ч нийгэм, орчин цаг үед байдаг болохоор, тэд бие биенээ ирлэн, бие биеэсээ суралцан, бие биеэ нөхөж байсан ажээ. Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, С.Буяннэмэх, Д.Намдаг, Ши.Аюуш, М.Ядамсүрэн, Г.Сэр-Од... Үүнтэй зэрэгцээд гардаг бас нэгэн асуудал нь үндэслэгчийн асуудал болно. Энэ тухайд доктор, профессор С.Лочин “МОҮҮЗ-ын үүсэл хөгжлийн асуудал, энэ утга зохиолд Нацагдоржийн эзлэх байр суурийг сөхөн үзэхэд шинэ уран зохиолын үндэслэгчийн асуудал заавал сөхөгддөг. Энэ асуудал ил далд хэлбэрээр нэлээд маргаантай байдлаар явж ирсэн бөгөөд өдгөө ч хэвээрээ байсаар л байна. Ер нь “үндэслэгч”-ийн асуудал их нарийн төвөгтэй эмзэг байдаг ажээ. Манай уран зохиолын түүхэнд албан ёсоор “Үндэслэгч” гэдэг асуудлыг 1969 оны 1-р сарын 9-нд МАХН-ын ТХ, СнЗ-

<sup>3</sup> Ч.Билигсайхан “Монголын уран зохиолын түүхийг үечлэн судлах нь”, “Хэл зохиол”, ШУА, ХЗХ, УБ, 2001, 98-р тал

өөс МЗЭ-д ирүүлсэн баярын бичигт “МАХН-ын цогт уриа дуудлагыг эн тэргүүнээ сод соргоогоор хүлээн авч, хувьсгалын шинэ үзэл санаа, хүсэл эрмэлзлэлийг уран зохиолд бадрангуй хурцаар тусгасан манай шинэ утга зохиолыг үндэслэгч Д.Нацагдорж болон бусад ахмад зохиолчдын бүтээл...” гэж анх удаа тодорхойлсон юм. Түүнээс хойш уран зохиолын холбогдолтой албан баримтууд болон зохиолчид, судлаач, шүүмжлэгчдийн ихэнх бүтээлд энэхүү тодорхойлолтыг дагаж Нацагдоржийг албан ёсоор үндэслэгч хэмээн болсон юм. Үүнээс өмнө ч Нацагдоржийг “үндэслэгч” хэмээн бичих явдал зонхилж байсныг дурдах хэрэгтэй. Гэхдээ Нацагдорж, Дамдинсүрэн, Буяннэмэх нарыг хамтатган “Үндэслэгчид” хэмээн нэрлэх явдал ч бас багагүй байсан билээ. Нөгөөтэйгүүр Нацагдоржийг “Шинэ уран зохиолын ууган төлөөлөгч” гэх нь байлаа. МЗЭ-ийн II их хурлын илтгэлд Нацагдоржийг “Шинэ үеийн утга зохиолыг үүсгэн байгуулагч” гэсэн байдаг бол эрдэмтэн Г.И.ММихайлов 1955 онд хэвлүүлсэн “Очерк истории Монгольской литературы” гэдэг бүтээлдээ Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн нарыг “Үндэслэгчид” гэжээ. Л.Түдэв “Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, С.Буяннэмэх гэх мэт шинэ утга зохиолын тулгын чулууг тавилцсан” гэж бичсэн авч, Герасимович Д.Нацагдоржийг шинэ уран зохиолыг үндэслэгч гэжээ. Үндэслэгчийн асуудал дээр шүүмжлэгч Д.Цэнд өөрийн гэсэн өвөрмөц байр суурийг олон жилийн турш баримталж ирсэн нь содон ажиглагддаг. Тэр “Шинэ уран зохиолыг үндэслэгч” гэдэг өгүүлэлдээ “1963-66 онд бидний хэсэг хүмүүс “Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх”-ийг анх зохион бичиж...энэ ажлын судалгааны дүнд Ц.Дамдинсүрэн бол орчин үеийн Монголын уран зохиолыг үндэслэгчийн нэг гэдгийг албан ёсоор дэвшүүлэн тавьсан билээ” гэж дурсаад МАХН-ын ТХ зөвшөөрөөгүй гээд баахан хүмүүсийн хэлсэн үгнээс эш татаж өөрийнхийгөө батлах зорилт тавьсан байх юм” гэсэн байдаг.

Гэхдээ 1930-аад оны зохиолчид, тэр цагтаа үнэхээр мундаг байсан. Дээр нь бас нэг гол хүчин зүйл нь Д.Нацагдорж гуайн өөрийнх нь эрдэм судлалын үйл ажиллагаа, түүхийн ухааны болон хэл бичгийн ухааны мэргэжилтний онол арга зүйн мэдлэг, мэргэшил нь түүний туурвил зүйн нэгэн суурь болсон байдаг. Ийм болохоор түүний уран бүтээлийн утга агуулга, өгүүлэмж, хэрэг явдал нь цаг хугацаагаар зүсэхээс илүүтэй сэтгэх арга, үнэт зүйл, ертөнцийг ойлгох хэлбэрийг ялгаж таниулахад чиглэсэн байдаг. Энд Их зохиолчийн “Миний нутаг” ба “Түүхийн шүлэг”-г авч үзэж болно. Хэрэв “Миний нутаг”-г **орон зайг**



голлож, **цаг хугацааг** ерөнхийд нь харуулсан байх бол, “Түүхийн шүлэг”-т **цаг хугацааг** голлож, **орон зайг** ерөнхийд нь томъёолон дүрсэлжээ. Ингэж **орон зай** (“Миний нутаг”) **цаг хугацаа** (“Түүхийн шүлэг”) хоёр сая нэгдэн нийлж, Монголчуудын үнэт зүйлийн сэтгэлгээний шүтэн

барилдлага бий болж байна. Угаас “Оршихуй” гэдэг зүйл цаг хугацаа, орон зайнаас зайлан бултахын ямар ч аргагүй тул, аль нэг нь гээгдэх аваас, мөн чанаргүй, сүнс сүлдгүй болох аж. Нэгэн зэрэг, зэрэгцэн оршиж буй олон дүр баатрын байрласан дарааллыг **орон зай** хэмээх ухагдахуун (“*Миний нутаг*”) нь илэрхийлдэг бол, **цаг хугацаа** (“*Түүхийн шүлэг*”) нь бие, биеийг халж, сольж байгаа олон үзэгдлийн оршин байх дарааллыг илэрхийлдэг. Тийм болохоор цаг хугацаа (“*Түүхийн шүлэг*”), орон зай (“*Миний нутаг*”) нь оршихуйн гүн ухааны үндэс болж байна.

Энэчлэн, нэгэн сайхан хээгүй монгол залуу нөхрийн тухай өгүүлсэн “Хуучин хүү” гэж байхад, яг үүнтэйгээ тэнцүүлсэн гэмээр үзэсгэлэнт монгол охины тухай “Хөдөө талын үзэсгэлэн” гэж бий. “Алс газар сурахаар явагч” -д дотогшоо таньсан танилтыг чухалчилсан байхад “Берлин явсан замын тэмдэглэл”-дээ гадаад ертөнцийн танилт үнэлэмжээ өгүүлсэн байдаг. Энэ мэтээр “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе” - “Уул усны охин”, “Харанхуй хад” - “Морь эрэхээр одов” ... гэх мэт олон зохиол нь шинэ хэлбэртэй, тэр хэрээрээ шууд үнэмшихэд тулгуурласан бус эргэлзэж, шинжлэхэд чиглэсэн, өөрийн утгыг бүтээсэн, уламжлалд захирагдах бус, уламжлалыг шүүсэн шинжтэй, тогтмол, нэгэн хэвийн хөдөлгөөнгүй биш, харин ч үүний эсрэг нээлттэй, хувьсамтгай шинжтэй зохиолууд байдаг нь ерөөс уншигчдыг сэтгэлгээний шинэ эрлийн зүг дагуулж байжээ гэдгийг илтгэн харуулна. Хөөрхий муу гэвш Лодонг эмгэнэлтэй л гэнэ, инээдэмтэй л гэнэ. Үгүй ээ, гэвшийн тухай зохиол биш ээ, энэ бол Цэрэнлхамын тухай, шүүмжлэлт реализм л гэнэ. Тийм биш ээ, энэ бол ерөөс хүний мөн чанарыг харуулсан, хүн хүндээ татагдах, хүний сэтгэлийн хязгааргүй, хүлээсгүй, юунд ч үл баригдах тэр нандин орчилог үзүүлсэн л гэнэ. Хувьсамтгай байгаа биз. Чухам энэ баймж чанарыг л утга зохиолын өгүүлэмж судлалын онолчид, *бичгийн зохиол* гэдэг зүйл болсны баталгаа, *бичгийн зохиолын амин сүнс нь* гэдэг юм билээ.

Тэгэхээр энэ тал дээр “Учиртай гурван толгой” бол үнэхээр гайхамшиг даа. Гадаад, дотоодын олон судлаач, уншигчдын хүлээн зөвшөөрсөн жүжиг. Хүлээн зөвшөөрсний учир нь, дэлхийн утга зохиолд эртнээс хэвшин тогтсон “*дурлалын гурвалжин*” гэдэг ойлголт, ухагдахуун, нэр томъёо, түүний үйл хэргийг үзүүлдэг туурвил зүйн туршлагаас давсан туурвил зүйн сэтгэлгээг үзүүлсэнд оршино. Жишээ нь, өнөө бид нар дэлхийн сонгодог гэж хүлээн зөвшөөрсөн Жакомо Пуччинигийн “Тоска” (1887 он), Жузеппе Вердигийн “Трубадур” (1850-1852 он), “Травиата” (1853 он) зэрэгт хайрлаж дурласан хүн нь өөрийнх нь үл болонгуут, зөвхөн өөрийнхөө бүтээгүй хайрын төлөө өшөө авах сэтгэлээр, дурлалт хосын амьдралыг хорлон сүйтгээд, эцэстээ өөрийн амийг егүүтгэн золиосолдог ийм эмгэнэлт “хайрын гурвалжин”-г бүтээсэн бол “Учиртай гурван толгой”-д тэр “хайрын гурвалжин”-г үзүүлснээрээ нийтлэг, түгээмэл (universal) байгаа ч гэсэн, энэ мэт сонгодог бүтээлд хараахан гаргаагүй “хайртай байсан хүмүүс нь амьдралын хамгийн ноцтой, эгзэгтэй, шийдвэрлэх агшинд жинхэнэ мөн чанараа таниулж байгааг: “*Юндэн өнөөх урьдын чулууны дэргэд унана. Хоёр хүн "Чи юунд амины хэрэг гаргав? Маньг хэрэгт холбогдуулав. Чамайг албаны газар хүргэж бид хэргээс гарна."* гэж туслахыг байж харин түүнийг барин хүлж авч одоход Балган аргагүй болж хөтлөгдөн явах замд "*Нансалмаа надад хэрэггүй*" гэж чанга дуугаар хоёр гурав дахин

хэлж одно. *Хоролмаа айсан мэт болж "Юндэн надад хэрэггүй" гэж мөн чанга дуугаар хэдэнтээ хэлж зугтан одно.*" гэж үзүүлсэн юм. Энэхэн хэсэгт байгаа "Юндэн надад хэрэггүй, *Нансалмаа надад хэрэггүй*" гэж, энэ үйлдсэн хэрэг учир явдлаа огтхон ч үл тоон, улмаар дараачийн цаг хугацаа, орон зай руу нэвтрэхийг зорьж, хүсч буйг үзүүлсэн нь, угтаа хүний жинхэнэ мөн чанарыг таниулсан хэрэг юм. Үүгээрээ манай Д.Нацагдорж өрнөдийн сонгодог бүтээлийг туурвил зүйн сэтгэлгээг давж, гүнзгийрүүлж чадсан ба ингэснээрээ хүний амьдралын мөн чанарыг ухааруулах, бодуулах, хүний оршихуйн мөн чанарыг таниулсан гүн ухаан руу хөтлөн аваачиж, эмгэнэлийн дараачийн үе шат (*post tragedy*) руу оруулж байгаагаараа Монгол жүжгийн зохиолын үнэт зүйл болон мөнхөрсөн байна. Улмаар энэ бүтээлийг гадаад хэлээр орчуулан, тэр хэлт үндэстэн, өөрсдийн одоо үеийн үндэсний дуурийнхаа сонгодог гурван бүтээлийнхээ нэгийг нь болгожээ. Одоогоор лав, Монголын орчин үеийн уран зохиол, бүтээлээс "Учиртай гурван толгой"-с өөр ямар ч бүтээл ингэж соёлын экспорт болж, харь улсын үндэсний сонгодог бүтээлийн түвшинд очсон нь үгүй шүү.

Энэ тал дээр нэрт эрдэмтэн доктор, профессор Д.Цэдэв "Д.Нацагдоржийн урлан бүтээх эрдмийн онцлог бол зохиолоос зохиолд байнгын эрэл хайгуул хийдэг байсанд оршино. Энэ нь их зохиолчийн монгол ардын аман яруу найраг, хуучны бичгийн зохиол, өрнө дахины болон дорно дахины сонгодог утга зохиолыг гүнзгий судалснаар уламжлах шинэчлэх ёсны амьд холбоог тогтоож чадсантай нь холбоотой юм. Ерөөс Д. Нацагдоржийн уран бүтээл нь Монголын шинэ утга зохиолын үндсэн зарчмыг бий болгохын төлөө эрэл хайгуул байсан гэж бүхэлд нь нэгтгэн үнэлж болно. ... Шинэ утга зохиол, түүний үндсэн зарчмын анхны үлгэр жишээг их зохиолч зохиол туурвилаараа үзүүлсэн гэж хэлж болно. Д. Нацагдоржийн бүтээлийн өргөн сэдэв, гүн агуулга, уран зохиомж, яруу сэтгэлгээ, оновчтой дүрслэл тэргүүтэн нь орчин **үеийн** монголын утга зохиол урлагийн шинэ уламжлал болж, өнөөгийн уран бүтээлч залуу авьяастан нарын зохиолынхоо чанар чансааг хэмжих хэмжүүр, урлах эрдмийн шалгуур сургууль болж байна. Д. Нацагдорж бол гандан бууршгүй яруу найраг, хүүрнэл зохиол, жүжиг тэргүүтнээрээ монголын орчин үеийн утга зохиолын үүсэл хөгжил, төлөвшилд гарамгай үүрэг гүйцэтгэж, хожим хойчийн зохиолчдод үлгэр дуурайл болж байгаагаараа зөвхөн манай орны төдийгүй дэлхийн уран сайхны соёлд хувь нэмэр оруулсан сод уран бүтээлч, яруу сайхны тэнгэрт мөнхөд гялалзах гэрэлт од мөн. ...Тиймээс ч Нацагдорж биеэ умартан, өнгөрсөн үеэс монголын оюун санааны **соёлын** ирээдүй рүү гүүр барьж эхлэгчдийн нэг байжээ. ... Монголын ард түмний сод билигт хүү Дашдоржийн Нацагдорж нийгэм олон түмнийхээ үзэл санааны өөрчлөлтийг гагцхүү суут зохиолчийн хувьд эрч далайцтай илэрхийлж чадсанд л түүний уран бүтээлийн давтагдашгүй чанар, урлах эрдмийн гайхамшиг, залгамж үедээ нөлөөлөх үлэмжийн их чадал, олон үеийн уншигчдыг эзэмдэн дагуулсаар байгаа увдис нь оршиж байна." хэмээн дүгнэсэн байдаг. Тэгэхээр их зохиолч Д.Нацагдорж уран бүтээлээрээ туурвил зүйн өмнөх үе, хуучин цагийн сэтгэлгээг халахдаа өнгөрснөө үгүйсгэх бус, харин түүнийг давж, шинэ нөхцөлд нийцсэн ухамсрын түвшинд утга зохиолоо туурвиж ирсэн нь мэдэгдэж байгаа юм. Энэ бол Д.Нацагдоржийн бүтээл туурвил, нийгэм-

соёлын үйл ажиллагаанд “соён гэгээрүүлэл” хэмээх зүйл тухайн үеийнхээ бусад зохиолч нараас илүү тод гүнзгий утга агуулгаар илрэн биелжээ гэсэн үг болно.

Д.Нацагдоржийн соён гэгээрүүлэлтийн үзэл санаа, үйл ажиллагаа зөвхөн Монголын нийгмийн шинэчлэлийн үйл явцын хүрээнд бус, өрнө дахины соёл шинжлэх ухаан, ялангуяа өрнөдийн нийгмийн соёл ахуй, гүн ухаан, хүмүүнлэгийн ухааны орчинд бүрэлдэн төлөвшиж гүнзгийрсэн тул тэрбээр “хөмөрсөн тогооны дотор” мэт байсан хоцрогдмол, түгжигдмэл нийгмийг, гэрэл гэгээтэй, шинэ нийгэм болгон хувиргах, “Хуучин хүү”-г “Шинэ хүү” болгоход шинэ цагийн эрдэм мэдлэг, иргэний боловсрол, анагаах ухаан, эрүүл аж төрөх ёс, шинэ ухамсар, ёс суртахуун, нийгэм хийгээд хүний амьдралын шинэ эрхэмлэл, үнэт зүйл нь асар их чухал болохыг өөрийн яруу найраг, үргэлжилсэн үгийн болон жүжгийн зохиолууддаа яруу тод тусган харуулсан юм. Ингэхдээ үндэсний утга зохиолын хэлний шинэ орчныг, шинэ сэтгэлгээгээр бүтээж өмнөхөөс огт өөр шинэчлэлийн зам руу хөтөлсөн юм.

Ийм учраас өдгөө Д.Нацагдорж хэмээх “*ЕРТӨНЦ*”-ийг танин мэддэг, ухааран ойлгодог, үнэлэн цэгнэдэг, эрхэмлэдэг, эрдэм мэдлэгийн иж бүрэн тогтолцоо бүхий бүхэл бүтэн салбар - “Нацагдорж судлал” үүсэн хөгжсөн юм. Нацагдоржийн ертөнц үнэхээр олон талтай учраас Нацагдорж судлал мөн олон талтай, нарийн нийлмэл шинжлэх ухаан болон төлөвшсөн билээ. Манай Нацагдорж судлалын гарамгай эрдэмтэд бол Б.Содном, Л.Балдан, Д.Цэдэв, С.Лочин, Ч.Жачин нар мөн.

**ШАРАЙД ДҮҮРЭНЖАРГАЛЫН ШҮЛГИЙН САНАА ДҮРИЙН  
ДЭЛГЭР ХАРАА, ГҮН ЦЭЭЛ УРАН ИЛРҮҮЛЭЛ**

**Чүү И**

*(БНХАУ, Өвөр Монголын Багшийн их сургууль  
Монгол судлалын дээд сургууль,  
доктор, профессор)*

*Агуулгын товч: Өгүүлэлд Өвөр Монголын зохиолч яруу найрагч Дүүрэнжаргалын уран бүтээлийн шинэлэг талыг авч үзсэн байна. Найрагчийн шүлгийн санаа дүр нь өвөрмөц онцлогтой байж, одоохоч, модерн үзлийн яруу найргийн олон зүйлийн илрүүллийн арга барилыг бүтээлчээр ашиглан, содон сайхан шүлгийн мөр бадгийг туурвин бүтээсэн байдаг. Мөн түүний яруу найраг нь гадаад ертөнцийг зураглан шүлэглэдэг байснаасаа дотоод сэтгэлийн зүг шимтэн, бясалгалын гүн утгатай, хоосны чанарыг ухааран илрүүлсэн тал руу дэвшижээ.*

*Түлхүүр үг: санаа дүр, Дүүрэнжаргал, Өвөр Монголын одоохоч чиглэлийн яруу найргийн туршилт, яруу найргийн туурвил зүй*

Умард хилийн дархан сахиул, амь ахуйн ариун голомт, хүн ардынхаа дулаахан бууц, хүсэл мөрөөдлийн тэнгэрлэг зай болсон Өвөр Монголын уран зохиолын тавцанд наяд оныхон гэдэг хийморилон зохиолчид уран бүтээлээрээ өсөж өндийсөн байдаг. Огторгуйн үй олон оддынхоо дунд Шарайд Дүүрэнжаргалын шүлэг үүрийн цолмон шиг гялалзаж байдаг. Тэр маань “Чингис иртэй чулуу” (2006) “Гал улаан ганцаардал” (2013), “Туравдагч туйл” (2017) зэрэг гурван шүлгийн түүвэр ба мөн найрууллын түүврээ хэвлүүлэн нийтэлжээ. Гурван шүлгийн түүврээс харахад яруу найрагчийн шүлэг тэрлэх ур чадвар идэг, идгээр боловсрон, гадаад ертөнцийн зураглалаас дотоод сэтгэлийн гоо тольдол тийш шилжиж ирсэн сэтгэлгээний ул мөрийг ажиглаж болно. Тус өгүүлэлдээ Шарайд Дүүрэнжаргалын гурван шүлгийн түүвэрт суурилан шүлгийнх нь санаа дүрийн тухай шинжлэхийг саналаа. Түүний шүлгийн санаа дүр нь умард хилийг сахин амьдарч байгаа хүн ардын нийтлэг сэтгэлгээний шинжийг тусган илрүүлж чадсанаар үл баран, зохиолчийн гал шиг өрнүүн, мэс шиг хурц онгод бясалгалын очсыг хадгалсан байдаг. Зохиолчийн шүлгийн мөр бадаг болгонд өвөрмөц гоо таашаалын гэгээ тодрон, одоохоч, модерн шүлгийн шаргаамал, бэлгэдлийн, гүн ухаалаг, шүүмжлэлийн шинж гялалзан уянгарч байдаг.

**НЭГ. ШҮЛГИЙН САНАА ДҮРИЙН ДЭЛГЭР ХАРАА**

Шарайд Дүүрэнжаргалын шүлгийн сэдэв өргөн дэлгэр байж, утга сэдвийн баялаг гүнзгий, санаа дүрээ уран дүрслэг илрүүлж чадсан байна.

**(Нэг) Эх оронч хайрын торгон илрүүлэл**

Эх орны нутаг дэвсгэрийн өргөн уудамд бахархах сэтгэлгээг илрүүлэхдээ

“Мэнэнгийн их тал  
Тэр чигээрээ уул байсан бол гэхээс  
Хараа үл хүрэх  
Тэнгэр богинодоно  
    Мэнэнгийн Богд уул  
    Тэр чигээрээ тал байсан бол гэхээс  
    Унаа үл хүрэх дэлхий багадна  
Мэнэгийн уул тал дунд  
Дуулж үзсэн найрагч миний л  
Санаа хүрэх дэндүү омголон” (“Гал улаан ганцаардал”, Р32)

Энд тэнгэр богинодоно, дэлхий багадана гэх мэтийн санаа дүрээр дамжуулан Мэнэнгийн их талын тэнгэр шиг гүн цээлтэй, хязгааргүй өргөн уудам байгаа гэдэг санааг илрүүлэхийн зэрэгтээ энэ их тал нутагтаа оршин тогтнож аз жаргалтай амьдарч байгаа ард түмний нэгэн гишүүн болох яруу найрагчийн сэтгэл л энэ уудам талыг багтаан, түүнээрээ сэтгэл хөхүүн, омог бардам амьдарч чадна гэдэг эзэн хүний омог сүлдийг тусган харуулсан байдаг. Зохиолчийн сэтгэлд яруу найраг бол хамгийн дотно, хамгийн үнэнч хайрын түшиг. Тэр маань:

“Би яруу найрагчид л итгэнэ  
Өөр хэнд ч итгэхгүй  
Өөр хэнд ч би

Эх орныхоо тухай тоож дэлгэхгүй”. (“Гал улаан ганцаардал”, Р43) хэмээн “Яруу найрагт бичсэн захидал”- даа илрүүлсэн байдаг. Тэрээр эх орноо өнөд сахиж хамгаална гэдэг сэтгэлийг эх байгалийн тухай уянгалалдаа уусган шингээж, байгаль ахуй лугаа нэгдэн уусах ухамсар болгон шүлэглэн илрүүлсэн байдаг. Түүний “Чингис иртэй чулууд” хэмээх шүлэгт:

“Тэнгэрлэг хүйсэнд ир орсон чулуудыг  
Тэнэг түүхийчүүл буруу уншиж  
Түрэмгий дайны улаан цэнэгээ  
Эх орон зүг минь хандуулдаг байж дээ!  
Бууцан талаа энхийн зүүднээс нь сочоохгүй гэж  
Иртэй тал нь үнэний цусаар лугшдаг юм  
Эзний хишигтэй энэ чулууг дэрлэж  
Зэрэглээ нь хүртэл дайсны зүг цойлдог юм.  
... Чингис хиртэй энэ чулуудаа тулж

Цэцэгс нь хүртэл л дайсны зүг гэдийдэг юм.” (“Чингис иртэй чулууд”) р21) гэж эх орноо сахин хамгаалах үзэл санааг байгалын “Иртэй тал нь үнэний цусаар лугшдаг юм”, “Зэрэглээ нь хүртэл дайсны зүг цойлдог”, “Цэцэгс нь хүртэл л дайсны зүг гэдийдэг” зэрэг санаа дүрд уусган харуулсан байдаг. Тиймээс яруу найрагчийн үзэхээр эх орон гэдэг бол хийсвэр ухагдахуун огт биш, харин тэнд амьдарч байгаа ард түмэн ба чин сэтгэлийг нь тээж яваа тал нутаг, хад чулуу, талын зэрэглээ, гоёхон цэцэгс зэрэг бүхий л оршихуй байж дээ! Яруу найрагчийн сэтгэл, эдгээр уянгын санаа дүрээр дамжуулан, эх орны бүхий л оршихуйг амьдчилан мэдэрч, торгон мэдрэмжээрээ ухаарч, өвөр “би”-ийн илрүүллийн цогцос болгосон байдаг. Тэр бас амь насны үнэ өртгийг үнэлэхдээ, “үхэл, амьдрал”-ын зайд тусган харуулж чадсан байдаг.

“Эх орон минь байгаа цагт  
Хэрэгсвэл өмнөөс нь би үхэж болно  
Зориг дутахгүй  
Эх орон минь алга болчихвол  
Хэрхэвч би амьдарч чадахгүй

Агаар дутна” (“Чингис иртэй чулууд”,р61) гэж хувь цогц ба хам цогц, амь нас ба эх орны харьцааг уянгалан шүлэглэсэн байдаг. Тэгэхээс шүлэгчийн маань шүлэг нь эх орондоо өргөсөн хайрын уянга ба эх орныхоо төлөө халуун амиа ч зориулахад бэлхэн байгаа оргилом сэтгэлээр бялхам байгааг мэдрэн ойлгож болно.

### **(Хоёр) Амьдрал ахуйн гэгээн тольдол**

Яруу найрагч умард хил хязгаар орны ард түмний ахуй амьдралыг өвөрмөц онцгой тусган харуулж чадсан байдаг. Онцгойлон адууны тухай маш олон шүлэг бичсэн байдаг. Тэдгээр шүлэгт адуу ба монгол хүний сэтгэлийн уусалцыг харуулж, оршихуйн дэс дэх гүнзгий агуулагдахууныг илчилсэн байдаг. Үүнд “Морио хүлээж жаргах наадам”, “Нүүдэл жаргах үдэш”, “Адууны мөрөөр эргэдэг монголын дөрвөн улирал”, “Адууны эрэл”, “Адууны гэгээ” зэрэг олон шүлгүүдийг дурдаж болно. “Хавар цаг адуу дэллэхүйн шүлэг”-тээ:

“Адуу дэллэхүй  
Анираар нь  
Алдуул салхин хурахуй  
Хурд үл саарахын шинж  
Адуу дэллэхүй  
Чимээнээр нь  
Цагийн алхаа наашлахуй  
Эрэл үл холдохын бэлгэ,  
Адуу дэллэхүй  
Сургаар нь  
Судгийн ногоо суга өснө  
Уяа үл өнчрөхүйн совин  
Адуу дэллэхүй  
Шинжээр нь  
Шүлгийн мөр хэлхэхүй

Ухаан үл унтрахын ерөөл” (“Гал улаан ганцаардал”,.Р45) Тус шүлэгт адуу дэллэх үйл ажиллагааг сэрэл сэтгэл ба бэлгэ ерөөлийн сэтгэлд идээшүүлэн уянгалж, шинэ сэвүүн шүлгийн санааг гаргаж чадсан байдаг. Үүнд алдуул салхин хурахуй гэдэг санаа дүр нь монгол амьдралыг гүн ухааран ойлгосон хүнээс олж хэлдэг үг болно. Энд адуу хураах, уургалах, адууны тоос үүл нүүх шиг салхи татуулан хурамдах үйл хөдөлгөөний агшныг шүлгийн санаанд уусган хурц тодхон илрүүлж чадсан байдаг. “Нүүдэл жаргах үдэш” гэдэг шүлэгтээ:

“Таанын манан дунд хөнгөн майхан шаагдаж  
Талын гурван чулуунаас хээрийн гал манасхийж  
Тархай хотолсон хоньд цэцгийн салхин хэвж  
Танил дүртэй мануул түүний цаана босгогдлоо  
... Зуны үдшийн уураг саран дэлхийг сүлж

Зуслангийн түмэн цэцэгст хөнгөн шүүдрээ жаргааж

Нүүдэл үдлэх үдэш тайван атлаа өрнүүн

Нүүдэлчин хүний амьдралаас амьдрал эхэлсэн аж!” (“Чингис иртэй чулууд”, р11) гэх мэтчилэн яруу сайхан байгаль орчныг зураглан шүлэглэж, малчин айлын амгалан тайван байдлыг тусган харуулсан байдаг. Шүлэгт “тархай хотолсон хоньд цэцгийн салхин хивж”, “зуслангийн түмэн цэцэгст хөнгөн шүүдрээ жаргааж” гэх мэт хам сэрлийн таашаал ба сэтгэл шилжилтийн арга маягаар дамжуулан, хил хязгаарын хөдөө орон нутаг өвөрмөцийг тусган харуулж чадсан байна.

### (Гурав) Хайр сэтгэлийн цэвэр хөөцөлдөл

Ариун нандин хайр сэтгэлийн цэвэр хөөцөлдөл ариун нандин хайр сэтгэл “Залуу нас минь”, “Амраг цагаан аялгуу”, “Зүрх сэтгэл минь”, “Хайраа аргадахуй” гэх мэт яруу найрагт түүний өвөрмөц цайлган хайр сэтгэлийн долгис намилзаж байдаг. Түүний “Залуу нас минь” гэх шүлэгт:

“Цэцгийн үнэртэй салхитай эмнэгийн нуруунд сундалж

Чимгийн хээтэй тамгыг дааганы ташаанд ноцолдуулж

Уулын жороо зэрэглээг зултай хүлгээрээ басаж

Овооны сургаар зуны шөнө уяа сойлгод яаран

Морьдын нарийн тоосонд тогтож ядалгүй хийрхэж

Морьтойгоо хамт айргийн тавд найрын магтаалд хийморьжиж

Хар азарганы хур дэл шиг уул усаа таллаж

Халуун залуу нас минь морины нуруунд бий

...Уртын дууны намиадаа магтаж

Уяхан хүүхний харц дагуулан дэвж” (“Чингис иртэй чулууд”, р65) гэх мэтчилэн, маш яруу сайхан шүлгийн санаагаар залуу насны хийморь сүлд, цог жавхааг шүлэглэн уянгалж, сайхан залуу хүүхэнчүүчдийн харц, хурдан морь, эрэмгий бөхчүүд, уртын дуу мэт санаа дүрээр дамжуулан, уламжлалт нүүдэл ахуйн гоо сайхан дүр зургийг урлан бүтээж, зураг үзэгдлийн далдад хүн ардын зориг золбооны өөдөрхөг талыг харуулж чадсан байдаг. Шүлэгч маань цэвэр нандин хайр сэтгэл ба чин үнэнч зоримог хайрыг дээдлэн үзэж бол хүн төрөлхтөнд л байж болох, гоч өвөрмөц, үнэнч дурлал байхыг хүсэн мөрөөдсөн байдаг. Тэрээр:

“Зөндөө хайртай сэтгэлийг минь

Зөнч шувуу зуугаад

Чамд очно

Шувууны хэл сур даа амраг минь

...Чамдаа л гэсэн үнэнийг минь

Сунгаа хол шүлэг минь аваад

Чамд очно

Шүлгийн минь сойлгыг тайл даа амраг минь” (“Гал улаан ганцаардал”, р38)

Сэтгэлийг минь зуугаад, үнэнийг минь аваад гэх мэтийн санаа дүрээр дамжуулан амраг хайрын сэтгэлийг өвөрмөц сайхан илрүүлсэн байдаг. Тэр бас амраг сэтгэл нь хүнийг ариусгадаг гэж үзэж шүлэглэсэн байдаг. Түүний “Амраг цагаан аялгуу”-д:

“Сарны гэрэл сэтгэлийн ёнхорыг хөндөн дуу төрж

Салхины айзамд бий бие минь лимбэ мэт дурд хөглөн  
Инж буурал цэцгийн хөхөлбар туяа мэт дотроосоо гэрэлтэн  
Яруу тунгалагханаар чиний тухай бодож өөрийгөө ариусгалаа”  
 (“Туравдагч туйл”, р65) гэж амраг сэтгэлийн цэвэр ариун санааг уянгалан  
хүний сэтгэлийг ариусган гэгээрүүлэх тал илрүүлсэн байдаг.

**(Дөрөв) Өвөрмөц сэрэл сэтгэлгээний гялс цэг**

Шарайд Дүүрэнжаргалын шүлгийн өвөрмөц нэгэн сэдэв бол яруу  
найрагчийн уянгалагч биеч цогцын амьд сэрмүүн сэрэл сэтгэлгээний гялс  
цэгийн илрүүлэл болно. Эдгээр гялс цэг нь яруу найрагчийн шүлгийн мөр  
бадагт од шиг цацран гэрэлтэж байдаг. Түүний “Туравдагч туйл” даа түүвэрлэн  
оруулсан яруу найргууд үндсэндээ сэрэл сэтгэлгээний яруу найргууд болно.  
Тус түүвэрт “Сэтгэлээрээ амьдрагч”, “Сэтгэл хийгээд намар”, “Чамайг санах  
хэцүү”, “Сэтгэлийн үүрсээ”, “Сэтгэл 1”, “Сэтгэлийн бурхандаа хань татах  
шүлэг”, “Сэтгэлийн мана”, “Сэтгэлийн өрх татахгүй”, “Сэтгэлийн босгоо  
сандайлж бичсэн шүлэг”, “Сэтгэлээ би”, “Сэтгэлийн өндөрт”, “Сэтгэлийн  
тайлан”, “Сэтгэлийн шувуу”, “Сэтгэлийг минь та төсөөлнө үү”, “Сэтгэгдэл”,  
“Санасан сэтгэлийн цуурай” гэх мэт шүлэгчийн сэрэл сэтгэлгээний шүлгүүд  
орсон байдаг. Түүний “Сэтгэл хийгээд намар” гэдэг шүлэгт:

“Юу ч гэмээр юм бэ дээ, энэ намар цагийг  
Ертөнц тэр чигээрээ навчинд хувилна  
Он өнжсөн хуанлийн хуучин цаас мэт  
Ямаар ч юм бэ дээ, энэ намар цагийг  
Ямар ч дуу аялаад нэмэр болохгүй  
Сэтгэл гэдэг модонд гунигийн үрэл бөнжигнөөд  
Сэрүүн салхинаар хөсөр унахад нь яс янгинана  
... Юу ч гэмээр юм бэ дээ, энэ намар цагийг

Ертөнц тэр чигээрээ сэтгэл минь болно (“Туравдагч туйл”, р2) шүлэгт  
хүн байгалийн уусалдлыг намрын навчсын учрал жич намрын жиндүү  
хүйтэнтэй тольгтон үзүүлж, хүн байгалийн уусан нэгдсэн бясалгалын орон зайг  
илрүүлсэн байдаг.

Хамгийн өөдөрхөг үгсийг овоолоод ч  
Хадагтай овооноос өндөр байж чадахгүй  
Хамгийн гунигтай үгсийг унагаад ч  
Хатсан навчсаас хүнд байж дийлэхгүй  
Хамгаас гэгээтэй үгсийг асаагаад ч  
Хаврын эхний яргуй шиг гэрэлтэхгүй  
Хамгийн илчтэй үгсийг нөмрөөд ч

Хайртай хүний харц шиг төөнөхгүй.” (“Туравдагч туйл”, р 133) гэж  
“Хамгаас гэгээтэй үгсийг асаагаад ч” гэдэгдээ эсрэг тэсрэгийн дурайлгалын  
аргаар сэтгэл зүрхний шүтлэгийн ариун дагшин чанар, үхэл амьдрал ээлжлэх  
орчлын гуниг, жич хайртай амраг сэтгэлийн нууцлаг эмзэгхэн, гэгээнлэг талыг  
дүрслэн үзүүлж чадсан байдаг.

## **ХОЁР. САНАА ДҮРИЙН АГУУЛАГДАХУУНЫ ГҮН ЦЭЭЛ**

Шарайд Дүүрэнжаргалын шүлгийн санаа дүр нь урлагийн торгон мэдрэмж ба олон зүйлийн илрүүллийн арга барилаар дамжуулан, олон давхарлаг санааг илрүүлж чаддаг.

### **(Нэг) Хам сэрлээр очилсон нарийлаг мэдрэмжтэй**

Хам сэрлийн үзэгдлийг бий болгож, шүлэг санаа агуулагдахууныг өргөтгөж чаддаг бол шүлэгчийн товойм онцлог байдаг. Шүлгийн хэл хэллэг яруу урсам, гоо таашаалын сэтгэлийн шинэ соргогийг үүдэн бүтээсэн байдаг.

“Сэтгэл гэдэг модонд гунигийн үрэл бөнжгөнөөд

Сэрүүн салхинаар хөсөр унахад нь яс янгинана” (“Туравдагч туйл”, р2) Сэтгэл гэдэг уулаас хийсвэр зүйлийг мод гэдэг бодит хэрэг бодисоор тольтгож, гуниг гэдэг сэрэл сэтгэлийг бөнжигнөөд гэдэг бодитой үзэгдэх үйл үгээр өгүүлэхэд, хүмүүст хийсвэр сэрэл сэтгэгдэл байсан бол бодит үзэгдэл болж танигдах боломжтой болсон байдаг. Үнэндээ гунигийг олж харах боломжгүй атлаа сэрүүн салхинаар хөсөр унах ба яс янгинана гэдэг үйл үгээр өгүүлээд, сэтгэл хөрөх гэдэг байдлыг бодитой үзэгдэл болгож танин мэдрүүлжээ. Тиймээс хам сэрлийн арга барил нь үгийн утгыг тэлрүүлж, шүлгийн санааг уужим хол болгох боломжтой болсон байдаг.

### **(Хоёр) Бэлгэдэлд шингэсэн торгон санаатай**

Яруу найрагч маань бэлгэдлийн санаа дүрийг бүтээж, эх оронч сэтгэл ба янаг хайрын сэтгэлээ илрүүлсэн байдаг. Үүнд чулуу бол яруу найрагчийн бүтсэн чухал нэг санаа дүр болно. “Чулуу нь жаргадаг эх орон”-доо:

Эх орны минь хилийн

Мөнхийн болд харуул

Эрдэнэт тулгыг минь хөлд

Мэргийн алтан учиг

Хол явсан үрээ

Салхиараа дуудан даллаж

Хулан тахийн туурайг

Галтай хадаараа аргамжин

Сахиул буурал овоон минь

Ерөөлийн сүүтэй нэмүүлж

Сарьдаг өндөр хайрханд минь

Итгэл эгшиглэн дэгдэрлээд

Нутгаа санасан миний алганд

Зүрх болон нулимсарч

Намайг эрсэн эцгийн минь

Нүдийг зүүд зөгнөн дулаалж”

... гэдэгт чулуу бол хилийн харуул, гал тулгын учиг, овоонд өргөх шүтлэг, уул хайрхны итгэл, хол явсан үрийн сэтгэл дэх нутаг, үрээ санасан эцгийн сэтгэл дэх түшиг гэх мэт олон санааг ачаалан тээсэн байдаг. Түүний “Зүүдний оромж” арга гэх мэт шүлэг нь бэлгэдэл ба далд зүйрлэл ашиглан өвөр “би”-ийн ганцардал ба гунирхлын сэтгэлийг илрүүлэхийн дагуу нийгмийн хэлбэрч үзлийн зарим асуудлыг ч егөөдөн тусгасан байдаг.

“Яайжгий сандал минь яриач

Ягдаг нохой шиг байнга залхагддаг

Хуучин толь минь ерөөлч  
Үнэн худалгүй дандаа магтдаг  
Хөгшин хаалга минь манаач  
Хүн болгоныг хардаж сэрддэг  
Хүрэн ширээ минь хэрүүлч  
Хүүхэн болгоныг харааж муулдаг”

“Танц нүд нь хоргонд нэрийн хуудас дүүрэн  
Ганц нь ч надад жинхэнээсээ хэрэг болдоггүй  
Гадагш гарахдаа өмсдөг ганцхан майжгий гутал  
Гадагш гарах шаардлага үнэндээ надад үлдээгүй”

(“Гуравдагч туйл”, р 127) Тус шүлэг нь одоохоч үзлийн арга барилын арга маягаар өнчрөл гаацаардлын сэрэл сэтгэлгээнийг дүрслэгээр илрүүлж чаджээ. Үнэндээ хүний оршихуйн мөн чанар бол ганцаардал өнчрөл болох юм.

### **(Гурав) Зүйрлэлд ууссан сэтгэлгээний уянгалал**

Шүлэгчээс ил зүйрлэлийг яруу найрагтаа дэлгэрэнгүй ашиглаж санаа дүрийн угсруулал ба давхцлын үзэгдлийг бий болгож, шүлгийн санааг өргөн цээл болгодог. Түүний “Нууц” гэдэг шүлэгт:

“Онъсого мэт  
Орчлонгийн ааш мэт  
Он жилийн түлхүүр мэт  
Ондоо ертөнцийн хаалга мэт  
Онгод буудаг зам мэт  
Одоо хийгээд ирээдүйн зай мэт  
Хүн бүхэн л мэдэх сэн гэж дурладаг  
Би тийм гоё нууцтай  
Нууцаа би заримдаа дэлгэмээр болдог

Гэхдээ хэнд вэ? Олохгүй байдаг” (“Гуравдагч туйл”, р4) Үнэндээ нууц бол шүлгийн мөр бадагт хэлсэн бүх өгүүлэхүүний шинжийг багтаасан байдаг. Яруу найрагч маань оршихуйн олон үзэгдлийн дундаас мөн чанарыг нь ухааран таньж, олон санаа дүрээр дамжуулан, оршихуйн утгасын олон далд шинжийг илрүүлж чадсан байдаг.

## **ГУРАВ, ЯРУУ НАЙРГИЙН ХЭВ НАМБЫН ШИНЖ.**

### **(Нэг) Өвөрмөц шаргаамал шинж**

Шарайд Дүүрэнжаргалын шүлэг нь үгсийн тунгаалт сайтай байж өвөрмөц бүтээлч шинжтэй байдаг. Одоохоч, модерн шүлгийн хам сэрлийн арга барил ба цаг орон зайн мэдрэмжийг органикаар уусган шүлэглэж, өвөрмөц санаа ахуйг гаргаж чадсан байдаг.

“Чинэсэн үзмийн амт  
Чиний уруулыг санагдуулах нь  
Намрын дунд сар” (“Гал улаан ганцаардал” р54) Түүний шүлэг нь:  
“Хөх усанд чулуу хаяхад  
Хөх усан үймнэ  
Хөөрхий сэтгэл минь

Усан мэт эмзэг (“Гал улаан ганцаардал” р46) байгалийн үзэмж бодистой барилдан шүтэлдэж, хүн байгалийн уялдал нэгдлийг бий болгож, цөөн хэдэн

үгээр сэрэл сэтгэлээ товч оновчтой шүлэглэн, яруу найргийн содон шаргаамал шинжийг харуулж байгаа нь энэ аж.

### **(Хоёр) Баялаг бүтээлч шинж**

Шарайд Дүүрэнжаргалын шүлэг нь өвөрмөц бүтээлч шинжтэй байж, мөр бадаг болгоноос нь шинэ сэвүүн гайхалтай санаа төрж байдаг. Түүний “Үс унах чимээ” гэх шүлэгт:

“Үс унах чимээ  
Тэнгэр ниргэх шиг нүргэлнэ  
Харийн нутагт  
Тэнгэр ниргэх ч  
Үс унахын дайтай бодогдоно  
Ээжийнхээ өвөрт  
...Уул нурах ч  
Үс унахын дайтай санагдана

Аавынхээ нөмөрт (“Гал улаан ганцардал”,р163) Тус шүлэгт үс унахын аниргүй байдлыг тэнгэр нурах мэт гэх асар их зайтай оршихуйтай харьцуулан өгүүлсэн нь, хойд хоёр бадагт шүлэглэж байгаа аав, ээжийнхээ өвөрт амгалан тайван байгаа сэтгэлийг товойлгон илрүүлэхэд дэвсгэр суурь болж өгчээ. Энэ нь гоо амтархлын хувьд өвөрмөц содон болж чадсан байдаг. Түүний “Гунигийн зураглал”-д:

“Хүсэж, хүлээж  
Хөх тэргэрийн өдтөй эрх чөлөөг  
Дөнгөж нэг харлаа  
Цовоо дуугаар мөчир дээр дээр минь жиргэнэ дээ гэхэд

Цонхны гадна” (“Гал улаан ганцардал”,р135) Тус шүлэг нь гүн далд бэлгэдлийн утга бүхий түүхийн санаа дүрээр эрх чөлөөг хүсэн хүлээж байгаа сэтгэл ба шилний гадна байгаа эрх чөлөө арай ч ойртож ирэхгүй байгааг бэлгэдэн илрүүлсэн байдаг. Тэр “Гунина, гунихгүй” гэдэг шүлэгтээ:

“Модод шуугихад навчис нь  
Тэнгэр өөд хөөрөөд  
Тэндээс бороо болон асгарч  
Навч дахиад ургахын шалтгаан болох

Ийм сан бол би гунигаар яах юм бэ” (“Гал улаан ганцардал”,р137) Тус шүлэг нь намрын навчсын унах уйтгарт ахуйг амь насны орчлын чухал нэг гогцоо гэж мэдэрсэн бүтээлч сэтгэлгээ нуугдаж байдаг. Тус шүлэг нь бясалгалын амттай байж, амь насны оршихуйн тухай гүнзгий гэгээрэл ухаарлыг харуулж чадсан байдаг. Тэгэхээр, шүлэгчийн шүлгийн санаа уран, сэтгэлгээний хувьд гүнзгий бясалгалын шинжтэй бүтээлч шинжтэй болсон байдаг.

### **(Гурав) Хурц тод шүүмжлэлийн шинж**

Тэр хүн чанарын тухай “Хүн чанарын оршуулга” гэдэг шүлэгтээ:  
“Хүйтэн чулуун гантиг дээр  
Хүрч чадаагүй мөрөөдөл минь гэж бичээд  
Хүрз барьж өөрийн гараар нүх ухаад  
Хүн чанараа хөдөөлүүлж орхив

Ичгүүр, айдас гэдэг чинь хүн чанар л юм байна” (“Гуравдагч туйл”,р96) гэж хүмүүсийн ичгүүр, айдасгүй болж, хүн чанараа алдаж байгааг үзүүлсэн байдаг.

### **(Дөрөв) Яруу уянгалаг шинж**

Яруу найрагчийн шүлэг төрөх орон зай нь ганцаардал байж мэднэ. Шарайд Дүүрэнжаргалаас ганцаардал гэх сэрэл сэтгэлийг дуу шиг яруу, тунгалаг болгон илрүүлсэн байдаг. Түүний яруу найргийн ганцаардлын орон зай нь өвөрмөц содон байдаг. Тэрний “Ганцаардал” гэх шүлэгт

“Ганцаардал миний бурханлаг орон зай  
Ганцаардал миний тарнилаг цаг хугацаа  
Ганцаардал миний тэнгэрлэг өв хөрөнгө  
Ганцаардал миний тэмүүлдэг газар усан  
Ганцаардал миний хамаг үнэн  
Хамаг үймээнт гадагш алсрахуй  
Дотуур нь  
Бүхэл бүтэн хүний ертөнц  
Ганцаардал миний хамаг ариун анир  
Дотогшоо ариусахуй  
Гадуур нь

Бурхны гэрэл цацарсан найрагчийн сэтгэл! (“Гал улаан ганцаардал”р68) хамгийн эрхэмсэг сүрлэг дээд үгсийн сондорыг хэлхэж, хамгийн агуу их сэтгэлийн мэдрэмжийг бий болгосон гэлтэй. Энд ганцаардал гэдэг үгийн агуулагдахуун тэлэрч, гэгээрэл ухаарлын түвшнийг илрүүлсэн утгатай болж, яруу найрагчийн өвөрмөц оршихуйн түвшнийг тусган харуулж чадсан байна.

### **(Тав) Гүн ухаалаг шинж**

Ертөнц бол эсрэг тэсрэгийн нөгцөлдөл болно. Хүмүүс амьдран орших явцдаа олон зүйлийн эсрэгцлийн хүчсээс зориуд зайлж байдаг. Гэхдээ тэдгээр бултан зайлж байгаа юмс хэрэг бодис нь ерөөс л нүдэн өмнө байж л байдаг. Үнэндээ хүмүүс харанхуй сүүдрээс зугтаж, нүдээ аньдаг боловч, үнэндээ гэрэл гэгээг өөрөөсөө хаацалж байдаг л байжээ. Үүний тухай “Өлгий” гэдэг шүлэгтээ:

“Харанхуйг мартаж гэж нүдээ таг аних  
Харанхуйг биеэсээ үл сэдрээх гэж таг таних  
Аньсан зовхины минь гадна нил гэрэл гэдэгт итгэх

Тийм ээ, бие минь харанхуйн өлгий “Туравдагч туйл”,р92 гэмээн шүлэглэсэн байдаг. БНХАУ-ын гүн ухааны гол чөмгийн нэг нь таван махбодын сургаал болно. Тэрээр “Морины нүд шиг дэлхийдээ би хайртай” гэдэг шүлэгтээ хүн ба байгалийн бүтэн цогц болох мөн чанарыг өгүүлсэн байдаг.

“Уулс ясыг минь чулуугаа зөөллөж бүтээсэн

Голууд цусыг минь усаа бүлээлж нэрсэн

Бороо зүсийг минь үүлэндээ залбиран урлуулсан

Салхи өсөд өөрийг минь өвсөндөө даатган ургуулсан” (“Туравдагч туйл”,р92) гэж хүн бол таван махбодоос бүрэлдэж, орчлон ертөнцтэйгөө нэгдэн оршдог мөн чанарыг танин ухаарч илрүүлсэн байдаг.

Тэр бас “Тэг цагийн шүлэг”-гээ:

“Өнөөдөр биш, маргааш ч биш, өчигдөр бүр ч биш

Энэ л торгон зай дээр би шүлгээ бичиж байна

Цаг хугацааны эхлэл ч юм шиг төгсгөл ч юм шиг

Энэ л агуулгагүй хоосныг би үгээр нөхөж байна (“Гуравдагч туйл”,р35)  
Тус шүлэгт яруу найрагч тэг цаг гэдгээр одоо л цагтаа амьдрахын ухаарлыг илрүүлжээ. Хүний амьдрал гэдэг хэдийгээр өнгөрсөн, одоо, ирээдүй хэмээх цаг, зайн дунд оршиж байгаа төдий боловч, амь насны утга чанар нь зөвхөн одоо агшинд л бүрэлдэж байгаа аж. Тиймээс агуулгагүй хоосныг нөхөх гэдэг нь амьдрахуйн бүх утга агуулга болно. Ерөнхийлөөд үзвэл, Дүүрэнжаргалын шүлгийн санаа дүр нь өвөрмөц онцлогтой байж, одоохоч, модерн үзлийн яруу найргийн олон зүйлийн илрүүллийн арга барилыг бүтээлчээр ашиглан, содон сайхан шүлгийн мөр бадгийг туурвин бүтээсэн байдаг. Түүний яруу найраг нь гадаад ертөнцийг зураглан шүлэглэдэг байснаасаа дотоод сэтгэлийн зүг шимтэн, бясалгалын гүн утгатай, хоосны чанарыг ухааран илрүүлсэн байдаг. Тийм ч учраас залуу яруу найрагч маань сориг сойгоо тэнцүүлж, туурвил бүтээлийнхээ аянд ганзага сайтай аялж байнам!

#### **Ном зүй:**

1. Шарайд Дүүрэнжаргал “Чингис иртэй чулууд”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.2006 он.
2. Шарайд Дүүрэнжаргал “Гал улаан ганцаардал”,үндэстний хэвлэлийн хороо.2013 оны хэвлэл.
3. Шарайд Дүүрэнжаргал “Гуравдагч туйл”, үндэстний хэвлэлийн хороо.2013 оны хэвлэл.

**“ГАРЫН ТАВАН ХУРУУ” КИНО БА ЖҮЖГИЙН ЗОХИОЛЫН  
БҮТЦИЙН ХАРЬЦУУЛАЛ**

*Хасгоо*

*(БНХАУ, Өвөр Монголын их сургууль,  
Монгол судлалын дээд сургууль, доктор, лектор)*

“Гарын таван хуруу” жүжиг 3 бүлэг, 13 үзэгдэлтэй. Зөрчил мөргөлдөөний шинж ба агуулгаар нь авч үзвэл төв жүжиг байж, хэл хэллэг ба илтгэх арга хэлбэрээр нь үзвэл яриат жүжиг, зохиомж хэлбэрээрээ олон үзэгдэлт жүжиг болно. “Жүжгийн зохиолын бүтэц бүрэлдүүнийг судлах нь үзэгдэл тус бүр болон эл учир явдал хоорондын нарийн зохиомжийг судлах явдал болно”<sup>4</sup>. Жүжгийн зохиолын дотоод зүй тогтол, бүтцийг анхааран судлах нь зохиогчийн сэтгэхүйн жам ёсыг гаргахад онцгой үүрэг гүйцэтгэдэг. Эртнээс нааш уламжлан хөгжүүлсэн зохиолын бүтцэд шууд буюу тонгоруу тоочилтын хэлбэр, хаалттай буюу нээлттэй хэлбэр зэрэг байдаг. Хаалттай хэлбэрийн хамаг анхны жүжиг нь Софоклын хувь заяаны эмгэнэлт жүжиг *Эдип Хаан* юм. Хаалттай хэлбэрийн жүжгийн онцлог нь тайзанд гарах дүрийг хамаг бага хэмжээнд хязгаарладаг бөгөөд зөрчил нь нэг хөгөөр дээшлэх жүжгийн үйл явдалтэй, жүжгийн үйл хөдөлгөөний талбар, цаг хугацааг их хялбарчлан үзүүлдэг. Ийм хэлбэрийн жүжигт 19-р зууны Х.Ибсений (Henrik Ibsen) “Хүүхэлдэйнхэн”, 20-р зууны Со Еү-ийн (曹禺) “Аянгат бороо” зэргийг дурдаж болно. Өгүүлэн бей “Гарын таван хуруу” жүжиг нь мөн хаалтат жүжгийн хэлбэрт багтана. Олонх судлаачид жүжгийн зохиолын бүтцийг таван хэсэгт хуваан үздэг, даруй эхлэл, тайлбар, өрнөл, оргил, төгсгөл гэх мэт. Ч.Лодойдамбын жүжгийг найруулсан “Гарын таван хуруу” киног 1982 онд Хөдөлмөрийн Гавьяат Улаан Тугийн одонт Монгол кино үйлдвэр бүтээж үзэгчдэд хүргэжээ. Өгүүлэлд 1982 оны “Гарын таван хуруу” киног сонгосоноо тодорхойлъя.

**Нэг. Эхлэл**

**1. “Гарын таван хуруу” жүжгийн эхлэл ба тайлбар**

Нэг жүжгийн зохиолын эхлэлт нь маш чухал, үйл явдалд хувиралт үүсэхээс яг өмнөх үеийн байдлаас жүжиг эхлэх нь зүйтэй, энэ нь зохиолчийн чадварыг шалгасан асуудал, ерөөс эхлэлт нь байдлыг тушаахаар барахгүй зөрчлийг зохих хэмжээгээр илчлэх үүрэгтэй. Хамаг чухал нь эхлэлт нь дүрийн үйл хөдлөлөөр илрэх ёстой, харин дүрийн үг яриагаар биш, яг энэ нь хүмүүсийн жүжгийн эхлэлт болон тайлбарыг андуу ойлгодог алдаагийн нэг билээ. Ч.Лодойдамбын “Гарын таван хуруу” жүжгийн эхлэлт нь “Хөшигний өмнө

<sup>4</sup> 劳逊 (J.H.Lawson) : 《戏剧与电影的剧作理论与技巧》, 北京: 中国电影出版社, 1980, 275页。

дэгжин хувцастэй тавь эргэм насны эрэгтэй хүн гарч ирнэ. Тэнд тэр хүн зүүн тийшээ инээмсэглэн харлаа. Ажлын хувцастай хорь гаруй насны эмэгтэй гарч ирнэ. Энэ эмэгтэйд эрэгтэй хүн дуудах гэснээ урамгүй болно. Эмэгтэй зогсолгүй явсаар өнгөрнө. Эрэгтэй хүн санаа алдан хойноос нь гунигтай гомдолтой харсаар хоцорно. Эрэгтэй хүний нүднээс нулимс дусалж буй бололтой”<sup>5</sup> гэж эхэлдэг. Шагдар Сүрэнгэй уулзахаар ирсэн боловч Сүрэн түүнийг ойшоосонгүй, Шагдрын царайн хувиралт нь баярлаж байснаасаа нулимс дуслуулж буйгаар төгсдөг, энэ нь бүрэн бүтэн эхлэл төгсгөл бүхий үйл хөдлөлтэй жүжгийн эхлэлт болж чаджаа. Үүнээс болж үзэгчид Шагдар болон Сүрэн хоёр зөрчилтэйг үзэн гарна. Улмаар зөрчлийг зохих хэмжээнд илчилсэн зорилгодоо хүрчээ. Жүжгийн эхлэлд шаардагддаг бас нэг зүйл нь даруй “хувиралтын өмнөх хэсгээс эхлэх” гэдэг ойлголт юм. Уг жүжиг нь Сүрэн болон Шагдрын иймэрхүү зөрчилт харилцааны үүсвэрийг хайх сүвэгч эхлэлтийн хэсэгт гарч ирснээр амжилттай болжээ.

И.В.Гёте (J.W.Goethe) жүжгийн гол дүрийн тухай өгүүлэхдээ “үргэлжилсэн үгийн зохиолын гол дүр хөдлөнгүй бусаар илэрч болно, гэвч жүжгийн гол дүр эрхэвш хөдлөнгүйгээр гарч ирэх хэрэгтэй, учир нь хамаг хэрэг явдал бүр түүнд харш болох хэлбэрээр өрнөнө. Энэ явцад тааралдах бүх харш саадыг арилгана эсгүүл тэр эдгээр харш саадын үрэгдэл болно”<sup>6</sup> гэж тодорхой онолын дүгнэлт өгсөн байдаг. Хөдлөнгүйгээр гарч ирж байгаа Шагдар бол уг жүжгийн гол дүр болохыг эхлэлт хэсэгт тодруулжээ. Жүжгийн тайлбар гэдэг нь олонхдоо дүрийн танилцуулга. Дүрийн гадар байдлын зураглалыг дүрийн үг яриагаар дамжуулан гаргадаг. Жүжигт Хүнчанар (эрэгтэй хүн рүү дохиж) “энэ хүнийг Шагдар гэдэг. Саяны үүнээр өнгөрсөн охин бол Сүрэн гэдэг юм. Уул нь энэ хоёр төрсөн эцэг охин юм шүү. Гэвч Сүрэн Шагдарт хязгааргүй гомдсон хүн дээ”<sup>7</sup> хэмээн Хүнчанар гэх хийсвэр дүрийн үг яриагаар тайлбарыг эхлүүлжээ. Үүнээс болж Хүнчанар дүр тайлбарыг цогцлох чухал үүрэгтэй дүр болж жүжгийн бүтцийн нэг хэсэг болон оролцжээ. Жүжгийн нэг хийсвэр дүрээр тайлбарыг орлуулж байгаа нь зохиомжийн хувьд их шинэчлэлт юм.

## 2. “Тарын таван хуруу” кинь эхлэл

Дэлгэцийн бүтээл бол үзэгдэх байдал, сэтгэлийн хөдөлгөөний илэрхийллийг чухалчилдаг, кино зохиолд мөн эхлэл, өрнөл, төгсгөл гэсэн тогтсон бүтэц байдаг. Киноны бүтэц нь араг яс бөгөөд түүн дээр зохиолынхоо санааг зангидах хэрэгтэй байдаг. “Тарын таван хуруу” кино нь үйл явдлын шулуун тоочилттой, тухайлбал цаг хугацааны дагуу бараг арван жилийн явдлыг хамарчээ. Киноны эхний хэсэгт ерөөс гол дүрийн зорилго, сэтгэл санааны байдал, гуниг зовлон, хүсэл сонирхол зэргийг гаргаж өгдөг, үүнийг кино зохиолчид үйл явдлын “хурдасгагч”<sup>8</sup> гэж нэрлэдэг. “Тарын таван хуруу” кино таван хүүхдийн үзэгдлээр эхэлдэг. Идрийн хамаг хайртай тоглоом модон зарааг тусгайлан үзүүлнэ. Энэхүү модон зарааг Сүрэн “өө, энэ чинь заг модны үндэс

<sup>5</sup> Ч.Лодойдамба, *Түүвэр Зохиол*, УБ, УХГ, 1977, 627-р тал.

<sup>6</sup> 沈炜元: 《阐释戏剧》, 上海: 百家出版社, 2008年, 2页.

<sup>7</sup> Ч.Лодойдамба, *Түүвэр Зохиол*, УБ, УХГ, 1977, 627-р тал.

<sup>8</sup> Дэвид Тройтер, *Кино зохиолчдын библи* (нэмж засварласан 4 дэх хэвлэл), УБ. 2011, 18-р тал.

байна. Ямар өрөвдмөөр юм бэ”<sup>9</sup> гэж хэлсэн нь сүүлэрх хүүхдүүдийн хөөрхийлөлтэй амьдралыг амжилттай урьдчилан тусгажээ. Тухайн анхааруулсан үг нь киноны бүх санааг гаргаж ирсэн. Дараа нь хүүхдүүдээс үзэгдлийг хол руу шилжүүлж тэрэгнээс бууж яваа Шагдар болон Должин хоёр дээр тусгана. Должин “хог дээр байсан ч авахгүй, солиотой юм шиг” гэж хуучны хэрэггүй эдлэл авлаа гэж Шагдрыг зэмлэхэд, Шагдар “хүүхдүүдэд маань хожим нь хэрэгтэй шүү дээ. Должин минь”<sup>10</sup> гэж хариулдаг, үүнээс гол дүр болох Шагдрын сэтгэл санааны байдал нь хүүхдүүдээ хайртай бөгөөд тэдний хожмын тухай бодож сэтгэж байгааг илрүүлсэн. Киноны анхны зураглал маш чухал, үзэгчдэд арвин зүйлийг тодруулж өгдөг, бид дээрх үзэгдлээс “Гарын таван хуруу” киноны хам сэдэв нь хотод амьдарч байгаа гэр бүлийн харилцааны тухай гарахыг олж мэдэх бөгөөд эцэг Шагдар болон эх Должин нь удаан жил хамт амьдарснаас хоорондох харьцаа нь нэлээд цэвдэг болсныг Должны зэмлэлээс үзэн гарч болно.

Дараа нь Шагдар гэр бүлээрээ жүжиг үзэхээр явъя гэж санаачлахад Должин “хүүхдийн юмаар яах вэ. Эднэр үзнэ биз, би чадахгүй”<sup>11</sup> гэж хэлнэ, эндээс Шагдар болон Должны оюун санааны хөөцөлдөл ондоо байхыг гаргажээ. Тэд жүжиг үзэхээр яваад болсон үйл явдал нь киноны анхны эргэлтийн үүсвэр юм. Идэр, Гэрлийн тоглоомыг эвдэлсэн болохоор өмнө үзэгдэлд гарсан модон зараагаа түүнд өгнө гэж амлалаа. Ингэснээс болоод Шагдар, Хорлоотой анх уулзах бөгөөд түүний охин Гэрийг таньж авдаг. Энэхүү үзэгдэлд Идэр “Гэрлийн аав нь нас барьчихсан юм гэнэлэй”<sup>12</sup> гэж ярьснаас Шагдрын тайван байсан амьдралыг нэг тийш хөтлөх цэгийг тавьж өгчээ. Хурдасгагч нь тэнцвэртэй байсан амьдралыг нь хаа нэг тийш хөдөлгөх, гол дүрд шинэ асуудал, хэрэгцээ, зорилго, хүсэл төрүүлэх үйл явдал байх хэрэгтэй, дээр өгүүлсэн үйл явдал уг киноны амжилттай хурдасгагчийн нэгэн болж чаджаа. Дэлгэцийн бүтээл бол үзэгдэх байдлыг харилцан ярианаас илүү үйл хөдлөлөөр илэрхийлэх нь чухал гэж үздэг, тухайлбал амжилттай киноны хэл бүтээвэл киноны уран сайхны онцлог улам сайжирдаг. Эхний хэсэгт Шагдар гэрийн хашаагаа модон бансаар хадан битүүлж байгаа, бага хүү Идэр нь хашааны цаана наадан хоцрон үлдэж байгаа киноны дүрслэлийн хэлээр харуулдаг. Энэ нь цаанаа бэлгэдэл утгатай. Гэрийн хашаа нь Шагдрын гэр бүлийг төлөөлж байх бөгөөд үр хүүхдээ хашааны гадна орхих үйл явдлын урьдлыг бэлгэдэж үзүүлжээ. Шагдар бага хүүгээ оруулахын тулд битүүлсэн хашаагаа эвдэн байж оруулснаас энэхүү хашаа нь сэв суудаг, даруй гэр бүлийн хямрал гарахын бэлгэдэл болжээ. Шагдар, хүүдээ хэлэхгүйгээр модон зарааг нь эзэн мэдэж, Хорлоотой уулзах шалтаг болгож тэднийд авчирч өгдөг, Шагдрын хувинцар сэтгэлийг хүүхдийн гэнэн цайлган сэтгэлтэй харьцуулал болгож энэ үзэгдэлд амжилттай үзүүлжээ. Шагдар Хорлоогийн гэрт орж ирээд дотор өрөөнд сууж байтал үүд тогшино. Идэр орж ирээд хаалганы хажууд зогсон,

“Идэр : эгч ээ. Энэ Гэрлийнх мөн биз дээ?

---

<sup>9</sup> И.Нямгаваа кино зохиолыг бичсэн, *Гарын таван хуруу*, Монгол Кино Үйлдвэр, 1982.

<sup>10</sup> Дээрхтэй адил.

<sup>11</sup> Дээрхтэй адил.

<sup>12</sup> Дээрхтэй адил.

Хорлоо : тийм ээ.

Идэр: би Гэрэлд модон зараа өгнө гэгчхсэн юм. Тэгсэн чинь хулгайд алдчихлаа, би Гэрэлд дараа нь өөр юм өгнө гэж хэлээрэй.

Хорлоо: орооч, миний хүү

Идэр: эгч ээ, би их яарч явна. Ээж намайг талх авуулахаар явуулсан юм. Тэгэхээр нь би наашаа гүйгээд ирлээ. Баяртай гээд хаалгаар гарна.

Хорлоо : аав чинь...

Идэр: аав ажилдаа явчихсана гээд хаалганы цаанаас хэлнэ”<sup>13</sup>. Дээрэх мэт ил тод харьцууллаар арвин санааг тоймчилжээ. Модон зараа нь Идрийн хувьд аавыг нь төлөөлж байгаа бэлгэдэл, энэ нь утга далдалсан үзэгдэл мөртөө нэгдүгээр эргэлтийн цэг. Шагдар, Хорлоотэй нууц амраг болж байгаа том үйл явдал эхлэлт, эхний хэсэг энд хүрээд дуусаж байна.

## Хоёр. Өрнөл

### 1. “Гарын таван хуруу” жүжгийн өрнөл

Өрнөлийн хэсэг гэдэг нь жүжгийн хэрэг учир хувьсаж байгаа хэсгийг зааж байна. Жүжгийн зөрчил үүсэж, улмаар хурцдан, бүхийл жүжгийн үйл хөдлөл нь алхам алхмаар ороолдон оршихыг хэлнэ. Судлаач Х.Лавсон (J.H.Lawson) жүжгийн өрнөлийн хэсгийг дөрөв ангилжээ. “нэг: шийдвэр (зорилго болон зорилгод хүрэх бололцоот чанарын тухай уйлаалт); хоёр: хүчир бэрхшээлтэй нүүрдэх (хүчир бэрхшээл нь олонхдоо тулгарч мэдэх зүйл, учир нь шийдвэр нь хүчир бэрхшээлийн талаар нэгэнт урьдчилсан танилттэй байдаг); гурав: тэсвэр тэвчээрийн шалгалт (зөрчлийн дунд бүх хүчээрээ хүчир бэрхшээлийг хориглох буюу илэн давсны дараа , ялж ялагдахыг ялгаруулах мөч); дөрөв: орхил (хамаг сүүлчийн зорилго илрэх мөч)<sup>14</sup> гэх мэтээр ангилжээ. Жүжгийн өрнөлийг бичих аргын хувьд гуравдугаар зүйл нь “ зайлшгүй талбар” гэгч болно.

#### 1.1 Шийдвэр

Жүжгийн зөрчил илэрсний дараа үзэгдэл болгон дээр бачим байдлыг бий болгож, алхам алхмаар дээш ахиулах чухалтай, уг жүжгийн нэгдүгээр үзэгдэлд Шагдрыг гэрийн улсууд нь хүлээж байгаа нь нэгэн бачим байдалд орсон үйл явдал, дараа нь ямар болохыг хүсэн эрмэлзлэх хүслийг өдөж чаджээ, залгаад хоёрдугаар үзэгдэл нь нэгдүгээр үзэгдлийн тайлбар болсон бөгөөд гол баатар Шагдрын хүсэлт (意志), дарай тэр Хорлоотой амьдралаа холбох гэсэн хүсэлтийг дэлгэжээ.

#### 1.2 хүчир бэрхшээлтэй нүүрдэх

Шагдар дээрх хүсэлтэй болсноос түүнд хэдэн зүйлийн хүчир бэрхшээл тулгарна. юуны урьд тэр өөрийн биеэ хүлээн зөвшөөрүүлж чадахгүй. Дараа нь бодит нийгмийн байдал түүний хийдлийг хүлээн зөвшөөрөхгүй. Түүний гэр бүлийн шахалт нь эцэстээ салж явах зоригийг чангаруулж, тэр гэр орон, эхнэр хүүхдээ орхин явна. Ингэж явсны дараа ямар учир гарна вэ гэж үзэгчид хүсэн

---

<sup>13</sup> Дээрхтэй адил.

<sup>14</sup> 劳逊 (J.H.Lawson) : 《戏剧与电影的剧作理论与技巧》, 北京: 中国电影出版社, 1980, 306页。

хүлээх хүсэлт бий болно. Явсны дараа Шагдарт бас хүчир бэрхшээл тулгана, даруй Хорлоогийн охин түүнийг хүлээн авахгүй болоод зөрчил улам дээшээ өрнөсөөр байна.

### 1.3 зайлшгүй талбар

“Зайлшгүй талбар нь цаг, газар орны талаар оргил хэсэгтэй давхцах талтай ч үүргийн хувьд их зөрөөтэй байдаг, жүжгийн эл дүр тэд нарын зорилго болон бодит байдал хооронд зөрөөтэй байхыг улам тодорхой мэдэрч, улмаар бодит байдлын тухай өөрийн танилтаа дээшлүүлэхээр чармайдаг, энэ нь дүрүүдийг хөдөлгөөнтэй байлгах нөхцөл юм. Чухал мөчид тэдгээр дүрүүд зөрөөгөө таньж мэдэх үес зайлшгүй талбар нь бүрэлддэг”<sup>15</sup>. Уг жүжгийн логкийн зайлшгүй талбар нэгдүгээр бүлгийн дөрөвдүгээр үзэгдэлд гардаг, даруй Шагдар болон Должны ам зөрөлдөж, Шагдар гэрээс явж байгаа хэсэг юм. Сэтгэлзүйн зайлшгүй талбар бас уг жүжигт илрэн гарч ирсэн гэж үзэлтэй, аравдугаар ангид суралцаж байгаа охин Сүрэн аавынхаа орхин явсанд сэтгэл санааны хүндрэлтэй болох нь зайлшгүй, иймээс зохиогч нэгдүгээр бүлгийн долдугаар үзэгдэлд энэхүү сэтгэл зүйн зайлшгүй талбарыг тохируулжээ. Тухайлбал, долдугаар үзэгдэлд Должин нас барсны дараа, Шагдар Хорлоог дагуулан таван хүүхдийнхээ гэрт ирж, Сүрэнгийн хоёр бага дүүг нь тэд аваачиж өсгье, аль эсхүл өргөж авах сайн айл олж өгье гэж хэлжээ. Ингэхэд ерөөс аавдаа гомдолтой байсан Сүрэн, дээр нь дүү нарыг нь авч явах гэхийг сонсоод Шагдарт “манайд худалдах юм байхгүй”<sup>16</sup> гэж хэлэхэд хүүрүүлдэг. Сүрэнгийн сэтгэлзүйн хувиралт илт мэдэгдэнэ.

## 2. “Гарын таван хуруу” кини өрнөл

Эхний хэсгээс өрнөлийн хэсэг рүү орж ирснээс гол дүрд тохиолдох саад, бэрхшээл, зөрчил гаргах бөгөөд дүрийн зан чанрыг томруулж өгнө. Нэрт кино найруулагч Гомбожавын Жигжидсүрэн уг киног “сэтгэхүйн драмын төрлөөр бүтээгдсэн”<sup>17</sup> гэж тодорхойлсон нь өрнөл хэсгийн дүрүүдийн дотоод сэтгэлийн зөрчил, илрэлээс харагдана. Өрнөл хэсэгт Шагдрын Хорлоотой суух гэсэн зорилгод саад болох зөрчлүүдийг гаргасан. Шагдар өөрийн биетэйгээ зөрчилдөнө. Кинонд үүнийг шийдэхдээ толин дотроос Шагдар ганцаар ярьж байгаагаар үзүүлжээ. Энэ бол Шагдрын дотоод сэтгэлийг илрүүлэх нэгэн арга юм. Шагдар Хорлоотой хотын захад зугаалж байхад толинд Шагдрын дүрс гарч “Шагдар аа, юу болж байна. Иймэрхүү юмнаас болоод хэдэн хүүхдүүдэд чинь эмгэнэлт явдал учрах юм биш биз. Бодооч, ухаараач”<sup>18</sup> гэх мэтээр ярьдаг. Кинонд Шагдрын өөрийн биетэйгээ зөрчилдөж байгааг дээрх мэт аргаар шийдвэрлэжээ. Должин, Шагдрын тухай бараглаж байхдаа сэтгэл санааны хувьд илт хувиралт гарсан, киноны эхэнд Должин, Шагдрыг зөвхөн зэмлэдэг байснаас оюун санааны хөөцөлдлийг нь анхаардаггүй байсан билээ. Өрнөл хэсэг хүрэхэд тэр Шагдартай харьцаагаа сайжруулахын тулд зориуд түүнтэй ойртдог. Гэвч Шагдар хүлээн авсангүй. Должин өөрийнхөө орон дээр хэвтээд нулимс урсаж байгаа үзэгдлийг томруулж харуулсан. энэ нь Должны гомдсон

<sup>15</sup> Дээрхтэй адил, 307-р тал.

<sup>16</sup> Ч.Лодойдамба, *Түүвэр Зохиол*, УБ, УХГ, 1977, 635-р тал.

<sup>17</sup> Г.Жигжидсүрэн, *55:25 Сүүдэр шийний хүүхдүүд*, УБ, 2017, 157-р тал.

<sup>18</sup> И.Нямгаваа кино зохиолыг бичсэн, *Гарын таван хуруу*, Монгол Кино Үйлдвэр, 1982.

сэтгэлийг илэрхийлж гаргасан мөртөө Шагдрын сэтгэл санаанд зохих хүндрэл авчирсан. Гэвч Шагдрын Хорлоотой суух зорилго тодорхой учир Должныг ойшоодоггүй. Должин гомдсон учир дахиж өөртөө татахыг болиж байгааг бороотой өдөр Шагдар хариж ирэхэд нь монгол гэрийн үүдээ таг дараад оруулахгүй үзэгдлээр харуулсан. Улмаар Шагдар, Должны сэтгэлийн зай холдож, Должин ч Шагдарт шууд “чи багахан шиг дарлаарай, би чиний явдлыг мэдсэн шүү... өвгөн чи таван хүүхдээ бодвол зүгээр сэн. Харин би тэр хүүхнийг чинь харсан шүү”<sup>19</sup> гэж зөрчлийг хурцатган, Шагдрын шийдэл хийхийг түргэтгэж байна. Үүний дагуу Шагдрын сэтгэлд бас нэг хүндрэл болж болох зүйл нь хорлоогийн өөрийг нь дэвчиж байгаа сэтгэл билээ. Хорлоо “адгуус хүртэл чи бид хоёрыг жигшиж байна. Чи надад энэ үгээ хэлээгүй гэж бод, чи надтай уулзаагүй, учраагүй гэж бод, би тэр хүүхдүүдийн инээдийг уйлах дуугаар солихыг хүсэхгүй байна. Ойлгож байна уу...”<sup>20</sup> гэж хэлдэг. Хорлоогийн сэтгэлийн зөрчил нь Шагдарт авч хэлбэл түүний хүсэл мөрөөдлийн галын очийг улам бадруулах үйлдэлтэй. Түүний зорилго нь улам тодорч, түүний өөрийн биетэйгээ зөрчилдөж байгаа сэтгэлийг бууруулах үйлдэл бас зэрэгцээ бий.

Өрнөлд болж байгаа үйл явдлын зөрчлөө улам хурцатгах хэрэгтэй байдаг, ингэхэд киноны бүтэц дэх чимхүүр, даруй өрнөл хэсгийн үндсэн агшин их үйлдэлтэй. “чимхүүр нь сэтгэл гижигдсэн зохиолын өрнөл хэсгийн урагш хөдөлгөх хүч”<sup>21</sup> болдог. Кинонд Шагдар, Должин хоёр түлээ хагалж түлш бэлтгэж байхдаа салж явах тухай яриа өрнөдөг, Шагдар эцэст нь “юу ч болсон хамаагүй, би Хорлоотой сууна. Гүйцэ !”<sup>22</sup> гэж хэлээд сүхээ модон дээр хүчтэй хатгаад явна. Энэ үед Должны уйлах дуу өндөржих нь хатгасан сүхийн ир модонд биш Должны сэтгэлд тусахыг харуулж чаджээ. Сүрэн гарч ирээд бага үүдийг бөглөн ааваа хориглосонд Шагдар том үүдийг хүчтэй өшиглөөд тэргэндээ орно. Гэтэл тэргээ ноцоох гэсэнээ чадсангүй, яг энэ үед ус түлхэж ирээ дөрвөн хүү нь аавынхаа тэргээ ноцоож чадахгүй байгааг олж үзээд гүйн ирж түлхэж замд нь оруулж өгнө. Тухайн үзэгдлийг судлаач гал голомтоо хаян явж байгаа Шагдрын тэрэг нь ноцохгүй гэдэг киноны дүрслэх хэл мөн гэж үздэг. Уг үзэгдэл бол киноны чимхүүр болно. Үүнийг амжилттай гаргаж чадсан талаар кино найруулагч Г.Жигжидсүрэн “ахуй орчноор киноны хэлэх санааг тодорхойлж, дүрслэлийн хэллэгийг чадварлаг гаргасан хэсэг”<sup>23</sup> хэмээн дүгнэсэн нь бий. Энд хүрээд Шагдрын Хорлоотой амьдрах гэсэн гадаад үйл явдлын зорилго нь биелж байгаа боловч дотоод сэтгэлийн хямрал нь дуусаагүй. Харин ч улам хурц болдог. “кино зохиол бүрийн гадаад дотоод түүх нь өөрийн гэсэн эргэлтийн цэг, бүтэцтэй байдаг”<sup>24</sup>.

---

<sup>19</sup> Дээрхтэй адил.

<sup>20</sup> Дээрхтэй адил.

<sup>21</sup> 劳逊 (J.H.Lawson) : 《戏剧与电影的剧作理论与技巧》, 北京: 中国电影出版社, 1980, 13页。

<sup>22</sup> И.Нямгаваа кино зохиолыг бичсэн, *Гарын таван хуруу*, Монгол Кино Үйлдвэр, 1982.

<sup>23</sup> Г.Жигжидсүрэн, *55:25 Сүүдэр шийний хүүхдүүд*, УБ, 2017, 157-р тал.

<sup>24</sup> Дэвид Тройгер, *Кино зохиолчдын библи* (нэмж засварласан 4 дэх хэвлэл), УБ. 2011, 36-р тал.

“Гарын таван хуруу” кинонд Шагдар, эхнэр хүүхдээ хаяж явсны дараа Должин нас барж, тэр хүүхэдтэйгээ нүүр учрах аргагүй байгааг харуулдаг, Хорлоотой суусан боловч таван хүүхдээ өргөн тэтгэх бодолтой. Гэвч Сүрэн хүлээж авдаггүй учир эцэг охины хооронд зөрчил гарна. Уг зөрчлийг тодорхой харуулсан хэсэг бол Шагдар, Хорлоотой цуг таван хүүхэд дээрээ ирж, тоосонд дарагдсан монгол гэрт орон Сүрэнтэй ярилцдаг.

“Хорлоо -Сүрэн минь, нас чинь бага байна, тэгээд ч олон дүүнэртэй амьдрахад хэцүү шүү дээ. Чи ядаж хоёр бага дүүгээ бидэнд өгчих л дээ. Эгч нь өсгөөд өгье.

Сүрэн - нэг гарын таван хурууны хоёрыг нь огтлох гэж юу ?тийм ч амархан огтлуулахгүй байх шүү.

Хорлоо - хэрвээ чи бидэнд дургүй байвал бид үрчилж авах сайн хүн олж өгье.

Сүрэн - манайд худалдах юм байхгүй, гарцгаана уу даа ?”<sup>25</sup> гэж хэлдэг, харин Шагдар нэг ч үг дугарсангүй боловч орсноос аваад хойморт байгаа Должны хөргийг ширтээр байлаа. Тэр дугуй боловч сэтгэлдээ хямрал тээж яваа азай. Өрнөл хэсгээс төгсгөлийн хэсэг рүү шилжихэд киноны дүрийн гадаад буюу дотоод аль нэгэн талд хямрал гарч төгсдөг, мөнч кино зохиолын хоёрдэх шилжилтийн цэг юм. Тус кинонд Шагдрын дотоод сэтгэлийн хямрал хамаг хүнд илрэх үзэгдэлд шилжилтийн цэг гаргадаг. Энэ нь Шагдар өөрийн гадаад зорилгоосоо болж салж явсан гэртээ дахин ирэх үзэгдлийн хэсэг юм. Уг хэсэгт Шагдар хүнтэй үг ярилцсангүй боловч киноны дүрслэлийн хэлээр гүйцэд илэрхийлж чаджээ. Кинонд эзгүй гэрийн хашаа, салхины аяаар хөдөлж байгаа үүд, онгорхой цонхоор нисэн гарах тагтаа, гэрийн новшийг цонхоор хаяж байгаа хажуу айлын авгай, хамаг чухал нь киноны эхэнд Шагдрын хүрээлэн босгосон гэрийн хашааг хажуу айлын эрэгтэй их ёжтойгоор нурааж байгаа ба Шагдрын хүүхдэд минь хэрэгтэй шүү дээ гэж авчирсан эртний эдлэл □ гуулин шанаг, гуулин суулга нь нохойн идүүр болсон зэрэг нь Шагдрын нүдэнд тусаж байна. Энэхүү үзэгдэлд хашааг нурааж байгаа хажуу айлын эрэгтэйн дүрийн байдал их үүрэг гүйцэтгэсэн. Эрэгтэй хүний сүхээр хашааг нураах үйл хөдлөл нь түүний зан чанарыг илэрхийлж чадах мөртөө Шагдарт өөрийн зүгээс ёжилсон, хошигносон, бүр “хохь чинь” гэж хэлж байгаа мэт үзүүлжээ. Дээрх үзэгдлээр Шагдрын сэтгэлийн хямрал ихсэж , сэтгэлийн тэнхээ нь нурж байхыг үзүүлж чаджээ.

## Гурав. Төгсгөл

### 1. “Гарын таван хуруу” жүжгийн оргил ба төгсгөл

Жүжгийн оргил хэсгийн тухай судлаачид адил бус өнцгөөс тайлбарладаг. Аль нэг нь үнэн гэхэд хэцүү, зохиолчид юуг гол болгохоор тогтоогдоно. Х.Лавсон “хүний дотоод сэтгэлээс урган гарсан шийдвэр буюу зорилгодоо хүрэхийн тулд өрнүүлсэн тэмцэл нь хамаг оргилдоо хүрэх үес, хамаг их бачимдлыг бий болгож, хязгаар даган хүрдэг. Оргил гэдэг бол нэг жүжгийн үндсэн үйл хөдлөл, тэр нь өмнөх бүх үйл явдлын үнэ өртөг ба утга

---

<sup>25</sup> И.Нямгаваа кино зохиолыг бичсэн, *Гарын таван хуруу*, Монгол Кино Үйлдвэр, 1982.

агуулгыг тогтоож дэлнэ”<sup>26</sup> гэж үзжээ. Юуны урьд жүжгийн үндсэн зөрчлийг тодруулах хэрэгтэй, тэгвэл үндсэн үйл явдал тодрон гарна. Үүнийг тодорхой болгосны дараа бусад үйл явдал нь жүжигт ямар үүрэг гүйцэтгэж байх нь илэрч гарна. Үндсэн үйл явдлын тодорхойлол нь оргил хэсэг хаа байгааг илрүүлэх чухал урьдал юм.



Жүжгийн үндсэн үйл явдал бол нэгэн тойрог эргэлтийн шугам юм. Жүжиг анх эхлэхэд Шагдар Сүрэнтэй уулзах гээд зогсож байсан бол өндөрлөхөд мөн яг уг орондоо уулзах гэж хүлээж байна ( зураг мэт.Гэвч цаг хугацааны давтагдашгүй

шинжээс үзвэл эхлэлт төгсгөл нь хэзээд нэг шугамд нийлэхгүй. Гол баатар нь өнгөрсөн амьдралаа эргэцүүлэн бодож байхаар өрнөжээ. Эргэцүүлэх зохиомжийн хувьд зохиогчийн “хугараагүй ноён нуруу” өгүүлэгтэй адил төстэй байдаг. “Түүхийн үүднээс жүжгийг ажиглавал, оргил хэсгийн сонголт нь түүхийн нөхцөлийн хязгаарлалыг хүлээдэг”<sup>27</sup>, тухайлбал түүхэн цаг хугацаанаас нэг хэсэг хугацааг шилэн авч мөн дотроо төгсгөл гаргах гэдэг явдал бол хязгаардмал юм. Түүх хэзээд урагшлахаа зогсохгүй. Уг жүжигт төгсгөл мэт боловч нөгөө түүхийн утгаараа өөр хэрэг явдлын эхлэлт байж мэднэ. Иймээс уг жүжгийн оргил болон төгсгөлийг нэгэн цэг дээр тавьсан нь хялбарчилсан асуудал биш. Жүжгийн үйл явдлын бүтцийн дагуу ийм төгсгөлтэй болох нь зайлшгүй. Олонх Европын нэрт жүжигч оргил хэсэг ба төгсгөл нь давхцуулдаг. Иймээс зарим судлаачид оргил хэсэг нь төгсгөлөөс бага л өмнө байдаг гэсэн дүгнэлт гаргасан байдаг.

## 2. “Гарын таван хуруу” кинэ төгсгөл

Өрнөлийн хэсэгт гол үйл явдал нь Шагдар эхнэр хүүхдээ орхиод явсан үйл явдал юм. үүнтэй дагалдаж гарч ирсэн нь Должин ба хүүхдүүдийн амьдралын үйл явдал болно. Должин нас барсны дараа хүүхдүүдийн амьдрал муудаж, элдэв учир тохиолдоно. Таван хүүхдийн амьдрал улмаар муудах боловч Шагдрын дэмжлэгийг хүлээн авахгүй, үүнээс болж Шагдрын дотоод сэтгэл нь улам хүндрэлд орно. Харин төгсгөлийн хэсэгт кинонд Сүрэн дүүнэртэйгээ хамт олны хүчинд дэгжирч, сайжирч байх гадаад байдлыг үзүүлэх мөртөө Сүрэн өсөн томоожиж, цэвдэг сэтгэл нь зөөлөрч хүнийг хайрлах болж Чулуунтай найзалдаг үйл явдал өрнөнө. Гол дүрийн дотоод, гадаад зорилгоос

<sup>26</sup> 劳逊 (J.H.Lawson)：《戏剧与电影的剧作理论与技巧》，北京：中国电影出版社，1980，205页。

<sup>27</sup> Мөн 339-р тал.

үүссэн үйл явдал нь оргил цэг дээр тодорхой болох хэрэгтэй байдаг. Уг киноны төгсгөлд Шагдар охин Сүрэнтэйгээ уулзах гээд зогсож байгаар төгсдөг. Толин дэхь дүрсээр Шагдрын дотоод сэтгэлийг илрүүлэн гаргасан, кинонд толинд дэхь дүрс “Шагдар чи ямар нүүрээрээ тийш очиж явна. Чи тэдний өмнө ялтэй хүн”<sup>28</sup> гэх бөгөөд өнгөрсөн амьдралаа эргэцүүлэн бодох зуур Шагдар машинтайгаа Сүрэнгийн хуримд явж байна. Хуримын газар хүрч ирээд хамтын зураг авч байгаатай тааралддаг. Хэн нь ч Шагдрыг дуудаж цуг зураг авсангүй, таван хүүхэд л түүний зүг харсан боловч юу ч дугарсангүй, Сүрэнгийн царайн том дүрслэл гарах бөгөөд Сүрэн нулимстай нүдээр түүнийг харж байна. Дээрх үзэгдэл бол уг киноны оргил цэг. Шагдрын хүүхдүүдээ харж чадахгүй халирч байгаагаар өөрийн өнгөрсөн амьдралдаа харамсаж байхыг гаргасан. Сүрэн хурим хийж байгаа жаргалтай агшинд тэр эцгээ дуудаж цуг зураг авсангүй, эцэгдээ гомдсон сэтгэлээс болж хоёр нүднээсээ нулимс бөмбөрүүлжээ. Уг төгсгөлийг судлаач “үзэгчдэд тунгаан бодох бололцоо олгож, эргэцүүлэн ойлгох талаасаа кино сонирхолтой болсон”<sup>29</sup> хэмээн үнэлсэн байдаг. Уг кино Шагдрын үзэл санааны ухаарлаар төгсөж байгаа юм.

#### **Дөрөв. Дүгнэлт**

Ч.Лодойдамбын адил гарцагт жүжиг, киноны бүтцийн харьцууллаар дамжуулж тухайн уран бүтээлийн урлагийн гоо сайхныг адил бус талаас үнэлэх боломжтой.

**4.1 загварын өөрчлөлт:** “Гарын таван хуруу” жүжиг нь Европын жүжгийн уламжлал дэх хаалттай хэлбэрийн бүтцээр зохиомжлогдсон бол кино нь цаг орон зайн хязгаарлалыг хүлээдгээрээ шууд тоочилт буюу цагийн дарааллын хэлбэрээр зохиомжлогдсон. Жүжигт үйл явдлыг тонгоруу тоочилтын хэлбэрээр, даруй Шагдрын эргэцүүлээр дамжуулж гаргахаар зохиомжилсон. Уг загварын адил бус тал нь тухайн урлагийн бүтээлийг илрүүлэх аргын зөрөө юм. Дээр хэсэгт тодруулсан мэт бүхүйл загвар дээр адил бус бөгөөд дотоод зохиомж бас нэлээн зөрөөтэй. Хүнчанар гэдэг дүр нь жүжгийн дотоод зохиомжийн нэг хэсэг юм. Хүнчанар дүрийн гол үйлдэл нь жүжгийн үзэгдлүүдийг холбож өгөх холбоосын үйлдэлтэй. “Гарын таван хуруу” кинонд Хүнчанар гэх дүр гаргахгүй бөгөөд энэхүү зохиомж байхгүй, харин Хүнчанар гэх дүрийг Шагдрын дотоод сэтгэл гэж ойлгосноос Шагдар толинд өөрийн биетэйгээ ярьдаг хэлбэрээр илэрдэг. Жүжгийн зохиолд Хүнчанар гэгч тусгай дүр байх бөгөөд Шагдартай нэгдмэл дүр биш юм. Шагдартай харилцан ярилцах хэлбэрээр тайснаа гардаг.

**4.2 зайлшгүй талбар болон чимхүүрийн ялгаа:** Жүжгийн зайлшгүй талбар нь жүжгийн зөрчлийг хурцатгах, үйл явдлыг нэн урагш ахиулахад нөлөөлөх хүчин зүйл бүхий бүтцийн нэг хэсэг юм. Үүнтэй адилаар чимхүүр нь кинонд адилхан үүрэг гүйцэтгэдэг. “Гарын таван хуруу” жүжигт логкийн зайлшгүй талбар болох үзэгдэл бол Шагдар, Должин болон таван хүүхдээ хаян явж байгаа үзэгдэл. Энэ нь яг кинонд чимхүүрийн хэсэг болж өгдөг. Жүжгийн зохиолд логкийн талаас Шагдарт зайлшгүй тохирох үр дүн болохыг гаргах нь зорилго байсан бол кинонд үрээ хаян явж байгаа эцгийн хатуу сэтгэл, гэнэн

<sup>28</sup> И.Нямгаваа кино зохиолыг бичсэн, *Гарын таван хуруу*, Монгол Кино Үйлдвэр, 1982.

<sup>29</sup> Г.Жигжидсүрэн, *55:25 Сүүдэр шийний хүүхдүүд*, УБ, 2017, 156-р тал.

цайлган үрийнхээ сэтгэлийг харьцуулж гаргах нь зорилго болжээ. Кинонд үйл хөдлөл нэмж, орчин ахуйтайгаа уусалцуулж бүтээсэн киноны дүрслэл нь үзэгчдийн сэтгэлд илүү бууж, сэтгэлийн хүндрэлийг нэмэгдүүлэх гоо зүйн таашаал бий болгосон, харин жүжгийн дээрх хэсэгт харилцан яриа арвин болсноос үйл хөдлөл дутагдсан талтай. Нөгөө нэг зайлшгүй талбар гэж үзэж болох Шагдар, Хорлоо хоёр хүүхдүүд дээр ирж, Сүрэнд хоёр дүүгээ бидэнд өгчих, бид өсгөж өгье гэж хэлдэг үзэгдэл юм. Жүжигт сэтгэл зүйн зайлшгүй талбар болох үндэслэл нь Сүрэнгийн дотоод сэтгэлийн эмзэг байдал ба гадаад төрхийн гэрсүү чанга байдалтай харьцуулал болсон явдал юм. Жүжгийн энэхүү үзэгдэл Сүрэнгийн дотоод сэтгэлийг илүү үнэмшилтэй гаргажээ, мөн ч энэхүү үзэгдэлд Сүрэн шийдэл хийж жүжгийн үйл явдлыг урагш ахиулдаг. Дүрийн өсөлт нь “дүр шийдвэр гаргаж ямар нэгэн алхам хийснээр гарч ирнэ”<sup>30</sup>, жүжигт тусгагдсан Сүрэнгийн сэтгэлзүйг илэрхийлж чадах дотоод гадаад харьцуулал бүхий байдал нь Сүрэнгийн дүрийн өсөлтийг харуулсан. “Гарын таван хуруу” кинонд адил үзэгдэл байгаа боловч Сүрэнгийн дүрийн шийдлийг тодруулсангүй бөгөөд Сүрэнгийн дотоод сэтгэлийн илрэлийн нэг л талыг дүрсэлж гаргажээ, тухайлбал Сүрэнгийн сэтгэлийн гомдол ба ширүүн үг ярианы байдлыг үзүүлдэг. Киноны тус үзэгдэлд Сүрэнгийн дотоод сэтгэл ба үг яриа нь нэгдэлтэй болсон ч дүрийн шийдэл тодорхойгүй болсноос дүрийн өсөлтийг төгс гаргаж чадсангүй талтай. Сүрэнгийн дотоод сэтгэлийн хувирлын жам хууль алдагдахад хүрчээ. Даруй кино төгсгөлийн үе хүрсэн байхад Сүрэн бас Чулууныг хүлээн авахгүй мэт үг яриа гарч ирдэг, жишээлбэл, “Сүрэн □гоё үгийг хэн ч хэлж чадна. Гэтэл чиний нүүрэн дээр ирээдүйн Шагдар биш гэсэн баталгаа алга байна шид”<sup>31</sup> гэж хэлдэг, энэ нь гадаад үйл явдалтайгаа нийцэхгүй байгааг дурдах нь зүйтэй. Дүрийн шийдэл тодорхойгүй болсны бас нэгэн шалтгаан нь кинонд Чулуун гэх туслах дүрийн үйлдлийг гүйцэд бадруулж чадсангүйд оршино. Жүжигт Ялууны яриа Сүрэнгийн дотоод сэтгэлийг хувиргах чухал хүчин зүйл бүхүй үүрэгтэй болж шийдэл хийхэд хүргэдэг.

**4.3 Төгсгөлийг зохиомжилсон аргын зөрөө:** “Гарын таван хуруу” кинонд Сүрэн хурим хийж аз жаргалтэй амьдрал руу алхаж байхаар өндөрлөдөг, жүжигт Сүрэн, дүүнэртэйгээ гэр бүлийн хоол идэж байхаар өндөрлөдөг. Гэвч энэхүү төгсгөлийн уур амьсгал нь адилхан. Кино болон жүжиг бүр Сүрэнгийн гомдолтой сэтгэл, Шагдрыг хүлээн авахгүй байгаа нь дүрслэгджээ. Жүжгийн төгсгөлд Шагдар Сүрэнтэй үг ярихаар ирэхэд нь түүнийг ойшоохгүй зөрөн явж, гомдсон сэтгэлийг нь илтгэдэг, киноны төгсгөлд Сүрэн нүднээсээ нулимс асгаруулж байгаа нь түүний гомдсон сэтгэлийг илэрхийлэх талаар илүү үнэмшилтэй. Төгсгөлийн хэсэг ерөөс зохиолын утга санааг тодорхойлж, дүрийн зорилгыг тодруулж өгдөг учиртай. Кинонд Хүнчанар гэх дүрийг Шагдрын дотоод сэтгэлийн цааварлал болгосноос киноны бүхийл явцад Шагдар өөрийгөө буруутгахаас биш зөвтгөж өнгөрсөнгүй, энэ нь киноны төгсгөлд, Шагдар өнгөрсний үйл явдалдаа харамсахын урьдал болжээ. Иймээс кинонд Шагдар бол ухаарлын дүр, түүний хувь заяа зөв тийш эргэж

<sup>30</sup> Дэвид Тройтер, *Кино зохиолчдын библи* (нэмж засварласан 4 дэх хэвлэл), УБ. 2011, 56-р тал.

<sup>31</sup> И.Нямгаваа кино зохиолыг бичсэн, *Гарын таван хуруу*, Монгол Кино Үйлдвэр, 1982.

байна гэдгийг харуулах зорилготой. Яг судлаач Д.Мягмарсүрэнгийн хэлсэн адил “Шагдар амьдралын эргэлтэд бодол санаа нь өөрчлөгдөж, өөрөө өөртэйгээ тэмцэж, эцэст зөв зам дээр гарч ирж бий хүн”<sup>32</sup> мэтээр харуулсан байна. Гэтэл жүжгийн зохиолд Хүнчанар гэх хийсвэр дүртэй бөгөөд энэ дүр нь нийгмийн ёс суртахууны хэм хэмжээг тусгадаг нийгмийн байр суурьтай. Шагдартай эсэргүүцэж зогсдог нэгэн дүр болохоос биш түүний дотоод сэтгэлийн илрүүлэл биш. Шагдар ч гэсэн биеэ зөвтгөх өөрийн байр суурьтай. Жүжгийн төгсгөлд тэр хүүхэд дээрээ ирж уучлал хүсэх гэсэн нь нийгэмтэй зөрчилдөж байгаа түүний биеийн зөрчлөө шийдвэрлэх нэг арга, харин өөрийн өнгөрсний үйл хэрэгдээ гэмшиж, өнгөрснийхөө бүхнийг үгүйсгэж байгаа биш. Жүжигт Шагдар гэх дүрийн зан төрхийг хар цагаанаар төгс илэрхийлж гаргасан бол кинонд Шагдын үйл явдлын хар талыг л илэрхийлж гаргажээ. Киноны төгсгөл дээр жүжгийн зохиолоос илүү нийгмийн ёс суртахууны өнгө аясыг шингээжээ. Уг жүжгийн эхлэл нь бүрэн бүтэн эхлэл төгсгөл бүхий үйл хөдлөлтэй болсноос жүжиг нь амжилтын эхний алхам сайн тавигдсан хэмээн үзжээ. Өрнөл хэсэгт гол дүрийн хүсэлт, шийдвэр жич түүнд тулгарах хүчир бэрхшээлийг бичихээр дамжуулж, алхам алхмаар жүжгийн зөрчлийг хурцатгах зорилгодоо хүрч чадсан, жүжгийн бүтцийн чухал нэг хэлбэр болох зайлшгүй талбар уг жүжигт хоёр хэсэг бий, нэгдүгээр бүлгийн дөрөвдүгээр үзэгдэл болон нэгдүгээр бүлгийн долдугаар үзэгдэл болно. хамаг чухал нь тус жүжгийн үндсэн үйл явдал бол нэгэн тойрог эргэлтийн шугам бөгөөд жүжгийн оргил ба төгсгөл нь нэг цэг дээр давхцаж бий гэж үзжээ. Киноны бүтцийг гурван хэсэгт хуваан ажигласан юм. Эхлэл хэсэгт гол дүр Шагдын сэтгэл санааны байдал, сонирхол, зорилго зэргийг киноны дүрслэлийн хэлээр чадамгай гаргасан. Өрнөл хэсэгт Шагдын Хорлоотой суух гэсэн зорилгод саад болох зөрчлүүдийг гаргасан. Киноны төгсгөлийг Шагдын үзэл санааны ухаарлаар өндөрлүүлсэн хэмээн үзэж бий.

### Ном Зүй

1. 劳逊 (J.H.Lawson) : 《戏剧与电影的剧作理论与技巧》·北京：中国电影出版社·1980年。
2. Ч. Лодойдамба зохиож, Д.Даржа, Х. Хоногой нар эмхэтгэсэн, *Түүвэр зохиол*, Улсын Хэвлэлийн Газар. 1977 он.
3. 沈炜元 : 《阐释戏剧》·上海：百家出版社·2008年。
4. Дэвид Тройтер, *Кино зохиолчдын библи* (нэмж засварласан 4 дэх хэвлэл), УБ. 2011.
5. И.Нямгаваа кино зохиолыг бичсэн, “Гарын таван хуруу” кино. Монгол кино үйлдвэр. 1982 он
6. Г.Жигжидсүрэн, 55 : 25 сүүдэр шийн хүүхдүүд ,улаанбаатар. 2017 он.
7. Т. Мягмарсүрэн, “Уран дүр бүтээлч сэтгэлгээ”, *Утга зохиол урлаг* сонин. 1983.7.22 , №30.

---

<sup>32</sup> Дү. Мягмарсүрэн, “Уран дүрийн бүтээлч сэтгэлгээ”, Утга зохиол урлаг сонин, 1983.7.22.№30. 2-р тал.

**БНХАУ-ЫН ОРЧИН ҮЕ [ОДОО ҮЕ]-ИЙН ШИЛДЭГ РОМАНЫ  
МОНГОЛ ОРЧУУЛГЫН СУДЛАЛ -I**  
[Зян рун "Чонон сүлд" романы жишээн дээр]

*Jiu Yue*

*(БНХАУ, Бор тохой Их сургууль,  
Хэл бичгийн ухааны доктор)*

*Агуулгын товч: Өгүүлэлд БНХАУ-ын орчин үеийн шилдэг романы төлөөлөл болсон Зян Рун (姜斌)-ы "Чонон сүлд" романы монгол орчуулгын судалгааны байдлыг тодруулж өгсөн байна. Орчуулагч Д.Болдбаатар болон Ван Шю Ин нарын орчуулсан "Чонон сүлд" роман нь орчуулгын онол аргын хувьд баатруудын хоорондох харилцан яриа, үйл явдлын өрнөлийг ихэвчлэн үгчлэн орчуулах аргаар, романы баатруудын бодол санаа, дотоод зөрчил, сэтгэлийн хөдөлгөөн, олон төрлийн уран дүрслэл, мөн үндэстний сэтгэлгээний онцлог бүхий үг хэллэгт голдуу утгачлан орчуулах аргыг ашиглажээ. Мөн түүх, соёл, зан заншлын онцлог бүхий үг хэллэгийг нэмэлт зүүлт, тайлбар хийх аргаар тус тус орчуулсан байна. "Чонон сүлд" роман нь хятад зохиолчийн харь үндэстэн (монгол)-ий дунд, өөр соёл иргэнийн орчинд тодорхой хугацаанд аж төрөн суухдаа тэдний соёл, амьдрал ахуй, үзэл бодол, санаа сэтгэлийг өөрийнхөөрөө танин мэдээд үнэлэн дүгнэсэн, монгол хүний талаар мэдээж авсан ойлголт, үнэлэмжээ уран зохиолын хэлээр, уран дүрээр илэрхийлсэн бүтээл юм. Иймээс энэ нь орчуулагчийн ажлыг зарим талаар хөнгөвчилсөн, орчуулгын чанар сайн болоход нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, монгол үндэстний тухай зохиол учир орчуулагч Д.Болдбаатар уулаас монгол зохиолчийн бичсэн зохиол мэт найруулан орчуулж чаджээ.*

*Түлхүүр үг: Хятадын орчин үеийн шилдэг роман, монгол орчуулга, орчуулга онол арга, орчуулгын судлал шүүмж*

Хятадын уран зохиол түүн дотроо хятад романыг Монгол Улсад орчуулж ирсэн уламжлал, туршлага нь нэн эртний түүхтэй төдийгүй өвөрмөц онцлогтой. Монгол орчуулгын түүхээс үзэхэд хятад хэлнээс их төлөв иргэний чиглэлийн, уран сайхны зохиол бүтээлийг орчуулж иржээ. Энэ уламжлал Юань улсын үеэс эхлэн одоог хүртэл тасралтгүй үргэлжилсээр байгаа төдийгүй энэ хугацаанд арвин их өв, туршлагыг хуримтлуулсан байдаг. Энэ туршлагад үндэслэсэн хятад монгол хэлний уран зохиолын орчуулгын ажил нь 1990-ээд оноос илүү идэвхэжсэн ба шинэ зууны эхэнд БНХАУ-ын гадаад бодлого нээлттэй, өргөн цар хүрээг хамрах болсонтой холбоотойгоор 2000 оноос хойш орчуулгын ажил улам эрчимжжээ. Түүнчлэн орчуулагчдын эгнээ өргөжин, чадвар сайжирсан нь ч үүнд нөлөөлсөн нь мэдээж юм. Үүнээс гадна орчуулагчдын чадвар сайжирч, орчуулгын ажлын цар хүрээ нэмэгдэхийн хэрээр орчуулгын чанарт анхаарах болсон байна. Тиймээс орчуулгын асуудлын ерөнхий сэдвийн хүрээнд болон тусгай зохиолын орчуулгын ур чадварт судалгаа хийсэн бүтээлүүд цөөнгүй гарав. Үүнд, ялангуяа бидний судалгааны

эх хэрэглэгдэхүүн болгон сонгосон Зян Руны “Чонон сүлд” романы талаар эрдэм шинжилгээний өгүүлэл, магистрын зэрэг хамгаалсан бүтээлүүд хэвлэгдэн гарсан байдаг. Үүнийг танилцуулбал:

**Зян Рун “Чонон сүлд”.** Хятад хэлнээс орчуулсан романы талаар гарсан судлал, шүүмжийг ажиглан үзвэл гол төлөв “Чонон сүлд” романы талаар бичсэн нь олонх байна. Энэ нь сэдвийн хувьд монголчуудын ахуй амьдрал, соёлтой илүү холбоотой учир Монгол Улсын уншигчдын анхаарлыг ихэд татсантай холбоотой гэж хэлж болно. Зохиолын талаар утга зохиолч судлаач, шүүмжлэгч Ч.Билигсайхан “*Монгол чонын тухай хятад зохиолчийн сонгомол*” /2011/ өгүүлэл, Ц.Буянзаяа “*Чонон сүлд ба үндэсний оришихуй*” /2013/, Г.Чойжилсүрэн “*Зян Рун, Анатолий Буйлов хийгээд алдагдсан ертөнц*” /шүүмж/, Я.Ганбаатар “*Зян Руны “Чонон сүлд” хийгээд монголчууд бид*” /тэмдэглэл/, М.Энхсайхан “*Чонон сүлд ба Хятадын үндэсний үзлийн тухай*” /Өдрийн сонин №10, 2011.01.02/ зэрэг шүүмж тэмдэглэл бичсэн бол Ван мэн “*Хятадын зохиолч Зян Руны “Чонон сүлд” романы үзэл санаа ба монгол орчуулгын ур чадвар*” сэдвээр магистрын дипломын ажил бичжээ.

Юуны өмнө Г.Чойжилсүрэнгийн шүүмжид уул романыг хэрхэн үнэлж дүгнэснийг авч үзье. Тэрбээр “Чонон сүлд” романыг “*эрт уничихаад дахин сөхөөгүй номоо эргүүлэн унишж байгаа мэт санагдсан*” гэж үнэлжээ. Үүний учир нь “Чонон сүлд” роман Зөвлөлтийн зохиолч Анатолий Буйловын “Их нүүдэл” романтийг ихэр мэт адилхан болохыг онцолжээ. Түүний үзэхээр хоёр романы онцлог нь

1. Хоёр роман бусад реалист зохиолын адил эхлэл, өрнөл, туйл, тайлал, сайн, муу баатад, хөнгөн хошигнолтой, гол баатарт тохиолдож буй толгойтой үс босом аймшиг, гайхалтай зан заншил зэрэг хүний амьдралын өнгө бүрийг үгийн ураар сүлэн илэрхийлсэн.
2. Номуудад гарч буй өөр нэг чухал санаа бол суурьшмал иргэн нүүдэлчин, малчин, анчин иргэдийг удирдаж хэзээ чадахгүй гэсэн үзэл юм

хэмээгээд “Романууд үзэсгэлэнт тал нутаг, хөглөгөр их тайгын унаган хөвгүүд болох өвгөн малчин Билиг, цаачин Аханя нар хүнэн түйрэн (хүн дүрст хөнөөлт шороон шуурга) болох харь элэгтийн өмнө хүчин мөхөстөн бие барж буйгаар төгсөж буй нь хүн төрөлхтний ууган амьдралын хэлбэр болох нүүдэлчид, анчид цагийн эрхэнд суурин иргэншилд идэгдэн, байгаль дэлхийтэйгээ хамт эргэн сэргэхгүйгээр мөхөн сөнөж байгааг бэлгэдэн харуулсан зохиолчдын тайлал юм” гэж дүгнэжээ.

Эрдэмтэн, орчуулагч Я.Ганбаатар “Чонон сүлд” романы тухай “*Энэ ном монгол үндэстнийг, монголчууд биднийг дэлхий дахинаа, хүн төрөлхтөнд дахин нэг удаа нээж өгөв*” хэмээгээд хятад судлаачийн хувьд өөрт төрсөн сэтгэгдлээ ийнхүү хуваалцжээ. Түүний үзэхээр романд дараах хэдэн чухал санааг өгүүлсэн байна. Үүнд:

1. Романы хэлэх гэсэн эхний санаа бол “*Чоно бол байгалийг тэнцвэржүүлэгч*” гэсэн санаа ажээ. Энэ нь бас цаад утгаараа өнөөдөр улам бүр хурцаар тавигдаж, хүн төрөлхтний “оршин байх эсэхийн” шийдэл болоод байгаа хуурайшилт, цөлжилт, цаг уурын өөрчлөлтийн эсрэг, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, байгаль эхийн үр сад болсон

- хүн төдийгүй, адгуус амьтад, тухайлбал хүний, нэн ялангуяа хятад хүний үзэн яддаг “заналт дайсан” - чоныг ч хайрлан хамгаалах маш чухал санааг “байдаг дуу хоолойгоороо” хашхиран хүргэхийг хүсжээ.
2. Харин хэлэх гэсэн удаах санаа нь *“Нүүдэлчид бол чоно. Чоно байгалийг тэнцвэржүүлэгч бол нүүдэлчид хүн төрөлхтнийг тэнцвэржүүлэгч мөн”* гэсэн санаа юм. Энэ бол хүн төрөлхтний түүх судлалд урьд өмнө ч байсаар ирсэн “тэнгэрийн элч, тэнгэрийн гэсгээл, тэнгэрийн ташуур” хэмээх ойлголтын шинэлэг хэлбэр мөн. Шуудхан хэлэхэд зохиогч номдоо хятад үндэстнээ хоньтой зүйрлэж, монгол үндэстнийг чонотой зүйрлэн, ер нь энэ хоёр үндэстний бүх зүйлийг хүмүүсийнх нь зан чанар, ааш аяг, гэсвэр хатуужил, зүрх зориг, зүрхгүй хулчгар байдал, хамаг бүхний, амь амьдралын эх сурвалж, уг үүсгэл болсон байгаль дэлхийтэй зохицон харьцах байдал, хандлагыг ч харьцуулан жишиж өгүүлжээ.
  3. Түүнчлэн зохиогч энэ бүтээлээрээ өнгөрсөн түүхийн бичлэгт, үзэл үнэлгээнд нь цоо шинэ байдлаар, огт өөр өнцгөөс нь харж үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьжээ. Зохиогч эхлээд *“...Хатуухан хэлэх юм бол түүхийн үнэн мөнийг сэргээх асуудал. Тийм болохоор хятадын түүхийг шинээр бичээд зогсохгүй, түүх бичлэгт хувьсгал хийх цаг болсон. Түүх бичлэгт хувьсгал хийхгүй бол Хятад Улс авралгүй болно”* (678-р тал) гэсэн бол удаад нь зохиогч үүгээрээ энэ бүтээлийн анхны уншигчид болох хятад хүмүүстээ, хятад үндэстэнд хандаж, нүүдлийн соёл иргэншил, нүүдэлчин малчин ард түмнүүд, түүний дотор энэ соёл иргэншлийг түүчээлэн авч яваа өнөөгийн монгол үндэстний талаарх тэдний ойлголт, үзэл хандлагыг өөрчлөхийг зорьжээ. Харин олон мянган жил зэрэгцэн оршиж ирсэн Төв Азийн нүүдэлчин ард түмнүүдэд энэ үзэл суртал яагаад хүрээгүй вэ? гэвэл нүүдэлчин ард түмнүүдэд өөрийн гэсэн, хүчтэй үзэл суртал байсан учраас өөр үзэл суртал авах хэрэг байсангүй, тэр үзэл суртал нь бусдынхаас дутуугүй хүчирхэг байсан учраас тэднийг өөрийн хүрээнд оруулалгүй, хөндөлдөн зогсоор иржээ. Тэр бол Зян Рун зохиолчийнхоор бол чонон сүлд, судлаачдын дунд хэвшсэн нийтлэг нэр томъёогоор бол чоно шүтлэг, чоно шүтээн мөн. Нүүдэлчдийн үзэл суртлыг чоно шүтлэг гэж нэрлэх нь дутуу, явцуу байж болох бөгөөд, зүй нь энэ ойлголт нь нүүдэлчдийн үндсэн, өнө эртний сэтгэлгээ болсон Тэнгэрийн үзэл юм.

Эцэст нь тэрбээр *“Романы үндсэн утга агуулга, үзэл санаа нь хоёр зүйл дээр төвлөрч байна. Нэг нь байгаль хамгаалах үзэл санаа бол нөгөө нь хүний нийгмийг хамгаалах үзэл санаа юм. Бүр тодотговол эн тэргүүнд, онгон дагинаараа үлдсэн дэлхийн сүүлчийн тал нутаг Төв Азийн их хээр талыг, улам бүр цөөрсөөр байгаа талын хөх чоныг хайрлан хамгаалахын хамтаар хүн төрөлхтний ууган аж төрөх ёс болсон нүүдэлчин малчин амьдралыг, түүнд үндэслэсэн нүүдлийн соёл иргэншлийг хамгаалан хадгалж үлдэх явдал авай”* хэмээн зохиолыг дүгнэсэн байна. Мөн зохиолч Ц.Буянзаяа *“Чоно сүлд”* романы талаар *“Чонон сүлд ба хонин сэтгэлгээ”* нэртэй шүүмж-өгүүлэл нийтлүүлсэн нь уншигчдын дунд маргаан дэгдээсэн учир өөрийн бодол эргэцүүлээ тайлбарлан *“Чонон сүлд ба үндэсний оршихуй”* нэртэйгээр хэвлүүлжээ. Тэрбээр зохиолын үзэл санааг дараах хэдэн өнцгөөс тайлбарлажээ. Үүнд:

1. Зян Рун “Чонон сүлд” романдаа монголчуудын өөрсдийнх үнэлдэггүй, бүдүүлэг харанхуйд тооцдог оюун санааны далд ертөнцийг нь, амьдрах чадварыг нь хятадын ард түмэн ашиглах ёстой шүү гэдгийг байн байн сануулсан байх юм. Дэн Шяо Пиний “Нээлттэй хаалганы бодлого”-оор богино хугацаанд эрчимтэй хөгжиж чадсан Хятад оронд өнөөдөр оюун санааны шинэ чиг баримжаа зайлшгүй хэрэгтэй болсон, олон жил тус улсын хөгжлийн бодлогыг тодорхойлж ирсэн коммунист үзэл санааных нь чиг баримжаа явцгүй болон мухардалд орсон гэдгийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сүүлийн үед багагүй өгүүлэх болсон. Тиймээс Хятадын сэхээтнүүд улс орныхоо хувь заяанд анхаарлаа хандуулан ирээдүйн хятад үндэстэн оюун санааны ямар чиг баримжааг барьж оршин тогтнох вэ гэдэгт санал бодлоо уралдуулаад эхэлжээ. Зохиолч Зян Рун ч энэ хандлагад анхаарлаа чиглүүлэн Хятадын уламжлалт Күнзийн номлолын сул талыг монголчуудын чоно мэт идэвхтэй амьдрах чадвараар нөхөн байж хүчирхэг улс хэвээр байна гэдэг үзэл санааг дэвшүүлсэн байна. Энэ бол “Чонон сүлд” романы амин чухал үзэл санаа юм.
2. “Чонон сүлд” романд хадгалагдаж буй бас нэгэн чухал үзэл санаа бол хятад хүн бол нүүдэлчин цусны угшилтай, тэрхүү цусандаа байгаа хэв шинжээ сэргээн шинэ түвшинд гаргаж өөрсдийн оюун санааны чухал бүрэлдэхүүн хэсэг болгох ёстой гэсэн үзэл юм. Тиймээс Зян Рун эх орон нэгтнүүддээ хандан монголчууд нь зэрлэг бүдүүлэг түүхтэй, дайнч түрэмгий шинжтэй, соёл боловсрол муутай хүмүүс боловч хятадын түүхэнд төдийгүй хүн төрөлхтний түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тиймээс ирээдүйд монголчуудын тэрхүү гайхамшигт шинжийг бид үндэснийхээ эрх ашигт нийцүүлэн ашиглахын тулд монголчуудын ёс заншил, сэтгэлгээ, ахуй амьдралыг хамгаалж үлдээх ёстой юм. Хэрвээ өнөөдөр хятадууд өөрсдийнхөө нэгээхэн хэсэг болсон нүүдэлчдийн ахуйг үгүй хийчихвэл хожим бидэнд нөхөж боломгүй гарз болно шүү гэдгийг номлон сургасан нь “Чонон сүлд” романд нь илэрхий тусгалаа олжээ.
3. Үүнээс гадна “Чонон сүлд” романы далдад нуугдан буй нэгэн чухал асуудал бол Хятадын түүхэнд цусан зам татуулан үлдсэн улаан хамгаалагчдын үеийн туслах малчдын дүр төрхийг эерэг байдлаар дүрслэн үзүүлсэн явдал юм. Энэ тухай “Чонон сүлд ба хонин сэтгэлгээ” шүүмж өгүүлэлдээ дурдсан байгаа. Улаан хамгаалагчдын үед жирийн монгол малчин “Хятадын бодлого”-ыг шүүмжилнэ гэдэг бол тухайн үедээ бол байж боломгүй зүйл юм. Гэтэл тэр нь өнөө цагт “Чонон сүлд” романд уран зохиолын аргаар гоёчлогдон өгүүлэгдсэн явдал хэмээхэд хэтийдэхгүй гэдэгт итгэлтэй байна. Үүнийг миний хувьд өөрийн эх орондоо хязгааргүй хайртай Зян Рун зохиолч эх орныхоо түүхийн нэгэн бараан үеийг гэгээн сайхнаар хулдан өгүүлэхийг чухалчилсан гэж ойлгож байгаа юм

гэж дурджээ. Тэрбээр эцэст нь “Хятадын зохиолч Зян Рун нь “Чонон сүлд” романдаа өөрийн эх орныхоо хувь заяанд санаа тавин улс үндэстнийхээ ирээдүйн төлөө хүчирхэг оюун санааны оршихуйг шинээр бүтээх ёстой, тэгэхдээ нүүдэлчдийн амьдралын гүнд нуугдан буй сэтгэлгээг ашиглан хонь мэт ноомой байдлаа чоно мэт хүчирхэг болгон төлөвшүүлэх ёстой гэсэн үзэл

санааг дэвшүүлсэн гэдэг нь илтэд анзаарагдах байх аа гэж найдаж байна. Мөн түүнчлэн хүн төрөлхтөнд аюул гамшиг тарьсан атомын бөмбөгийн хөнөөлийг ч өөрийн улс үндэстэнд тусаа өгсөн гэж зоригтойгоор хэлж чадаж байгаа нь түүний Хятад эх орныхоо төлөө гэсэн амин халуун сэтгэлийнх нь илэрхийлэл болж байна гэдгийг анзаарч байгаа байх аа гэж итгэж байна” хэмээн дүгнэсэн байдаг.

Тэгвэл утга зохиолч судлаач, шүүмжлэгч, профессор Ч.Билигсайхан романы уран сайхны талаар ийнхүү бичжээ. Романд Монголын тал, малчин монголчууд, тэнгэрийн хийморьлог амьтан чоно, монгол гэрийн нохой, монгол морь, тэр дундаа монгол азарганы тухай гайхамшигтай сайхан дүрслэл олон. Зян Рун хэдийгээр хятад үндэстний зохиолч боловч монгол нүүдэлчний амьдрал, түүний нарийн ширийн нууц, тал нутгийн эмзэг атлаа өгөөмөр хөрс шороо, ан амьтан зэргийн учрыг гайхалтай нарийн дүрсэлжээ. Монгол адуу чоныг хөөж, чонотой тэмцэн, энэхүү тэмцлийнхээ хүчинд чухамдаа жинхэнэ хүлэг морь болдог гэдгийг романд тун ч чадварлаг үзүүлсэн байна. Түүнчлэн эмзэг нарийн, нимгэн хөрс бүхий Монгол нутаг хүүхдийн зулай мэт хэврэг, тэгсэн атлаа соргог шимтэй өвс ногоо, тунгалаг сайхан ус бэлчээрийн хүчээр үеийн үед тэнгэрийн хөх чонын ивээл дор оршсоор ирсэн юм гэдгийг романд нэн сайхнаар дүрсэлжээ. Зохиолын төгсгөл рүү Зүүн үзэмчин хошууны энэ их тал нутагт хятадын суурин тариачид нэвтрэн орж хөрс шороо, ан амьтдыг нь чухам л урвуулж орхих аж. Зохиолч энэ тухай дүрслэлийг сэтгэл шимшрүүлэм үнэмшилтэй харуулсан байна. Энэ романы уран сайхны талаар олон зүйл өгүүлж болох боловч энэ удаа азнаж тал нутаг, монголчууд, чоно гурвын тухай үүнээс илүү тод, уран бичнэ гэдэг бараг боломжгүй зүйл болохыг ухаарав гээд “Чонон сүлд” романы монгол орчуулгыг “Д.Болдбаатар орчуулагчийн хэл найруулга, ахуй байдлыг мэдрэх хэл, хэллэг нэн хурц оновчтой тод гарсан нь “Чонон сүлд” романыг монгол уншигчдад нэн сэтгэл таатай хүлээн авах шалтгаан болжээ”<sup>33</sup> хэмээн дүгнэсэн байна.

Зян Руны “Чонон сүлд” роман нь уншигч, судлагч шүүмжлэгчдийн анхаарлыг татаад зогсохгүй, зохиолын үзэл санаа, орчуулгын асуудал нь энэ чиглэлээр суралцаж буй магистр, докторуудын сонирхлыг ихэд татах болсны жишээ нь Ван Мэнгийн бичсэн “Хятадын зохиолч Зян Руны “Чонон сүлд” романы үзэл санаа ба монгол орчуулгын ур чадвар” /Уб., 2012/ магистрын зэрэг горилсон бүтээл юм. Тэрбээр “Чонон сүлд” романтай холбоотой олон асуудлыг түүн дотор зохиолчийн намтар, роман бичигдэж хэвлэгдэхэд нөлөөлсөн хүчин зүйл, зохиолын үзэл санаа, түүхэн үндэс, онцлог болон уншигч судлаачдын сэтгэгдэл шүүмжлэлийг судалсны зэрэгцээ романы Өвөр Монголд гарсан, Монгол Улсад гарсан хоёр орчуулгад задлан шинжилгээ хийж тус тусын онцлогийг гаргажээ. Судалгааны ажлын дүнд тэрбээр:

1. Чонон сүлд романыг бичих болсон шалтгаан нь ӨМӨЗО-д малчдын дунд арван нэгэн жил амьдран нүүдэлчдийн тухай төдийгүй чоно гэдэг амьтны талаар сонирхон судалсан нь зохиолын сэдэл санаа болсон.

---

<sup>33</sup>Ч.Билигсайхан “Монгол чонын тухай хятад зохиолчийн сонгомол бүтээл” -Утга зохиолын шүүмжлэл /бүтээл туурвилын эмхэтгэл/ Уб., 2022, х.220-224.

2. 2004 онд зохиолоо хэвлүүлсэн нь зохиолчийн хувийн боломж, нөхцөл байдлын тохироо, мөн цаг үеийн өнгө аяс, уншигчдын эрэлт хүсэлтийг мэдэрсэнтэй холбоотой.
3. Романаараа дамжуулан дараах хэдэн гол үзэл санааг илэрхийлсэн. Үүнд:
  - Нүүдэлчдийн соёл иргэншил хэдийгээр олон мянган жил оршин байгаа ч энэ нь эх байгальтайгаа нягт холбогдсон, дасан зохицох арга ухаан тул үүнийг хоцрогдсон гэж үзэж болохгүй.
  - Чоно нь тал нутгийн малчдын амьдралд ахуйд чухал нөлөөтэй, монголчууд дэлхийг байлдан дагуулсан гайхамшигт ялалтад чонын тулаан элдэв арга түүхэн гавьяатай байсан гэж үзсэн.
  - Суурьшмал амьдралд ч бас дутагдалтай зүйл байдаг, өрсөлдөөн багатай тайван хөдөлмөр нь хятад хүмүүсийг сул дорой болгосон тул хүчирхэг байхын тулд чононоос суралцах, эх дэлхийгээ хайрлах хамгаалах арга ухаанд суралцах хэрэгтэй.
  - Өвөр Монголын тал нутгийн бэлчээр ус сүйдэхэд Хятадын төрийн алдаатай бодлого нөлөөлсөн гэх зэрэг болно гэжээ.
4. “Чонон сүлд”-ыг баримтат уран зохиол гэж үзэхэд учир дутагдалтай, харин уран сайхны бичвэр гэж үзээд түүнд зохиомол өгүүлэмж, уран хэтрүүлэг, орон зай ба цаг хугацааны шилжилт зэрэг романд уран сайхны дүр бүтээх, дүрслэх элемент давамгайлж байж болохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.
5. Зохиолд өгүүлэгдэх чоно нь байгалийн бодит чоно бус харин зохиолчийн “үзүүлэхийг хүссэн чоно” гэж ойлгох ёстой. Чоноор дамжуулан байгаль орчны сүйрэл, хүн амын хэт өсөлт, төвлөрөл зэрэг асуудлыг хөндсөн. Зохиолчийн дэвшүүлсэн зарим үзэл санаа өнөө цагт их ач холбогдолтой. Гэхдээ нөгөө талаар зохиолч үзэл санаагаа илэрхийлэхдээ түүхийг хэтэрхий дураараа ашиглах хандлага ажиглагдсан бөгөөд асуудлыг өрөөсгөл талаас нь авч үзэн учир шалтгааны хувьд алдаа гаргасан байна.
6. Уг романы хоёр орчуулгыг харьцуулж үзвэл Д.Болдбаатарын орчуулга Өвөр Монгол орчуулгыг ашигласан бөгөөд арга барил, ур чадварын хувьд Өвөр Монгол орчуулгаас илүү сайн болсон. Орчуулагч хятад, монгол хэлийг маш сайн эзэмшсэн тул орчуулгаа монгол уншигчдын сэтгэлгээнд нийцүүлэн яруу сайхан найруулах тал дээр нэлээн их анхаарал хандуулсан гэж дүгнэжээ.

Энэ бүхнээс үзвэл, БНХАУ-ын орчин үеийн шилдэг романы төлөөлөл болсон Зян Рун (姜绒)-ы “Чонон сүлд” романы монгол орчуулгын судалгааны байдлыг тодруулж өгсөн байна. Орчуулагч Д.Болдбаатар болон Ван Шю Ин нарын орчуулсан “Чонон сүлд” роман нь орчуулгын онол аргын хувьд баатруудын хоорондох харилцан яриа, үйл явдлын өрнөлийг ихэвчлэн үгчлэн орчуулах аргаар, романы баатруудын бодол санаа, дотоод зөрчил, сэтгэлийн хөдөлгөөн, олон төрлийн уран дүрслэл, мөн үндэстний сэтгэлгээний онцлог бүхий үг хэллэгт голдуу утгачлан орчуулах аргыг ашиглажээ. Мөн түүх, соёл, зан заншлын онцлог бүхий үг хэллэгийг нэмэлт зүүлт, тайлбар хийх аргаар тус тус орчуулсан байна. “Чонон сүлд” роман нь хятад зохиолчийн харь үндэстэн (монгол)-ий дунд, өөр соёл иргэншлийн орчинд тодорхой хугацаанд аж төрөн

суухдаа тэдний соёл, амьдрал ахуй, үзэл бодол, санаа сэтгэлийг өөрийнхөөрөө танин мэдээд үнэлэн дүгнэсэн, монгол хүний талаар мэдэж авсан ойлголт, үнэлэмжээ уран зохиолын хэлээр, уран дүрээр илэрхийлсэн бүтээл юм. Иймээс энэ нь орчуулагчийн ажлыг зарим талаар хөнгөвчилсөн, орчуулгын чанар сайн болоход нөлөөлсөн байна. Өөрөөр хэлбэл, монгол үндэстний тухай зохиол учир орчуулагч Д.Болдбаатар уулаас монгол зохиолчийн бичсэн зохиол мэт найруулан орчуулж чаджээ.

### **НОМ ЗҮЙ:**

Ч.Билигсайхан “Монгол чонын тухай хятад зохиолчийн сонгомол” /2011/ өгүүлэл,  
Ц.Буянзаяа “Чонон сүлд ба үндэсний оршихуй” /2013/,  
Г.Чойжилсүрэн “Зян Руи, Анатолий Буйлов хийгээд алдагдсан ертөнц” /шүүмж/,  
Я.Ганбаатар “Зян Руны “Чонон сүлд” хийгээд монголчууд бид” /гэмдэглэл/,  
М.Энхсайхан “Чонон сүлд ба Хятадын үндэсний үзлийн тухай” /Өдрийн сонин №10,  
2011.01.02/  
Ван мэн “Хятадын зохиолч Зян Руны “Чонон сүлд” романы үзэл санаа ба монгол орчуулгын ур чадвар”

**В.ИНЖАННАШИ (1837-1892) БОЛ XIX ЗУУНЫ МОНГОЛЫН  
СОНГОДОГ ЗОХИОЛЧ МӨН**

*Liu Yue*

*(БНХАУ, Өвөр Монголын НШУА,  
Хэл судлах газарын ЭШАА,  
МУБИС-ийн докторант )*

*Агуулгын товч:* Алдарт зохиолч В.Инжаннаши бол, Монгол бичгийн зохиолын туурвил зүйн сэтгэлгээний орчинд анх удаа уран зохиолын бүхий л төрлөөр эн тэгш уран бүтээлээ туурвисан зохиолч болсон бөгөөд түүх нийгэм, гүн ухаан, байгалийн болон хүний дотоод сэтгэлийн утга уянга, нийгмийн шүүмжлэлт сэтгэлгээ зэрэг цаг үеэ үнэлэн туурвисан бодит үнэлэмжийг буй болгож чадсан байна. Ийм учраас түүний уран бүтээл нь Монгол утга соёлын биеэ даасан томоохон үзэгдэл болж байна. “Зохиолч” хэмээх мэргэжлийн хөдөлмөрийг буй болгож, анхны шан үндэс үрийг нь суулгаж өгчээ. Энэ бүхний үр дүнд нийгмийн соён гэгээрүүлэгч сонгодог зохиолчийн үүргээ төгс гүйцэтгэсэн зохиолч - нийгмийн бие хүн болж чаджээ. Үүнд В.Инжаннашийн уран бүтээл гол гавьяа, үнэ цэн нь оршиж байна. Тийм учраас монгол утга зохиол, бичгийн зохиолын үе үеийн судлаачид, гадаад дотоодын олон эрдэмтэн В.Инжаннашийг Монголын сонгодог зохиолч болохыг хүлээн зөвшөөрч, шинэ шинэ судалгаа хийсээр байна. Тэгвэл сүүлийн үед В.Инжаннашийн зохиол бүтээлийг хэл шинжлэлийн үүднээс, зохиолын хэл найруулга, онч мэргэн цэцэн үгс, дүр дүрслэл, зохиолын хэлний уран яруу хэрэглүүрийг хэрхэн үүдэн бүтээсэн байдал, үгийн сангийн онцлог зэргийг анхаарах болов. Өгүүлэлд эдгээр асуудалд нарийн дүн шинжилгээ хийж үнэлэн дүгнэсэн байна.

*Түлхүүр үг:* В.Инжаннаши, сонгодог зохиолч, сонгодог зохиол, XIX зууны бичгийн зохиол

Аливаа зохиолчийн уран бүтээлийг судлахдаа, тухайн нийгмийн орчин, түүхэн цаг үетэй нь холбон судлах нь гарцаагүй билээ. Ингэхийн тулд юуны өмнө, тухайн зохиолчийг жинхэнэ зохиолч болоход нь нөлөөлсөн байж болох, нутаг ус, өвөг дээдэс эцэг эх, ах дүүс нь ямар хүмүүс байсан, багш сурган хүмүүжүүлэгч нь хэн байсан, нийгмийн ямар орчинд хүмүүжин төлөвшсөн зэргийг нь анхааралтай ажиглан судлах ёстой болдог. Энэ үндэслэлд тулгуурлан В.Инжаннашийн нийгмийн орчин, түүнийг жинхэнэ сонгодог зохиолч болоход нөлөөлсөн нөлөөллийн талаар авч үзвэл, дараах байдалтай байна. Үүнд:

**В.Инжаннашийн гэр бүл:** В.Инжаннаши нь сурвалжит, язгууртан гэр бүлээс гаралтай, тэр цаг үе нийгмийнхээ *элит*<sup>34</sup> орчны нэгэн төлөөлөгч байжээ. Түүний аав Лхаванноровын Ванчинбал (1794-1847) багаасаа монгол, хятад шастир бичиг уншиж хүмүүжсэн *төрийн зүтгэлтэн*<sup>35</sup>, *цэргийн жанжин*<sup>36</sup>, яруу найрагч, хүүрнэл зохиолч хүн байв. Тийм болохоор Ванчинбал хятад, манж, дорно дахины шүлэг зохиол нэвтэрхий мэддэг, их соёлтой, боловсрол сайтай хүн байлаа. Монгол, хятад, төвд, манж хэлний олон номын цуглуулга бүхий баялаг номын сантай, энэ баялаг оюуны өвөө үр хүүхдүүддээ уншуулж, зааж, сургаж, дагуулдаг байв. Чухамдаа “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар” бол Ванчинбалын эхэлж бичсэн бүтээл бөгөөд тэрээр 1830-1840 оны үед эхний 8 бүлгийг нь бичсэн байдаг.

Инжаннашийн ээж Манюушка (1802-1875) мөн язгууртны гэр бүлээс гаралтай, гэрийн сургуулиар багаасаа хүмүүжин төлөвшсөн, монгол, хятад бичгийн хэлийг гарамгай эзэмшсэн, монгол, хятадын түүхэн судар товчоог судлан, бичгийн сургаалтны шүлэг номыг унших дуртай хүн байжээ. Манюушка Күнз, Мэнзийн сургаал, Гэрийг засах сургаал, Хүүхдээ сургах ёсныг мэддэг, зураг зурдаг, ардын аман үлгэр ярих дуртай, цээж сайтай, ерөөсөө л утга соёлын боловсрол сайтай байлаа. Ийм учраас Ванчинбал, Манюушка нарын гэр бүлээс Гуларанс, Гүнначуг, Сүнвэйданзан, Инжаннаши зэрэг Монгол утга зохиол, бичиг соёлын нэрт төлөөлөгчид төрөн гарсан байна.

Гуларанс (1820-1955) бол шүлэгч, түүхч, орчуулагч, яруу найрагч, бичгийн гүн утгач хүн болсон учраас монгол хэл, хятад хэл, түүх, үлгэр домогт их сайн, байгалийн үзэмж, гоо сайхныг хүний дотоод сэтгэлийн нарийн өнгө аястай хослуулан илэрхийлсэн “Анх намар”, “Намрын салхин”, “Өвлийн үзэмж”, “Цагийн хур”, “Хаврын бороо”, “Намар”, “Тунгалаг зун” зэрэг олон уянгын шүлэг бичсэн нь алдаршжээ. Орчуулагчийн хувиар тэрээр хятадын эртний сонгодог роман “Сүн улсын хүйтэн уулын бичиг”, “Тансан ламын баруун этгээдэд зорчсон нь”-г орчуулж байжээ. Тэгвэл Гүнначуг (1832-1866) нь

---

<sup>34</sup>Италийн социологич В.Парэтогийн дэвшүүлсэн үзэл. Орчин үеийн улс төр судлалд, социологийн онолд элитийг (франц. elite, латинаар: eligere, сонгох, ялгах) харьцангуй их хэмжээний эд хөрөнгө, эрх ямба, улс төрийн эрх мэдэл, ур чадвар эзэмшдэг хүчирхэг хүмүүсийн жижиг бүлэг гэж тодорхойлж байна. Харин Кембрижийн толь бичигт “Бусад хүмүүстэй харьцуулахад хамгийн сайн эсвэл хамгийн хүчирхэг гэж тооцогддог хүмүүс. Боловсрол чухал үүрэг гүйцэтгэдэг, маш сайн зохицуулалттай оршихуй юм.” [“*TYPEI definition in the Cambridge English Dictionary*”. [dictionary.cambridge.org](http://dictionary.cambridge.org).] гэж тайлбарласан байна.

<sup>35</sup> Ванчинбал хошуу нутагтаа Туслагч тайжийн алба хашдаг байв. Түүний намтарт 1837 онд хааны зарлигаар Хүрээ хошууны ламын заалдлагыг шүүн тасалсан гэж тэмдэглэсэн байдаг.

<sup>36</sup> 1840 онд Хятадад “Хар тамхины дайн” дэгдэхэд, хошууныхаа монгол цэргийг толгойлон, Англичуудын эсрэг дайнд оролцож, Ин Кеү хотын хавьд түүний удирдсан монгол цэрэг дайсанд цохилт өгч, алдаршиж байжээ. Бас Төр гэрэлтийн 22-р он [1842]-д Английн цэрэг умарш түрэн орохыг сэргийлэхийн төлөө тус хошууны ноёд цэргээн дайчлан зарлиг хүлээж, боомтын ойролцоо газар буудаллан суухад Ванчинбал удирдагч жанжин нь байв. Дайны дараа өмнөд хятадад цэргийн алба хашиж байгаад, 1847 оны үед нутагтаа эгэн иржээ.

шүлэгч, эрдэмтэн, уран зураач болсон бөгөөд багаасаа бичиг сурч, монгол, хятад ном уншин, шүлэг бичиж, зураг зурдаг байсан гэдэг. Гүнначугийн туурвил зүйн онцлог нь тэрээр зөвхөн уран бүтээлийн ажил эрхэлсэнгүй, монгол, хятад шүлгийн үндэсний өвөрмөц онцлогийг зэрэгцүүлэн тайлбарлах болон “Улаан асрын зүүд”, “Садрыг цээрлүүлсэн уянга”, “Авлахыг хориглох уянга”, “Шүлгийн тухай өгүүлэл” зэрэг шүүмж тэмдэглэл бичиж, яруу найргийн онолын талаар судалгаа хийж байсан юм.

Сүнвэйданзан (1834-1898) нь мөн яруу найрагч, орчуулагч, түүхч болсон. Бага наснаасаа ах нартайгаа монгол, хятадын бичгийн зохиол, түүхийг ихэд сонирхон уншин судалж, монгол, хятад, манж, төвөд хэлэнд нэвтэрсэн байна. Сүнвэйданзангийн туурвил зүйн өвөрмөц тал нь дорно дахины *хэмжээт шүлэг*<sup>37</sup> бичих туршилтууд хийж байсан явдал болно. Тэрээр тав, долоон үгийн хэмжээт шүлэг ба тасархай, тасархай бадгууд бичиж байлаа. Тиймээс Инжаннаши “Хөх судар”-ын нөхвөр дэвтрийн зарим бүлгийн өмнө Сүнвэйданзан ахынхаа шүлгүүдээс оруулсан байдаг. Сүнвэйданзан орчуулгын төрөлд амжилттай ажилласныг, ах Гүларансынхаа дуусгаж амжилгүй үлдээсэн “Хүйтэн уулын бичиг”-ийн монгол хэлний орчуулгыг гүйцээн дуусгасан болон хятадын алдартай их түүхийн бичгийн зохиол “Тун Жян Ган Му”-г орчуулснаас нь мэдэж болно. “Ган му” бичгийн орчуулга нь, Инжаннашид “Хөх судар” романаа бичихэд маш их тус дөхөм болсон байна.

Ванчинбалынхны шүлэг яруу найраг, хүүрнэл зохиол, онол шүүмжийн өгүүлэл хийгээд уран зургийн бүтээлүүд нь дорно дахины хэв шинжийг хадгалсан, суурьшмал аж төрлийн ахуй байдал амьдралын үнэнийг илүүтэй дүрсэлсэн, хүний мөн чанар, ёс суртахууны тал руу гүн хандсан, гүн ухаан, уянгын ухаарал, танин мэдэхүйн шинжтэй, цаг үе, нийгмийнхээ шүүмжлэлт чиглэл бүхий соён гэгээрүүллийн өвөрмөц содон, нэн торгомсог уран тансаг туурвилууд байдаг юм.

Гэр бүлийн ийм орчин, уур амьсгалын дунд өсөж, төлөвшсөн болохоор Инжаннашийн ирээдүйн замнал тодорхой байлаа. Тэр тусмаа сурвалжит язгууртан тайж угсааны ноён хүн өөрийн отгон хүүгээ хэрхэн хүмүүжүүлж, ямар хүн болгон төлөвшүүлдэг тэр цагийн тогтсон зан үйл хэвшлийн нэг мөн. Тийм ч учраас Ванчинбал Инжаннашийг 5 нас хүрмэгц гарал үүсэл удам угсааныхаа угийн бичгийг цээжлүүлж, 10-тайд нь монгол, хятад, манж, төвд дөрвөн хэл бичиг заалгажээ. Инжаннаши ч дөрвөн бичигт маш хурдан нэвтэрч, монгол судлал болон хятад судлалаар гүнзгий боловсролтой болж, өөрийн эрхгүй шүлэг зохиол бичиж, уран зураг зурах болов. 17 настайдаа нагацын тал болох Харчин Баруун хошууны засаг төрийн Дүүрэн ван Цэвэгдоржийн ордонд байсан ба энэ үеийнхээ амьдралаас сэдэвлэсэн “Улаан үүлний нулимс” зохиолоо бичжээ. Мөн уран зургийн хамт туурвисан “Хөх хад”, “Цагаан үүл”,

---

<sup>37</sup> Эртний Хятад, Япон, Солонгос, Төвөдийн утга зохиолд тус, тусын үндэсний онцлог, сэтгэлгээний хэв маяг бүхий шүлгийн өвөрмөц тогтолцоо бий болжээ. Энэ нь мөр доторх үеийн тоог журамлан тогтоох (3 мөр ба үеийн тоо нь заавал 5-7-9 байх (хайку), мөр бүрийн үгийг 6 үеэр жигдлэх (ши жин) ... гэм) байдалд, өөрөөр хэлбэл хэмжиж болох нэгжид суурилсан байдаг.

“Эйрэг сайраг хэдэн иш хулс” зэрэг шүлгүүдээ бичжээ. Эндээс ганцхан “Цагаан үүл”-ийг онцлон үзэхэд шүлэгт

*“Холхи ууланд цагаан үүл ургаж  
Хорголзон эвхрэлдэн хөх огторгуйд орвой  
Хумьж дэлгэхүйд бүтэх эвдрэх дагалцан  
Хурж сарнихуйяа өөрийн эрх үгүй  
Хурц гэрэл наранд хандсаны шалтгаан  
Хурднаа тасрах салхинаа хийсэгдэхийн харгай  
Хурамхан зуур лус лугаа уулзваас  
Хувхай бодисыг шимтэй болгон чадмуй”<sup>38</sup>*

хэмээн дүрсэлжээ. Энэ шүлэг бол энгийн нэгэн хэмжээт шүлэг биш юм. Яагаад гэвэл шүлэгт амьдралын зөрчил тэмцлийн зүй зохист өрнөл, өөрчлөл, шинэчлэл, улирал хувьсал хөгжлийн логикийг харуулсан юм. Өөрөөр хэлбэл тухайн цаг үе, нийгмийн зан дадал өөрчлөгдөн хувирч, шинэчлэгдэж буй агшинг, оршин буй соёл шинэ соёлоор, амьдралын хэвшил, шинэ хэв маягаар солигдож буйг үзүүлсэн, ийм учиртай шүлэг байна. Тэгэхээр “Цагаан үүл” шүлэгт агуулсан санаа нь тун гүнзгий бөгөөд үүгээрээ Монгол бичгийн утга зохиолын хөгжлийн цаг үеийг зааглаж өгч буй ач холбогдолтой бүтээл болсон байна.

Арван долоон настай залуу хүүгийн, нийгмийн өөрчлөл, солигдлыг бясалган таньсан ухаарал гэхэд үнэхээр гайхамшигтай. Учир нь эл бүтээлд зөвхөн монгол хүнд л хамаарах оюун сэтгэлгээний зүйлийг бус, нийт хүн төрөлхтөн, хүн, нийгмийн амьдралын утга учир, ёс суртахуун, эрхэмлэн дээдлэх үнэт зүйл, түүх соёл, гүн ухаан, үйлийн үрийн үзэл санаа, хүнлэг энэрэнгүй чанар энэ бүхнийг нэгтгэн, нэгэн бүхэл болгон, цогцоор нь дэвшүүлсэн байгаа юм. Шүлэгт нийгмийн зөрчил, хөгжил хөдөлгөөний асуудлыг ингэж чадамгай гаргаж чадсан нь нэг талаас хувь хүний онцлог, нөгөө талаас тухайн нийгмээс хувь хүнд хандах хандлагатай холбоотой гэж үзэж болно. Ингэж Инжаннаши утга зохиолын түүхэн хөгжлийн явцын нэгэн цаг үеийн заагийг тогтоон, шинэчлэлийн өөр нэгэн үеийг эхлүүлж чадсаны үндэс суурь нь түүний гэр бүлийн орчиндоо түүх судар судлан суралцаж, бясалган ухаарч байсан тэр цагт тавигдсан бөгөөд тийнхүү өөрийгөө хөгжүүлж чадсаны үр дүнд нийгэм цаг үеэ философийн үүднээс ингэж зөв танин мэдсэн байна.

### **В.Инжаннашийн уран бүтээлээ туурвин байх үеийн нутаг орон хийгээд нийгмийн нөхцөл байдал, гадаад, дотоод орчин:**

XVIII, XIX зууны үеийн Өвөр Монголын Зостын чуулганы Түмэд Баруун хошууны Шударга бат хороо буюу В.Инжаннашийн төрж өссөн газарт тариалангийн соёл буюу суурин иргэншил, мал аж ахуйн соёл буюу нүүдлийн соёл иргэншил хоёрын хооронд үл таарах зөрчил мөргөлдөөн хүчтэй өрнөж байв. Нэг талаас малын бэлчээрийг нь хагалаад, тариа ногоо тарина. Нөгөө талаас үүнийг нь эсэргүүцэж, газар нутгийнхаа төлөө, нутаг усаа хайрлаж хамгаалж тэмцээр иржээ. Тийнхүү түүхэн цаг хугацааны нэгэн үе өнгөрөхөд

<sup>38</sup> Инжаннаши В. *Цагаан үүл*. – “Монгол уран зохиолын дээжис - I боть”. Эрхлэн, эмхэтгэж редакторласан Л.Хүрэлбаатар. Уб.,

Түмэд нутаг нь нүүдлийн болон суурин соёлын аль алиныг нь хүлээн авч нэвтрэлцсэн, нийлэгшсэн, хоёр соёлын дундын шинж чанар бүхий өвөрмөц бүс нутаг болжээ. Чухам энэ үед буюу XVIII зууны эхэн үеэс хятадын эртний түүхэн сонгодог зохиол, адал явдалт роман бичгийн зохиолыг орчуулах ажил эрчимтэй өрнөж, улмаар хятадын эртний сонгодог романууд нь ардын дунд аман хэлбэрээр, үлгэрч хуурчдын тоглолтоор дамжин түгэн дэлгэрч эхлэв. Тодруулбал, бичигтэн ардын таашаалыг татсан “Жүн дагинын тууж”, “Тансан ламын үлгэр”, “Жийдаан хуушааны намтар”, “Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл”, “Нэгэн давхар асар”, “Улаан асрын зүүд” зэрэг олон шилдэг зохиолын орчуулга шил, шилээ даган гарч иржээ. Эдгээр романыг уншсан билиг авьяас төгөлдөр ардууд, сонсон тогтоосон үлгэрч хуурчид бие биендээ хачир чимэг нэмж ярьж өгдөг<sup>39</sup> зэрэг үгийн урлагийн шинэ төрөл зүйлүүд буй болсон байна. Ард түмэн аман зохиолын энэхүү шинэ төрөл зүйлийг өлгийдөн авахад нь эртний баатарлаг туульсын зохиолын аялгуулан хайлдаг уламжлалт арга, хөг эгшиглэн, хөгжмийн зэмсэг тэргүүтэн нь угаас олон түмний оюуны амьдралд бэлэн байсан учраас эл шинэхэн төрөл соёлон хөгжих шимтэй хөрс нь болсон гэж хэлж болно. Үүний зэрэгцээ “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Шар тууж”, “Асрагч нэртийн түүх” Рашпунцагийн “Болор эрих”, “Болор толь”, Мэргэн гэгээний “Алтан товч”, Саган сэцний “Эрдэнийн товч”, Галдан туслагчийн “Эрдэнийн эрих”, “Монгол боржигид овгийн түүх” зэрэг монголын сонгомол түүхэн бүтээлүүд Өвөр Монгол, Халх, Дээд Монгол, Буриадын нутгаар ихэвчлэн гар бичмэл хуулбараар тарж байлаа. Монгол нэгдсэн төр бутран сарниж, их хааны үеийн нэгдсэн төрийн бүхий л газар нутаг Манж чин улсын эзэмшилд орсны дараагаар монголчуудын тусгаар тогтнол эрх чөлөөний сэтгэлгээ ахин оргилон буцалж Чингис эзэн хааны үеэ хүсэмжлэх явдал монгол бичгийн мэргэдийг эзэмдэж эхэлсний тодорхой нотолгоо нь эдгээр товчоо, эрих, толь юм.

Тэгвэл гадаад орчинд, Испани, Голланд, Англи, Франц гэх мэт өрнөдийн улс орны колони байсан латин америкийн бүс нутагт үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөн амжилтад хүрч, Чили, Аргентин, Мексик, Перу, Бразил зэрэг биеэ даасан тусгаар улсууд байгуулагдаж байлаа. Хими, физикийн шинжлэх ухааны шинэ шинэ нээлтүүд үйлдвэрлэлд нэвтэрч, тээвэр харилцаа холбоонд технологийн дэвшил гаран, энэ нь үйлдвэрийн том хотууд хөгжих таатай нөлөөг үзүүлэх болов. Төмөр зам тавигдаж усан болон уурын хөдөлгүүрт тэрэг буй болж, дотоод шаталтын хөдөлгүүр, цахилгаан эрчим хүч ашиглах болсон зэрэг аж үйлдвэрийн 1, 2-р хувьсгал Ази, дорно дахины ард түмний ахуй амьдралд ч ямар нэг хэмжээгээр хамааралтай байж, нөлөөгөө үзүүлсэн нь В.Инжаннаши, нийгмийн амьдрал, түүний мөн чанарыг цаг үеийнхээ үүднээс шинээр танин мэдэж, ухааран, уран бүтээлдээ гүн сэтгэмж, далд утгаар дүрслэн өгүүлэх бололцоог олгосон нэгэн сэжим нь болсон гэж хэлж болно.

Үүнээс гадна гадаадын уран зохиолын орчинд, өрнө дорнын улс түмэнд хүн нийгмийн үнэн бодит амьдралыг хэзээ хэзээнээс давуулаг уран яруу

---

<sup>39</sup> Үүнийг судлаачид хятад хэлний “本子” [бэнз] буюу “дэвтэр” гэдэг үгнээс үүдэлтэй аман зохиолын шинэ төрөл “Бэнсний үлгэр” гэж нэрлэдэг

үзүүлсэн реалист шинж чанартай зохиол энд тэнд цойлон гарч ирж, чухам уншигчдаа “байлдан дагуулж” эхэлсэн байна. Тухайлбал хүн нийгмийн амьдралын дотоод ертөнцийг билгийн нүдээр өнгийж харж, дүрслэн бичиж чадсан адал явдалт зохиолын том төлөөлөгч английн зохиолч Майн Рид (1818-1883), Америкийн алдарт зохиолч, өгүүллэгийн мастер Марк Твейн (1835-1910), Энэтхэгийн нэрт зохиолч нийгмийн зүтгэлтэн Рабиндранат Таагүр (1861-1941) зэрэг олон гайхамшигт зохиолчдыг нэрлэж болно. Энэ мэт бодит амьдралын уран сайхны тусгал болсон агуу зохиол бүтээлийн алсын тусгал ч В.Инжаннашийн уран бүтээлийн төлөвшил, түүхэн романы туурвил зүйд эрхбиш нөлөөлсөн байх учиртай. Энэ бүхнээс үзвэл: “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Шар тууж”, “Асрагч нэртийн түүх” Рашпунцагийн “Болор эрх”, “Болор толь”, Мэргэн гэгээний “Алтан товч”, Саган сэцэний “Эрдэнийн товч”, Галдан туслагчийн “Эрдэнийн эрх”, “Монгол боржигид овгийн түүх” зэрэг монголын сонгомол түүхэн бүтээлүүд болон *“үнэн болсон явдал бодитой хүнийг гол баатраа болгосон маягтай мөртлөө нэлээд уран сайхны зүйлээр чимэглэн зохиосон “Монголын Убаши хун тайжийн тууж”, Ойрадын “Хув нагваралын тууж” маягийн бүтээлүүд хожуу үед гарах болсон нь Инжаннашийн түүхийг бичих шинэ эрмэлзэл хандлагын холын тусгал гэж үзүүштэй”*<sup>40</sup>.

Хятадын түүхэн роман болон Монгол ардын бэнсэн үлгэрийн жаяг дэг маяг, түүний туурвил зүй, уран сайхны сэтгэлгээний байдал, уран дүр бүтээх арга, уран сайхны зөрчил байдал зэргийн нөлөөлөл, хаялгаар В.Инжаннаши монгол бичгийн утга зохиолын түүхэнд анх удаа романуудаа туурвиж иржээ. Тухайн цагийн шинжлэх ухаан, техник, технологийн хөгжил дэвшил, хүн нийгмийн үнэн бодит амьдралыг хэзээ хэзээнээс давуулаг уран яруу үзүүлсэн реалист шинж чанартай зохиолын алсын тусгал В.Инжаннашийн уран бүтээлийн сэтгэлгээнд эергээр нөлөөлсөн гэж үзэж болно. Үүнээс үзвэл уран бүтээлийн уламжлал шинэчлэл, харилцаа холбоо гэдэг бол маш холын цуурайг дараа дараагийнхаа үедээ дамжуулж явдгийн нэг жишээ гэж хэлж болох юм.

#### **Монгол бичгийн утга зохиолд В.Инжаннашийн хийсэн шинэчлэл:**

В.Инжаннаши утга зохиолын бүхий л төрөл зүйлээр уран бүтээлээ туурвиж, оршин асан нийгэм цаг үеийнхээ толь болж чадсан зохиолч юм. Учир нь тэрээр анхны шүлэг яруу найргаараа л утга зохиолын түүхэн хөгжлийн туурвил зүйн сэтгэлгээний нэгэн шинэ цаг үеийг эхлүүлсэн юм. Ийм шүлгийн нэг болох, дээр онцлон өгүүлсэн “Цагаан үүл” шүлгийг судлаачид өндөр үнэлдэг.

*“Холхи ууланд цагаан үүл ургааж  
Хорголзон эвхрэлдэн хөх огторгуйд орвой  
Хумьж дэлгэхүйд бүтэх эвдрэх дагалцан  
Хурж сарнихуйяа өөрийн эрх үгүй  
Хурц гэрэл наранд хандсаны шалтгаан  
Хурднаа тасрах салхинаа хийсэгдэхийн харгай  
Хурамхан зуур лус лугаа уулзваас*

<sup>40</sup> Билигсайхан Ч. Ухаарахуй. Уб., 2014, х.151.

*Хувхай бодисыг шимтэй болгон чадмуй”*

Шүлгийн гүн ухааны сэтгэмжийг доктор С.Байгалсайхан: “... үүл огторгуйд хөвөн хөөрөн явах нь хэнээс ч юунаас ч үл шалтгаалж байгаа ба нарны хурц гэрэл, хүчтэй салхины улмаас учир шалтгааны хэлхээ холбоонд орж, дараагийн юмс үзэгдэлтэй харьцах чанартай болж байна. Энэ нь нарны гэрэл хүчтэй салхины нөлөөгөөр лустай учран газар дэлхийг норгох бороо болон сав шим ертөнцийг ундаалах эх үндэс болох”<sup>41</sup> гэж тодорхойлсон бол, профессор Л.Хүрэлбаатар: “... ер юмны салах хагацах бүтэх эвдрэх хууль зүй, байгаль нийгмийн аливаа үзэгдлийн мөн чанарыг зөвхөн илрэх хэлбэр төдийгөөс нь бус, дотоод агуулгын шалтгаант тал, түгээмэл хэлхээ холбооны салишгүй нэгдэл дунд нь авч үзэх сэтгэлгээний гүнзгийрэл буюу ямар нэг өөрийн эрхгүй нийгмийн доторх эмгэнэлт хувь заяаны далд битүү санааг агуулжээ”<sup>42</sup> хэмээн тайлбарлажээ. Тэгвэл:

*“Уянгат модонд үүрлэсэн хос болжмор хамтаар өссөн бөлгөө*

*Учрал нь муу болоод нэгэн болжмор хол нисэж одвой*

*Уйтгарлан хоцорсон өрөөсөн болжмор ханиасаа салаад*

*Урт шөнө эгишглэн уйлавч хэрэгсэх хүмүүн үгүй”*

хэмээх “Хос болжмор” шүлэгтээ байгальд хандах хүний сэтгэлийн харьцаагаар амьдралын ханьсах ижилсэхийн баяр жаргал, хагацах салахын уйтгар гунигийг гайхалтай урнаар гаргаж, хэнд ч үгүйлэгдэмгүй, хэний ч санамгүй тэр хоёр хөөрхий болжморын бие биенээсээ салан одсон явдлыг хүний амьдралын бүхэл бүтэн утга учир дээр өргөн гаргаж, хувь заяаны өрөвдөлтэй эмгэнэлтэй дэнсэн дээр хэмжиж цэгнэснээрээ хүнлэг энэрэнгүй үзлийн уянгат дуулал болсны дээр эчнээ далд утгаараа мөн үеийнхээ нийгмийн хүн хүндээ хандах сэтгэл санааны булингар хирийг хүчтэй шүүмжилсэн байна. Энэ бүхэн бол түүний шүлгүүд сонгодог бичгийн яруу найраг болсны баталгаа болох юм.

В.Инжаннаши “Саран хөхөөний шастир” хэмээх хайр дурлалын сэдэвтэй жүжиг бичсэн байдаг. Жүжгийн гол дүр болох Лин Жү бол 18 настай, язгууртан залуу юм. Тэрээр “Жүн Дэ Фү” нэрт ордонд ээж Тянь Фү Рэний хамт аж төрдөг байв. Удалгүй Лин Жү садан төрлөө даган нийслэл хотод хүрч ирэв. Нийслэлд ирээд Лин Жү, нэгэн вангийн охин Чи Жу хэмээгчийг харснаас хойш мөрөөдөн санах болж, шөнийн зүүдэндээ түүнтэйгээ учран жаргадаг байжээ. Удалгүй Лин Жү нутагтаа буцах болж, аян замдаа Ан Юань гэгчтэй вантай санамсаргүй таарч явах болов. Гэтэл энэ ван нь дурлалт бүсгүй Чи Жугийн эцэг нь байсан ба Ан Юань вантан, хээнцэр цэвэрхэн, эрхэмсэг цовоо Ли Жүг ихэд тоон ордондоо дагуулан авчирч охинтойгоо суулгахаар шийджээ. Гэтэл вантаны охиныг өөрийн хайрт Чи Жу байсан гэдгийг Ли жү үнэндээ мэдээгүй байжээ. Энэ зуур хүүгийн ээж Тянь Фү Рэн, хүүгээ Ү Иүй гэгч охинтой суулгахаар зуучийн хүмүүстэй хэлэлцэн тохироод байв. Ийнхүү энэ хэдэн язгууртан залуус бүгд дотроо өөр өөрийн хайр сэтгэлт хүнээ болон өөрсдийгөө өрөвдөн бодож, өрх гэрийн толгойлогч нарын үзэл, хүслээр шийдсэн хуримын

<sup>41</sup> Байгалсайхан С. *Өрнө дорнын гүн ухааны үүднээс монгол утга зохиолын ур чадварыг тодруулах нь (Инжаннашийн зохиолын жишээн дээр)*. – Олон улсын монголч эрдэмтдийн VII их хурал. Уб., 1997.

<sup>42</sup> Хүрэлбаатар Л. *Улайх униарын өнгө гэрэл*. – “Огторгуйн цагаан гарди”. Уб., 1995.

явдалд сэтгэл зовничноож байв. Сүүлдээ сэтгэл гутран Чи Жү, Ү Иүй хоёр охин өөрийн хайр дурлалд үнэнч байхын төлөөнөө амиа егүүтгэхээр шийдсэн байв. Ингээд тогтсон өдөр ирж, хурим болоход шинэ өрөөнд нүүр уулзангуутаа байдал огт өөр тийш эргэжээ. Чухам эмгэнэл зовлон нь баяр баясал болон хувирч байгаагаар зохиол төгсөж байна. Судлаачид уг бүтээлийг Инжаннаши, Харчин вангийн ордонд учирсан хайр дурлалын амьдралаасаа эх үндэс авч бичсэн гэж үздэг. Жүжгийн үнэ цэн нь орчин үеийн амьдралын драм, түүний зөрчлийг урнаар илэрхийлснээрээ шинэлэг бүтээл болсон байна.

В.Инжаннашийн гол зохиол нь романууд нь болно. Тэрээр 26, 27-тойдоо “Улаан үүлний нулимс” романаа туурвив. Уг роман бол монгол утга зохиолын түүхэнд хамгийн анхны, бичгийн зохиолчийн бие дааж туурвисан аж байдлын роман бөгөөд зохиолд харчин вангийн ордон дахь амраг хайрын амьдралаа өгүүлжээ. Нийт 42 бүлэгтэй гэх боловч 24 бүлэг нь уламжлагдан үлдсэнээс 15 бүлэг нь бүрэн ажээ. Инжаннаши уг романаа мөн харчин вангийн ордонд өнгөрүүлсэн амьдралаасаа сэдэвлэн бичжээ. Зохиолын гол баатар “Ру Иүй” буюу “Ру Ин” бол Инжаннашийн өөр нэг хятад нэр “Бо Ин” гэдэгтэй таардаг. Өөр нэгэн баримт бол нэлээн нас ахисан хойноо бичсэн нэг шүлэгтэй: “Улаан үүлний нулимс” дахь “Ру Иүй Күнз болбоос ... Инжаннаши болой” гэж бичсэн байдаг. Зохиолд доорд давхраатны язгууртан гаралтай Ру Иүй Күнз, Бе вангийн ордонд очсоноос явдал нь өрнөж байгаа нь харчин вангийн ордонд аж төрж байсантай нь нэлээд төстэй ажээ.

“Улаан үүлний нулимс” романд өгүүлэмжээ дараах хоёр шугамаар өрнүүлжээ. Нэг нь Ру Иүй, язгууртны охин Зи Шу хоёрын хайр дурлал. Нөгөө нь Ру Иүй, Зи Шугийн шивэгчин охин Чи Юүн хоёрын хайр дурлалын асуудал. Эндээс Ру Иүй, Чи Юүн хоёрын харилцаа нь чухал байр эзэлдэг. Тиймээс Чи Юүны “Чи” нь “улаан” гэсэн үсэг болно. Тиймээс “Чи Юүн” бол “Улаан үүл”, “Улаан үүлний нулимс” бол “Чи Юүны нулимс” ажээ. Романы гол дүрүүд Ру Иүй, Чи Юүн, Зи Шу, Ша Жин, Ан Жүань, Жин Зи нар нь эрдэм мэдлэг, ёс боловсролтой, залуу насны цог золбоогоо бадруулж буй сэргэлэн залуус учир эцэг эх, гэрийн толгойлогч, ахмадын мэдлээр шийдэгдэх уламжлалт ураг барилдах ёсны хүлээсэнд үл өртөн, харин ч өөрийн амьдралынхаа жижигхэн ч атугай эрх чөлөөт орон зайд ухамсартай, ухамсаргүйгээр эрх чөлөөт дурлал хайрандаа согтуурч байна. Эцэстээ Зи Шу охин нас барж, шивэгчин охин Чи Юүн насан өндөр болсон, нөгөө нэг шивэгчин охин Чиян Вей нь Зи Шугийн үхэлд холбогдоод, шоронд байхдаа өлсгөлөн зарлан үхсэнээр зохиол төгсдөг.

1864-1865 оны үес Инжаннаши “Нэгэн давхар асар” романаа туурвижээ. Романд өөрийн эцэг эхийнхээ ураг төрлийнхний элдэв зөрчлийн талаар өгүүлжээ. Инжаннашийн ээж Манюшка ихээхэн зовлон амссан хүн байжээ. Судлаачид уг романыг гэр бүлийнхээ дотоодын зөрчлийг эерүүлэх гэсэн зорилгоос үүдэлтэй гэж үзсэн байдаг. Харин энэхүү романыхаа үргэлжлэл болсон “Улаанаа уйлах танхим” романаа Манюшкаг нас барсны дараа дэлгэрүүлэн бичжээ. Энэ хоёр зохиолд Пү Иүй, Лү Меи, Чин Мө, Шен Рү зэрэг залуусын хайр дурлал, ухаарал, хувь заяагаа холбосон хуримын баяр баясал, уйтгар гуниг, учрал хагацал, тэдний амьдралын төлөөх тэмцэл, хоорондын зөрчил тэмцлийг харуулжээ. Зохиолын гол баатар дөрвөн залуу хоорондоо нагац төрлийн холбоотой, багаасаа хамтдаа өсчээ. Идэр залуу насанд хүрмэгц

тэдний дунд аяндаа охид хөвгүүдийн хайр дурлалын сэтгэл үүсчээ. Гэтэл тэдний эцэг эхчүүдийн дунд, ялангуяа Пү Иүйгийн гэр бүлийнхэнд дотоод зөрчил гарчээ. Пү Иүйгийн ээж Жин Фү Рен нь уян зөөлөн зан аальтай, ач охин Лү Меид илүү хандаж, хүүгийнхээ эхнэрийг болгохыг хүсэх бол, эмэг эх То, эцэг Вей Хөү нар нь зээ охин Шен Рүг бэр болгохоор тогтжээ. Гэр дотор ийнхүү санал зөрөлдөөн үүсэн байх үед Дүн бей Жүны Сү бэйс охин Сү Жигээ Пү Иүйтэй суулгах хүсэлтэй байгаа хэлэв. Ингээд Пү Иүй хэдийгээр дургүй байсан ч чин сэтгэлийн хайраа өгсөн Лү Меигээсээ хагацаж, Сү бэйсийн ордонд хүрч, Сү Жийг буулган авчирчээ. Тэгтэл Сү Жий гуниглангуй дүнсгэр болохоор хэдхэн жилийн дараа өвчилж нас нөгчив. Ийм явдал болж байх зуур Лү Меи, Чин Мө, Шен Рү нар цөм эцэг эхийн шийдсэнийг эсэргүүцэн тэмцжээ. Лү Меигийн эх Гү овогт, охиноо зүс царай туйлын муухай, өөрөөс нь 30 гаруй ах нэгэн харийн арилжаачны эхнэр болгохоор шийдсэнийг дуулаад амиа егүүтгэхээр шийдэж байтал, шивэгчин охин Хуа Мейгийн тусалснаар эр хүний хувцас өмсөн зугатаажээ. Чин Мөгийн эцэг, эх нь түүнд Сан Ян Сианы шадар ноён, хэдийгээр нас ойролцоо боловч үлэмж муухай төрсөн, зэрэмдэг эртэй суулгах болсонд, хуримлах замдаа гол руу үсэрч, золоор Неи Ге Шүэ Ши гэгч хүн аварч амь хэлтрэв. Шен Рүгийн эх нь охиндоо нэгэн өвчин эмгэгт баригдсан айлын залууг эр болгон сонгож өгсөн боловч өнөөх залуу нь хуримнаас өмнө нас барж, залуугаараа бэлэвсэрэв. Энэ бүхний эцэст Пү Иүй Лү Мей, Чин Мө, Шен Рү нар уулзалдаж, ариун хайрын этгэлээрээ гэр бүл болцгоож зохиол төгсөж байна.

Энэхүү хоёр романд гарч буй үйл явдлын эх “дүр зураг” Инжаннашийн гэр бүлийнхний орчинд Чин улсын Сайшаал ерөөлтийн оноос Төр гэрэлтийн эхний он буюу 1805-1821 оны үес болсон гэдэг. Зохиолын гол дүр Пу Иүйн эх дүр нь Инжаннашийн эцэг Ванчинбал бол, Пу Иүйн авааль гэргий Су Жийн эх дүр нь Ванчинбалын авааль гэргий Сүнжидлхам ажээ. Пу Иүйгийн хожим гэрлэсэн Мен Шен Рү бол Ванчинбалын сүүлийн гэргий, Инжаннашийн төрсөн эх Манюшка болно.

Ийнхүү жинхэнэ амьдралаас урган гарсан “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” роман нь өнгөн талдаа залуусын хайр дурлалын асуудлыг өгүүлсэн мэт боловч тухайн үеийн нийгэмд, гэр бүлд өнгө мөнгийг үнэлж ирсэн дотоод зөрчлийг хурцаар шүүмжилжээ. Тиймээс энэ хоёр романыг соён гэгээрэх үзлийг дэвшүүлжээ гэж үзэж болно. Тухайлбал, тэр цагт буюу Чин улсын үед Монгол иргэдээс төрд ажиллуулах шалгаруулалт явуулдаггүй, байжээ. Тэгвэл зохиолд Пү Иүй, Фен Минд болсон нэгэн удаагийн сүмийн хурал цуглаан дээр, эртний хүний бичсэн таталган бичлэг бүхий бүтээлийг өндөр дуугаар уран тод эгшиглэн уншихад хятадын ноёд ихэд гайхан цочиж байна. Мөн тэрээр Ханжеу хотод, өмнөд орны нэрт бичгийн хүн Ши Лин Юнтэй шүлгээр өрсөлдөн, найз нөхөд болж байна. Ингэж монгол үндэстний эрдэмтэн чадалтныг зориуд дарж байгааг шүүмжлэн эсэргүүцжээ. Түүнчлэн эмэгтэй дүрээрээ эмэгтэйчүүдийн соёл боловсролын асуудлыг дэвшүүлжээ. Мө, Чин Мө, Шен Рү нар бол бүр соёл мэдлэгтэй, ой билигтэй охид юм. Тэд шүлэг, зураг сурч, уралдан, шинэ үзэл санаа, шинэ амьдралын төлөө цуцалтгүй тэмцэгч нар билээ.

“Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” дахь энэхүү чухал үзэл санаа нь монгол оронд соёл гэгээрлийг хөгжүүлэх, нийгэмд ардчиллыг хөгжүүлэх, шинэчлэлтийн тусгал болж байгаа юм. Эл хоёр романы хувьд тэмдэглэх нэг зүйл бол Монголын уран зохиолын харилцан нөлөөллийн бодит үзэгдэл болсон билээ. Тухайлбал, хятадын “Улаан асрын зүүд” романти хэрхэн харьцах асуудлыг судлаачид онцгойлон анхаарч иржээ. Нэг хэсэг нь “Улаан асрын зүүд”-ийг найруулан орчуулсан, тиймээс “Нэгэн давхар асар”, “Улаанаа уйлах танхим” нь бие даасан бүтээл биш гэх бол нөгөө нь хэдийгээр “Улаан асрын зүүд”-ийн туурвил зүйн арга маяг нөлөөлсөн боловч Чин улсын үеийн Монголын нийгэм, амьдралд үндэслэн туурвисан юм. Тийм болохоор ойролцоо түүхэн цаг үед хэдий ч хоёр өөр үндэстний соёлын зөрөө, хэл, дүрслэл, сэтгэлгээ, дүрүүдийн зан чанар зэргээрээ үлэмж ялгаатай билээ.

В.Инжаннашийн уран бүтээлийн оргил нь “Их Юань улсын мандсан төрийн Хөх судар” билээ. Тийм ч учраас академич Д.Цэрэнсодном “Өдрийн сонин”-д өгсөн нэгэн ярилцлагадаа: *“Бид өөрсдийн энэ туурвил зүйн бүтээлийг Европынхтой харьцуулж жишидэг. Үүгээр бол “Хөх судар” бол яалт ч үгүй Монголын анхны түүхэн роман мөн байна гэсэн. Үнэндээ түүхэн романы нөхцөл, шаардлага, хэр хэмжээнд бүрэн нийцсэн. Харин ч бүр давна уу гэхээс дутахгүй цараатай том бүтээл. Тиймээс Инжаннаши Монголын анхны түүхэн романыг туурвисан. Өөрөөр хэлбэл, туульсын зохиолын XIX зууны үеийн аугаа их хөшөө дурсгалыг босгосон хүн мөнөөс мөн л дөө”*<sup>43</sup> хэмээн үнэлсэн байдаг. В.Инжаннаши энэ романаа нийт 120 бүлэг бичихээр төлөвлөж байсан хэдий ч бидний үед 69 бүлэг нь уламжлан ирсэн юм. Эхний 8 бүлгийг эцэг Ванчинбал нь, үлдсэнийг нь Инжаннаши гүйцээн бичжээ. 69 бүлгийн эхний 60 бүлэгтээ Чингис хааны мэндэлснээс нас барсан үе буюу 1162-1227 оны хооронд болсон олон үйл хэрэг явдал, улс гэрээ нэгтгэж, хаан төрийг тогтоож, их улсаа байгуулсан тухай харуулсан бол, дараах 9 бүлэгтээ Өгэдэйг хаан сууснаас хойших үе буюу 1229-1241 оны үеийн явдлыг үзүүлжээ. Ийн үзвэл XII зууны сүүл XIII зууны эхэн үеийн монгол орны нийгэм-улс төрийн амьдралын 70 гаруй жилийн түүхэн хэрэг явдлыг өгүүлжээ.

Өөрөөр хэлбэл, XII-XIII зуунд монголчууд Чингис хааны удирдлага дор хатуу ширүүн тэмцлийг давж, улмаар нэгдсэн их гүрэн болж хөгжөөд, дэлхийг төвшитгөхөөр өрнөд рүү дайлсан энэхүү түүхэн зурвас үеийн байдал нь “Хөх судар”-ын үндсэн суурь өгүүлэмж болсон гэсэн үг юм. Тийм ч учраас “Хөх судар”-ыг туурвисан гол зорилго бол тэр цагийн монголчуудад өвөг дээдсийнхээ баатарлаг түүхийг ойлгож мэдэхийг уриалж, улмаар үндэстнийхээ түүхийг ойлгож мэдсэн байдлаар дамжуулан, үндэстнийхээ итгэл, зориг, хүчийг сэргээж, Чин улсын эрхшээлд өдөр ирэхүй доройтон уруудаж буй монголчуудаа гэгээрүүлэн бадраах эрмэлзсэнд оршино. Энэ тухайгаа Инжаннаши “Хөх судар”-ын “Товчит толт”-ын VII ангид: *“Ертөнцийн хүн уг язгуур удам үндэснээ мэдэх нь зүй болой. ... Тийнхүү тайж Инжаннаши би монгол тоотноо нийтээр мэдтүгэй, ухтугай хэмээн эцэг ноёныхоо хураасан Хөх монголын их Юань улсын олон зүйлийн судар бичиг шаашир түүх бүрийг*

---

<sup>43</sup> Цэрэнсодном Д. В.Инжаннаши туульсын зохиолын XIX зууны үеийн аугаа их хөшөө дурсгалыг босгосон хүн. – “Өдрийн сонин” 2017 оны 5-р сарын 6-ны өдрийн дугаар.

*цөм уудлан гаргаж, эцэг ноёныхоо санааг залгамжлан энэ их Юань улсын судрыг бүртгэн бичвэй” хэмээн дурджээ. Зохиолд, нэг жилийн дотор болсон түүхэн хэрэг явдлыг нэг бүлэгт багтаан өгүүлэх журмыг баримталжээ. Дорно дахины олон бүтээлд өгүүлэх зүйлийнхээ утга санааг шүлгээр зангидан илтгэх туурвил зүйн ур маяг түгээмэл байдаг. Энэ арга барилын дагуу эхлээд тухайн бүлэгт өгүүлэх зүйлийн утга санааг нэг бадаг шүлгээр илэрхийлж, дараа нь түүнийгээ тайлбарлах маягаар хүүрнэн өгүүлсэн байдаг. Бичлэгтээ ардын аман зохиол, зан үйл, ёс горимын зүйлийг өргөн ашигласан учраас уран сайхны тал нь давамгайлах хандлагатай байдаг. Тиймээс зохиолын баатрууд нь түүхт хүнээсээ нэлээд өөр, зохиогч, туурвигчийн хүсэж мөрөөдсөн уран сайхны дүр болсон юм. Жишээ нь: романд дүрслэн үзүүлсэн Чингис бол чухам үнэн түүхт Чингис хаан бус үлгэр туулийн туйлын хүслэнгийн сайн талын баатар шиг хүсэл мөрөөдлийн илэрхийлэл болсон дүр юм. Романд дүрсэлснээр Чингис хаан нь аливаа чухал хэрэг явдлыг бусадтай зөвлөдөг, хэрэв бусдын саналыг авал үгүй үйлдсэн зүйлд алдаа дутагдал гаргавал биеэ шийтгэдэг, хувцас хунар, хоол унд, морь унаагаа цэрэг эрстэйгээ ав адилхан хувааж эдэлдэг билээ.*

Тиймээс профессор Залгаа “В.Инжаннашийн уран бүтээлийн үндсэн шинж” өгүүлэлдээ: *“Зохиол дахь Чингис хаан бол юуны урьд аугаа бодлого, алсын хараатай улс төрч бөгөөд баатарлаг дайчин удирдагч юм. Тэрээр бичиг цэргийн эрдэм хосолж, ой билигтэй, сод мэргэн, уудам багтаамжтай, өршөөнгүй сэтгэлтэй, эрс шуурхай, хатан бат, шаргуу даамгай, цаг тохиол хандаш байдлыг эзэмдэж чаддаг, алсын хараа бодлоготой бөгөөд хошуучлаг дагуулах чадвартай, цэргийн явдлыг дагуулагчийн дүр”* хэмээн дүгнэсэн бол профессор С.Байгалсайхан: *“...Монголын эзэнт гүрний их хаан Чингисийн дүрийг нэлээд тодорхой дэлгэрэнгүй урласан Инжаннашийн “Хөх судар” романд Чингис хаан бол XIII зууны үеийн байлдан дагуулагч түүхт хүн биш, Нууц товчоонд гардаг язгууртны талын төлөөлөгч биш, монголын тусгаар тогтнолын төлөө харийн түрэмгийлэгчдийн эсрэг тэмцэгч, тарж бутарсан олон аймаг улсын үрэлжийн дайн дажныг дарж, үндэсний нэгдэл бэхжилтийн төлөө тэмцэгчийн дүр. Чингисийн дүр бол түүхт хүний дүр биш, хөдөлмөрчин олон түмний хүсэн мөрөөдөж байсан ардын баатар юм гэж үздэг судлаачид цөөнгүй байдаг ба энэхүү үзэл нь уран дүрийн шинж чанарыг нэлээд гүн гүнзгий өргөн хүрээнд авч үзэхийг хойч үеийн судлаачдаас шаардаж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл амьдралын үнэн уран сайхны үнэний хоорондын харьцаа тэр дундаас зохиолын уран дүр илрэх бололцооны тухай нарийн үзэх шаардлагатай болж байгаа хэрэг. Амьдралын үнэн уран сайхны үнэн хоёрыг адилтган үзэж болохгүй бөгөөд амьдралын үнэнийг бүтээлч сэтгэлгээний үүднээс ургуулж байж, зохиолч өөрийн үзэл баримтлалын үүднээс тунгаан байж уран сайхан болгодог гэдэг зарчмаар авч үзвэл, хоорондоо олон зуун жилийн зайтай зохиогдсон дээрх хоёр зохиолыг алиныг ч буруутгах баримт олдохгүй бөгөөд үүнд нэгд: зохиол бичих тухайн цаг үеийн нөхцөл байдал зорилго нөлөөлсөн хоёрт: зохиол туурвин бүтээх уран сайхны туршилага, бүтээлч сэтгэлгээний хөгжилд яриангүй их өөрчлөлт гарсан гуравт: эцсийн эцэст хоёр зохиолд хоёуланд нь Чингис хааны эзэнт гүрэн байгуулсан түүхэн үнэн гарч байгаа тул “баатар эр ялж байвал буудсан байна уу, сэлмээр цавчсан байна уу, гараар боож алсан байна уу түүнийг яаж үзүүлэх нь зохиолчийн эрх” гэдэг уран зохиол*

дахь дүрслэлийн зарчмаар үзэхэд, байж болохгүй гажсан өөрчлөгдсөн зүйл байхгүй юм. Нийгмийн хөгжлийн гол хандлагыг өөртөө тусгаж уу?, үгүй юу?, тухайн үеийн хүний нийтлэг зан чанарыг өөртөө шингээж үү? үгүй юу? гэдгээр уран сайхны ач холбогдол тодорхойлогддог юм”<sup>44</sup> гэж дүгнэжээ.

Онолын энэ ойлголтыг романы бодит жишээн дээр үзвэл: *“Чингисийн цэрэг нэгэн удаа аян замд хүнс хоол хүрэлцэхгүй болж өлсөж ундаасах цагт цэргүүдэд чихтэй (хулан) алж өгч өөрт нь ариун нандин хоол тусгай өгч байсанд: “Авч ир түүнийг адил хамтаар чихтэйн, махыг идмой би Айх, баярлахад олонтойгоо нэгэн цугаар идмой” гэж хэлээд миний хоол ундыг мохож туйлдсан цэрэгт идүүл гээд өөрөө чихтэйн махнаас цадтал идсэн гэж өгүүлжээ. Тэрчлэн дайны хөлд хэлмэгдсэн ард олныг зүйл бүрээр тэтгэж байсан мэтээр үзүүлсэн байна. Жишээ нь: Жамухагийн цэргийн хөлд өртсөн ард иргэдэд улсын сангаас арьс, ноос, бүс бараа, хонь мал зэрэг эд агуурс, идэш ундааны зүйлээр тусалж байсан гэжээ. Романд Чингисийг хаан ширээнд суулгахаар шадар нөхөд нь хүсэхэд хэдэн удаа дургүйцсэн байдлыг үзүүлжээ. Жишээ нь: Оюутсэцэний бичсэн шүлэгт:*

*“Хаан сууж тэнгэрийн хөвүүн болно гэгч  
Хамаг бүхний эцэг, эх болох нь буюу  
Хамаг бүхнийг өөрийн үр мэт өршөөж  
Халхай би үнэхээр чадаагүй тул  
Хоосон нэрийн төдий тэрхүү хааныг  
Халгуу би үнэхээр үйлдэхгүй буюу  
Халуун санаат сайд эрдэмтэн түшмэд та нар  
Харшилт энэ хэргийг дахиж битгий дуртга”*

гэж шууд татгалзсан байдлаар илэрхийлжээ. Үүнээс хойш Чингисийн дөрвөн хүү, есөн өрлөг тэргүүтэн зүүн аймгийн эзэд цугларч хаан ширээнд суухыг хүссэнд тэрээр: *“Эдүгээ би нийт арван хоёр хааныг барьж алав. Тэгээд өөрөө хаан болж сэтгэлээ ичгүүр болгон яах юм бэ?”* гэж хаан суухаас дахин дахин татгалзсан мэтээр бичиж байна. Энэ бүхэн бол ийм энэрэнгүй, шударга сайн хаан байгаасай гэсэн ард түмний хүсэл мөрөөдлийг зохиолдоо илэрхийлсэн хэрэг юм. Түүнээс гадна нэгэнт уран сайхны зохиол учир “Монголын нууц товчоо” зэрэг түүхэн сурвалжид гардаггүй олон баатрыг нэмж зохиох юм уу эсвэл, “Монголын нууц товчоо”-нд байдаг бодит хүний нэр, үйл явдлыг чөлөөтэй өөрчлөн зохиомжилсон байдаг. Тухайлбал, “Монголын нууц товчоо”-нд байдаггүй Өнчин хүүгийн шастир, Аргасун хорчийн домог зэргийг оруулж, Солонго, Алтаншагай зэрэг дүрийн хайр сэтгэлийн шугамыг их уран сайхнаар гаргасан байдаг. Тухайлбал, Оюутсэцэний ашиг тус, гэм хорыг шүүмжлэн өгүүлсэн хэсэг, Чингис хааны Тайчуудыг дарсан зэрэг явдлыг “Алтан товч”-оос ашигласан бололтой байдаг. Мөн “Хөх судар”- дахь “Бета улс” хэмээх нэр нь “Монголын нууц товчоо”, “Алтан товч”-д байдаггүй бөгөөд үүнийг “Эрдэнийн товч”-оос уламжилж хэрэглэсэн бололтой. Мөн хятадын “Юань улсын судар”-аас нэлээд олон өгүүлэмжийг оруулсан байдаг.

Энэчлэн Мухулай, Найман аймгийн хотыг гэнэдүүлэн дайрч, Найманд бүслэгдсэн Хэрэйд аймгийг чөлөөлж буй байлдаан, Чингис хаан Бэлгүтэй

<sup>44</sup> Байгалсайхан С. Уран дүрийн онолын лекцүүд. Уб., 1998, х.45.

дүүгийнхээ ураг найрын явдлаар хөнгөн цэргээр Хэрэйд аймагт очсон гэнэн түгшүүрт үйл явдал, Боорчи уран сүйхээт аргаар Жарууд аймгийг дайран эзэлсэн, Зэлмэ, Солонгос аймагт элчээр мордсон, Чингис хаан 8000 морьт цэргээр Сарлуг улсын түмэн холбоот цэргийг дарсан, Мухулай халдахаар ирсэн Тухмаг улсын цэргийг, байлдааны уран тактик “хөдөлгөөнт тулааны арга”-аар ядраан, туйлдуулж байгаад хялбархан дийлсэн, Монголын цэрэг Алтан улсын цэрэгтэй байлдсан зэрэг бол цөм зохиолчийн уран сэтгэмжээр бүтсэн зүйл билээ. Ийнхүү В.Инжаннаши ард түмний үндэсний ухамсрыг сэргээн сэнхрүүлж, хамжлагын нийгмийн гэм дутагдлыг шүүмжилсэн “Хөх судар” романаа бичсэн нь Монголын шинэ бичгийн утга зохиолын түүхэнд уран бүтээлийн туурвил зүйн сэтгэлгээний томоохон шинэчлэл болсон төдийгүй анхны сонгодог зохиол бичгийн роман болон мөнхөрсөн байна.

**В.Инжаннашийн уран бүтээлийн үнэ цэн:** Өнөөдөр Инжаннашийн Монголын уран зохиолын түүхэнд оруулсан хувь нэмэр, эзлэх байр суурь, түүний уран бүтээлийн үнэ цэн, бүтээлч өв уламжлалын асуудлыг гадаад дотоодын олон эрдэмтэд судалсаар байна. Профессор Б.Л.Рифтин “Монголын анхны романы төрөл, найруулгын онцлог” бүтээлдээ: *“Инжаннашийг зөвхөн монгол романы үндсийг тавьсан сайн зохиолч төдийгүй, бас томоохон яруу найрагч байсныг дүгнээд, хөри зэргэлдээ орны болон Алс Дорнодын утга зохиолын урт удаан хугацааны уламжлалыг түшиж, монгол үндэсний романыг бүтээх оролдлого хийсэн хийгээд тэгэхдээ тэр үеийнхээ Алс Дорнодын романуудад хатуу тогтсон зохиомжийн нэгэн хэв загварын өнгөн хальсыг хуулан хаяж, үндэсний хэлбэрт оруулан бүтээлч шинэчлэл хийж, бараг бүтэн зуунаар үгүйлэгдэж байсан монгол үндэсний романы хөгжилд чухал хувь нэмэр оруулсныг тодорхой иш баримтаар нээн харуулсан.”*<sup>45</sup> гэж үзсэн байна. Профессор Ч.Билигсайхан: *“Монголд бичгийн зохиолчид хэзээнээс төрсөн бэ? Яаж төрсөн бэ? гэдэг сонирхолтой асуудал төдийгүй монгол уран зохиолын хувьсал хөгжлийн нэг тодорхой түүхтэй холбогдоно. XIX зууны үед В. Инжаннаши Монгол бичгийн уран зохиолын эхийг тавьсан агуу зохиолч гэдэг нь илэрхий. В.Инжаннаши өмнөх үеийн их бичээчдийн уламжлалд илүүтэй шүтэж өсөж хүмүүжсэн бөгөөд эртний бичиг эрдмийн их соёлт Нанхиадын уран зохиол түүхийг нэвтэрхий мэддэг, түүнээс бүтээл туурвилдаа үлгэр авдаг байсныг өнөөдөр олон судлаач нэгэнт нотолжээ. В.Инжаннаши алдарт “Их Юань улсын мандсан төрийн хөх судар” романаа бичихдээ өмнө үеийн Монгол бичээчдийн уламжлалыг жаахан шинэчлэн өөрчлөх зорилтыг зориуд баримтлан хэрэгжүүлсэн. Чухам энэ зорилтын үүднээс “Хөх судар” романыхаа өмнө “Товчит тольт” хэмээх онолын чанартай оруулбар, том удиртгал зориуд бичиж, тэндээ өөрийн туурвилын зорилгоо тодорхойлсон байдаг. Монгол уран зохиолын энэ шинэ чиглэл хандлага XIX зууны дунд, сүүл үеэс эрчимжиж аажимдаа XX зуунд Монгол туургатнуудын дунд дэлхийн бусад улс үндэсний жишгээр зохиомол юм уу хээнцэр сонин үйл адал явдлыг үзүүлсэн беллитеристик уран зохиолыг төрүүлсэн билээ. Эдгээрийг зохиодог*

---

<sup>45</sup> Рифтин Б.Л. Жанрово-композиционные особенности первых монгольских романов. Специфика жанров в литературах Центральной и Восточной Азии. М., 1985, с.193.

хүмүүсийг зохиолч гэж сая нэрлэх болов”<sup>46</sup> хэмээн үнэлжээ. Энэ бол уран бүтээлийн ертөнцөд гарсан томоохон үзэгдэл мөн. Өөрөөр хэлбэл, В.Инжаннаши зохиол бүтээлээрээ монгол бичгийн утга зохиолд шинэчлэл хийхийн зэрэгцээ утга зохиолын нэгэн шинэ үеийн үүдийг нээж, хожим хойчийн уран бүтээлийн шинэ үндсийг тавьж, шинэ талбарыг гаргаж өгсөн байна.

Анх удаа уран зохиолын бүхий л төрлөөр эн тэгш уран бүтээлээ туурвисан зохиолч болсон бөгөөд түүх нийгэм, гүн ухаан, байгалийн болон хүний дотоод сэтгэлийн утга уянга, нийгмийн шүүмжлэлт сэтгэлгээ зэрэг цаг үеэ үнэлэн туурвисан бодит үнэлэмжийг буй болгож чадсан байна. Ийм учраас түүний уран бүтээл нь Монгол утга соёлын биеэ даасан томоохон үзэгдэл болж байна. “Зохиолч” хэмээх мэргэжлийн хөдөлмөрийг буй болгож, анхны шан үндэс үрийг нь суулгаж өгчээ. Энэ бүхний үр дүнд нийгмийн соён гэгээрүүлэгч сонгодог зохиолчийн үүргээ төгс гүйцэтгэсэн зохиолч - нийгмийн бие хүн болж чаджээ. Үүнд В.Инжаннашийн уран бүтээл гол гавьяа, үнэ цэн нь оршиж байна. Тийм учраас монгол утга зохиол, бичгийн зохиолын үе үеийн судлаачид, гадаад дотоодын олон эрдэмтэн В.Инжаннашийг Монголын сонгодог зохиолч болохыг хүлээн зөвшөөрч, шинэ шинэ судалгаа хийсээр байна. Тэгвэл сүүлийн үед В.Инжаннашийн зохиол бүтээлийг хэл шинжлэлийн үүднээс, зохиолын хэл найруулга, онч мэргэн цэцэн үгс, дүр дүрслэл, зохиолын хэлний уран яруу хэрэглүүрийг хэрхэн үүдэн бүтээсэн байдал, үгийн сангийн онцлог зэргийг анхаарах болов. Учир нь аливаа хэлний үгийн санг баяжуулдаг нэг гол эх булаг нь зохиолын хэл байдаг билээ. Ийм учраас В.Инжаннашийн зохиолын үгийн сан монгол хэлний үгийн санг баяжуулахад ямар хувь нэмэр оруулав гэдгийг орчин үеийн хэл шинжлэлийн онол арга зүйн үүднээс анхааран судлах болсон нь сайшаалтай.

---

<sup>46</sup> Билигсайхан Ч. *Монголын уран зохиолын үүслийн үндсэн хоёр эх булаг*. – ШУА-ийн ХЗХ. Уран зохиол судлал. Уб., 2005, Tomus 10, Fasc. 4.



# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ



**МОНГОЛ УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦААШДЫН ЧИГ  
ХАНДЛАГА ЭРСДЭЛ, БУУРУУЛАХ БОЛОМЖ**

*Д.Бямбадорж  
(Мэдээллийн Сүлжээ, Аюулгүй Байдлын салбар  
ШУТИС, Мэдээлэл, Холбооны Технологийн  
сургууль, доктор)*

*Агуулгын товч: Олон улсын кибер аюулгүй байдал нь технологийн хурдтай хөгжлийн гол тулгуур салбар болоод байна. Дижитал хувиргаа, өгөгдлийн өсөлт, хиймэл оюун, автоматжуулалт нь шинэ төрлийн кибер эрсдлийг үүсгэж, засгийн газар, бизнес, иргэдэд сорилт болж байна. Монгол Улс дижитал шилжилтээр хурдтай хөгжиж, интернэт хэрэглээ нэмэгдэж байгаа ч кибер аюулгүй байдлын чадавх, хууль эрх зүй, технологийн хэрэгжилтэд цаашид анхаарах шаардлагатай хэвээр байна. Энэхүү судалгаа нь дэлхийн болон бүс нутгийн кибер аюулгүй байдлын өнөөгийн байдал, Монгол Улсын дижитал хөгжилд эрсдэл ба боломжуудыг тодорхойлох зорилготой. Түлхүүр үг: дижитал хувиргаа, өгөгдлийн өсөлт, кибер аюулгүй байдал,*

**МОНГОЛ УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Монгол Улсын кибер аюулгүй байдлын тогтолцоо нь Кибер аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний кибер аюулгүй байдлын стратеги зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр [1] зохицуулагддаг. Мэдээллийн системийн бүрэн бүтэн байдал, нууцлал, хүртээмжийг хамгаалах, онц чухал мэдээллийн дэд бүтцийг хамгаалах зохицуулалт, стандартыг хуульчлан баталгаажуулсан бөгөөд үүний хэрэгжилтийг хангах үүрэгтэй. Үндэсний төв болох Public CSIRT, Кибер аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагууд үйл ажиллагаа [2] хэрэгжүүлснээр төр-хувийн хамтын ажиллагааны хүрээнд кибер халдлагыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэл, туршлага солилцох, иргэд болон бизнес эрхлэгчдэд сэрэмжлүүлэг өгөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Сүүлийн жилүүдэд төрийн байгууллагууд уруу чиглэсэн халдлагын өсөлт, 2025 оны судалгаагаар нийт халдлагын 70 % нь зөвхөн засгийн газрын системүүд уруу чиглэсэн нь кибер аюулын эрсдэлийг нэмэгдүүлж, бодлогын хэрэгжилт, хариу үйлдлийн чадавх, хүний нөөц, төр-хувийн хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагыг [3] тодорхой харуулж байна.

**МОНГОЛ УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС БА СОРИЛТУУД**

Монгол Улсын кибер аюулгүй байдлын дотоод хүчин зүйлс нь техникийн дэд бүтэц, тухайлбал сүлжээ, сервер, өгөгдлийн сан-гийн хөгжлийн хязгаарлалт, мэргэшсэн хүний нөөцийн дутагдал, мөн бодлого, зохицуулалтын

сул талууд-тай холбогдон төрийн байгууллагуудын дотоод сүлжээ болон мэдээллийн системийн аюулгүй байдалд эрсдэл учруулж, халдлага, мэдээллийн алдагдал, нэвтрэлтийн эмзэг байдлыг [4],[5] нэмэгдүүлж байна. Учир нь Монгол Улс хуучирсан тоног төхөөрөмж болон олон улсад хориглосон тоног төхөөрөмжийг төр-хувийн хэвшлийн байгууллагад нийлүүлж байгаа нь томоохон хэмжээний эрсдэл үүсгэж байна.

## **МОНГОЛ УЛС УРУУ ЧИГЛЭСЭН КИБЕР ХАЛДЛАГА**

Монгол Улс уруу чиглэсэн кибер халдлага, мэдээллийн дайралт нь хөрш орнуудын кибер бодлого, бүс нутгийн геополитик, олон улсын түвшний кибер халдлага, мэдээллийн дайралтын өргөн хүрээтэй нөхцөл байдалтай шууд холбоотой бөгөөд энэхүү халдлага нь үндэсний дэд бүтэц, төрийн болон хувийн салбарын мэдээллийн системийн аюулгүй байдал, нууцлал, мэдээллийн бүрэн бүтэн байдалд нэмэлт эрсдэл үүсгэж, засгийн газрын үйл ажиллагаа, нийгмийн болон эдийн засгийн чадавхад шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлж байна. Дээрх үр дагавараас улбаалан кибер аюулгүй байдлын стратеги, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чадавх, хүний нөөцийн чадавх, техник технологийн шинэчлэл, олон улсын стандарт, сайн туршлагыг нэвтрүүлэх хэрэгцээ үүсэж байна.

## **МОНГОЛ УЛСЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**

Монгол Улсын кибер аюулгүй байдлын цаашдын чиг хандлага нь дижитал төрийн үйлчилгээ, “Smart city” төслүүд болон Cloud, AI, IoT зэрэг дижитал технологийн өргөн хэрэглээтэй холбоотой эрсдлийг удирдах, хамгаалахад төвлөрч, үүнд үндэсний кибер стратеги, зохицуулалтын шинэчлэл, олон улсын стандарт, сайн туршлага нэвтрүүлэх замаар төр-хувийн салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөн мэргэшсэн хүний нөөцийг хөгжүүлэх, сургалт, чадвар дээшлүүлэх бодлогыг системтэй хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тодорхой харуулж байна.

## **КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ БУУРУУЛАХ ЗӨВЛӨМЖ**

Кибер аюулгүй байдлын эрсдлийг бууруулах зөвлөмжид үндэсний хэмжээнд цогц стратегийн төлөвлөгөө боловсруулах, түүнчлэн төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг тогтмол эрчимжүүлж, мэдээллийн технологийн дэд бүтцийг бат бөх, найдвартай болгон хөгжүүлэх шаардлага чухал юм. Энэ нь зөвхөн төрийн мэдээллийн системийг хамгаалах төдийгүй хувийн салбар, үндэсний чадавхыг бэхжүүлж, кибер халдлагаас үүсэх хохирлыг бууруулах үндэс суурийг тавьдаг. Мөн олон улсын стандарт, сайн туршлага, ISO, NIST зэрэг хяналт, аудитын тогтолцоо, үнэлгээний аргачлалыг тогтмол нэвтрүүлэх нь мэдээллийн системийн найдвартай байдал, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, үндэсний аюулгүй байдлын чадавхыг өргөжүүлэхэд гол үүрэг

гүйцэтгэдэг. Ийнхүү зохицуулалт, технологийн бат бөх дэд бүтэц, хүний нөөцийн чадавх, олон улсын стандартын хэрэгжилтийг нэгтгэн хэрэгжүүлэх нь Монгол Улсын кибер орчныг тогтвортой, найдвартай хөгжүүлэх үндсэн суурь болж байна.

## **ДҮГНЭЛТ**

Монгол Улсын кибер аюулгүй байдал нь үндэсний хөгжлийн чухал тулгуур хүчин зүйл бөгөөд дижитал шилжилтийн амжилттай уялдаж байна. Дотоод болон гадаад эрсдлийг нэгтгэн системтэйгээр удирдах нь үндэсний аюулгүй байдлын зайлшгүй шаардлага юм.

Ирээдүйн чиг хандлага нь технологийн дэвшил, хүний нөөцийн боловсрол, төрийн бодлого, зохицуулалтын уялдаа холбоонд төвлөрч, эдгээрийг амжилттай хэрэгжүүлснээр Монгол Улс цахим орчны тогтвортой байдлыг хангах, дижитал хөгжилд тууштай ахиц дэвшил гаргах боломжтой болно.

### **Ном зүй:**

1. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ХЭСГЭЭС “КИБЕР АЮУЛГҮЙ ТУХАЙ”
2. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ “АЛСЫН ХАРАА”
3. <https://mddic.gov.mn/> “Монгол Улс уруу чиглэсэн кибер халдлагын 70 хувь нь Засгийн газрыг “онилдог”
4. <https://mddic.gov.mn/wp-content/uploads/2025/06/250605-REVISED-VERSION-OF-TRANSLATION-1.pdf>
5. <https://rsglobal.pl/index.php/ijitss/article/view/4298>

ТАРХМАЛ БАЙРШИЛ БҮХИЙ МЭДРҮҮРИЙН СҮЛЖЭЭГ (USN)  
ХҮНИЙ ЗҮРХНИЙ АЛСЫН ОНОШЛОГООНД ХЭРЭГЛЭХ НЬ

Н.Чулуунбаатар

(Соёл Эрдэм дээд сургууль,

Мэдээллийн технологийн тэнхим)

Хураангуй


Утасгүй тархмал мэдрүүрийн дэвшилтэт технологиуд суурилсан хүний түрхний хэмнэл ECG, SpO2, цусны даралт, хүний биеийн температур болон идэвхтэй хөдөлгөөний мэдээллийг тухайн пациентын гэр, гадуур одор тутмын хэвийн үйл ажиллагааны үед болон эмнэлгийн орчинд бодит цагийн горимоор алсын зайд оношлогооны мэдээллийг төв сервер, эмч болон харгалзагчид байршлын хамт мэдээлэх урьдчилсан эмнэлгийн арга хэмжээ авах зорилгоор multi modal sensing (MSUS) U-эмнэлгийн системийг өөрийн орны нөхцөлд тохируулан нэвтрүүлэхэд чиглэгдэнэ. 21-р зууны технологи гэдэх USN суурилсан мэдрүүрийн зангилааны техник, технологи програм хангамжийг боловсруулж хүний амь настай холбоотой эмнэлгийн оношлогооны тусгай зориулалтын долгион мэт тасралтгүй анхлагч сигналыг цуглуулах, боловсруулалт хийж мэдээллийн пакетийг алсын зайд утасгүйгээр алдагдалгүй дамжуулах U-эмнэлгийн бүтэц нь хамгийн өндөр шаардлагатай, урьтамж өндөр мониторинг систем юм.

Түлхүүр үг

Multi modal sensing (MSUS), ECG Electrocardiogram, USN Ubiquitous Sensor Network, U-эмнэлэг, IEEE Institute of Electrical and Electronics Engineering


I Оршил

Эмч Хэтгэч Хаанаас ч гэгдэх 21-р зууны технологи болох ойрын ирээдүйд бүгдийг сүлжээнд холбож болох тархмал байршил бүхий мэдрүүрийн сүлжээ (USN) нь зөвхөн анхдагч



мэдээллийг хүлээн авах болон мэдээлэл дамжуулах технологийн хөгжилд шинэлэг дэвшилтийг бий болгохоос гадна хөгжингүй орнуудад эдгээр мэдрүүрийн мэдээлэлд суурилсан шинэ хэрэглээ, үйлчилгээг нийгмийн бүхий салбарт ялангуяа анагаах ухаанд зүрх судасны алсын зайн оношлогооны U-эмнэлгийн системд түлхүү нэвтрүүлж эхлээд байна.

Дэлхий эрүүл мэндийн байгууллагаас



мэдээлснээр дэлхийн хүн амын нас баралтын хамгийн өндөр хувийг зүрх судасны өвчлөлт эзлэж байгаа бөгөөд энэ нь ихэвчлэн оноогийн дэлхийн хүн амын 10% -г эзлэж байгаа 65 -с дээш (2050 хүртэл 22% хүртэл өсөх хандлагатай) өндөр насны хүмүүст тохиолдож байна.

Зураг-1. Монголд зүрх судасны өвчний


шалтгаант нас баралт (5 жилээр)

Манай орны хувьд анагаах ухааны хамтарсан байгууллагуудын судалгаагаар монгол эрэгтэй хүний дундаж наслалт 65.5 байгаа бөгөөд зүрх судасны өвчлөлтөөр нас баралтын (Зураг-1) эзлэх хувь хамгийн өндөр, өсөх залуужих, хандлагатай байгаа нь сэтгэл түгшээсн асуудал болоод байна. Иймд хөгжингүй орны жишгээр оноогийн дэвшилтэт технологийг өөрийн орны өвөрмөц онцлогт тохируулан анагаах ухааны салбарт нэвтрүүлэх нь нэн шаардлагатай тулгамдсан асуудлын нэг болоод байна.

III. Үндсэн хэсэг

Уг систем нь гэрийн нөхцөлд амьдарч байгаа настай болон архаг түрхний өвчтэй хүмүүсийн гадуур одор тутмын хөдөлгөөнт идэвхтэй үйл ажиллагааны үеийн түрхний хэмнэлийн сигнал, биеийн температур, цусны даралт, хөдөлгөөний акселометр болон хүчил төрөгчийн хэмжээг бодит цагийн горимд локал болон глобал сүлжээгээр дамжуулах эмчийн болон харгалзагчийн байнгийн хяналтад мониторинг өгөгдлийн бааз бүхий систем үүсгэх, оношлогоог найдвартай байлгах, урьдчилсан арга хэмжээ авах улмаар эмч пациентийн хоорондын харилцааг уян болгоно.


MSUS U-эмнэлгийн систем нь (Зураг-2) үндсэн 4 хэсгээс бүрдэнэ: - мэдрүүрийн зангилаа (sensor node), - үүрэн телефоны функцууд бүхий локал процессорын төхөөрөмж болон мониторинг багаж, -төв сервер, -PC терминал



1. Эрүүл мэнд болон идэвхитэй үеийн мониторинг  
ECG, акселометр  
SpO2, цусны даралт, Биеийн температур
2. Мэдээллийн дамжуулалт  
Ultrasonic /RF дамжуулагч

**Зураг-2. MSUS U-эмнэлэгийн системийн ерөнхий бүтэц**

Мэдэрүүрийн зангилаа (Sensor node) нь хүний биед байрлах био мэдрүүр бүхий 40мм хэтрэхгүй хэмжээтэй микроконтроллерын удирдлага бүхий төхөөрөмж (Зураг-3) байх бөгөөд анхан шатны боловсруулалт хийж мэдээллийг хэрэглэгчийн үүрэн телефоны утасгүй Dongle буюу IEEE 802.15.4 утасгүй мэдээлэл дамжуулах стандартын дагуу төв сервер болон карманы PDA төхөөрөмж рүү дамжуулах бөгөөд улмаар зүрхний цахилгаан




**Зураг-3. Мэдэрүүрийн зангилааны дизайн**  
бичлэгийн үндсэн санг бүрдүүлж өгсөнөөр утасгүй тархмал мэдрүүрийн дэвшилтэт технологид суурилсан хүний зүрхний хэмнэл буюу ЗЦБ-ийн мэдээллийг алсын зайд оношлогооны төв серверт мэдээлэх, хүлээн авсан өгөгдлийг боловсруулж урдчилан оношлогоо хийх, цаг алдалгүй арга хэмжээ авахад боломжийг бүрдүүлнэ.

**IV. Зүрхний цахилгаан бичлэг, үндсэн шүд, сегментүүд, Дохио боловсруулалт, Статистик тархалт. Полигон, гистограмм.**

Зүрх ажиллах үедээ өөрөө автоматаар сэрэл үүсгэж түүнийгээ потенциалын ялгавар үүсгэн дамжуулдаг. Уг потенциалын ялгаврыг цаасан дээр буулгасан муруйг зүрхний цахилгаан


бичлэг(ЗЦБ) буюу Electrocardiogram ECG гэнэ ECG нь бүхий хүний биеийн гадаргуу, электрод хоорондын хүчдэлийн ялгавар болон хугацааны хамаарлын дүрслэл



**Зураг -4. ЗЦБ – ийн шүд ба сегмент**

**Зүрхний цахилгаан бичлэгийн Стандарт холболт**

Биеийн гадаргууд үүсэж байгаа цахилгаан орны цэг бүрт зүрхний импульс өөр өөрийн потенциалын ялгавартай байдаг. Цахилгаан орны тодорхой хоёр цэгийг холбон тус хоёр цэгийн цэнэгтийн ялгааг бүртгэж авах зорилгоор бүртгэгч электродуудыг хооронд нь холбож ЗЦБ хийхийг стандарт холболт буюу Эйнтховены (Einthoven, 1903) холболт гэнэ. Баруун ба зүүн гарыг холбосон холболтыг стандарт I, баруун гар, зүүн хөлийн хоорондох холболтыг стандарт II, зүүн гар, зүүн хөлийн хоорондох холболтыг стандарт III холболт гэх бөгөөд стандарт гурван холболтын дүнд үүсч байгаа гурвалжинг Эйнтховены гурвалжин хэмээн нэрлэдэг .



**Зураг -5 ЗЦБ – ийн холболтууд**

**Дохио боловсруулалт**

Аналог дохио нь  $X_a(t)$  тасралтгүй (эсвэл хэсэгч лезн – тасралтгүй ) функцээр тодорхойлогдон би чигдэнэ. Харин аргумент ба функц өөрөө  $t' \leq t \leq t'', x'_a \leq x_a \leq x''_a$  завсруудаас дурын утгыг авна. Аналог дохионд "ердийн" телефоны ба р адио нэвтрүүлгийн ярианы дохио болон "ер-дийн" телевизийн дохионууд хамаарна. Дискрет дохио нь  $X(nT)$  ( дискрет хугацааны өгөгдлийн дараалал ) торолсон функцээр тодорхойл одон бичигддэг.  $X(nT)$  нь  $x' \leq x \leq x''$  завсарт ду рын утгыг, үл хамаарах  $n$  хувьсагч нь  $n=0,1,2,\dots$  гэсэн зөвхөн дискрет утгуудыг авна.

### Фурьегийн хувиргалт


Математикт Гармоник шинжилгээг үргэлжилсэн хугацааны Фурьегийн хувиргалтаар маш нарийн тодорхойлдог. Үүнд дискрет хугацааны Фурьегийн хувиргалт, Фурьегийн дискрет хувиргалтууд мөн адил хамаарна.

Зүрхний цахилгаан бичлэгийн математик загварыг гаргахдаа P-Q муж, Q-R-S бүрдэл, S-T муж тус бүр дээр боловсруулалт хийн математик томъёог гаргасны үр дүнд нэг бүтэн үе ECG дохионы нийлбэр томъёог гаргана.

X	Үргэлжилсэн хугацааны	Дискрет хугацааны
Товчлол	$x(t) = \int_{-\infty}^{\infty} X(f) e^{i2\pi ft} df$	$x[n] = \Delta t \int_{-\frac{1}{2\Delta t}}^{\frac{1}{2\Delta t}} X(f) e^{i2\pi f n \Delta t} df$
-	$X(f) = \int_{-\infty}^{\infty} x(t) e^{-i2\pi ft} dt$	$X(f) = \sum_{n=-\infty}^{\infty} x[n] e^{-i2\pi f n \Delta t}$
Хэлбэр	$x(t) = \sum_{k=0}^{N-1} X[k] e^{i2\pi k t / T}$	$x_n = \frac{1}{N} \sum_{k=0}^{N-1} X_k e^{i2\pi k n / N}$ $n = 0, \dots, N-1$
-	$X[k] = \frac{1}{T} \int_{-\frac{T}{2}}^{\frac{T}{2}} x(t) e^{-i2\pi k t / T} dt$	$X_k = \sum_{n=0}^{N-1} x_n e^{-i2\pi k n / N}$ $k = 0, \dots, N-1$

### Зүрхний цахилгаан бичлэгийн математик загварууд . Фурьегийн цуваа:

Энэ томъёо нь ЗЦБ – ийн нэг үеийн R, T шүдний хувьд гаргасан томъёо юм. Зүрхний дохилтын нэг үеийг Фурьегийн цуваагаар загварчлая



Үүний тулд зүрх нэг минутанд 60 удаа цохилдог гэж үзье. Тэгвэл нэг үе  $\tau = 1$  секунд болно. 1секунд=1000мсек  
R долгион нь хамгийн ихдээ 25mV хэмжээтэй ба 40мсек орчим үргэлжилж байна. R долгион нь бараг гурвалжин хэлбэртэй тул шулуун шугам гэж үзэж болно.

Олон гишүүнтийн арга хэрэглэх ба дараах байдлаар томъёолно.  
 $p = 2L = 1000\text{мсек}$  (2.1.1)

$$L = 500$$

$$f(t) = -0.0000156(t - 20)^4 + 2.5$$

$$f(t) = f(t + 1000)$$
 (2.1.2)

### Томъёоны тайлбар

Энэ томъёо нь 4 зэрэг дээр суурилсан нь парабол хэлбэрийг гаргахад хэрэгтэй юм.  $(t-20)$  – гэсэн томъёо дараах байдлаар шийдвэрлэгдсэн. Үүнд: муруй  $(0;0)$  цэгээс эхлээд  $(40;0)$  цэгээр өнгөрч байгаа ба 40 мсек үргэлжилж төв цэг нь  $t=20$  болно. "+2.5" гэсэн нь лугшилтын амплитуд нь 2,5 мВ гэдгээс гарч ирсэн.  
 $-0.0000156$  нь  $a(t - 20)^4 + 2.5 = 0$  гэдгээс  $a =$

$0.0000156$  гэж олдоно.

Томъёоны " $f(t) = f(t + 1000)$ " хэсэг нь импульс 1000мсек тутам дахин давтагдана гэдгийг илэрхийлж байна.

### Өргөтгөсөн томъёо (T шүдийг нэмсэн)

$$f(t) = \begin{cases} -0.0000156(t - 20)^4 + 2.5 & \text{хэрэв } 0 < t < 40 \\ -9.375 \times 10^{-5}(t - 280)^2 + 0.6 & \text{хэрэв } 200 < t < 360 \end{cases}$$


$$f(t) = (t + 1000)$$

Үгүйлэл томъёогоор илэрхийлсэн ЗЦБ – ийн R болон T- үеийн графикийг байгуулав.

```

Editor - C:\Documents and Settings\Administrator\My Doc
1 - t1=0:40;
2 - a=(-0.0000156*(t1-20).^4+2.5);
3 - t2=200:360;
4 - b=(-9.375*10^(-5)*(t2-280).^2+0.6);
5 - plot(t1,a,t2,b);
6 - title('R - wave');
7

```



Зураг -6 томъёоны үр дүн

### R-шүдний хувьд:

$e=25\text{мм/сек}$ ,  $w_p = 0.08\text{с}$ ,  $h_p = 0.1\text{мВ}$ ,  $\tau_p = 60$ ,  $s_p = 0.1$ ,  $\phi_r = 0.16\text{с}$ ,  $PR = 0.12$ ,  $w_q = 0.02\text{с}$ ,  $w_r = 0.06\text{с}$


$$V = 10 \cdot \text{Sin} \left( \frac{\log \left| \frac{s_p}{10 \cdot h_p} \right|}{\log \left| \cos \frac{\pi \cdot PR}{120e} \right|} \right) \left( \frac{\pi \cdot \tau_p}{60e} \cdot t + \phi_r + \frac{\pi \cdot \tau_p (2PR + w_q - w_r)}{120e} \right) = 10 \cdot 0.1 \cdot$$

$$\text{Sin} \left( \frac{\log \left| \frac{0.1}{10 \cdot 0.1} \right|}{\log \left| \cos \frac{\pi \cdot 60 \cdot 0.08}{120 \cdot 25} \right|} \right) \left( \frac{\pi \cdot 60}{60 \cdot 25} \cdot t + 0.16 + \frac{\pi \cdot 60 (2 \cdot 0.12 + 0.02 - 0.06)}{120 \cdot 25} \right) =$$

$$= \sin \frac{\ln(0.1)}{\ln(0.99)} \left( \frac{\pi}{25} t + 0.004\pi + 0.16 \right) =$$

$$\sin^{250} \left( \frac{\pi}{25} t + 0.004\pi + 0.16 \right);$$

Бодолтын үр дүнд гарсан тэгшитгэлээр график байгуулж үзье.



Эрүүл хүний зүрхний цахилгаан бичлэг болон янз бүрийн зүрх судасны эмгэгтэй (Зүрхний шигдээс, Титэм судасны эмгэг, Зүүн ховдлын агшилтын саатал, Тосгуурын пароксизмын тахикарди, Миокардын цус багадалт) зүрхний бичлэгийн хувьд харьцангуй давтамжийн гистограммыг байгуулан тархалтыг бодож хоорондын хамаарлыг гаргав.

Эрүүл хүний зүрхний цахилгаан бичлэгийн Стандарт I, II, III –р холболтын I үеийн хувьд харьцангуй давтамжийн гистограмм байгуулж үзье.




Зураг -7 ЗЦБ Стандарт 1,2,3 холболт

Стандарт II холболтыг харуулсан зургаас  $\Delta t = 0.01$  хугацааны алхамтайгаар харгалзах хүчдэлийг харуулсан хүснэгтийн дагуу тархалтыг Зураг-8 харуулав.

Дээрх Стандарт 2-р холболтын тархалтыг байгуулсны адил Зүрх судасны эмгэгүүдээс дээрхи төслийн хэсэгтээ Зүрхний шигдээс, Титэм судасны эмгэг, Судасны үрэвсэл, Зүүн ховдлын агшилтын саатал, Тосгуурын пароксизмын тахикарди, Миокардын цус багадалт, Хурц миокардын согог зэрэг эмгэг бүхий зүрхний цахилгаан бичлэгүүдийг ашиглав.

Мөн 60,65,70 настай эрэгтэй хүний Титэм судасны эмгэг бүхий зүрхний цахилгаан бичлэгүүдийн тархалтыг гаргаж хооронд нь харьцуулалт хийлээ.



Зураг -8 Стандарт II холболтын тархалт

Дээрхи зүрхний цахилгаан бичлэгүүдийн тархалт нь Generalized Extreme Value Distribution (мөн Pareto distribution тархалттай төстэй) гэж тодорхойлогдон гарсан ба энэхүү тархалтын функц нь дараах байдлаар тодорхойлогдоно.  $y =$

$$f(x|k, \mu, \sigma) = \left(\frac{1}{\sigma}\right) \exp\left(-\left(1 + k\frac{(x-\mu)}{\sigma}\right)^{\frac{1}{k}}\right) \left(1 + k\frac{(x-\mu)}{\sigma}\right)^{-1-\frac{1}{k}}$$

Энэ томъёо нь  $k, \mu, \sigma$  гэсэн 3 параметраас хамаарна.

$$1 + k\frac{(x-\mu)}{\sigma} > 0$$

$k$ - shape буюу хэлбэр,  $\mu$ - location буюу байрлал,  $\sigma$ - scale буюу далайц юм. Энэ 3 параметрээр тархалтын магадлалыг тодорхойлдог.

Эрүүл хүний зүрхний цахилгаан бичлэгийн хувьд дээрхи параметрууд  $k=0.132$ ;  $\mu=0.009$ ;  $\sigma=0.073$  гэж тодорхойлогдон гарч байна.

Туршилт хийгдсэн эмгэг бүхий зүрхний цахилгаан бичлэгүүдийн тархалтын үр дүнг нэгтгэн үзэв. Үүнд:

Зүрхний өгөөж нэр	Дундаж хэлбэл Утга	k параметр	σ параметр	μ параметр
Тосгуурын пароксизмын тахикарди	0.051	-0.352	0.066	0.0255
Зүүн ховдлын агшилтын саатал	0.0109	-0.146	0.093	0.017
Титэм судасны эмгэг	0.018	-0.175	0.128	0.047
Миокардын цус багадалт	0.024	-0.358	0.162	-0.100
Судасны үрэвсэл	0.026	-0.125	0.145	-0.175
Зүрхний шигдээс	0.057	0.407	0.059	-0.052
Хурц Миокардын согог	16.351	0.124	0.065	-0.001

Дээрхи хүснэгтэнд зүрхний эмгэгийг хөнгөнөс нь хүнд рүү нь жагсаасан ба үүнээс харахад эмгэг хүндрэх тусам дундаж хазайлт нь ихсээж байна гэдэг дүгнэлтийг гаргаж байна.

Цаашид улам баяжуулан бүх эмгэгийн хувьд тархалтын параметруудийг тодорхойлон гаргаж сан бүрдүүлснээр ЗЦБ-ийн мэдээллийг алсын зайд оношлогооны төв серверт мэдээлэх, хүлээн авсан өгөгдлийг боловсруулж урдчилан оношлогоо хийх, цаг алдалгүй арга хэмжээ авахад ач холбогдлоо өгнө

#### **Дүгнэлт**

Утасгүй мэдээлэл солилцох сүлжээний мэдрэх, боловсруулалт хийх болон дамжуулалт, хүлээн авах хэсгүүдийг нэг бяцхан төхөөрөмжид нэгтгэсэн

Тэжээлийн эх үүсгэврийг хэмнэлтийн горийн программын алгоритм болон техникийн шийдлүүд нь нөөц тэжээлийн эх үүсгүүрийн хугацааг уртасгах, олон тооны бяцхан төхөөрөмжүүдийг нэгтгэх холбох боломжийг бүрдүүлнэ

USN сүлжээний хэрэглээний гол үр дүн нь настай хүмүүс болон сувилгаа, асаргаа шаардлагатай, эмнэлэгийн хяналтад байх өвчтөний биеийн байдлыг зайны тасралтгүй мониторинг хяналтын системээр өнөөгийн орны дэд бүтцийг түшиглэн хянах, байршлыг тогтоох, урьдчилсан оношлогоо хийх, цаг алдалгүй арга хэмжээ авах зэрэг нэн чухал олон талын ач холбогдолтой болно.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

**I** Chung W-Y & Myllylä R Ubiquitous Sensor Network for Chemical Sensors.

Rare metal materials and engineering 35(S3): 400–404.

**II** Lee Y-D, Lee D-S, Chung W-Y & Myllylä R) A Wireless Sensor Network

Platform for Elderly Persons at Home. Rare metal materials and engineering 35(S3): 95–99.

**III** Lee Y-D, Lee D-S, Walla G, Myllylä R & Chung W-Y Query Based Duplex

Vital Signal Monitoring System Using Wireless Sensor Network for Ubiquitous Healthcare. IFMBE Proceedings, World Congress on Medical Physics and Biomedical Engineering 2006. August 27–September 1, Coex, Seoul: 388–391.

**IV** Chung W-Y, Walla G, Lee Y-D & Myllylä R Design issues and implementation of query-driven healthcare system using wireless sensor Ad-hoc network. IFMBE Proceedings, International Workshop on Wearable and Implantable

Body Sensor Networks (BSN). March 26–28, RWTH Aachen University, Germany: 99–104.

**V** Chung W-Y, Bhardwaj S, Purwar A & Lee D-S A Fusion Health Monitoring using ECG and Accelerometer Sensors for Elderly Persons at Home. Proceedings of EMBC 2007(29th Annual International Conference of the IEEE Engineering in Medicine and Biology Society). Lyon, France, August 23–26: 3818–3821.

**VI** Lee D-S, Bhardwaj S, Alasaarela E & Chung W-Y (2007) An ECG Analysis on Sensor Node for Reducing Traffic Overload in u-Healthcare with Wireless Sensor Network. Proceedings of IEEE Sensors Conference, Georgia, USA, October 28–31: 256–259.

ДЭЭД БОЛОВСРОЛ ДАХЬ ХИЙМЭЛ ОЮУНЫ НӨЛӨӨ БА  
MOODLE СИСТЕМД ХИЙМЭЛ ОЮУНЫГ  
НЭГТГЭХ БОЛОМЖ

*Б.Мөнхчимэг*

*(Соёл Эрдэм дээд сургууль,  
Мэдээллийн технологийн тэнхим)*

*Агуулгын товч:* Сүүлийн жилүүдэд хиймэл оюуны технологийн хурдацтай хөгжил нь дээд боловсролын сургалтын бүтэц, үнэлгээ, удирдлагын арга зүйд гүнзгий өөрчлөлт авчирч байна. Ялангуяа сургалт удирдах системүүд (СУРГАЛТ УДИРДАХ СИСТЕМ) нь хиймэл оюуныг өөртөө нэгтгэх үндсэн платформ болон хөгжиж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, хувь хүнд тохирсон суралцах орчин, автомат үнэлгээ, урьдчилан таамаглах аналитик зэрэг боломжуудыг бүрдүүлж байна. Энэхүү өгүүлэл нь дээд боловсрол дахь хиймэл оюуны хөгжлийн үе шат, боловсролын чатбот болон бүтээлч хиймэл оюуны нөлөө, хиймэл оюуны ойлголт, чадвар (AI literacy)-ын шаардлагыг онолын эх сурвалжид тулгуурлан шинжилж, Moodle системд хиймэл оюуныг нэгтгэх боломж, чиглэл, сорилтыг тодорхойлохыг зорилоо. Судалгааны үр дүнд СУРГАЛТ УДИРДАХ СИСТЕМ хөгжлийн гурван үе шат—статик, интерактив, AI-интеграцлагдсан системийн логик хувьслыг тодорхойлж, Moodle-д хиймэл оюуныг нэвтрүүлэхэд шаардлагатай зорилго тодорхойлолт, өгөгдлийн бэлтгэл, туршилт, тасралтгүй сайжруулалтын стратегийн хүрээг санал болгож байна. Мөн хиймэл оюуны хэрэглээтэй холбоотой ёс зүй, өгөгдлийн нууцлал, дижитал тэгш бус байдал, когнитив хараат байдлын эрсдэлийг онцлон авч үзэв. Энэхүү судалгаа нь Moodle-д суурилсан ухаалаг суралцах орчныг онолын түвшинд тодорхойлох замаар дээд боловсролын дижитал шилжилтийн стратегид хувь нэмэр оруулахыг зорьж байна.  
*Түлхүүр үг:* хиймэл оюун, бүтээлч хиймэл оюун, сургалт удирдах систем, moodle

**I. ДЭЭД БОЛОВСРОЛ ДАХЬ ХИЙМЭЛ ОЮУНЫ  
ХӨГЖЛИЙН ТОЙМ**

**1.1. Хиймэл оюуны хэрэглээний эхэн үе**

Дээд боловсролын салбарт хиймэл оюуны хэрэглээ нь хэдэн арван жилийн турш тасралтгүй хувьсан хөгжиж, үйл ажиллагаа болон чадамжийн хувьд аажмаар өргөжин тэлж ирсэн байна. Анхны үеийн системүүд нь гол төлөв Ухаалаг багшлах системүүд (Intelligent Tutoring Systems, ITS) хэлбэртэй байсан бөгөөд эдгээр нь дүрэмд суурилсан, тодорхой нэг мэдлэгийн салбарт чиглэсэн, суралцагчийн хариултад тохируулан зөвлөмж өгөх бүтэцтэй байв. [15], [16].

Ухаалаг багшлах системийн зорилго нь багшийг загварчлан дуурайж, суралцагч бүрт тохирсон заах арга зүйг хэрэгжүүлэхэд оршиж байсан бөгөөд тухайн цаг үедээ хувийн сургалтын дэмжлэг үзүүлэх технологийн чухал дэвшилд тооцогдож байв. [17]. Гэвч эдгээр системүүд нь хязгаарлагдмал

өгөгдөл, дүрэмд суурилсан алгоритмын хүрээнд ажилладаг байсан тул өргөн хүрээний танин мэдэхүйн харилцааг дэмжих боломж харьцангуй бага байлаа.

## **1.2. Машин сургалт ба боловсролын өгөгдлийн эрин үе**

2010 оноос хойших хугацаанд боловсролын орчинд хиймэл оюуны хэрэглээ эрс өргөжсөн бөгөөд энэ шилжилтийг дэмжсэн хоёр үндсэн хүчин зүйл байв.

Нэгдүгээрт цахим сургалтын платформууд, Нийтэд нээлттэй онлайн хичээлүүд (Massive Open Online Courses, MOOC), боловсролын програм хангамжийн хэрэглээ огцом нэмэгдсэнээр асар их хэмжээний сургалтын өгөгдөл бий болсон [18], [19]. Үүнтэй уялдан сургалтын аналитик (Learning Analytics) хэмээх чиглэл хөгжиж, суралцагчийн оролцоо, ахиц, гүйцэтгэлийг өгөгдөлд суурилан шинжлэх боломж бүрдсэн [20].

Хоёрдугаарт, машин сургалтын алгоритмын дэвшил нь их хэмжээний боловсролын өгөгдлийг боловсруулах, хэв шинжийг илрүүлэх, суралцагчдын гүйцэтгэлийг таамаглах, улмаар хувь хүнд тохирсон зөвлөмж боловсруулах боломжийг эрс нэмэгдүүлсэн [21], [22]. Үүний үр дүнд дээд боловсролын салбарт хиймэл оюунд суурилсан сургалтын зөвлөмжийн системүүд, програмчлал болон математик зэрэг бодлогын хичээлүүдэд автомат үнэлгээний шийдлүүд, мөн нарийвчилсан хуулбар илрүүлэх механизм бүхий программ хангамжууд өргөнөөр нэвтрэх болсон байна [23]. Жишээлбэл: Turnitin платформ нь академик шударга байдлыг хангах зорилгоор текстийн ижилсэл, хувилбар илрүүлэх алгоритмыг ашигласан анхны хиймэл оюунд суурилсан шийдлүүдийн нэг байв.

2020 оноос өмнө хэд хэдэн их сургууль оюутны үйлчилгээний чатбот, түгээмэл асуултад хариулах систем, виртуал багшийн туслахын туршилтуудыг хэрэгжүүлж эхэлсэн нь боловсролын хиймэл оюуны хэрэглээ практикт шилжиж буйг илтгэнэ [24].

## **1.3. Боловсролын чатбот ба виртуал туслахууд**

Их хэлний (LLM) загвартай шууд хамааралгүй боловч боловсролын салбарт хиймэл оюуны хэрэглээг харуулсан анхаарал татахуйц жишээ нь 2016 онд АНУ-ын Жоржиа Технологийн Институтэд нэвтрүүлсэн “Жилл Ватсон” нэртэй хиймэл оюунд суурилсан багшийн туслах систем юм [25]. Уг системийг профессор Ашок Гоил IBM компанийн IBM Watson платформд тулгуурлан боловсруулсан бөгөөд онлайн хичээлийн хэлэлцүүлгийн форумд оюутнуудаас ирдэг давтамж өндөртэй асуултад автоматаар хариулах үүрэг гүйцэтгэж байв. Хамгийн сонирхолтой нь оюутнууд улирлын төгсгөл хүртэл “Жилл Ватсон” нь хүн бус, хиймэл оюунд суурилсан систем болохыг мэдээгүй байсан нь их багтаамжтай онлайн сургалтыг үр ашигтай дэмжихэд хиймэл оюуны технологи бодитой боломжтойг харуулсан туршлага болсон юм. Энэхүү жишээг боловсролын чатбот системийн хөгжлийн дараагийн шатны эхлэлийг тавьсан тохиолдол хэмээн судлаачид үнэлдэг [26].

#### **1.4. Бүтээлч хиймэл оюун ба их хэлний загварт суурилсан системүүдийн эргэлтийн үе**

2020-аад он нь дээд боловсрол дахь хиймэл оюуны хэрэглээ чанарын шинэ шатанд шилжсэн үе болж байна. Ялангуяа 2022 оны сүүлчээр ChatGPT-ийг олон нийтэд нэвтрүүлснээр бүтээлч хиймэл оюунд суурилсан, их хэмжээний өгөгдлөөр сургасан хэлний загварууд их сургуулийн сургалт, судалгааны орчинд шууд хэрэглэгдэх бодит боломж бүрдсэн [27].

Өмнөх үеийн хиймэл оюуны шийдлүүд нь ихэвчлэн хэрэглэгчид үл харагдах байдлаар өгөгдөл боловсруулах, автомат үнэлгээ хийх, гүйцэтгэлийн таамаглал гаргах зэрэг хязгаарлагдмал чиг үүрэгтэй байсан бол бүтээлч хиймэл оюун нь илүү идэвхтэй, харилцан үйлчлэлд суурилсан шинжтэйгээр дараах боломжийг нээж байна. Үүнд:

- Академик түвшний бичвэр боловсруулах
- Бодит цаг хугацаанд санал, тайлбар өгөх
- Судалгааны даалгавар, төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- Нарийн төвөгтэй ойлголтыг энгийн, хүртээмжтэй байдлаар тайлбарлах

Ийнхүү оюутнууд онолын болон мэргэжлийн төвөгтэй агуулгыг тайлбарлуулах, эсээ болон судалгааны бичвэр боловсруулах, программчлалын код бичих, эх сурвалжийн чиглэл тодорхойлох зэрэг үйл ажиллагаанд чатбот системийг ашиглах нь нэмэгдэж байна. Энэ өөрчлөлт нь сургалтын даалгаврын бүтэц, үнэлгээний арга зүй, академик шударга байдлын бодлого, цаашлаад төгсөгчдөөс шаардах мэргэжлийн ур чадварын шалгуурыг дахин авч үзэх шаардлагыг бий болгож байна [28], [29].

#### **1.5. Хөгжлийн логик ба өнөөгийн нөхцөл байдал**

Дээд боловсрол дахь хиймэл оюуны хөгжлийг дараах гурван үндсэн үе шатанд ангилан авч үзэж болно.

1. Ухаалаг багшлах системийн үе — хүний багшийн үйл ажиллагааг загварчилсан, дүрэмд суурилсан, хариу үйлдэл нь урьдчилан тодорхойлогдсон сургалтын системүүд давамгайлж байсан үе.
2. Машин сургалт ба их өгөгдлийн шинжилгээний үе — сургалтын үйл явцаас цугларсан өгөгдөлд тулгуурлан автомат үнэлгээ хийх, суралцагчдын гүйцэтгэлийг таамаглах, шийдвэр гаргалтыг өгөгдлөөр дэмжих боломж бүрдсэн үе.
3. Бүтээлч хиймэл оюун ба их хэмжээний өгөгдлөөр сургасан хэлний загварт суурилсан системийн үе — харилцан ярианд тулгуурласан, шинэ агуулга үүсгэх чадвартай, бодит цагийн дэмжлэг үзүүлэх боломжтой шийдлүүд эрчимтэй хөгжсөн үе.

Энэхүү хувьсал нь хиймэл оюуны зорилго, чадамж хэрхэн өргөжин өөрчлөгдсөнийг илэрхийлж байна. Анхны системүүд нь багшийг орлуулах, заах үйл ажиллагааг автоматжуулахад төвлөрч байсан бол орчин үеийн шийдлүүд нь багш, суралцагчтай хамтран ажиллах, мэдлэг бүтээх үйл явцыг дэмжих, сургалтыг илүү уян хатан, хувь хүнд тохирсон болгох чиглэлд шилжиж байна. Иймээс дээд боловсрол дахь хиймэл оюуны хөгжлийн түүхэн логикийг ойлгох нь сургалт удирдлагын системийн орчны өөрчлөлт,

үнэлгээний арга зүйн шинэчлэл, педагогикийн зохион байгуулалтын хувьслыг онолын үүднээс тайлбарлах чухал суурь болдог.

### **1.6. Сургалт удирдах систем ба хиймэл оюун: Ухаалаг суралцах орчны чиг хандлага**

Дээд боловсрол дахь хиймэл оюуны хөгжлийн дараагийн логик алхам нь сургалт удирдах системтэй уялдан хөгжих явдал юм. Сургалт удирдах систем нь их сургуулийн сургалтын үндсэн дэд бүтэц болж, хичээлийн агуулга байршуулах, даалгавар болон шалгалт зохион байгуулах, оюутны оролцоо, гүйцэтгэлийг хянах, сургалтын өгөгдөл цуглуулах төвлөрсөн орчин болон төлөвшсөн.

Анхны сургалт удирдах системүүд нь агуулга хадгалах, даалгавар хүлээн авах, сорил авах зэрэг удирдлагын шинжтэй функцэд төвлөрч байсан бол өнөө үед сургалтын стратеги, үнэлгээний арга зүй, багш-оюутны харилцаа, өгөгдөлд суурилсан шинжилгээтэй нягт уялдсан сургалтын экосистем болон өргөжин хөгжиж байна. Тухайлбал Moodle зэрэг нээлттэй эхийн системүүд нь модульчлагдсан бүтэц, аналитик тайлан, интерактив сургалтын орчныг дэмжих замаар сургалтын дизайны боломжийг өргөжүүлж байна.

Хиймэл оюуны хөгжлийн гурван үе шат—ухаалаг багшлах систем, машин сургалт ба өгөгдлийн шинжилгээ, бүтээлч хиймэл оюунд суурилсан системүүд—нь сургалт удирдах системийн хөгжлийн чиг хандлагатай уялдан дараах өөрчлөлтийг авчирч байна. Үүнд:

1. Агуулга төвтэй системээс суралцагч төвтэй системд шилжих
2. Статик үнэлгээнээс сургалтын үйл явцад суурилсан үнэлгээ рүү шилжих
3. Нэгдсэн, ерөнхий хөтөлбөрөөс хувь хүнд тохирсон, уян хатан сургалтын зохион байгуулалт руу шилжих

Хиймэл оюуны интеграц нь сургалт удирдах системд дараах шинэ боломжуудыг бий болгож байна. Үүнд:

- Оюутны оролцоо, гүйцэтгэлийн өгөгдөлд тулгуурласан таамаглалын загвар
- Суралцах хоцрогдлыг эрт илрүүлэх эрсдэлийн дохиоллын систем
- Хувь хүнд тохирсон санал, зөвлөмж бүхий адаптив сургалтын орчин
- Форматив үнэлгээний автомат санал, тайлбар

Эдгээрээс үзэхэд хиймэл оюун нь сургалт удирдах системийн нэмэлт туслах хэрэгсэл төдий бус, харин түүний дотоод үйл ажиллагааг өгөгдөлд суурилсан, ухаалаг механизмаар шинэ шатанд гаргах стратегийн хүчин зүйл болж байна.

## **II. ДЭЭД БОЛОВСРОЛ ДАХЬ ХИЙМЭЛ ОЮУНЫ ОЙЛГОЛТ**

### **2.1. Хиймэл оюуны ойлголт, чадварын онолын тодорхойлолт**

Хиймэл оюуны ойлголт, чадвар нь хувь хүн хиймэл оюунд суурилсан систем, хэрэгслийг ойлгох, оновчтой ашиглах, гаргасан үр дүнг шүүмжлэн үнэлэх, мөн тэдгээрийн боломж, хязгаарлалтыг ухамсарлах цогц чадамжийг

илэрхийлдэг [28]. Энэхүү ойлголт нь дээд боловсролын орчинд улам бүр чухал байр суурь эзэлж байна. Ялангуяа бүтээлч хиймэл оюун болон их хэмжээний өгөгдлөөр сургасан хэлний загварт суурилсан хэрэгслүүд сургалт, үнэлгээ, судалгааны үйл ажиллагаанд өргөн нэвтэрч буй өнөөгийн нөхцөлд энэ асуудал онцгой ач холбогдолтой болжээ [11, 28].

Рошеле болон хамтран судлаачдын тэмдэглэснээр [29], хиймэл оюун нь сургалтад шинэ боломжууд нээж байгаа боловч заах арга зүй, хичээлийн агуулга, үнэлгээний бүтцэд гүнзгий өөрчлөлт, сорилтыг бий болгож байна. Ийм нөхцөлд дэвшилтэт технологид суурилсан сургалтын арга барилыг нэвтрүүлэх шаардлага урган гарч байгаа бөгөөд хиймэл оюуны ойлголт, чадвар нь нэмэлт ур чадвар төдий бус, боловсролын чанарын үндсэн бүрэлдэхүүн хэсэг болж хувирч байна.

EDUCAUSE байгууллагын тайланд [30] хиймэл оюуны ойлголт, чадварыг дараах дөрвөн харилцан уялдаатай хэмжүүрээр тодорхойлсон байна. Үүнд:

1. Хиймэл оюуны системийн суурь ойлголтыг эзэмших
2. Хиймэл оюуны хэрэгслийг идэвхтэй, үр ашигтай ашиглах
3. Хиймэл оюунаар боловсруулсан үр дүнг шүүмжлэн үнэлэх
4. Хиймэл оюуны хэрэглээтэй холбоотой ёс зүй, нийгмийн асуудлыг ойлгож, хэлэлцүүлэгт оролцох

Энэхүү бүтэц нь хиймэл оюуны ойлголт, чадварыг зөвхөн техникийн хэрэглээний түвшинд бус, шүүмжлэлт сэтгэлгээ, ёс зүйн хариуцлагатай холбон авч үзэж байгаагаараа онцлог юм.

## **2.2. Хиймэл оюуны чадвар ба бусад дижитал чадварын ялгаа**

### **2.3.**

Хиймэл оюуны ойлголт, чадвар нь дижитал чадвар, мэдээллийн чадвар, медиа чадвар, өгөгдлийн чадвар зэрэг ойлголтуудтай уялдаа холбоотой боловч тэдгээрээс илүү өргөн хүрээ, гүнзгий агуулгыг хамардаг.

- Дижитал чадвар нь дижитал технологийг ашиглах, цахим орчинд хариуцлагатай, аюулгүй оролцох чадварыг хамарна [31].
- Мэдээллийн чадвар нь мэдээллийг хайх, үнэлэх, шүүмжлэн ашиглах чадамжийг илэрхийлнэ [31].
- Медиа чадвар нь медиа агуулга, илэрхийллийг дүн шинжилгээ хийх, утгыг задлан ойлгохтой холбоотой [33].
- Өгөгдлийн чадвар нь өгөгдлийг тайлбарлах, шинжлэх, дүгнэлт гаргах, шүүмжлэн ашиглах чадварыг илэрхийлэх бөгөөд суралцах үйл явцын өгөгдөлд суурилсан шинжилгээ, хиймэл оюунд тулгуурласан боловсролд онцгой ач холбогдолтой [30].
- Метачадвар буюу суурь чадвар нь дээр дурдсан чадваруудыг нэгтгэсэн өргөн хүрээний ойлголт бөгөөд метатанин мэдэхүй, хамтын суралцах үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагыг багтаадаг [34].

Харин хиймэл оюуны ойлголт, чадвар нь алгоритмын логик, “хар хайрцаг” шинжтэй ил тод бус системийн ажиллагаа, тэдгээрийн нийгэм, ёс зүйн үр дагаврыг ойлгох шаардлагаар онцгойрон ялгардаг [32]. Учир нь хиймэл оюун нь зөвхөн мэдээлэл боловсруулах төдий бус, хүний хэл яриа, ой санамж,

шийдвэр гаргалт, бүтээлч сэтгэлгээнд нөлөөлөх чадвартай технологи болж хөгжиж байгааг танин мэдэх шаардлагыг бий болгож байна [35].

#### **2.4. Хувийн төлөвлөгөөт суралцахуй ба хиймэл оюун**

Хиймэл оюунд суурилсан сургалтын орчинд амжилттай суралцахын тулд өөрөө зохицуулсан суралцах (self-regulated learning) чадвар онцгой ач холбогдолтой.

Сүүлийн үеийн судалгаанд хиймэл оюунтай холбоотой дөрвөн тулгуурт өөрөө зохицуулалтын бүтэц санал болгосон [36]:

1. Урам зориг (дотоод/гадаад, өөртөө итгэх итгэл)
2. Танин мэдэхүйн болон метакогнитив стратеги
3. Цаг, даалгаврын удирдлага
4. Орчин, технологийн зохицуулалт

Эдгээр чадвар нь их хэлний загвар болон суралцах аналитиктай орчинд бие даасан, хариуцлагатай суралцахад зайлшгүй шаардлагатай. Салбарын жишээнүүд (жишээлбэл GeoAI, байгалийн хэл боловсруулалт) нь хиймэл оюуны хэрэгслийг үр дүнтэй ашиглахын тулд буруу ойлголтыг засах, ажлын урсгалыг төлөвлөх, мотивацийг хадгалах микро-чадварууд чухал болохыг харуулж байна [37].

#### **2.5. Хэт найдах байдал ба “оюуны чадварын доройтол**

Хиймэл оюуны хэрэгслийн өргөн хэрэглээ нь шинэ төрлийн эрсдэлийг дагуулж байна. Судалгаагаар ChatGPT зэрэг хэрэгслийг хэт ашиглах нь ажлын ой санамж, бүтээлч байдал, гүйцэтгэх үйл ажиллагаанд тархины идэвхжил буурахтай холбоотой байж болзошгүйг харуулжээ [39]. Энэхүү үзэгдлийг “*оюуны чадварын доройтол*” (cognitive debt) гэж нэрлэдэг.

Оюуны чадварын доройтол гэдэг нь хүний танин мэдэхүйн үүргийг алгоритмын системд шилжүүлснээс үүдэх ур чадварын бууралтыг илэрхийлнэ. Иймээс хиймэл оюуны чадварын боловсролд хиймэл оюуныг зөв ашиглах чадвар төдийгүй хиймэл оюунаас хараат бус, өөрөө удирддаг суралцах чадвар (self-regulated learning) чухал хэсэг болж ордог.

#### **2.6. Их дээд сургуулийн түвшний шаардлага**

Сүүлийн үеийн судалгаагаар дээд боловсрол эзэмшихээр бэлдэж буй оюутнуудын хиймэл оюуны ойлголт, чадвар хангалтгүй байгааг харуулж, бүх түвшинд хиймэл оюуны чадварыг хөтөлбөрт системтэйгээр нэвтрүүлэх шаардлагатайг онцолж байна. Хөгжиж буй орнуудад технологийн нөөц ба сургалтын боловсон хүчний хомсдол нь энэ хэрэгцээг улам тодотгож байна [40]. Хиймэл оюуны чадвар хөгжүүлэх стратеги нь дараах боломжуудыг бүрдүүлдэг:

- Академик шударга байдлыг хамгаалах
- Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх
- Хуулбарлах эрсдэлийг бууруулах
- Хариуцлагатай хэрэглээг дэмжих

Үр дүнг хэмжихийн тулд хиймэл оюунтай холбоотой ойлголт, ур чадварыг үнэлэх оношлогооны хэрэгсэл ашиглах нь оюутанд чиглэсэн дэмжлэг үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг [36].

### **Ш. ДЭЭД БОЛОВСРОЛД ХИЙМЭЛ ОЮУНЫ ЕРӨНХИЙ ХЭРЭГЛЭЭ**

Хиймэл оюун (AI) нь дээд боловсролд суурь хэрэгсэл болж, заах, суралцах, судлах, бичих, оюутны үнэлгээ зэрэг олон академик үйл ажиллагаанд нөлөөлж байна. Ялангуяа 2020 оноос хойш генератив AI хэрэгслүүд (жишээ нь ChatGPT, Copilot, Claude, Gemini гэх мэт) дэлхий даяар тархсанаар эдгээр технологийн хэрэглээ хурдан өргөжиж байна. Crompton болон Song [25]-ийн үзэж байгаагаар, хиймэл оюун нь хувь хүнд тохирсон суралцах боломжийг нэмэгдүүлж, заах үйл ажиллагааг хүртээмжтэй болгох замаар дээд боловсролыг өөрчлөх асар их боломжтой юм.

Сүүлийн үеийн судалгаагаар хиймэл оюун нь зөвхөн заах аргыг дэмжих, суралцахыг хувь хүнд тохируулах (хэрэглэгчид тохируулсан сургалт, цаг тухайд нь санал, эргэх холбоо) төдийгүй захиргааны ажлыг хөнгөвчлөх (жишээ нь хуваарь гаргах, харилцаа холбоо) болон бүтээлч сэтгэлгээ, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх боломжийг олгодог болохыг харуулж байна [38]. Гэсэн хэдий ч эдгээр судалгаанууд өгөгдөл хамгаалалт, алгоритмын тэгш бус байдал, дижитал тэгш бус байдал, хүний харилцааны хомсдол зэрэг эрсдлийг онцолж, хиймэл оюуныг боловсролын үнэт зүйлстэй нийцүүлэн хэрэглэхийн тулд анхааралтай төлөвлөлт, багшийн сургалт, бүх оролцогч талуудын хамтын ажиллагаа шаардлагатайг сануулж байна [38]. Эдгээр хамгаалалттай хэрэглэх тохиолдолд AI нь дээд боловсролыг илүү адаптив, хүртээмжтэй, үр дүнтэй болгох боломжтой бөгөөд жишээ нь газарзүйн салбар, NLP, learning analytics, ITS зэрэг нь оюутанд төвлөрсөн суралцах орчинг дэмжиж байгаа боловч ёс зүй, хүртээмжийн асуудалтай тулгардаг [37].

#### **3.1. Дээд боловсрол дахь хиймэл оюуны давуу тал**

Хиймэл оюун ба дээд боловсролын хооронд асар их боломжит уялдаа холбоо бий. Хиймэл оюун нь сургалтыг хувь хүнд тохируулан зохион байгуулах, агуулга боловсруулахад дэмжлэг үзүүлэх замаар оюутны оролцоог нэмэгдүүлж, суралцах үр дүнг оновчлох боломжтой. Энэ нь суралцагчдын амжилтыг сайжруулах, тогтвортой суралцах байдлыг нэмэгдүүлэх, мөн шүүн тунгаах болон шүүмжлэлт сэтгэлгээний чадварыг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Хиймэл оюуныг сургалтад нэгтгэснээр бүтээлч боломжууд хязгааргүй өргөждөг. Тухайлбал, шинэлэг сургалтын материал, симуляци, виртуал лаборатори боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. Хиймэл оюуны-г VR (виртуал бодит байдал)-ийн симуляцитай хослуулах нь ирээдүйн мэргэжилтнүүдийн өөртөө итгэх итгэл, асуудал шийдвэрлэх чадвар, клиник бэлтгэлийг нэмэгдүүлж, бодит нөхцөлд тулгарах сорилтуудад бэлэн болгоход тусалдаг. Мөн хиймэл оюун нь суралцагч бүрийн өвөрмөц суралцах хэв маягийг харгалзан үзэж, хүртээмжтэй боловсролыг дэмжих боломжтой. хиймэл оюун нь оюутны илүүд үздэг суралцах арга барилыг тодорхойлж, хичээлийн агуулгыг түүнд тохируулан өөрчилж чадна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй

суралцагчдын хүртээмжийг нэмэгдүүлдэг. хиймэл оюуны дасан зохицох чадвар нь суралцахад тулгарч буй бэрхшээлийг илрүүлж, багш нарт шаардлагатай дэмжлэгийг хамгийн тохиромжтой хэлбэрээр үзүүлэх боломж олгоно. Үүнээс гадна хиймэл оюун нь хэлний саадыг бууруулахад тусалж, илүү олон оюутанд боловсрол эзэмших боломжийг нээж өгдөг.

### **3.2. Дээд боловсрол дахь хиймэл оюуны тулгамдсан асуудлууд**

Хиймэл оюун ба дээд боловсролыг хослуулах нь олон давуу талтай боловч сорилт, ёс зүйн асуудлуудаас шалтгаалан болгоомжлол үүсдэг. Дээд боловсролд хиймэл оюуныг нэвтрүүлэх шилжилт нь тодорхой эрсдэл дагуулна. Үүнд:

- Ёс зүйн асуудал: хиймэл оюунаар бүтээсэн контентын үнэн зөв, магадлал, академик шударга байдал.
- Дижитал тэгш бус байдал: Технологийн нөөц, хүртээмжийн ялгаа нь оюутны суралцах боломжид нөлөөлж болзошгүй.
- Хувийн мэдээлэл, өгөгдлийн хамгаалалт: хиймэл оюун системд өгөгдөл оруулахад нууцлал, GDPR зэрэг дүрмийн хэрэгжилт.
- Хүний оролцоо, багшийн удирдлага: хиймэл оюунд хэт найдах нь когнитив чадвар, бүтээлч сэтгэлгээний доройтолд хүргэх эрсдэлтэй.

Гэсэн хэдий ч, эрүүл мэндийн боловсролын салбарын багш, сургагчид хиймэл оюуны хувьсгалыг зөв удирдах, суралцах процессыг дэмжих боломжтой бөгөөд хөндлөнгөөс ажиглагч хэвээр үлдэх шаардлагагүй юм.

## **IV. ДЭЭД БОЛОВСРОЛ ДАХЬ СУРГАЛТ УДИРДАХ СИСТЕМИЙН ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ**

Дээд боловсролын хүрээнд сургалт удирдах систем нь суралцах, заах, үнэлгээ, мэдээллийн урсгалыг нэгтгэсэн үндсэн платформ болж ирсэн. Сургалт удирдах системийн хөгжлийн явц нь гурван үндсэн үе шаттай холбон тайлбарлагддаг:

### **4.1. Статик сургалт удирдах систем (Static сургалт удирдах систем)**

Эхний үеийн сургалт удирдах систем нь статик, төвлөрсөн бүтэцтэй бөгөөд голлон контент хүргэх зорилготой байв. Багш нь хичээлийн материалыг байршуулж, оюутнууд зөвхөн хүлээн авах үүрэг гүйцэтгэдэг, интерактив элемент бараг байдаггүй. Үүнд дараах онцлогууд орно:

- Агуулга нь PDF, үзүүлэн, видео гэх мэт статик файлуудаар дамждаг.
- Оюутны оролцоо хязгаарлагдмал, зөвхөн хичээлийн агуулгыг үзэж, татаж авах.
- Сургалтын үр дүнг үнэлэх, хичээлд тохирох санал авах процесс гараар явагддаг.

Статик сургалт удирдах систем нь эхний шатанд боловсролын дижиталжуулалтын суурийг тавьсан ч хувь хүнд тохирсон суралцах боломж, өгөгдөлд суурилсан үнэлгээ зэрэг боломжууд дутмаг байв.

### **4.2. Интерактив сургалт удирдлагын систем**

Дараагийн үе шат нь интерактив сургалт удирдах систем, оюутны оролцоо, багшийн харилцааг нэмэгдүүлэхэд төвлөрсөн. Энэхүү үе шатанд сургалт удирдах систем нь зөвхөн контент хүргэх биш, суралцах туршлагыг идэвхтэй дэмжих боломжтой болсон. Үүнд:

- Онлайн тест, quiz, discussion forum, assignment submission зэрэг интерактив элементийг багтаасан.
- Хувийн суралцах аргачлал (adaptive learning) болон бодит цагийн эргэх холбооны зарчмыг тодорхой хэмжээнд дэмжих.
- Суралцагчийн идэвхийг хэмжих, оюутны оролцоог дүн шинжилгээ хийх боломжтой, гэхдээ ихэнхдээ статистик, стандарт арга ашигладаг.

Интерактив сургалт удирдах систем нь суралцах үйл явцыг хувь хүнд илүү тохирсон болгох боломжийг нээсэн ч, хиймэл оюуны дэмжлэггүйгээр зөвхөн зөвлөмж, өгөгдлийн анализ нь хязгаарлагдмал байлаа.

### **4.3. Хиймэл оюуныг сургалт удирдах системд нэгтгэх нь**

Сүүлийн үеийн үе шат нь хиймэл оюунтай нэгтгэсэн сургалт удирдах систем, оюутны суралцах орчинг ухаалаг, динамик болгодог. Бүтээлч хиймэл оюун, сургалтын аналитик, машин сургалтын алгоритмыг сургалт удирдах системд шууд нэгтгэж, оюутны суралцах зам, үнэлгээ, дэмжлэгийг автоматжуулж чаддаг. Онцлог нь:

- Хувийн тохируулга бүхий суралцах орчин: хиймэл оюун оюутны суралцах хэв маяг, гүйцэтгэл, өмнөх мэдлэгийг дүгнэж, хичээлийн агуулгыг тохируулна.
- Автомат үнэлгээ, эргэх холбоо: Зохиомжийн даалгавар, олон сонголтот шалгалт, эссэ зэрэгт хиймэл оюун автомат үнэлгээ, саналыг өгнө.
- Сургалтын аналитик: (Learning analytics) хиймэл оюун ашиглан оюутны оролцоо, хичээлийн үр дүнг үнэлж, багшид зөвлөмж гаргана.
- Chatbot, виртуал туслах: ChatGPT-ээр ажиллах чатбот эсвэл виртуал багш нь асуулт хариулах, даалгавар боловсруулахад тусална.
- Ёс зүй, хариуцлагатай хэрэглээ: хиймэл оюуны хэрэглээтэй холбоотой академик шударга байдал, өгөгдлийн нууц, ёс зүйн асуудлыг сургалт удирдах систем бодлогоор хянах боломжтой.

Хиймэл оюуныг сургалт удирдах системд нэгтгэх нь оюутны ухаалаг суралцах орчныг бүрдүүлэх, сургалтын үр дүнг дээшлүүлэх, багш нарын цаг, эрчмийг үр ашигтай ашиглахад чиглэсэн хамгийн дэвшилтэт арга юм. Энэ нь зөвхөн технологийн шинэчлэл бус, педагогик шинэчлэл, хувь хүнд тохирсон суралцах стратегийг сургалт удирдах системд нэвтрүүлэхэд чухал алхам болно.

### **4.4. Сургалт удирдах систем-д хиймэл оюуны хэрэглээ**

Сургалт удирдах системийн хүрээнд хиймэл оюун нь суралцагчдын платформ дахь зан төлөв, оролцоо, гүйцэтгэлийг гүнзгий шинжилдэг сургалтын загвар, алгоритмуудын цогц хэлбэрээр ажилладаг. Цуглуулсан өгөгдөл нь сургалтыг цаашид сайжруулах, хөгжүүлэх суурь болж, хичээлийг оюутны хэрэгцээнд нийцүүлэх, зөвлөмж өгөх, шаардлагатай дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Сургалт удирдах систем платформд нэгтгэсэн “ухаалаг туслах” хэлбэрээр AI дараах үндсэн үүргүүдийг гүйцэтгэдэг:

#### **1. Дасан зохицох сургалт (Adaptive learning)**

Хиймэл оюун нь оюутан хичээлийн материалыг хэр хэмжээнд эзэмшсэнийг хянаж, ойлголт дутуу байгаа хэсгийг илрүүлдэг. Гүнзгий дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн сэдвийг илүү сайн ойлгоход туслах нэмэлт материалын жагсаалтыг санал болгодог.

## **2. Тохирох контент үүсгэх ба сонгох**

Сургалт удирдах систем нь видео, нийтлэл, сорил, флаш карт зэрэг өргөн хүрээний сургалтын болон интерактив материалын сантай байдаг. Оюутан тодорхой сэдвээр ажиллаж байх үед хиймэл оюун нь уг сангаас нэмэлт, тохирох материалыг санал болгож, ойлголтыг бататгахад дэмжлэг үзүүлдэг.

## **3. Чатботоор дамжсан онлайн туслах**

Сургалт удирдах систем нь өргөн хэмжээний сургалтын материал, олон курс агуулсан тохиолдолд шаардлагатай хичээл, нийтлэл зэргийг олоход цаг зарцуулах шаардлагатай болдог. Ийм үед хиймэл оюунд суурилсан чатботоос асуулт асууж, хурдан мэдээлэл авах боломжтой. Энэ нь хиймэл оюуны хэрэглээний энгийн жишээ бөгөөд үүнээс гадна олон төрлийн хэрэглээ бий.

## **4. Урьдчилан таамаглах аналитик ба эрт үеийн дэмжлэг**

Суралцагчийн идэвх сулрах, хэд хэдэн шалгалтад амжилтгүй оролцох зэрэг нь AI системд эрсдэлийн дохио болдог. Ийм тохиолдолд хиймэл оюун нь сануулга илгээж, багштай уулзах, суралцах замаа өөрчлөх зэрэг зөвлөмж өгч, эрт үеийн дэмжлэг үзүүлдэг.

## **5. Үнэлгээний үйл явцыг автоматжуулах**

Сургалтын загварууд нь хиймэл оюунд тестийн хариулт, богино бичгийн даалгаврыг үнэлэх, шуурхай санал хүсэлт өгөх боломж олгодог. Жишээлбэл: оюутан эссэ бичиж сургалт удирдах системд байршуулсны дараа хиймэл оюун нь текстийг задлан шинжилж, бүтэц, логик дараалал, сул талыг тодорхойлон зөвлөмж өгнө. Ингэснээр багш нарын ажлын ачаалал буурч, үнэлгээ илүү хурдан, системтэй явагдах боломжтой болно.

## **Сургалт удирдах систем платформд хиймэл оюуныг нэгтгэх үндсэн үе шат**

Сургалт удирдах систем платформд хиймэл оюуны (AI) шийдэл нэвтрүүлэх нь стратегийн түвшний төлөвлөлт, техникийн бэлтгэл, институцийн бэлэн байдлыг шаардсан олон шатлалт үйл явц юм. Иймд AI интеграц нь шууд хэрэгжилт бус, урьдчилсан дүн шинжилгээнээс эхлэх ёстой.

### **1. Зорилго тодорхойлох**

Юуны өмнө AI хэрэгслүүд ямар асуудлыг шийдвэрлэхийг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

- Сургалтын агуулга судалж дуусах хувийг нэмэгдүүлэх
- Захиргааны ачааллыг бууруулах
- Суралцагчийн оролцоог нэмэгдүүлэх
- Хувь хүнд нийцсэн сургалтыг хэрэгжүүлэх

Эдгээр зорилгод үндэслэн тохирох AI хэрэгслүүдийн жагсаалтыг гаргана. Жишээлбэл: хэрэглэгчид тохируулсан алгоритм, урьдчилан таамаглах аналитик, чатбот, автомат үнэлгээний систем гэх мэт.

### **2. Дэд бүтцийн бэлэн байдлыг үнэлэх**

Дараагийн алхам бол одоо ашиглаж буй сургалт удирдах системийн техникийн боломжийг үнэлэх явдал юм. Үүнд:

- API болон гуравдагч талын интеграц дэмждэг эсэх
- Хэрэглэгчийн зан төлөвийн хангалттай өгөгдөл хуримтлагдсан эсэх
- Өгөгдлийн чанар, бүтцийн стандарт

Хиймэл оюуны алгоритм үр дүнтэй ажиллахын тулд чанартай, хангалттай хэмжээний өгөгдөл зайлшгүй шаардлагатай.

### **3. Тэргүүлэх функцүүдийг сонгон хэрэгжүүлэх**

Хиймэл оюуны бүх боломжийг нэг дор нэвтрүүлэх нь эрсдэлтэй тул сургалтын гол асуудлыг шийдвэрлэх функцүүдийг эхний ээлжид сонгоно. Сонгосон шийдлийн эргэн тойронд техникийн дэд бүтцийг байгуулж, шаардлагатай бол орчин үеийн технологи эсвэл гуравдагч талын үйлчилгээ ашиглана.

Мөн системийн өргөтгөх чадварыг урьдчилан тооцох шаардлагатай. Суралцагчдын тоо өсөх үед систем оргил ачааллыг даах чадамжтай байх ёстой.

### **4. Туршилт ба хэмжилт**

Хиймэл оюуныг системд нэгтгэх шийдлийг эхний ээлжид хязгаарлагдмал хэрэглэгчийн бүлэг дээр туршина. Үндсэн үзүүлэлтүүдийг хэмжинэ:

- Оролцооны түвшин
- Курс төгсөлтийн хувь
- Нэг курсэд зарцуулсан дундаж хугацаа
- Хэрэглэгчийн сэтгэл ханамж

Мөн багш, суралцагчдын санал хүсэлтийг цуглуулж, үр дүнтэй болон сайжруулах шаардлагатай хэсгүүдийг тодорхойлно.

### **5. Тасралтгүй сайжруулалт**

Туршилтын дараа AI функцүүдийн хэрэглээ, үр нөлөөг тасралтгүй шинжилнэ. Үр ашиг нэмэгдсэн эсэхийг үнэлж, шаардлагатай бол алгоритмыг тохируулах, контентыг шинэчлэх, UI/UX-ийг сайжруулах замаар системийг боловсронгуй болгоно. Ийнхүү AI интеграц нь нэг удаагийн үйл явц бус, өгөгдөлд суурилсан тасралтгүй хөгжлийн цикл юм.

## **Сургалт удирдах системд хиймэл оюун нэвтрүүлэхийн үр өгөөж**

Хиймэл оюуныг сургалт удирдах системд нэгтгэх нь сургалтын чанар төдийгүй байгууллагын менежментийн үр ашгийг нэмэгдүүлдэг стратегийн давуу талтай.

### **1. Зардал ба захиргааны ачааллыг бууруулах**

Үнэлгээ, сануулга, ахицын хяналт зэрэг олон үйл явц автоматжсанаар сургалтын удирдлагын зардал буурна. Захиргааны ажилтнууд AI-ийн боловсруулсан өгөгдөлд тулгуурлан шийдвэр гаргах боломжтой болно.

### **2. Сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх**

Хувь хүнд тохируулах механизмын ачаар суралцагч “зөв материалыг, зөв цагт” хүлээн авна. Ингэснээр суралцах явц илүү сонирхолтой, үр дүнтэй болж, сургалтыг богино хугацаанд амжилттай дүүргэх боломж нэмэгдэнэ.

### **3. Аналитик дээр суурилсан стратегийн шийдвэр**

AI аналитик нь сургалтын үр дүнг илүү гүнзгий, цогцоор харах боломж олгоно. Энэ нь:

- Бодлогын түвшний илүү оновчтой шийдвэр гаргах
- Сургалтын төсвийг үр ашигтай зарцуулах
- Байгууллагын сургалтын хөрөнгө оруулалтаас илүү их үнэ цэнэ бий болгох боломжийг бүрдүүлнэ.

### **4. Хэрэглэгчийн туршлагыг сайжруулах**

Хиймэл оюунд суурилсан чатбот болон ухаалаг туслахууд нь суралцагч, ажилтнуудад шуурхай хариулт өгч, агуулгад уян хатан хандах боломж бүрдүүлнэ. Энэ нь байгууллагын эерэг төлөв байдлыг бэхжүүлж, сургалтын орчныг орчин үеийн, шинэлэг шийдэлтэй болгож харуулдаг. Ийм системийг ажиллуулахад заавал том баг шаардлагагүй; харин суралцагч бүрийн хэрэгцээнд дасан зохицох ухаалаг алгоритм чухал үүрэгтэй.

## V. ДҮГНЭЛТ

Дээд боловсрол дахь хиймэл оюуны хөгжлийн логик нь ухаалаг багшлах системээс машин сургалт, улмаар бүтээлч хиймэл оюунд суурилсан харилцан үйлчлэлтэй орчин руу шилжсэн гурван үндсэн үе шаттайгаар тодорхойлогдож байна. Энэхүү хувьсал нь сургалтын агуулга төвтэй загвараас суралцагч төвтэй, өгөгдөлд суурилсан, адаптив зохион байгуулалт бүхий систем рүү шилжих нөхцөлийг бүрдүүлжээ.

Сургалт удирдах системүүд, ялангуяа Moodle зэрэг нээлттэй эхийн платформууд нь хиймэл оюуны интеграцийн стратегийн суурь дэд бүтэц болж байна. Хиймэл оюуныг сургалт удирдах системд нэгтгэснээр суралцах аналитик, эрт үеийн эрсдэлийн илрүүлэлт, автомат үнэлгээ, чатбот туслах, хувь хүнд тохирсон сургалтын зам зэрэг ухаалаг функцүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдэж байна. Гэсэн хэдий ч энэхүү интеграц нь технологийн шийдлээс гадна педагогик шинэчлэл, өгөгдлийн засаглал, ёс зүйн хяналт, хиймэл оюуны ойлголт, чадварыг системтэй хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хиймэл оюуныг Moodle системд амжилттай нэгтгэх нь зөвхөн техникийн интеграц бус, харин багш, суралцагч, байгууллагын түвшний бэлэн байдал, стратегийн төлөвлөлт, тасралтгүй үнэлгээний үйл явцтай уялдах цогц шинэчлэл юм. Иймээс хиймэл оюуныг сургалт удирдах системд нэгтгэх нь дээд боловсролын ирээдүйн ухаалаг суралцах экосистемийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох хандлагатай байна.

## НОМ ЗҮЙ:

- [1] O. Agaci, "Learning management systems in higher education," *Journal of Educational Technology*, 2017.
- [2] N. Shumeiko, "Digital transformation of LMS platforms," *International Journal of Educational Systems*, 2024.
- [3] A. P. Lopes, "Learning management systems in higher education," *Procedia - Social and Behavioral Sciences*, vol. 174, pp. 215–222, 2014.
- [4] R. Mukhametshin et al., "Implementation of LMS in blended learning," *International Journal of Emerging Technologies in Learning*, 2019.
- [5] A. Ghosh et al., "Digital platforms in higher education," *Education and Information Technologies*, 2019.
- [6] S. Gamage et al., "Moodle as a learning management system in higher education," *Sustainability*, vol. 14, 2022.
- [7] D. Kaleci and M. Kapıdere, "The use of Moodle in higher education," *Procedia - Social and Behavioral Sciences*, vol. 116, pp. 2715–2719, 2014.
- [8] R. Simanullang and J. Rajagukguk, "Online learning through Moodle," *Conference Series*, 2020.

- [9] N. Aldahwan and D. Alsaed, "The role of AI in learning management systems," 2020.
- [10] S. Gowrabhathini et al., "AI integration in LMS," *Education and Information Technologies*, 2023.
- [11] L. Manhiça et al., "Artificial intelligence in higher education systems," *Computers and Education: AI*, 2022.
- [12] M. P.-C. Lin, "ChatGPT in higher education," *Interactive Learning Environments*, 2023.
- [13] M. Elam, "Ethical considerations of AI in education," *AI & Society*, 2024.
- [14] M. Roshanaei et al., "Bias and ethics in AI-driven education," *Computers & Education*, 2023.
- [15] B. Woolf, *Building Intelligent Interactive Tutors*, Morgan Kaufmann, 2009.
- [16] K. VanLehn, "The behavior of tutoring systems," *International Journal of AI in Education*, 2011.
- [17] R. Nkambou et al., *Advances in Intelligent Tutoring Systems*, Springer, 2010.
- [18] C. Pappano, "The Year of the MOOC," *The New York Times*, 2012.
- [19] G. Siemens, "MOOCs and learning analytics," 2013.
- [20] R. Ferguson, "Learning analytics: drivers and developments," *International Journal of Technology Enhanced Learning*, 2012.
- [21] C. Romero and S. Ventura, "Educational data mining: A review," *IEEE Transactions on Systems, Man, and Cybernetics*, 2013.
- [22] T. Baker and P. Inventado, "Educational data mining and learning analytics," 2014.
- [23] D. Weber-Wulff, *False Feathers: A Perspective on Academic Plagiarism*, Springer, 2014.
- [24] S. Winkler and M. Söllner, "Unleashing the potential of chatbots in education," 2018.
- [25] A. Goel and R. Polepeddi, "Jill Watson: A virtual teaching assistant," *AI Magazine*, 2016.
- [26] A. Goel, "AI teaching assistants in online education," 2017.
- [27] OpenAI, "ChatGPT: Optimizing language models for dialogue," 2022.
- [28] M. Kasneci et al., "ChatGPT for education: opportunities and challenges," 2023.
- [29] UNESCO, "Guidance for generative AI in education and research," 2023.
- [30] J. Zawacki-Richter et al., "Systematic review of AI in higher education," *International Journal of Educational Technology in Higher Education*, 2019.
- [31] H. Chen et al., "Artificial intelligence in learning management systems," 2022.
- [32] S. Kovanović et al., "Learning analytics in LMS environments," 2021.
- [33] Long, D., & Magerko, B., "What is AI Literacy?," *CHI Conference Proceedings*, 2020.
- [34] Roshanaei, M. et al., "Artificial Intelligence and Pedagogical Transformation," 2023.
- [35] EDUCAUSE, *AI Literacy in Higher Education*, 2023.
- [36] European Commission, *DigComp 2.2: The Digital Competence Framework*, 2022.
- [37] Potter, W. J., *Media Literacy*, 2019.
- [38] Mackey, T., & Jacobson, T., "Metaliteracy," *College & Research Libraries*, 2011.
- [39] Pasquale, F., *The Black Box Society*, Harvard University Press, 2015.
- [40] Bender, E. et al., "On the Dangers of Stochastic Parrots," *FACCT*, 2021.



## **БОЛОВСРОЛ СУДЛАЛ**



**СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ЯПОН ХЭЛНИЙ ОРЧУУЛАГЧИЙН  
АНГИЙН ОЮУТНУУДАД ЯПОН СУДЛАЛЫН ХИЧЭЭЛИЙГ  
ЗААХ АРГА**

**-Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааны жишээгээр-**

*Асами Коичиро  
(Соёл Эрдэм дээд сургууль  
Япон судлалын тэнхмийн зочин багш, Магистр)*

**1. Соёл Эрдэм дээд сургуулийн Япон судлалын хичээл**

Миний бие 2023–2024 оны хичээлийн жилээс “Япон судлал” хичээлийг заадаг. Одоогийн байдлаар Соёл Эрдэм дээд сургуулийн Япон хэлний орчуулагчийн ангийн 4-р курст, нийт 3 кредит бүхий “Япон судлал” хичээл ордог. Энэ хичээлд “日本事情入門 View of Today’s Japan” гэдэг япон, англи хэлтэй сурах бичгийг ашигладаг. Энэ сурах бичгийн агуулга нь “Японы газар зүй, байгаль орчин ба улирал”, “Япончуудын амьдрал”, “Японы баяр, ёслол” гэх мэт нийт 21 сэдэвтэй.

Энэхүү хичээлээр Япон хэлний орчуулга болон Япончуудтай харилцахад шаардлагатай мэдлэгийг эзэмших боломжтой. Гэвч 4-р анги хүртэл Япон судлалын мэдлэгийг эзэмшдэггүй тул 1–3-р ангиар Япон руу явах оюутнууд Японд амьдрахад хэрэгтэй мэдлэгийг авч чадахгүйгээр явдаг гэсэн асуудал үүсдэг.

СЭДС нь Японы олон сургууль, байгууллагатай оюутан солилцоо, дадлагын гэрээтэй, учир нь 1-р ангиас ч Япон руу явах боломжтой. Мөн Япон руу явж чадахгүй оюутнууд СЭДС-ийн харьяа Шилийн булаг жуулчны баазад дадлага хийж, Япон жуулчидтай харилцах боломжтой. Ийм байдлаар оюутнууд Япончуудтай харилцан япон хэлээ сайжруулах боломжтой боловч Япон судлалыг 4-р анги хүртэл үздэггүй нь харилцаанд саад болдог.

Энэ удаа энэ сурах бичгийн “Япон дахь ажилчдын амьдрал” хэсгээс төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааг жишээ болгон судлах болно.

**2. Япон дахь төгсөх ангийн оюутны ажил хайх үйл ажиллагаа**

Эхлээд Япон дахь төгсөх ангийн оюутны ажил хайх үйл ажиллагааг тайлбарлая.

Япон дахь төгсөх ангийн оюутны ажил хайх үйл ажиллагаа нь Япон дахь байгууллагууд төгсөх ангийн оюутнуудыг жил бүр хичээлийн жил эхлэх хавар нэгэн зэрэг олноор ажилд авч, дараа нь дараагийн жилийн 4-р сарын 1-ний өдрөөс байгууллагад орж, байгууллагад хэдэн сар дадлага хийсний дараа тушаалын дагуу албан ёсоор ажилд ордог гэсэн дэлхийд ганцхан Японд байдаг онцлогтой систем юм.

Энэ системийн ачаар Япон улсын залуучуудын ажилгүйдлийн хувь сүүлийн 10 жилд 10-аас доош байгаа нь давуу тал болдог. Гэвч сургуулиа төгсөхөөс өмнө ажилчдыг сонгон шалгах шалгалтанд бэлдэх хэрэгтэй тул бакалаврын ангийн оюутнууд ч бүтэн 4 жил хичээлд суух боломжгүй байдаг. Мөн 4-р ангийн оюутан байхдаа хүссэн байгууллагад ажилд орж чадаагүй, эсвэл сургуулиа төгссөний дараа ажиллахаа орхиж, өөрийн хүссэн байгууллагад ороход хэцүү гэсэн сул тал ч байна.

Япон дахь төгсөх ангийн оюутны ажил хайх үйл ажиллагааны явцыг үзвэл:

- 3-р ангийн 3-р сар буюу 3-р ангийн сүүлийн сараас компаниудын зохион байгуулдаг “Компанийн танилцуулга”, “Компанийн үзэсгэлэн”-д оролцож, компаниудыг харьцуулан судална.

- Дараа нь хүссэн компанийн шалгалтанд бүртгүүлж, анкет бөглөн компани руу илгээдэг.

- Мөн ерөнхий эрдмийн шалгалт өгдөг.

- 4-р ангийн 6 сар буюу 4-р ангийн эхний улиралд ярилцлагад орж, хүссэн компанийн ярилцлагад тэнцэх хүртэл үргэлжлүүлнэ.

【Хүснэгт】 Япон дахь төгсөх ангийн оюутны ажил хайх үйл ажиллагааны явц  
3-р анги

3-р сар 4-р анги

4-р сар 4-р анги

5-р сар 4-р анги

6-р сар 4-р анги

7-р сар 4-р анги

8-р сар 4-р анги

9-р сараас

Бүртгэл

Компанийн танилцуулга

Компанийн үзэсгэлэн

Анкет илгээх

Цаасан шалгалт

Ярилцлага

Анкет болон ярилцлагыг бэлдэх нь Монголтой адилхан ч Япон компанийн шаардагддаг анкетаар олон асуулттай байдаг. Мөн ярилцлагыг дор хаяж 2 удаа, хамгийн ихдээ 5 удаа авдаг. Эхний ярилцлаганд залуу настай ажилтан оролцож, сүүлийн ярилцлаганд удирдах зөвлөлийн гишүүд эсвэл захирал оролцдог.

Анкетийн маягтын жишээний нэг хэсгээс үзвэл, нэр, хаяг, боловсролын зэрэг гэх мэт хувийн мэдээлэлээс гадна зан чанар, чадвар, туршлагатай холбоотой асуултууд байдаг. Түгээмэл асуугддаг асуулт нь “Өөрийн PR” болон “Оюутан байхдаа хамгийн их хүчин чармайлт гаргасан зүйл” юм. “Өөрийн PR” нь өөрийн зан чанар болон чадвараа өнөөг хүртэлх өөрийн туршлагаар батлан харуулах асуулт юм. “Оюутан байхдаа хамгийн их хүчин чармайлт гаргасан зүйл” нь хичээл бус цагаар хийсэн зүйл, түүнээс гарах өөрчлөлт, сурсан зүйлийг тайлбарлаж хариулах асуулт юм.

【Зураг】 Анкетийн маягтийн жишээний нэг хэсэг

Ийм асуултуудад хариулахын тулд Япон оюутнууд хичээлийн хажуугаар өөрийн зан чанарыг эргэцүүлж, өөрийгөө ойлгох, сургуулийн клубт оролцох, цагийн ажил хийх, дотоод болон гадаадад сайн дурын ажил хийх гэх мэт бэлтгэл хийх хэрэгтэй болдог.

Энэхүү системийн ачаар Япон залуучууд сургуулиа төгсөнгүүт шууд ажилд орох боломжтой байдаг. Гэвч энэ хугацаанд ажилд орохгүй бол цаашид хүссэн ажилд орох, эсвэл ажилд орсны дараа ажлаа сольход хэцүү гэсэн сул тал үүсдэг. Мөн Японы ажилчид ажлаа удаан сольдоггүй учир ажил олгогч нь ажилтны ачааллыг бодолгүйгээр хэт их ажиллуулах асуудал гардаг.

Энэ нь Японы алдартай стресстэй нийгэм, мөн “Кароши” (ажлын ачааллаас болж нас барах) зэрэг асуудлын нэгэн шалтгаан гэж хэлж болно.

Иймээс энэхүү систем нь Японы нийгэм, соёл, Япончуудын амьдралд их нөлөө үзүүлдэг. Тиймээс ийм туршлага хуримтлуулсан Япончуудтай харилцан ажиллахыг хүсэж буй бүх гадаад хүн заавал мэдэх ёстой мэдлэг юм.

### **3. Япон судлал хичээлд Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааг заах**

2025 оны 9-р сараас СЭДС-ийн Япон хэлний орчуулагчийн 4-р ангид 7 хоногт 2 удаа, нэг удаа 90 минут ордог “日本事情入門 Views of Today’s Japan” сурах бичгийг ашигласан “Япон судлал” хичээлээр 2025 оны 11-р сард “Япон дахь ажилчдын амьдрал” сэдвийг зааж, үүнээс Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааг дэлгэрэнгүй тайлбарласан.

#### **3.1 Эхний хичээл**

Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааг заахад эхний өдөр хичээлийн 90 минутын 45 минутаар “Япон дахь ажилчдын амьдрал” сэдвийн түлхүүр үгсийг зааж эхэлсэн. Үүнд:

- Япон улсад тэтгэвэрт гарах нас
- Өндөр наслалт
- Япон ажилчдын ажлын цаг
- Кароши
- Цалинтай амралт

гэсэн үндсэн ойлголтууд багтсан. Үүний дараа Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааг заах аргаар хичээлээ үргэлжлүүлсэн.

Энэ сурах бичиг нь 2004 онд хэвлэгдсэн учир мэдээлэл нь хуучирсан байсан. Тиймээс энэ удаагийн хичээлээр “Япон дахь ажилчдын амьдрал” хэсгийн “амьдралын туршийн ажил эрхлэх тогтолцоо”, “ажлын туршлага, насыг үндэслэсэн цалин хөлсийн тогтолцоо” гэх мэт хуучирсан мэдээллийг шинэчилсэн мэдээлэлтэй танилцуулсан.

“日本事情入門 Views of Today’s Japan” сурах бичгийн “Япон дахь ажилчдын амьдрал” гэсэн хэсгээс Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааны талаар үзвэл.

“Төгсөх ангийн оюутнуудыг хавраас намрын хооронд зохион байгуулагддаг сонгон шалгаруулах шалгалтаар ажилд авдаг бөгөөд, онцгой шалтгаангүй бол тэтгэвэрт гарах хүртэл ажиллуулах систем юм.”

“Энгийн үед подволк, жинс өмсдөг байсан оюутнууд 4-р ангийн хавраас гэнэт костюм өмсөж, компани руу очдог. Ажил хайх үйл ажиллагаанд зориулсан костюм өмссөн залуучуудын хувьд сонгон шалгаруулах шалгалт нь өөрийн ирээдүйг шийдэх чухал асуудал болдог.”

Ийнхүү богино тайлбар нь Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааг ойлгуулахад хангалтгүй байсан тул гүнзгий ойлгуулахын зорилгоор нэмэлт материал ашигласан.

Тухайлбал, Японы Оюутны Тусламжийн Байгууллага (JASSO)-гийн Япон улсад суралцах мэдээллийн сайт “Study in Japan”-ын Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааны гадаад оюутнуудад зориулсан танилцуулгын хэсэг-ээс Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагаа болон Япон дахь ажилтныг сонгон шалгах шалгалт гэсэн хуудсын агуулгыг ашигласан.

Энэхүү материалыг СЭДС-ийн Япон хэлний орчуулагчийн 4-р ангийн оюутнуудын Япон хэлний түвшинд тохируулан “Амархан Япон хэл” болгож, зураг, график бүхий А4 форматтай 8 хуудас бэлтгэсэн бөгөөд үлдсэн 45 минутыг тайлбарлахад зарцуулсан. Үндсэн сурах бичиг болох “日本事情入門 Views of Today’s Japan” сурах бичгийн “Япон дахь ажилчдын амьдрал” хэсгийг тайлбарласны дараа, А4 8 хуудсны хэмжээтэй нэмэлт материалаар заасан тул нэмэлт материалын тайлбар бүрэн дуусаагүй. Үлдсэн хэсгийг дараагийн хичээлээр заахаар болсон.

### 3.2 Сүүлийн хичээл

Дараагийн хичээлээр хичээлийн цагийн эхний 30 минутаар өмнөх хичээлийн нэмэлт материалын тайлбарыг дуусгасан бөгөөд Япон болон Монголын ажил хайх үйл ажиллагааг харьцуулан хэлэлцүүлэг хийсэн.

Хэлэлцүүлгийн явцад “Японы ажил хайх үйл ажиллагаа хэцүү ч, сургуулиа төгссөн ч ажилд ороход хэцүү Монголын байдалтай харьцуулахад Япон илүү дээр байна.” эсрэгээр “Японых шиг хэцүү зүйл хийж чадахгүй. Монгол нь илүү дээр.” гэсэн оюутнуудын санал ойролцоогоор тэнцэж байсан.

Дараагийн 20 минутаар ажил хайж буй Япон оюутнуудын сэтгэгдлийг ойлгуулах зорилгоор, 2-р бүлэгт танилцуулсан Японы анкетийн жишээг тарааж, оюутнуудад бөглүүлэх дасгал хийлгэсэн.

Энэхүү анкет бөглөх зорилго нь Япон оюутны сэтгэгдлийг ойлгох явдалд чиглэсэн бөгөөд үр дүнд нь хамаарахгүй юм. Бөглөхийн өмнө анкетийн жишээ болон “Өөрийн PR”, “Оюутан байхдаа хамгийн их хүчин чармайлт гаргасан зүйл” гэсэн асуултын утга, хэрхэн хариу бэлдэх талаар тайлбарласан. Үлдсэн 40 минутаар оюутнууд анкетыг бөглөхөд зарцуулсан боловч бүх оюутан дуусгаж чадаагүй. Энэ дасгалыг дараагийн 7 хоногийн хичээлд гэрийн даалгавар болгон өгөх замаар хичээлийг дуусгасан.

Дараагийн хичээл дээр нэг оюутан ч даалгавраа өгсөнгүй. Гэвч өмнө тайлбарласан шиг Япон оюутан ч удаан хугацаагаар бэлтгэж бодож бэлддэг тул, гадаад оюутан нэг 7 хоногийн хугацаанд Япон хэлээр бэлтгэж дуусгаж

чадахгүй нь зүй ёсны үр дүн юм. Даалгавраа өгөөгүй оюутнуудад “Энэ даалгаврын зорилго нь Япон оюутны сэтгэгдлийг ойлгуулах юм”, “Тиймээс дүнд нь хамаарахгүй”, “Японы ажил хайх үйл ажиллагаа болон Япон оюутны сэтгэгдлийг ойлгосон биз?” гэсэн тайлбарыг өгч, энэ удаагийн Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааг танилцуулах хичээлийг дуусгасан.

Энэ хичээлийг сонссон оюутнуудаас “Япон дахь төгсөх ангийн оюутнуудын ажил хайх үйл ажиллагааны талаар анх удаа сонссон”, “Япон оюутнуудын ямар хэцүү болохыг мэдэж авлаа” гэсэн сэтгэгдэл авсан тул хичээлийн агуулга, зорилгыг ойлгуулж чадсан гэж үзэж болно. Энэ ангийн оюутнууд ихэвчлэн дадлага эсвэл оюутан солилцоогоор Японд амьдарч байсан боловч Япон дахь ажил хайх үйл ажиллагааны талаар мэддэг оюутан нэг ч байгаагүй гэдгийг ойлгосон. Нэмж хэлбэл, энэ хичээлээр 8 хуудсны хэмжээтэй материалыг ашиглан амаар тайлбарласан учраас зарим оюутан сонирхол багатай байгааг харуулсан. Үүний тулд цаашид материалыг сайжруулах шаардлагатай гэдгийг ойлгосон.

#### 4. Дүгнэлт

Энэ удаагийн судалгааны үр дүнгээс үзэхэд, одоогийн Япон хэлний орчуулагчийн ангийн оюутнуудын Япон судлалын мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай харагдсан. Мөн оюутнуудын Япон судлалын мэдлэгийг ахиулахын тулд Япон судлалын хичээлд ашиглах сургалтын материалыг сайжруулах шаардлагатай гэдгийг ойлгосон.

Оюутнуудын Япон судлалын мэдлэг дутагдаж байгаа шалтгаан нь 1-р ангиас 3-р анги хүртэл зөвхөн Япон хэлний хичээлд төвлөрсөн одоогийн сургалтын хөтөлбөртэй холбоотой гэж үзэж байна. Энэхүү хөтөлбөрийн дагуу оюутнууд олон цагаар Япон хэл суралцаж, хэлний чадвараа сайжруулах боломжтой боловч сурсан хэлээ бодит нөхцөлд хэрэгжүүлэхэд шаардлагатай Япон судлалын мэдлэг хангалтгүй байна. Энэ нь чадварлаг Япон хэлний орчуулагч бэлтгэхэд тулгамдсан асуудал болж байна гэж хэлж болно. Иймээс Япон судлалын хичээлийг эрт үеэс, өөрөөр хэлбэл 1-3-р ангид багтаан заах саналыг дэвшүүлж байна.

Мөн Япон судлалын хичээлд ашиглаж буй сурах бичиг, материалтай холбоотой асуудал байна. Одоогоор хэрэглэж байгаа “日本事情入門 (Views of Today's Japan)” сурах бичгийн хамгийн сүүлийн хэвлэл 2004 онд хэвлэгдсэн тул зарим мэдээлэл хуучирсан байна. Иймээс уг сурах бичгийг хичээлд ашиглахдаа тухайн хэсгийн мэдээлэл хуучирсан болохыг онцлон тайлбарлаж, шинэчилсэн мэдээллийг нэмж заах шаардлагатай болдог. Түүнчлэн, Япон судлалыг Япон хэлээр заахад 3-р ангаас доош ангийн оюутанд ойлгоход хэцүү гэсэн асуудал байна. Иймээс шинэ мэдээллийг багтаасан, Монгол хэлний орчуулгатай шинэ Япон судлалын сурах бичгийг Япон судлалын тэнхимийн багш нартай хамтран зохион бүтээж, хэвлэх санаа байгаа.

## Ном зүй:

日本事情入門 Views of Today's Japan, 佐々木瑞枝, 2004

JASSO Study in Japan <https://www.studyinjapan.go.jp/ja/work-in-japan/employment/job-environment.html>

独立行政法人労働政策研究・研修機構

<https://www.jil.go.jp/kokunai/statistics/timeseries/html/g0301.html>

現在の日本の新卒採用システムの特徴と問題点 — 今後新卒採用システムや若者の労働環境はどのように変化していくべきか —

早稲田大学文化構想学部現代人間論系 岡部ゼミ・ゼミ論文/卒業研究 柴田萌子

[https://k-okabe.w.waseda.jp/semi-theses/1609moeko\\_shibata.pdf](https://k-okabe.w.waseda.jp/semi-theses/1609moeko_shibata.pdf)

リクナビ OpenES

<https://job.rikunabi.com/contents/entrysheet/3088/>

СУРГАЛТЫН АРГА, ХЭЛБЭРҮҮДИЙН ТУХАЙ АСУУДАЛД

*Ц.Отгон  
(ШУТИС-ийн ГХС-ийн Ази судлалын  
салбарын ахлах багш, Магистр)*

*Агуулгын товч:* Сургалтын аливаа нэгэн арга нь давуу болон сул талтай байдаг. Өөрөөр хэлбэл, бүх аргаас давуу арга гэж байхгүй бөгөөд сургалтын аль ч арга тухайн үеийн нөхцөл байдал, дэвшүүлсэн зорилтоосоо хамаараад улам хөгжин сайжирч байдаг зүйл юм. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ хэлний сургалтад хэрэглэж буй сургалтын арга, хэлбэрүүдийн тухай асуудлыг авч үзсэн юм.

*Түлхүүр үгс:* Сургалтын технологи, арга зүй, хэрэгцээ, шаардлага, үр дүн

**ОРШИЛ**

Сургалтын аргын талаар эрдэмтдийн олон янзын санал байдаг. Тухайлбал, эрдэмтэд сургалтын дидактик зорилгоор нь, мэдлэг эзэмших танин мэдэхүйн үйл ажиллагааны шинж чанараар нь, сурах хөдөлмөр хийх хэлбэрээр нь, сургалтын үйл ажиллагааны дэс дарааллаар нь сургалтын аргыг ангилж, зохих тайлбар жишээ гаргасан байдаг. Мөн зарим эрдэмтэн үнэмшүүлэн сургах, тайвшруулан сургах (нойрсуулан сургах) сонсгон үзүүлж сургах гэж сургалтын аргыг авч үзсэн нь бий. Ийнхүү эрдэмтэд сургалтын арга гэдгийг янз бүрийн талаас нь тодорхойлон ангилж, тайлбарлаж байсан боловч тэдгээрт нэгэн ерөнхий агуулга байгаа нь ажиглагдаж байна. Үүнд:

Сургалтын зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн суралцагсад /багш, суралцагч/-ын хамтын үйл ажиллагааны янз бүрийн хэлбэр гэсэн ерөнхий нэг санаа ажиглагдаж байна.

Сургалтын үйл ажиллагааг дарааллын хувьд 3 шатлалд хувааж болно.

I. Сургалтын өмнөх үйл ажиллагаа

II. Сургалтын үеийн үйл ажиллагаа

III. Сургалтын дараах үйл ажиллагаа болон эдгээрийг хэрэгжүүлэх үедээ зорилгодоо хүрэх хамгийн үр ашигтай аргуудыг авч хэрэглэдэг.

**СУДАЛГААНЫ ОНОЛЫН ХЭСЭГ**

Монгол Улсад хэлний сургалт нь догматик, уламжлалт болон хөгжүүлэх гэсэн гурван хэв шинжийг дамжин хөгжиж ирсэн. Эдгээр хэв шинж тус бүрийн талаар авч үзвэл:

“Догматик сургалт” нь бэлэн мэдээллийг багш суралцагчдад дамжуулж, суралцагчид цээжилж мэдээлдэг. Энэ сургалтын хувьд механик тогтоолт хөгждөг. Харин бие даан хийх ажилд төдийлөн нөлөө үзүүлдэггүй. Ийм учраас энэхүү цээжлүүлдэг сургалтыг боловсронгуй болгож багш

тайлбарлан ярих, суралцагчидтайгаа харилцан ярилцах, сургалтад тоног төхөөрөмж хэрэглэх, дасгал даалгавар өгч ажиллуулах гэх мэтийн хэлбэрүүдээр сургалтыг зохион байгуулж олон жил мөрдөж ирсэн энэ сургалтын хувьд суралцагчид зарим үед бие дааж сурах болох багш өөрөө ихэвчлэн дагуулж сургадаг. Энэ сургалтыг **уламжлалт сургалт** гэж нэрлэсэн. Энэхүү уламжлалт сургалтын хувьд суралцагсад төдийлөн бие дааж ажиллаж чадахгүй, сургалтын ажлын ихэнх хэсгийг багш гүйцэтгэдэг. Сургалтын энэхүү дэвшилтэт хэв шинж нь тухайн мэдлэгийг суралцагсдад механикаар цээжлүүлэхийн оронд анализ, синтез, сэтгэн бодох зэрэг үйлүүд гүйцэтгэн эзэмшүүлэхэд чиглэгдсэн байна. Уламжлалт сургалтын явцад суралцагсдыг бага наснаас нь оношлон таньж, сайн талыг нь хөгжүүлж, энэ насны суралцагсдыг сургах нь тэднийг дагуулан сургах нь уламжлалт сургалтын нэг гол чиглэл юм. Уламжлалт сургалтын үеэс суралцагсдын оюун ухааныг хөгжүүлэх сургалтад дэвшилттэй арга барил хэрэглэх, багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, сургалтад анги хичээлийн систем нэвтрүүлэх зэрэг шинэ хэлбэрийн сургах үйлүүд нэвтэрч эхэлсэн байна. Манай орны боловсролын системд 1921 оны үеэс 1970-аад он хүртэлх хугацаанд уламжлалт сургалт хүчтэй хөгжиж ирсэн. Энэ сургалт нь сургалтын зорилго, агуулга, арга зарчим, зохион байгуулалт, үр дүн гэсэн чиг хандлагуудаар боловсронгуй болж ирсэн юм. Тухайлбал: Догматик сургалтаар суралцагсдын механик тогтоолтыг хөгжүүлдэг дэвшилттэй хандлагад суурилж суралцагчид зөвхөн бэлэн мэдээллийг хүлээж авдаг идэвхгүй субъект биш харин багшийн зааж байгаа зүйлийг хэрхэн хүлээж авах яаж эзэмших арга барилыг олж тогтооход чиглэж иржээ. Уламжлалт сургалтын үед сургалтын зорилго зөвхөн бэлэн мэдээлэл хүлээж авах төдийгүй түүнийг яаж эзэмших талаар анхааран ажиллах, мэдлэгээ бататгаж хэрэглээ болгоход чиглэгдэж байсан.

Ийнхүү 1940-өөд оноос хойш голлон баримталж байсан сургалтын уламжлалт арга нь тухайн үедээ бага хугацаанд харьцангуй их мэдээллийг олон хүнд зэрэг түгээж байсан нь тэр үеийн нөхцөл байдалтай уялдаатай байсан гэж үзэж болох юм. Үүнээс өмнөх монголын бурхан шашны сургалтын уламжлалт аргуудаас хүнийг хэр хэмжээгээр нь хөгжүүлэх, бага насанд нь ихээхэн материалыг цээжлэн тогтоолгох, шавилан сургах арга зэрэг нь тухайн үедээ ихээхэн тогтворжсон үр дүнтэй аргууд байсан гэдгийг үгүйсгэх аргагүй.

Сургалтын уламжлалт арга гэдгийг тухайн зорилтыг шийдвэрлэхийн тулд нэг талаас бэлэн мэдээлэл дамжуулах, нөгөө талаас уг мэдээллийг хүлээн авах идэвхгүй хэлбэр хэмээн шүүмжилж, сургалтын арга зүйн асуудалд шинэ байр сууринаас хандахыг шаардаж байгаа билээ.

**Хөгжүүлэх сургалтын** онолын үндэс нь 19-р зууны сүүлч 20-р зууны эхэнд тавигдаж 100-аад жилийн хөгжлийг туулсан байна. Хөгжүүлэх сургалтын хөгжлийг 3 үе шат болгон хуваан үзэж болох юм. Үүнд:

1-р үе шат: 19-р зууны сүүлч 20-р зууны эхэн үе.

2-р үе шат: 20-р зууны 60-80-аад оны дунд үе. Хөгжүүлэх сургалтын онол болон сэтгэл зүйн үндэс судлагдсан үе.

3-р үе шат: 1980-аад оны дунд үеэс өнөөг хүртэлх үе нь онол болон туршилт судалгаа хэрэгжиж буй үе. Энэхүү үеийг дотор нь хоёр дэд хэсэг болгон хуваадаг. Үүнд:

1. ЗХУ-ын бүтээлч багш нарын хамтын сурган хүмүүжүүлэх үзэл санааны шат.

Энэ шатанд В.П.Шатолав, Ш.А.Амонашвили, С.Н.Лисенкова, И.Г.Иванов зэрэг багш нар идэвхгүй сургалтын системийг шүүмжлэн суралцагсдыг сурах хөдөлмөрт татан оруулах багш, шавийн хамтын хөдөлмөрт тулгуурласан сургалтын олон шинэлэг арга хэлбэрийг эрэн сурвалжилж практикт нэвтрүүлж чадсан юм.

2. Шавь төвтэй сургалтын шат 1990-ээд оны үеэс өнөөг хүртэлх үе бол шавь төвтэй сургалтын үе юм. Хөгжүүлэх сургалт жинхэнэ мөн чанараараа хэрэгжиж нийгэм дидактикийн үндэс тавигдсанаар манай улсад шавь төвтэй сургалт хэрэгжиж байна.

Шавь төвтэй сургалт нь хөгжүүлэх сургалтын нэг хэсэг юм. “Хөгжүүлэх сургалтын мөн чанар нь суралцагсдын оюун ухаан сэтгэл зүйн нөөц бололцоог нээн илрүүлж түүний чөлөөт хөгжлийг хангаж мэдлэг эзэмшин сурах оюуны арга барилд сургаж идэвхтэй бүтээлч бие даасан үйл ажиллагааны чадвар, дадал эзэмшүүлэх хамгийн үр ашигтай арга замыг олох явдал юм. Хөгжүүлэх сургалт нь дээр өгүүлснээр дараах мөн чанарыг агуулсан байна. Үүнд: Суралцагсдыг идэвхгүй сонсогчдоос идэвхтэй оролцогч болгох багш суралцагчдын хамтын идэвхтэй бүтээлч үйл ажиллагаагаар хэрэгжиж байдаг. Хөгжүүлэх сургалт нь ардчилсан, нээлттэй, тасралтгүй, байнга хөгжин дэвшиж боловсронгуй болж байдаг, удирдлага жолоодлого бүхий үйл явц (Даваажав, 2005: 12) юм.

Гэвч манай боловсролын тогтолцоонд мэдээлэл дамжуулдаг аргууд нь давамгайлан ур ухаан эзэмшүүлэх, бүтээлч хэрэглээг бий болгох аргууд нь төдийлөн хэрэглэгдэж байгаагүй юм.

Харин сүүлийн жилүүдэд хосолмол сургалтыг хэрэгжүүлж буй дэлхийн олон орны их дээд сургуулиудын туршлагын тухай танилцуулга, зөвлөмж, гарын авлагууд гарах болсон юм. Жишээ нь: 2017 онд БСШУСЯ-аас “CDIO ажлын орчин бүрдүүлэх, хосолсон болон идэвхтэй сургалт явуулах арга зүйн зөвлөмж”, 2020 онд Дэлхийн Боловсролын Холбооноос хосолмол сургалтыг хэрэгжүүлж буй 12 орны арга туршлагыг багтаасан танилцуулга болон хосолмол сургалтыг хэрэгжүүлэх аргачлалын талаарх гарын авлагыг гаргасан гэх мэт.

Иймд ШУТИС-ийн профессор багш нарын сургалт, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх, орчин үеийн сургалтын шинэлэг арга технологиудыг сургалтад нэвтрүүлж, их, дээд сургуулийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд сургалтын ямар технологи, арга зүй тохирох эсэхийг туршин, туршсан үр дүнгээсээ танилцуулж, харилцан туршлага солилцдог болсон. Хосолсон сургалтыг ч хэрхэн яаж хэрэгжүүлбэл илүү зохимжтой талаар хурал, семинар хийх 2017 онд БСШУСЯ-аас “CDIO ажлын орчин бүрдүүлэх, хосолсон болон идэвхтэй сургалт явуулах арга зүйн зөвлөмж”, болсон.

Дэлхий нийтэд ковид 19 цар тахал дэлгэрсэн тухайн цаг үед хосолмол сургалт нь орчин үеийн сургалтын чиг хандлага, суралцагчийн хэрэгцээ, шаардлагатай нийцэж байсан тул монгол улсын их дээд сургуулиудын сургалтад ч хосолмол сургалтыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Өөрөөр хэлбэл, танхимын болон цахим сургалтыг хослуулан оюутнуудын суралцах боломжийг нэмэгдүүлсэн юм. Оюутан цахим хичээлд орон зай, цаг хугацаанаас

хамааралгүйгээр оролцож, хичээлийн хөтөлбөрийн агуулгын 50%-ийг танхимаар судална. Ийнхүү танхим болон цахим сургалтыг хослуулан сургалт явуулж, цахим технологийг өргөнөөр ашигласан нь монголын боловсролын салбарт технологийн дэвшлийг авчирсан бөгөөд суралцагсадын идэвхтэй ажиллах үйл ажиллагааг голлосон прагматик сургалтын хэлбэрүүдийг хэрэглэх хандлагатай ч нийцэж байсан юм.

Танхимын сургалтын явцад багш, суралцагчийн үйл ажиллагаанд амьд харилцаа голлосон, сургалтын үйл явцыг багш удирдан чиглүүлж, багшийн үйл ажиллагаа зонхилох хандлагатай байдаг. Цахим сургалт нь интернэт, цахим технологид суурилсан сургалт юм. Иймд өнөөгийн монгол улсын их дээд сургуулиудад танхимын болон онлайн сургалтыг зэрэг явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон хосолсон анги, танхим олон болсон.

Танхим болон цахим хосолсон сургалтын хэлбэрүүд хоорондоо төсөөтэй хэдий ч сургалтын үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт зэргээрээ нэлээд ялгаатай байдаг. Үүнд:

Хосолмол сургалт нь танхим болон цахим сургалтын хэлбэрийг хослуулан сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах, суралцагчдын олон талын чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн сургалт юм. Холимог сургалт нь цахимаар судалсан хичээлийг танхимд давтан бататгаж танхимын хичээлийг агуулгыг судалдаг. Оюутан лекц, лабораторийн ажил, хэлэлцүүлэгт оролцох зэрэг биечлэн хийх шаардлагатай даалгавруудыг танхимд гүйцэтгэх боловч ихэнх дасгал даалгаврыг заасан хугацаанд багтаан хийж цахимаар илгээн сургалтанд оролцоно. Тонгоруу сургалт нь холимог сургалтын нэг төрөл бөгөөд уламжлалт сургалтын үйл ажиллагааг тонгоруулан, цахимаар хичээлийн агуулгыг судалж, ангид гэрийн даалгавраа хийж, харилцан яриа өрнүүлдэг сургалтын нэг хэлбэр юм. Оюутан лекц, семинарын материалыг цахим (и-мэйл, чат)-аар хүлээн авч бие даан урьдчилж судлах ба танхимын сургалтанд дадлага хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх хэлбэрээр (БСШУСЯ, 2017) оролцоно.

Сургалтын технологийн аль нэг хэлбэрийг уламжлалт сургалттай хослуулахад багшийн сургахуйн үйл ажиллагаа нь хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, оюутнуудыг сэдэлжүүлэх, дасгал ажиллуулах, даалгавар өгөх, шалгах, үнэлж дүгнэх байдаг бол оюутнуудын сурахуйн үйл ажиллагаа нь хичээлд оролцох, хичээлийн агуулгыг судлах, даалгавар гүйцэтгэх, багаар ажиллах байна. Харин сургалтын зорилтууд яаж тавигдсанаас хамаарч түүнийг хэрэгжүүлэх арга нь өөр өөр байж болох юм. Үүнд багш арга барилынхаа хувьд өөрөө үргэлж шинэчлэгдэж байх зохион байгуулах арга ухаанаа боловсронгуй болгож байх явдал хамгийн чухал (МУИС, НШУС, 2013) юм.

## **ТУРШИЛТЫН ХЭСЭГ**

Манай их дээд сургуулиуд 2020 оноос эхлэн сургалтандаа хосолмол сургалтыг хэрэгжүүлж байна. Ингэснээр сургалтын үйл ажиллагаанд танхим болон цахим сургалтыг хослуулан явуулсан сургалтын талаарх суралцагсдын санаа бодлыг судалж үзэв. Үүнд:

Бид энд МИС-ийн оюутнуудаас авсан санал асуулгыг ашиглав. ... Сургалтын үйл ажиллагааны энэхүү туршлагад түшиглэн хосолсон сургалтын талаарх оюутнуудын санаа баримтлалыг танадах зорилгоор 2100 гаруй

оюутантай тус сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт суралцаж байгаа 1-р дамжааны 307 оюутнаас санамсаргүй түүврийн аргаар танхим болон цахим сургалтын давуу талаас тус бүр гурвыг нэрлүүлэх хоёр асуултад хариулт авч нэгтгэн дүгнэхэд оюутнууд дараах байдлаар хариулсан. Үүнд:

Танхимын сургалтын давуу тал нь багштай нээлттэй байж, ойлгоогүй зүйлээ асууж тодруулах, амьд харилцаа үүсгэх боломжтой 168 оюутан буюу 54.7% нь, анхаарал сарнихгүй төвлөрч чаддаг, хичээлийг сайн ойлгодог, бүтээмж өндөртэй 106 оюутан буюу 34.5% нь, бусдаас суралцах, харилцан мэдлэг туршлагаа хуваалцаж, багаар ажиллах боломжтой 76 оюутан буюу 24.7% нь. номын санд суух, хэрэгцээтэй ном сурах бичгээ хүссэн үедээ авч хэрэглэх боломжтой гэж 29 оюутан буюу 9.5 % нь хариулсан.

Цахим сургалтын давуу талын талаарх асуултад цаг хугацаа хэмнэдэг (замын түгжрэлд цаг хугацаа алдахгүй) 122 оюутан буюу буюу 39.7 % нь, хаанаас ч, өөрийн цаг зав, хурдад тааруулж суралцах боломжтой гэж 76 оюутан буюу 24.7% нь, бие даан суралцах чадвар нэмэгддэг (өөртэйгээ ажиллах) гэж 63 20.5% нь, хичээл их ойлгомжтой, давтаж үзэх боломжтой учир хоцрогдол үүсдэггүй гэж 54 оюутан буюу 17.5% нь, гэртээ тав тухтай, чимээгүй, чөлөөтэй орчинд хичээллэх боломжтой гэж 54 оюутан буюу 17.5% нь, цагаа зохицуулж, өөрийгөө илүү хөгжүүлэх цаг завтай болдог гэж 37 оюутан буюу 12% нь эдийн засагт хэмнэлттэй, унааны мөнгө, хоолны мөнгө гэх мэтээр 30 оюутан буюу 9.7% нь компьютер мэдээллийн технологитой ажиллаж сурна гэж 24 оюутан буюу 7.8 % нь, байгальд ээлтэй, эрүүл мэндэд эрсдэлгүй гэж 11 оюутан буюу 3.5 % нь хариулсан (Оюун-Эрдэнэ, 2021).

Дээрх санал асуулгын үр дүнгээс харахад танхим болон цахим хосолсон сургалтыг хэрэгжүүлэхийн гол ач холбогдол нь суралцагсадын сонирхолтой нийцэж байгаа бөгөөд замын түгжрэлд цаг хугацаа алддаггүй, оюутнууд өөрсдийн хэмнэлээр ажиллах боломж буюу уян хатан байдлыг олгодог, цахимаар суралцагч өргөн цар хүрээтэй мэдлэг олж авах боломжтой, суралцагчийн чадамжаас хамаарч суралцах хугацааг тохируулж болдог, цахим сургалт нь хүссэн газраасаа мэргэжлийн сургалтыг авах боломжтой өртөг багатай, цахим сургалтыг сонгосон суралцагч богино хугацаанд илүү үр бүтээлтэй суралцдаг зэрэг давуу талтай байдаг байна.

### **СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

ШУТИС-ийн ГХС нь 2019 онд дэлхий нийтэд ковид 19 цар тахал дэлгэрч, хөл хорисон үеэс эхлэн тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагаар хэлний сургалтад цахим хэлбэрээр сургалт явуулж эхэлсэн. Бид ч ШУТИС-ийн нийт оюутнууд үздэг S.ML103 “Хэл ярианы соёл” монгол хэлний яриа, бичгийн соёлын хичээлд танхимын сургалтыг онлайн сургалтын хэлбэртэй хослуулан ижил түвшинд явуулсан холимог сургалтыг (google forms, classroom.google.com, plickers.com) зэрэг программ ашиглан хосолмол сургалтыг хэрэгжүүлсэн юм. Ингэснээр суралцагсдын сурлагын амжилт хэр түвшинд байгааг авч үзлээ. Үүнд:

2019-2020 оны хичээлийн жилийн намрын улиралд 128 оюутан хамрагдаж 99,15%, хаврын улиралд 121 оюутан хамрагдаж 100%-ийн амжилттай суралцсан (<http://www.must.edu.mn>, багшийн вэб, дүнгийн

шинжилгээ) байна. Уг хичээлийг судалсан оюутнуудын дүнг тухайн хичээлийн жилийн байдлаар авч үзвэл сурлагын амжилт бага зэрэг ахисан байдалтай байна.

Харин бид ГХС-ийн оюутнуудаас авсан хөл хорионы үеийн цахим хэлбэрийн сургалтын үр дүнгийн талаарх судалгаанд англи хэлний багш Ш.Оюумаагийн санал асуулгын дүнг авч ашиглав. Үүнд: ... Цахим хичээл нь танхимийн хичээл шиг үр дүнтэй байж чадаж байна уу? гэсэн асуултад тийм 7%, үгүй 63.20%, тэдэхгүй 21.10% нь, танхимийн сургалт цахим сургалтын үр дүн ижил гэж 8.80% нь хариулсан (Оюумаа, 2021) байжээ.

Иймээс цаашид хосолмол сургалтыг хэрэгжүүлж үр дүнтэй сургалт явуулахад:

1. Багш нарын зүгээс хосолсон сургалтыг оновчтой хэрэгжүүлэхэд сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулга, сургуулийн нөөц боломжоос хамааран хосолсон сургалтын хэлбэрүүдийн аль тохиромжтойг сонгох, сургалтын хэлбэрүүдийн төсөөтэй болон ялгаатай талуудыг улам сайн ойлгох хэрэгтэй байна.

2. БШУЯамны зүгээс Тухайн сургалтыг хэрэгжүүлсэн сургуулиудын арга туршлага болон тохиолдож болох эрсдэл, саад бэрхшээлийг судлах, туршилт сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах, суралцагчдын бэлэн байдлыг судлах, дидактик зарчмыг гүнзгийрүүлэн судалж, сургалтын хөтөлбөрийн дизайн болон хэрэглэгдэхүүнийг технологийн дагуу боловсруулах, багшлах боловсон хүчнийг бэлтгэх гэх мэт олон талын бэлтгэл ажил шаардлагатай байна. Мөн багш ажилчиддаа техник, цаас, принтерийн хор, шуудан хүргэлтийн үйлчилгээг ашиглах санхүүгийн асуудлыг шийдвэрлэж өгөх буюу дэмжлэг үзүүлэх, оюутнуудад их сургуульд элссэн цагаас эхлэн сургууль төгсөх хүртэлх хугацаанд хөнгөлөлттэй гэрээ хийсэн үүрэн холбооны операторуудын дугаарыг хэрэглүүлэх, шуудан, хүргэлтийн үйлчилгээг ашиглахын тулд монгол шуудан, хот доторх хүргэлтийн байгууллагуудтай хамтын ажиллах гэх мэт боломжийг ашиглуулах боломжийг хангах шаардлагатай (Оюумаа, 2021) юм.

## ДҮГНЭЛТ

Бид энэхүү өгүүлэлд монгол улсын хэлний сургалтад хэрэглэж ирсэн дараах сургалтын хэв шинжүүдийн сайн, муу талыг тодорхойлон дүгнэж, сургалт тус бүрийн давуу талыг сургалтдаа үргэлжлүүлэн ашиглах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Догматик сургалтын явцад цээжилж тогтоох ойг хөгжүүлдэг;
2. Уламжлалт сургалтын асуудал сэдэж тайлбарлах, хагас эрэл хайлт хийлгэдэг;
3. Хөгжүүлэх сургалтын бие даасан танин мэдэх үйл ажиллагааг хөгжүүлдэг.

Мөн бид сургалтын орчин үеийн шинэ чиг хандлагад нийцүүлэн явуулж байгаа танхим болон цахим хосолсон сургалтын хэлбэрүүдийн нь ч сайн, муу талыг тодорхойлон дүгнэв. Учир нь эдгээр сургалтын хэлбэр тус бүрийн давуу

талыг сургалтдаа тохируулан хэрэглэж суралцагсдыг тал бүрээр идэвхжүүлж, чөлөөт харилцаанд оруулбал сургалтын үр дүн дээшлэх юм. Үүнд:

1. Хосолмол сургалт нь цахимаар судалсан хичээлийг танхимд бататган ярилцахгүй, танхимд зөвхөн танхимын цагийн хичээлийг судалдаг;
2. Холимог сургалт нь цахимаар судалсан хичээлийг танхимд давтан бататгаж танхимын хичээлийг агуулгыг судалдаг;
3. Тонгоруу сургалт нь сургалтын материалыг хичээлээс өмнө цахимаар өгч хичээлийн цагаар танхимд ярилцаж бататгадаг.

Ялангуяа тонгоруу сургалт нь багш төвтэй сургалтаас оюутан төвтэй сургалт руу шилжиж буйг илтгэх сургалтын хэлбэр бөгөөд хичээлийн лекц болон бусад холбогдох материалыг цахим платформ ашиглан оюутан суралцагчдад дамжуулж, тухайн хичээлээр үзэж судалсан зүйлийг танхимд гүнзгийрүүлэн ярилцаж, мэдлэгээ хуваалцдаг сургалтын арга хэлбэр юм.

Энэ хэлбэрт тулгуурлаж суралцагсдын бие даан бүтээлчээр суралцаж мэдлэгээ гүнзгийрүүлэх, хуваалцах чадвар, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх боломжтой юм.

### **ABSTRACT**

Each teaching method has its advantages and disadvantages. In other words, there is no one method that is better than all others, and any teaching method is something that is constantly evolving and improving depending on the current situation and the goals it sets. Therefore, in this article, we have considered the issue of teaching methods and forms used in language teaching.

### **НОМ ЗҮЙ:**

1. (2013) МУИС, НШУС. Дээд сургуулийн сургалтын технологи, Улаанбаатар.
2. (2017) БСШУСЯ. СДИО ажлын орчин бүрдүүлэх, хосолсон болон идэвхтэй сургалт явуулах арга зүйн зөвлөмж, Улаанбаатар.
3. (2005) Даваажав Г. ШУТИС, КМТС, Гадаад хэлний сектор. Багш нарын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Гадаад хэлний сургалтын уламжлал шинэлэл өгүүлэл, Улаанбаатар.
4. (2021) Оюун-Эрдэнэ Т. МИС-ийн “Гадаад хэлний сургалтын онол, арга зүйн өнөөгийн чиг хандлага” сэдэвт онлайн семинарт хэлэлцүүлсэн илтгэл, Улаанбаатар.
5. (2021) Ш.Оюумаа, ШУТИС-ийн ГХС-ийн “Хэлний хэрэглээний асуудал 2021” эрдэм шинжилгээний хуралд Хөл хорионы үеийн цахим хэлбэрийн сургалтад тулгарч буй асуудлууд (ГХС-ийн оюутнуудын дунд хийсэн судалгаа) сэдвээр хэлэлцүүлсэн илтгэл, Улаанбаатар.
6. <http://www.must.edu.mn> (Багшийн вэб, дүнгийн шинжилгээ)

МОНГОЛ УЛС ДАХЬ ЯПОН ХЭЛ СУРАЛЦАГЧДЫН ХАНЗ ҮСГИЙН  
СУРГАЛТЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ БА  
ЗААХ АРГЫН СУДАЛГАА

*Ватанабэ Марина  
(Соёл Эрдэм дээд сургууль,  
Япон судлалын тэнхимийн  
магистрант)*

## 1. 要旨

モンゴル国では、近年日本語学習者数が増加傾向にあり、日本語は人気の第二言語の1つである。モンゴル語は、主語・目的語・動詞の語順が日本語と同じSOV型であり、文法構造が日本語に似ている。さらに、助詞も日本語と似ており、モンゴル国の学習者にとって日本語は第二言語の中で、比較的学びやすい言語とされている。一方で、モンゴル国は非漢字圏であるため、日本語学習をする上で漢字が大きな課題として報告されている。具体的な漢字指導の教授法が確立されていないこともあり、日本語教師にとっても非漢字圏学習者への漢字教育は喫緊の課題である。

本稿の目的は、非漢字圏であるモンゴル国における日本語学習者への漢字指導について、学習者の特徴や傾向を踏まえながら課題を明らかにし、効果的な漢字指導法を検討することである。

## 2. モンゴル国における日本語学習の現状

モンゴル国には、伝統的な縦書きのモンゴル文字とキリル文字の2種類あり、公用語はモンゴル語である。現在では、日常生活においてキリル文字が一般的に使用されており、前述の通り非漢字圏である。独立行政法人国際交流基金(以下、国際交流基金という)の「2021年度 海外日本語教育機関調査」によると、2021年度におけるモンゴル国の日本語学習者数は13,334人で、10万人あたりの学習者数は417.1人と開発途上国の中で世界トップである。総合的な日本語学習者数は、中国、インドネシア、韓国が圧倒的に多いが、人口比率の観点から見ると、モンゴル国における日本語学習者の人口比率は非常に高い。なお、モンゴル国家統計局 (National Statistics Office of Mongolia)によると、2024年12月31日時点でのモンゴル国の人口は354.4万人で、世界で最も人口密度の低い国の1つとされている。国際交流基金(2023)は、モンゴル国における日本語教育について、1975年にモンゴル国立大学文学部に副専攻として日本語コースが開設されたのを皮切りに、多

くの大学で日本語学科が開設されたり、初等・中等教育で日本語が第二言語として学ばれたり、日本語学習者数が増加傾向にあるとしている。

近年、日本語を学校のカリキュラムに含まれた科目の1つとして勉強するだけでなく、日本での進学や就職などを目標に日本語を主体的に学ぶ学習者も増加している。それに伴い、モンゴル国における日本語能力試験(以下、JLPTという)受験者数も年々増加傾向にある。モンゴル国の首都ウランバートル市では年2回、その他の2つの地方では年1回JLPTが実施されている。JLPTは、学習者にとって自身の日本語レベルを把握するためだけではなく、日本での大学進学や就職活動時に評価や優遇される判断材料となる。このような理由から、JLPT対策の授業を中心的に行う日本語コースや教育機関なども多い。

### 3. モンゴル国における漢字学習の課題

学習者は語彙や文法、聴解など、さまざまなことを勉強しなければならないが、その中でも非漢字圏の学習者にとって特に難しく挫折しやすいのが、漢字である。非漢字圏の学習者にとって馴染みのない漢字は、文字ではなく記号や絵のように認識されることも少なくないことが指摘されており、漢字学習の困難さは多くの研究で示されている。高嶋(2013)がウランバートル市の初中高一貫の外国語教育特化学校の中高中生計152人に行った調査では、A学校では全体の81%(74人中60人)、B学校では全体の86%(78人中67人)が「日本語学習で難しい点」で漢字を挙げた。2校合わせると、84%(152人中127人)もの学習者が漢字を難しいと感じており、非漢字圏のモンゴル人学習者にとって漢字学習がいかに困難であるかが確認できる。効果的な漢字指導ができれば、学習者の読解力や語彙力の強化だけでなく、日本語学習への意欲向上にも繋がるため、モンゴル人学習者に適した漢字指導法を早急に確立することが求められている。

ウラムバヤル(2005)がモンゴル国の大学1年生から4年生計119名を対象に行った漢字学習に関する質問紙調査から、学習者は漢字の読みが多い、画数が多い、漢字の書き順、形が似ている漢字を難しいと感じ、さらには漢字を使わないと忘れる、漢字が覚えられないなどが漢字学習の課題として明らかとなった。モンゴル人学習者にとって、漢字の意味よりも漢字の形や音韻、構造の複雑さといった漢字の形式的側面を困難だと捉えていることが確認された。このように、非漢字圏学習者にとって漢字の形態的処理の負担は大きく、漢字の視覚的・形態的複雑さが漢字習得をより困難にしていることを示している。また、キリル文字を日常的に使用するモンゴル国では、意識的に漢字学習をしない限り漢字を使用することはあまりない。このような限定的な漢字の使用機会、接触頻度の低さも、非漢字圏であるモンゴル国における漢字学習の課題の1つである。

また、ウラムバヤル(2011)が3大学のモンゴル人日本語教師4名に実施した漢字教育についてのインタビュー結果から、既習の漢字を使った文作成は行っているが、文脈の中で既存の知識を使って漢字を推測するストラテジー教育(例:ここでパスを【 】ください。a.乗せて b.乗って c.降りて d.降って)を行う機関はないことが明らかとなった。それに伴って、3

大学の日本語専攻の大学1年生から4年生計333名に実施した漢字語彙処理能力テストの結果においても、モンゴル人学習者は漢字の同音字の識別、文脈による漢字選択能力が低いことが示された。漢字を書くといった産出活動や漢字を読む、選択問題といった理解活動だけでなく、既存の知識から漢字を推測する漢字語彙処理ストラテジーに着目した漢字学習・指導が必要である。

#### 4. 日本語教育における外国人学習者向け漢字指導の基本

日本に住む日本人の場合、小学校から国語教育の一環で漢字学習が始まり、中学修了までに常用漢字表の漢字を理解し自然と使用できるようになる。一方で、外国人日本語学習者の場合、時間的制約や使用頻度の低さなどにより、国語教育とは異なり目的に応じて短期的・効果的に必要な漢字学習をしなければならない。岡崎(1993)は、漢字指導の順番について、まずは六書の中の象形文字と指事文字、次いで会意文字を段階的に導入することが望ましいと指摘している。加えて、「形(形態)・音(音韻)・義(意味)」の3要素に着目させ、漢字の基本を理解させる必要がある。

何度も書いて覚えるなどといった機械的な反復ドリルは、短期的な記憶には効果的だが、産出活動において有効ではないことが多くの研究で指摘されている。村島(2011)が実施したイメージング法と書字練習による学習法を比較分析した結果から、漢字の観察と漢字の形からイメージを思い浮かべるイメージング法は、反復ドリルによる書字練習よりもテストの平均値が高く、2日後のテストでも比較的字形再生できることが明らかとなった。こうしたイメージング法に基づき、くろしお出版では「ストーリーで覚える漢字300」という初級学習者向けの漢字学習教材も英語やベトナム語などで出版されている。

Flaherty&Noguchi(1998)が実施した調査結果から、漢字の反復ドリルよりも、漢字を構成要素に分解し各パーツに固有の意味を付与し、パーツ間を関連付けるストーリーを記憶させる構成要素分析教授法(Component Analysis method)の方が優位性が高いことが証明された。以上から、特に非漢字圏の日本語学習者には反復ドリルよりも、イメージング法や漢字を部首やパーツごとに分解して漢字の構成と意味を関連付ける教授法の方が効果的であり、漢字指導の基本である。

#### 5. 研究方法

本稿では、モンゴル国における日本語学習者へのインタビュー等の質的研究やアンケートや漢字テストの結果分析等の量的研究は行わず、先行研究を基に論旨を構成する。また、筆者が2024年4月から6月の3ヶ月間、モンゴル国の高等学校においてJLPTのN5、

N4、N3レベルの日本語学習者に行った漢字指導とその結果も踏まえ、先行研究と照らし合わせながら効果的な漢字指導法を検討する。

具体的には、高嶋(2013)がウランバートル市の初中高一貫の外国語教育特化学校の中高生に行った調査結果を分析し、ウラムバヤル(2005)と岡崎(1993)の調査結果を参考にする。加えて、モンゴル国の歴史・文化的背景からモンゴル国における日本語学習者の特徴・傾向を踏まえ、モンゴル人学習者への効果的な漢字指導法を検討する。

## 6. モンゴル人学習者への効果的な漢字指導法の検討

### 6.1 指事文字と象形文字から導入する

まず、漢字学習は楽しい、面白いと興味を持たせるのが第一段階のアプローチである。漢字学習をする前から漢字に抵抗感を抱く学習者も少なくないため、漢字に対してポジティブな印象を持たせることが重要である。段階的なアプローチとして、岡崎(1993)が指摘している通り、まずは「一・二・三」や「上・中・下」など、簡単な指事文字から指導するのが適切である。書き順が少なく、また形としてもシンプルであるため視覚的にわかりやすく覚えやすい。漢字の書き順には、上から下、左から右などの基本原則があり、簡単な指事文字で書き順にも意識を向けさせることができる。

指事文字は、数字や物・動物などの位置といった日常生活において頻繁に使用される基本的な単語が多く、基礎語彙とセットで導入しやすい。すぐに使える漢字であるため、学習者の動機づけを高める効果もある。イラストや地図を提示し、みんなの日本語初級 I 第10課の文型「あります」や第2課の「つくえ」や「かばん」などの語彙を用いて、文章を書かせる練習をするのがわかりやすい。例えば、さまざまな場所に物が置かれた部屋のイラストを提示し、「つくえの下にかばんがあります。」と指事文字を使った文章を書かせる。始めは教師が用意したイラストで練習し、応用として学習者自身の部屋にあるものや、教室を見渡して自由に文作成ドリルをし、最後に学習者の人数や時間配分に応じてペアやグループ、全体で共有する。他にも、地図を見せ「モンゴルは中国の上にあります。」など、学習者の身近なトピックでアプローチするのも学習者の興味を引く上で効果的である。

次に、象形文字である。物の形から作られた文字であり、「日」や「木」「山」などがある。イラストを見せながら、どのようにして象形文字が作られたのか成り立ちを見せるのが効果的である。視覚的にもわかりやすいため、学習者の興味を引きやすい。YouTubeなど、漢字の成り立ちをアニメーション化した動画もあり、漢字を楽しく指導することができる。状況に応じて、指事文字と象形文字のどちらから導入するか、あるいは両方を組み合わせながら導入するのか見極める必要がある。

## 6.2 アイデンティティの観点から会話活動を取り入れる

モンゴル人は遊牧文化の背景から、総合的なアイデンティティを持つと言われている。家族や友人、仲間など、周囲の繋がりの中で自己を認識し、周囲の人たちとのコミュニケーションを重視する。そのため、漢字指導においてもただ何度も書いて覚えるより、会話活動を通して漢字の意味を理解しながら学ぶ方が、効率よく漢字を習得しやすい。高嶋(2013)の調査結果から、日本語学習をするウランバートル市の中高中生計152人のうち、「良い授業とはどんな授業か」という問いに対し、「話すこと」と回答した生徒がA学校では69%(51人)、B学校では54%(42人)と最も多かった。

例えば、JLPTのN5の漢字である「月・火・水・木・金・土・日」という曜日の漢字を指導する際、学習者の今週、あるいは来週の予定を聞く。「曜」は、N4レベルの漢字であるが、漢字は1文字だけではなく熟語として使用されることが多いため、語彙数を増やす目的も兼ねて導入する。後にN4の漢字を学習する際に、事前に導入しておけば学習者は書けなくても見覚えがあり、スムーズに指導できる。曜日を使って学習者に実際の予定を聞くことで、何度も書いて覚えるよりもその漢字を使った熟語が印象に残りやすく、同時に会話を通して学習者との人間関係を構築できる。

さらに、例えば「月」という漢字であれば「つき」と「げつ」など、会話を通して自然に音読みと訓読みを指導することが可能である。コミュニケーションを重視し、周囲の環境の中で自己認識するモンゴル人学習者にとって、安心できる学習環境や教師との関係性は重要である。例え漢字学習であったとしても、このように会話しながら授業を進めていくことが、漢字への興味・関心や意欲へ繋がりに影響を与えるのである。

## 6.3 ポートフォリオ評価を導入する

総合的なアイデンティティを持つモンゴル人学習者にとって、分析的なアイデンティティを持つとされている日本人のような自己分析が苦手な傾向がある。自己分析をする習慣がなく、自己分析をしたことがない学習者もいる。そのため、日本語学習において、自分の得意な分野である長所や苦手な分野である短所を理解しきれていない学習者も少なくない。漢字学習と一言と言っても、書き順やとめ・はね・はらいといった字形が正確な学習者や漢字と意味が一致していない学習者、同音意義語で間違えやすい学習者など、学習者によって得意・不得意はさまざまである。

漢字学習において、特に間違えやすい箇所や苦手分野を学習者1人1人がきちんと把握しておくことが重要である。自分の長所や短所を学びの積み重ねから可視化するために、ポートフォリオ評価を導入するのが効果的である。日々の漢字プリントや宿題、小テストなどを学習記録として残しておくことで、「漢字が苦手」ではなく「漢字の何が苦手なのか」が明確になり、目標設定や客観的な自己評価などが容易になる。教師にとっても、学習者の漢字でつまづきやすいポイントや傾向が見えるため、指導計画が立てやすくなる。漢字の「何が」難しいのか、ボトルネックを明確にし、学習上の弱点を補完することが効率的な漢字学習や学習者の意欲に繋がるのである。ウラムバヤル(2005)の質問紙調査の結果で

は、漢字を覚えられない学習者が一定数いることが明らかとなり、ポータルサイトを導入することで、授業開始直後にウォーミングアップも兼ねて既習の漢字を復習できるため、こうした課題を改善することができる。

#### 6.4 歴史・文化的背景からゲームを取り入れる

チンギス・ハーンによるモンゴル帝国時代といった歴史的な観点や、ナードムといった歴史・文化的な観点から、競争意識が高い学習者も少なくない。そのため、漢字を使ったゲームを取り入れるのも効果的である。例えば、一方が漢字(例:山)、もう一方がイラスト(例:山のイラスト)のカードのペアを何十枚か用意し、神経衰弱をする。学習者はゲームを通して、楽しみながら視覚的に漢字と意味を一致させることができる。非漢字圏の学習者には、漢字を書いて覚えさせるだけではなく、正確さには欠けるが見て慣れさせることも重要である。他にも、教師が発した漢字に該当する漢字カードを誰よりも早く取る漢字かるたや、切り離された部首と部首以外のカードを組み合わせて漢字を作る漢字パズル、漢字ビンゴなど、漢字を使ったゲームはアイデア次第で無数にある。1から作らなくても市販の漢字ゲームもあり、日本で購入して現地の学校へ持っていくのが容易である。いずれのゲームも、漢字の導入やルール説明を十分に行った上で実施する必要がある。

#### 6.5 日本事情を扱ったテーマで漢字指導を行う

ポップカルチャーなどを通して日本事情に興味のある学習者も多く、漢字を指導する際に、その漢字に関連する日本文化も紹介するとより有意義な授業になる。例えば、初級レベルの学習者であれば、簡単に日本の正月について紹介し、その中で伝統的な正月の遊びである福笑いについて説明する。その後、N5の漢字である「口・目・耳・上・下・右・左」を使って、実際に福笑いをアクティビティとして導入する。漢字の意味を理解した上でゲームすることで、漢字が身に付くだけでなく日本文化にも触れることができる。

日本語中上級の学習者には、指導する漢字に関連する日本事情について、初級レベルよりも深く紹介する。例えば、N3、N2レベルの「恋」「愛」という漢字から、日本の恋愛事情について紹介する。他にも、季節ごとの行事やマナー、就職など、モンゴル国と日本を比較しながら会話を発展させるのも面白いだろう。アクティビティであれば、日本で老若男女問わず親しまれている遊びを取り入れ、漢字しりとり(例:三一人一間一食一事)や学習した漢字が各コマに書かれた人生ゲーム、すごろくなどが効果的である。あくまで、指導した漢字が使用語彙として使えるようになることが授業の到達目標であり、会話や日本事情、アクティビティがメインではない。教師は、教室コントロールや時間配分を意識しながら、効果的に会話やゲームなどを導入する必要がある。

## 7. 結論

非漢字圏であるモンゴル国の学習者にとって、慣れない漢字は日本語学習をする上で大きな課題の1つであり、学習者の特性に合った適切な漢字指導が学習者のモチベーションに大きく影響する。漢字指導には確立された教授法がなく、学習者の特性や学習目的などに応じて柔軟に指導する必要がある。漢字指導の前に、学習者にニーズ、レディネス調査をし、コースデザインを行うことが効果的な指導に繋がる。

総合的なアイデンティティや歴史・文化的背景から、モンゴル国における学習者には機械的な反復ドリル中心ではなく、会話やアクティビティなどを適宜導入し、漢字の意味や構造を重視した体系的な漢字指導が有効である。

本稿では、モンゴル国における日本語学習者を対象とした質的・量的研究を行わず、先行研究を基にモンゴル人学習者に効果的な漢字指導を検討した。今後は、モンゴル人学習者に効果的な漢字指導や教授法を、実践を通して検証し確立していく必要がある。

---

## 参考文献

1. 独立行政法人国際交流基金(JF) 2021年度 海外日本語教育機関調査「第2章 地域別の日本語教育状況」(2026年1月14日アクセス)
  - a. [https://www.jpf.go.jp/j/project/japanese/survey/result/dl/survey2021/east\\_asia.pdf](https://www.jpf.go.jp/j/project/japanese/survey/result/dl/survey2021/east_asia.pdf)
2. 独立行政法人国際交流基金(JF) (2025) 「2024年度「海外日本語教育機関調査」結果」(2026年1月14日アクセス)  
<https://www.jpf.go.jp/j/about/press/2025/dl/2025-031.pdf>
3. モンゴル国家統計局 (National Statistics Office of Mongolia) 「Статистикийн мэдээллийн нэгдсэн сан」(2026年1月14日アクセス)  
<https://www.1212.mn/mn>
4. 独立行政法人国際交流基金(JF) (2023) 日本語教育 国・地域別情報「モンゴル(2023年度)」(2026年1月15日アクセス)
  - a. <https://www.jpf.go.jp/j/project/japanese/survey/area/country/2023/mongolia.pdf>
5. 日本語能力試験 JLPT「海外の実施都市・実施機関一覧」(2026年1月15日アクセス)
  - a. [https://www.jlpt.jp/application/overseas\\_list.html](https://www.jlpt.jp/application/overseas_list.html)
6. 高嶋幸太 (2013) 立教日本語教育実践学会 日本語教育実践研究創刊号 pp.63-74「モンゴル初中等教育機関での授業実践 ―現状調査を踏まえたチーム・ティーチングの試み―」

7. ウラムバヤル ツェツェグドラム (2005) 国際交流基金日本語国際センター・国立国語研究所・政策研究大学院大学 日本語文化研究会論集創刊 pp.201-228「モンゴル国立科学技術大学の学生が使用している漢字学習ストラテジー —漢字シラバスの作成に向けて—」
8. ウラムバヤル ツェツェグドラム (2011) 国際交流基金日本語国際センター 政策研究大学院大学 言語文化と日本語教育41号 日本語文化研究プログラム博士課程「モンゴルにおける日本語教育 —高等教育機関における漢字教育に着目して—」
9. 岡崎正道 (1993) 岩手大学リポジトリ「日本語教育における漢字指導のあり方」
10. 村島千里 (2011) シラキユース大学「漢字学習における書字練習とイメージング法の効果の比較」
11. Mary Flaherty & Mary Sisk Noguchi (1998) JALT Journal, Vol. 20, No.2「Effectiveness of Different Approaches to Kanji Education with Second Language Learners」
12. みんなの日本語 初級 I 第2版本冊 スリーエーネットワーク

МОНГОЛ УЛСАД ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН  
БАЙДАЛ БА ТУЛГАМДСАН АСУУДЛУУД:  
СУРГАЛТЫН МАТЕРИАЛ БОЛГОН ЯПОН АНИМЭ АШИГЛАХ  
БОЛОМЖИЙН ТАЛААРХ СУДАЛГАА

*Макихара Аяако  
(Соёл Эрдэм дээд сургууль,  
Япон судлалын тэнхимийн  
магистрант)*

## 1. 要旨

モンゴルでは日本語学習が一定規模で継続しており、今後も留学・就労等を背景として需要が維持・拡大する可能性がある。一方、日本語教育機関の地理的偏在や教育者リソースの不足、学習継続の難しさといった構造的課題が重なり、学習機会が十分に供給されていない現状が指摘されている。こうした課題に対し、オンライン環境を活用した自律学習の設計は有望であるが、実際にはオンライン授業が一般化していないことも報告されている。

本稿の目的は、公開資料に基づいてモンゴルの日本語教育の現状と課題を整理し、その課題に対応する教材ツールとして日本アニメを位置づけたうえで、地方偏在・教育者不足・継続困難といった課題に対し、アニメ教材がどのように有効であり得るかを概念的に検討することである。

## 2. 研究方法

本稿は、一次的な質問紙調査や授業実践を行わず、二次資料分析によって論旨を構成する。具体的には、国際交流基金(JF)が公表するモンゴルの日本語教育に関する国別情報を用いて学習規模と教育機関の分布を把握し、教育供給の構造を整理する。併せて、モンゴルのデジタル環境の普及状況(インターネット普及率、モバイル接続数)に関する公開統計を参照し、オンライン学習の実装可能性を検討する。

さらに、アニメを素材とした日本語学習活動を提案する矢崎の教材開発研究(<https://shizuoka.repo.nii.ac.jp/records/3084>)を分析対象とし、アニメ教材を「インプット中心の消費」ではなく「共通体験を核にコミュニケーション活動へ展開する教授設

計」として捉える立場を採用する。また、ティーチング・ストラテジーの汎用性・発展性・共有化の議論を援用し、教育者不足や機会格差を緩和する枠組みとして整理する。

### 3. モンゴルにおける日本語教育の現状と課題

国際交流基金(JF)の国別情報によれば、モンゴルにおける日本語教育は、学習者 13,334 人、教育機関 117、教師 363 という規模で報告されており、学習需要は無視できない水準にある。しかし同資料は、教育機関の 90%以上が首都ウランバートルに集中している点を明記しており、地方学習者にとっては教育機会へのアクセスが制約される構造がある。こうした偏在は、教室型学習のみを前提とする場合、学習者数の拡大に対して供給側が追いつかない可能性を意味する。

また、教育形式の多様化は進んでいるものの、モンゴルの日本語学校におけるオンライン授業は「マネタイズや学習継続の面で一般化していない」と報告される。つまり、インターネット等の学習基盤が整っていても、学習者が継続しやすい仕組みや、教育資源が循環する設計が未成熟である点が示唆される。

ただし、オンライン化を阻害する要因が回線や端末の不足に起因すると断定することは難しい。実際、モンゴルのインターネット普及率は 83.9%とされ、モバイル接続数は人口比 147.8%相当とされる。これらの数字は、モンゴルにおいて、少なくとも「オンライン教材へアクセスし得る基盤」が一定程度存在することを示す。したがって主要課題は、接続環境よりも、教材設計と継続支援のあり方、そして地方における教育資源不足をどう補うかに位置づけられる。

以上より、モンゴルの日本語教育は(1)地理的偏在、(2)教育者リソース不足、(3)継続学習を支える教材・学習設計の不足という課題を抱えていると整理できる。

### 4. 教材としての日本アニメの可能性と課題対応

上述の課題に対し、日本アニメを教材ツールとして位置づける意義は、第一に学習継続(動機づけ)への寄与にある。日本アニメは学習者にとって親和性が高い場合が多く、単なる教材としての「義務」ではなく、自発的な視聴行動を学習機会へ転換し得る。さらに、YouTube 等の無料プラットフォームを通じてアクセス可能な素材が多いこ

とは、地方における教材アクセスを補完する点でも有利である。これは、教育機会の偏在が構造課題となっているモンゴルの文脈において、重要な意味を持つ。

第二に、アニメ教材は適切な教授設計によって、教育者不足や継続困難という課題に対し「教師依存度の低い学習モデル」を構成し得る。モンゴル国内の日本語教育者は自身が十分な日本語力を有さないまま生徒に教育する立場になる例が少なくない。これが学習者全体のレベルや学習継続意欲の低下につながっている可能性も示唆されている。( [https://www2.jica.go.jp/ja/priv\\_sme\\_partner/document/1567/Nz231-004\\_report.pdf](https://www2.jica.go.jp/ja/priv_sme_partner/document/1567/Nz231-004_report.pdf) ) 矢崎は、従来のアニメ活用が内容理解や文化紹介などインプット中心にとどまりがちであることを踏まえ、視聴という共通体験を基盤に学習者同士のコミュニケーション活動へ展開する設計を提案している。さらに、ティーチング・ストラテジーには汎用性・発展性があり、収集・蓄積・共有化によって教育資源として流通させ得る点が強調されている。

これらの議論を援用すれば、アニメ教材は「教材そのもの」ではなく「活動テンプレート（教授ストラテジー）のパッケージ」として地域差を縮小する可能性がある。すなわち、地方や教育者が少ない環境においても、ストラテジー共有があれば、学習者が一定の質で自律学習を進めやすくなる。

第三に、アニメの教材化は、オンライン学習が一般化しないという現状に対して、継続の仕組みを設計し直す契機となりうる。オンライン授業が継続しにくい要因には、単なる授業置換（対面授業を Zoom に移す）にとどまり、学習者が達成感を得られる学習単位や、反復・共有による習慣化の設計が弱い点が含まれる。アニメは短い視聴単位に分割しやすく、繰り返し視聴が自然に発生しやすい。この特性を、短尺視聴→タスク→共有といった学習導線に統合することで、学習の継続性を高める設計が可能である。

もっとも、アニメ教材の導入には限界もある。アニメの言語使用は口語的で場面依存性が高く、就労目的学習に直結しない表現も多い。したがって、アニメを主教材とするのではなく、学習目標（試験・就労・会話等）と結びつく形で補助教材として位置づけ、場面適合性やレジスターの注記を行うことが不可欠である。すなわち、アニメを「見せる」だけでなく、「教材化する」ための設計（ストラテジー共有、活動テンプレ、教師用ガイド）が前提となる。

## 5. 結論

モンゴルの日本語教育は一定規模の需要が存在する一方、教育機関の首都集中によるアクセス格差、教育者不足、学習継続を支える教材・学習設計の不足といった構造的課題を抱えている。一方で、インターネット普及率やモバイル接続の高さは、オンライン教材を活用した自律学習モデルが成立し得る環境条件を示している。

この状況を踏まえると、日本アニメは学習者の自発性を学習機会へ転換しやすい素材であり、さらに矢崎が示すような「共通体験を核に活動へ展開する教授設計」および「ティーチング・ストラテジーの共有化」という枠組みによって、地方偏在・教育者不足・継続困難を緩和する教育資源となり得る。

ただし、本稿の議論は二次資料に基づく概念的検討であるため、今後は実装後の継続率・学習到達度等を用いた実証的評価が必要である。

---

## 参考文献

- 国際交流基金(2023)国・地域別情報:モンゴル(2023年度)
- DataReportal(2024) *Digital 2024: Mongolia*
- World Bank(2023) Mobile cellular subscriptions (per 100 people) – Mongolia
- 矢崎満夫(2009)「アニメを素材とした日本語学習活動『アニメで日本語』の開発」



# ШҮҮМЖ ӨГҮҮЛЭЛ



**ХАРЬЦУУЛСАН УРАН ЗОХИОЛ СУДЛАЛЫН ТАВЦАН ДАХЬ  
ЭДГАР АЛЛАН ПО ба Д.НАЦАГДОРЖ**

*(ӨМБИС-ийн багш, доктор Манухуарын “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” бүтээлийн жишээн дээр)*

**Б.Мөнхбаяр  
(Доктор (Ph.D))**

Харьцуулсан уран зохиол гэдэг бол уран сайхан, туурвил зүйн сэтгэлгээгээрээ өөрийн улс орныхоо уран зохиолын хил хязгаарыг даван гарсан буюу хил хязгаарт үл хашигдан, өргөн харилцаа холбоонд орж буй зохиолыг хэлдэг. Ийм зохиолыг академич Ц.Дамдинсүрэн 1977 онд: “*Үлгэрүүдийн дотор үнэхээр уламжлан авсан ба санамсаргүй адил төсөөтэй болсон хоёр зүйл байдаг. ...Энэ ялгааг судлагчид олж чадвал үнэн зөв дүгнэлтийг хийж чадна*”<sup>47</sup> хэмээн тодорхойлсон байдаг. Да багшийн дэвшүүлсэн “*санамсаргүй адилших харилцаа*” хийгээд “*жинхэнэ уламжлагдах харилцаа*” гэсэн энэ томъёолол бол, хам ба цуваа цагийн хүрээнд, гадаад ба дотоодын орон зайн өргөн боломж дахь уран зохиолын хэлхээ холбоо хийгээд харилцан нөлөөллийн талаарх асуудал болох бөгөөд аливаа зохиол бүтээлд байгаа тийм гадаад, дотоод харилцаа холбоог нээн илрүүлж тодруулах нь утга зохиол судлалд чухал ач холбогдолтой ажил болохыг онцлон тэмдэглэсэн байгаа юм.

Тэгвэл Ц.Дамдинсүрэн багшийн дэвшүүлсэн “*санамсаргүй адилших харилцаа*” хийгээд “*жинхэнэ уламжлагдах харилцаа*”-г Америк, Монголын хоёр бодит зохиолын баримт тодруулан авч үзсэн нэгэн шинэ судалгааны бүтээл гарсан нь ӨМБИС-ийн багш, доктор Манухуарын “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” (Нандир дизайн хэвлэлийн компани, УБ., 2024) хэмээх ганц сэдэвт судалгааны зохиол болно.

Дөрвөн бүлэг бүхий эл бүтээлийг, агуулгын талаас нь тодорхойлон авч үзвэл, судлаач эхний бүлэгтээ Д.Нацагдоржийн хийсэн уран зохиолын болон түүхийн орчуулгын талаар, мөн эдгээр орчуулгын судлагдсан байдлыг авч үзэж үнэлэн дүгнэсэн байна.

Энд хамгийн чухал нь Д.Нацагдорж Э.А.Погийн “Алтан цох”-ыг орчуулах болсон учир шалтгаан зорилго нь юу байсан, хэрхэн орчуулсан, Д.Нацагдоржийн орчуулсан “Алтан цох”-ын герман эхэд судалгаа хэрхэн өрнөж ямар төвшинд хүрсэн энэ бүхнийг нягтлан судлаад эцэст нь Д.Нацагдоржийн орчуулсан герман хэлээр байгаа тэр “Алтан цох” чухам хаана, хэзээ, ямар хэвлэлийн газраас эрхлэн хэвлэсэн “Алтан цох” байсныг бодит баримтаар нотлон баталсан нь Д.Нацагдорж судлалд гарсан эргэлт, цоо шинэ дуу хоолой болж байна. Тиймээс судлаач чухам яаж, ямар аргаар Д.Нацагдоржийн гарт байсан “Алтан цох”-ыг тодруулсан бэ? Бидний мэдэхгүй байсан энэ асуудлыг хэрхэн судалж тогтоосон бэ? гэдэг нь нэлээд сонирхолтой асуудал юм.

<sup>47</sup> Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд “Монголын уран зохиолын тойм” II боть УБ, 1977, 328-р тал

Д.Нацагдорж “Алтан цох”-г 1935 онд герман хэлээс монгол хэлээр орчуулсан нь тодорхой. Энэ тухай Шинжлэх ухааны хүрээлэнгийн Тэргүүлэгчдийн 1935 оны 6-р сарын 11-ний өдрийн хурлын тогтоолд: “Түүхийн тасгийн эрхлэгч Д.Нацагдоржоос нөхөр Б.Ринчений захисан ёсоор Америк улсын уран зохиолч Аллан Погийн “Алтан цох” хэмээх зохиолыг герман хэлнээс орчуулан гүйцэтгэсний тул хянан тогтоож, зохих хөлсийг олгоно уу хэмээснийг хэлэлцээд, зүйтэй тул ёсоор болгон хэвлүүлэхээс гадна, уул орчуулгын үнэ хөлсийг хэвлэлийн хуудсаар бодож 230 төгрөгийг Д.Нацагдоржид олгохоор тогтов. Дарга Дэндэв, Тэргүүлэгч Амар, Тубянский, Цэенрэзэн, Юндэнбазар”<sup>48</sup> гэж дурджээ. Тэгэхээр Д.Нацагдорж 1935 оноос өмнө герман хэлээр хэвлэгдсэн “Алтан цох”-ыг орчуулсан нь байх ойлгомжтой болж байна. Судлаач Манухуар судалгааны яг зогсоц дээрээс юуны өмнө 1935 оноос өмнө герман хэлээр орчуулагдан хэвлэгдсэн “Алтан цох”-ын хэвлэлийн бүх эхийг бүртгэн олж цуглуулсан байна. Үүнд:

1. Der Goldkäfer - Poe, Edgar Allan.- Münster i. W.: Aschendorff, 1913.
2. Unheimliche Geschichten - Poe, Edgar Allan.- Stuttgart: Lutz, 1914, 5. Aufl.
3. Phantastische Erzählungen - Poe, Edgar Allan.- Leipzig: Insel-Verl., 1914, 16.- 25. Tsd.
4. Seltsame Geschichten - Poe, Edgar Allan.- Strassburg: Josef Singer Verl., 1918.
5. Der Goldkäfer - Poe, Edgar Allan.- Berlin: E. Flemming & C. T. Wiskott, 1923.
6. Der Goldkäfer - Poe, Edgar Allan.- München: Allgemeine Verlagsanstalt, 1924.
7. Der Goldkäfer - Poe, Edgar Allan.-Leipzig: Dt. Nationalbibliothek, 1924. [Online-Ausg.]
8. Der Goldkäfer - Poe, Edgar Allan.-Nürnberg: Verein. Margarine-Werke, [um 1928]
9. Der Goldkäfer - Poe, Edgar Allan.- Heidelberg: Meister, 1932.

гэсэн 9 хэвлэлийн эх багтсан байв. Эндээс харахад “Алтан цох” нь 1913-1932 оны хооронд, Германы Мюнстер, Штутгарт, Лайпциг, Берлин, Мюнхен, Нюрнберг, Хэйдэлберг зэрэг олон хотод герман хэлээр хэвлэгдсэн бөгөөд эдгээрийн аль нэгийг нь Д.Нацагдорж ашигласан болж байна. Нэг зохиолын, нэг хэлээр, энд тэнд, олон хот газар хэвлэгдсэн эхүүдээс “Нацагдорж энэ хэвлэлийг нь сонгож орчуулсан байна” гэж тогтоох амаргүй ч гэлээ, нэгэн байж болох магадлал бол Д.Нацагдорж, Берлинд болон Лайпциг хотод сууж байсан. Тэр тусмаа Лайпциг хотод илүү удаан амьдарч, тэндээс 1929 онд шууд Монгол руугаа буцсан. Иймээс Д.Нацагдоржид Лайпцигт хэвлэгдсэн “Алтан цох”-ын герман орчуулгыг ашигласан байх боломж илүү байсан байж магадгүй. Түүнчлэн нутаг буцахдаа Э.А.Погийн уран бүтээлээс авч харьсан ч байж мэдэх юм. Энэ бол миний л, надад төрөгдсөн хувийн бодол болно. Гэтэл судлаач Манухуар миний бодож буй дээрх таамаглалаар биш, дээр дурдсан бүх герман хэлний орчуулгуудыг Д.Нацагдоржийн монгол орчуулгатай, зохиолын хэлбэр,

---

<sup>48</sup> Д.Нацагдорж Бүрэн зохиол II боть, Удиртгал, тайлбар бичиж, эмхэтгэн редакторлан хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв. УБ., 2016, 462-р тал

бүтэц, үгийн сан, утгын талаар харьцуулан судлаад, Д.Нацагдоржийн ашиглах боломжтой гэж үзсэн эх [*Der Goldkafer Münster i. W.: Aschendorff, 1913; Phantastische Erzählungen Leipzig: Insel-Verl., 1914, 16.- 25. Tsd.*]-ээ гаргаж авсан байна. Улмаар ийн сонгосон эх дээрээ Э.А.Погийн 1843 онд анх нийтлүүлсэн англи хэлээрх “The Gold Bug”-г бас нэмэн харьцуулан судлахдаа, ялангуяа зохиолын хэлбэр бүтэц, баймж утга, далд санаа, давхар бэлгэдлийг гол цөм агуулгатай холбоослох үүрэг бүхий **эхлэл шүлэг, оришил, төгсгөлийн үгд** тулгуурлан үндсэн эхэд бичвэрийн нарийвчилсан судалгаа хийгээд “Д.Нацагдоржийн ашигласан эх бол Э.А.Погийн “Phantastische Erzählungen” (“Гайхамшигт явдлууд”) хэмээх 1914 онд Германы Лайпциг хотноо герман хэлээр хэвлэгдсэн түүвэр юм”<sup>49</sup> хэмээн баталсан байна.

Нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухаанд, судалгааны ийм арга зүйгээр тухайн эх сурвалж, хэрэглэгдэхүүнийг танин тодлох нь маш чухал ач холбогдолтой байдаг. 2014 онд ийм нэгэн явдал болсон юм. Хар хотын тууриас олдсон монгол бичиг үсгээрх олон дурсгалын дотор Пагва ламын зохиосон дөрвөлжин үсгээр бичсэн нэгэн тасархай хуудас байжээ. Судлаачид зөвхөн, тэрхүү тасархай хуудсанд бичигдсэн уншиж болох цөөхөн хэдэн үгийг л уншиж байснаас биш, тэр тасархай хуудас нь хэн гэдэг зохиолчийн, хэдэн онд бичсэн, ямар ном бүтээлийн хэсэг бусаг тасархай нь вэ? гэдгийг мэдэж таниагүй, тайлж тайлбарлаж чадаагүй байсан юм. Гэтэл 2014 онд Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Р.Отгонбаатар тэрхүү тасархай хуудас дээрх бичвэрийг зөв уншин тайлаад, үүндээ тулгуурлаад энэхүү дөрвөлжин үсгийн үсгийн дурсгал бол Сажа нутгийн эрдэмтэн Пагва лам Лодойжалцаны (1235-1280) зохиосон “Шэйжэ равсал шэйжавын данжой” буюу “Мэдэгдэхүүнийг бэлгэтэйеэ гийгүүлэгч нэрт шастир”-ын нэгэн хэсэг нь байна гэж таньж тайлбарласан билээ.

Судлаач Р.Отгонбаатарын хийсэн энэ судалгааны үр дүнд Монголын ном хэвлэл, соёлын түүх тэр дундаа дөрвөлжин үсгийн бар хэвлэлийн түүх нь XIV зуун буюу 1300-аад оноос эхлэлтэй бус бус XIII зууны сүүл үе 1280-аад оны үеэс эхлэлтэй гэдэг нь баримтаар нотлогдов. Бас Пагва лам Лодойжалцаны ном бүтээлийн тархалт, түүний уламжлал залгамжлалын харилцаа холбоо улам тодрон, тэлж байгааг мэдрүүлсэн юм. Нэн чухал нь уг тасархай хуудас чухам хэн болох нь танигдсанаараа улам үнэ цэнтэй, ач холбогдолтой үнэт өв дурсгал болж хувирсан билээ. Тэгвэл судлаач Манухуарын судалгаа яг үүн шиг, Д.Нацагдоржийн орчуулсан эх нь “энэ юм” гэдгийг тодруулснаар 1914 онд Германы Лайпциг хотноо герман хэлээр хэвлэгдсэн Э.А.Погийн “Phantastische Erzählungen” (“Гайхамшигт явдлууд”) түүвэр нь Монголын уран зохиол судлаачдад, Д.Нацагдорж судлаачдад, монголын орчуулгын зохиол судлаачдад асар үнэ цэн бүхий чухал дурсгал болж хувирлаа. Судлаач Манухуарын “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” бүтээлийн нэгдүгээр бүлгийн гол ач холбогдол нь үүнд оршино. Тэгвэл энэ бүтээлийн “Алтан цох”-ын монгол орчуулгын шинжлэл” хэмээх хоёрдугаар бүлэгт Д.Нацагдоржийн орчуулгын онол, орчуулсан арга барил, хэв маягийг

---

<sup>49</sup> Манухуар “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал”, УБ., Нандир дизайн хэлэлийн компани, 2024, 82-р тал

тодруулж, “Алтан цох” -ын чухал байр суурь эзэлж буй үгсийн гурван хэлний толь хавсаргажээ. Гуравдугаар бүлэг “Д.Нацагдоржийн “Харанхуй хад” ба Э.А.Погийн уран бүтээлийн харьцуулсан судлал” нэлээд сонирхолтой. Үүнд нэн түрүүнээ эл хоёр бүтээлийг харьцуулан судалсан Монгол улсын эрдэмтэн Б.Содном, С.Лочин, Л.Хэрээ, Г.Галбаяр, Японы эрдэмтэн Шибаяама Юүтака, Өвөр Монголын эрдэмтэн М.Баясгалан нарын судалгааны байдлыг авч үзэн үнэлж дүгнээд, дараа нь эл хоёр бүтээлийг харьцуулан судлах өөрийн судалгааны хараас зогсоо “Хүүрнэл зүйн үүднээс хоёр зохиолыг харьцуулах нь” гэж тодорхойлсон байна. Хүүрнэл зүй бол ХХ зууны эхэн үеэс үүсэж хөгжсөн, уран зохиол судлалын онол арга зүйн нэгэн шинэлэг чиглэл билээ. Хэрэв өгүүлсэн үгийн зохиолд өгүүлэмжийн өрнөл ба цагийн элементийг үзүүлэхийг чухалчилдаг бол хүүрнэл зүйд хүүрнэлийн байр суурь, зогсоц [I биеийн хүүрнэгч, III биеийн хүүрнэгч, хөндлөнгийн хүүрнэгч ...гэх мэт], хүүрнэлийн цаг, хүүрнэлийн орон зайг чухалчилдаг. Судлаач Манухуар хүүрнэл зүйн яг арга зүйгээр судлан, “Харанхуй хад” болон “Алтан цох” нь цөм I биеийн хүүрнэлээр хүүрнэн бичсэн зохиол юм. Хэрвээ “Харанхуй хад”-ын хүүрнэлийн зогсоц нь гол дүрийн I биеийн хүүрнэл бол “Алтан цох” нь туслах дүрийн хажуугийн хүүрнэл болно. Иймэрхүү хүүрнэл нь уншигчдыг зохиолын “Би” баатрын үйл ажиллагаа, амьдрал, дотоод сэтгэлийн ертөнцөд нь дагуулан оруулж, уншигчдын сэтгэлийг амархан татаж, үйл явдлын өрнөл, хөгжил, хувирлын нууцлаг шинжийг нэмэгдүүлдэг. Нөгөө талаар уншигчид зохиолын “Би” баатрын бодол санааг цаг ямагт зохих хэмжээнд ойлгож мэдэрч чаддаг. Жишээ нь зохиолын “Би” баатар “Харанхуй хад” гэдэг газрыг эрээд явж байгаа үеийн төөрөл, бачимдсан сэтгэл хийгээд бусад бодол санааг нь бүрэн ойлгож болно. “Би” баатар хүүрнэж байгаа учир нь сэтгэлийн ил байдлын онцлогтой холбоотой. “Алтан цох”-д уншигчид “Би”-гийн хүүрнэлээр дамжин “Би”-гийн бодол санааг зохиолд хүүрнэсэн шиг ойлгон мэдэж болдог, гэвч энэ нь I биеийн хажуугийн хүүрнэл учир, “Би”-гийн хараагаар, зохиолын баатар Леграндын бодол санаа, үйл ажиллагааг хязгаартай ойлгож чадна. Яг ийм учир, уншигчид зөвхөн хүүрнэгч “Би”-гийн хүрэн дэх учир явдал, байдлыг буюу “Би”-гийн мэдэх хүрэн доторх л байдлыг ойлгодог учраас олон сэжиг, олон таамаг, олон асуудалтай тулгардаг. Жишээ нь “Алтан цох”-д уншигчид хүүрнэгч “Би”-гийн бодол санааг ойлгодог боловч зохиолын баатар Леграндын бодол санаа, үйл ажиллагааг бүрэн ойлгохгүй учраас Легранд өдөржин үг дуугүй, нэг юм бодон суух буюу хүрз малтуур авч хээр хөдөө явахад, мөн түүнийг “Би”-гийн бодсон шиг солирсон буюу өвчилсөн гэж боддог. Тэгээд энэ солиотой юм шиг аашилдаг хүн яах гэж байгаа бол гэж зохиолын үйл явдлыг өрнөлтөд хөтлөгдөн амтархан унидаг юм. “Харанхуй хад”-д зохиолын “Би” баатар морио унаад гарч, зорьсон хэрэг юу болохыг мэдэхгүй морины санааг даган явахад уншигчид бас тэр аяар л хөтлөгдөн явдаг. Тэгээд замд тааралдсан айлын хар хүн болон хөгшин ээжийн үг яриа, үйл хөдөлгөөнийг мөн зохиолын “Би” баатар -тай адилхан тийм ч сайн ойлгохгүй. Тэр хөгшин ээж юуны учраас нь “Би”-д нэг чулуу өгснийг мөн ойлгож чадахгүй юм. Уншигчид зохиолын үйл явдал яаж үргэлжлэхийг тааж чадахгүй байдаг. Учир нь “Би”-гийн хайж байгаа “Харанхуй хад” гэдэг газрыг олох эсэх нь эргэлзээтэй юм.”

<sup>50</sup>гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл энд Д.Нацагдоржийн “Харанхуй хад”-д чухам юуг яриад байна гэдэг нь тодорхой хариултгүй л байсаар байгаагийн учир нь иймэрхүү I биеийн хүүрнэлийн байр суурь, зогсоц нь уншигчдад олон сэжиг таамаг, асуултуудыг санагдуулдаг, уншигчийг тэмүүлэлт шинжтэй болгодог, бас ийм I биеийн хүүрнэлтэй зохиол нь гүн нууцлаг имиж дүр төрхтэй болсон байдгийг хэлсэн хэрэг юм.

Судлаач энэ бүлэгтэй хоёр зохиолыг хүүрнэлийн загварын талаас харьцуулан авч үзсэн нь шинэлэг тал мөн. Хэдий олон судлаач “Харанхуй хад”, “Алтан цох” хоёр зохиолын өгүүлэмж, үйл явдалд ижил шинжтэй өгүүлэмж буюу хүүрнэлийн загвар харагддаг гэдгийг ажигласан байдаг ч гэлээ Манухуар:

1. **Зохиолын баатар нууц үгийг олсон:** “Харанхуй хад”-д зохиолын “Би” баатар нэг өглөө сэрэхэд тэмдэглэлийн дэвтрээсээ санамсаргүй хэдэн бүрэг бараг үг олж харна. *“химчик харандаагаар бичсэн хэдэн үсэг бараг бүрэг үзэгдэх нь түүнийг шүлсээрээ норгон, улмаар ажиглаваас: “Найман сарын гучны Бямба гариг, Харанхуй хад Ина (Ина)”* Э.А.Погийн “Алтан цох”-д зохиолын баатар Леграндын алтан цохыг боосон цаас нь галын дөлөнд халахдаа нууц үг нь гарч ирсэн байна. *“Түүнийг би базаж тасар татах гэтэл миний цох зурсны тэнд үнэхээр нэгэн хохимой толгойн дүрс зэрвэдхийн үзэгдэхүйеэ, гэнэт гайхсан бөгөөд нэгэн зэрэг би түүний учрыг олж ядав. ...Эдгээр тодорхой байдлыг нэхэж санан бодвоос саарь дээр хохимойн толгойн зураг гарсан нь гал дор халсандаа илэрсэн нь дамжиг үгүй хэмээн шийдэв. ...Гэтэл түүнийг бас халааваас мөн зурвас хуудсан дээр хохимойн толгой зурсан өнцгийн нөгөө эсрэг өнцөг дор нэгэн юмны дүрс бүрэлзэн илэрч үзэгдсэнийг би анхан дор ямааны дүрс хэмээн харав.”*
2. **Нууц үгийн учрыг удаан хугацаанд шинжин бодох:** Хоёр зохиолд зохиолын баатар (“Би” болон Легранд) санамсаргүй олж харсан нууц үгийнхээ санааг тэр даруйд нь ойлгож чадахгүй, харин нэлээд урт хугацаанд бясалган бодож байгаад сая гэнэт нэг юм бодож олсон байдлаар дүрслэгддэг. “Харанхуй хад”-д: *“Ина болбоос энгийн хүн бус бөгөөд эрдэмтэн охины манлай мөний тул, энэхүү бичсэн нь лав нэгэн учиртай биз ээ. Үүний учрыг олбоос, Инаг олох нь магад хэмээн сэтгэгдмэгц нэгэн аяга цай авчруулан уугаад, мөнхүү хэвтээ хэвээр уг тэмдэглэлийн утгыг шинжлэн боловсруулж эхлэв”* гэж дүрсэлсэн бол “Алтан цох”-д: *“Түүнээс би тэр даруй дор нэгэн гэрэл авч байшингийн нөгөө булан дор сууж тэрхүү саарийг нарийнаар шинжин үзсэн минь тэр бүлгээ. ... миний тархины хамгийн алслагдсан өнцгөөс тэр үдишийн сонин явдал юу билээ хэмээн галт хорхойн цог мэт өчүүхэн гэрэл сүүмэлзмэгц даруй босож, саарийг хайрцаг дор агуулан цоожлоод ганцаар болтлоо чинагш эргэцүүлэн бодохыг зогссон буй”.*
3. **Нууц үгийн заавраар эрэлд явсан:** “Харанхуй хад”-д, “Би” баатар тэмдэглэлийн дэвтэр дээрх *“Найман сарын гучны бямба гараг. “Харанхуй хад”. Ина”* гэдэг үгнүүдийг үзээд, Ина лавтай “Харанхуй

---

<sup>50</sup> Манухуар “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал”, УБ., Нандир дизайн хэлэлийн компани, 2024, 167, 168-р тал

хад” гэдэг газарт байна, найман сарын гучны бямба гараг нь болзсон өдөр, тэгээд зохиол дахь энэ өдөр нь болох тул “Би” тэр дороо морь эмээллэн, Инатай уулзахаар “Харанхуй хад”-ын эрэлд явдаг. “Алтан цох”-д Легранд саарь дээрх нууц үгийг галын илчинд олж харсны дараа, саарь дээрх хоёр өнцөгт тус бүр “ишиг” (kid) ба хохимой толгойн зураг байгааг үзээд, хохимой толгой нь далайн дээрэмчний сүлд тул, хамгийн тэргүүнд тэр ишиг (kid) нь далайн дээрэмчин Кид (Kidd)-ийн гарын үсэг болохыг таан мэдэж, англи хэлний үгийн хэрэглэгдэх давтамжийн дэс дараа, жам ёсыг үндэслэн, тэдгээр нууц үгийг тайлан уншиж, тэдгээр үг нь далайн дээрэмчний үлдээсэн газрын зураг болохыг мэдсэн бөгөөд тэдний алт эрдэнэс хадгалсан газрыг нь амжилттай эрж олжээ.

**4. Амьтан дохио өгөх:** “Харанхуй хад”-д “Би” баатар “Харанхуй хад” гэдэг газрыг эрхээр морио унан, элс цөл, бартаа бэрхтэй газрыг туулан, аянга цахилгаан буусан бороотой шөнө, хад асга сэхүйлцсэн газар хүрч очиход “Би”-гийн унасан морь юу нэгийг мэдсэн шиг их л үргэв. *“Гэтэл морин нэгэнт үргэн Харанхуй хадын дунд хангинатал янцагаах дуун ясан дор тултал жихүүцүүлэхүй лүгээ нэгэн амьтан тулж ирэхүйг мэдсэн боловч ихэд сочсон тул нэгэнт мэдрэл зайлжээ. ...”*. “Алтан цох”-д “Би” баатар, Юпитер болон Легранд далайн дээрэмчний булж тавьсан алт мөнгөний эрэлд явж, нэг газрыг олж аваад, ухаж байтал, дагуулсан нохой нь гэнэт сонин аашлах болсон байна. *“...бид малтсаар нэгэн цаг хагас болохуй дор нохой дахин хуцаж, сэжиглэлтэйгээр улина. Үүний урьд аваас тэр дэмий л саваа үгүйдэх буюу уулинхайдан хуцаж агсан нь илэрхий бөгөөд харин эдүгээ их л зэвүүн дуу гаргана. Юпитер түүний хоншоорыг дахин боох хэмээн оролдвоос харин тэр өмнөөс нь хэдэрлэн цовхорч, бидний малтаж бүхий нүхний дотор харайн орж ирээд галзуурсан мэтээр савраар газар маажлан самардана. Хэдхэн хормын зуур хүний ясыг хэсэг хэсгээр малтан гаргахыг бүртгэвээс хоёр хүний яс ажгуу. ...”* “Харанхуй хад”-д “Нэгэн амьтан тулж ирэхүй” болж, “Алтан цох”-д хүний ясыг хэсэг хэсгээр малтан гаргахыг бүртгэвээс хоёр хүний яс. ...”

**5. Харанхуй орчноос гялалзсан үнэт юм гарч ирэх:** “Харанхуй хад”-ын төгсгөлд “Харанхуй хад”-ны дунд хасын царайтай Ина гарч ирдэг. *“сочин босож үзвээс янаг охин Ина хажуу дор зогсож байх бөгөөд үзэсгэлэнтэй залуу охины хасын царай нь Харанхуй хадыг гэрэлтүүлэн байна.”*. “Алтан цох”-д харанхуй хонгилын дотроос гялалзсан алт эрдэнэс гарч ирдэг. *“Бид түүний дотроос юу гарах бол хэмээн ихэд чичрэн дагжин, дээр амьсгалаар айн нээмэгц тоолигүй үнэт эрдэнийн сан манай өмнө гэрэлтэн үзэгдэнэ. Харанхуй хонгилын дотор тусах дэнлүүний гэрэл дор овоолсон алт ба эрдэнийн чулуу гялтганан гялалзах нь нүдээр харахуйяа бэрхтэй гялбалзана.”*<sup>51</sup>

---

<sup>51</sup> Манухуар “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал”, УБ., Нандир дизайн хэлэлийн компани, 2024, 171, 172, 173-р тал

гэсэн хүүрнэлийн 5 загвар гаргаж, харьцуулсан нь оновчтой, шинэлэг харьцуулал болсон байна. Өөрөөр хэлбэл хүүрнэлийн эл 5 загварын хүрээнд “Харанхуй хад”, “Алтан цох” хоёрын дүр, үйл явдлыг нарийн харьцуулахад, хоёр зохиол адилхан дүр дүрслэл ба хүүрнэлийн загвартай байгаа буюу хоёр зохиолын баатар санамсаргүйгээр, ямар нэгэн тохиолдлоор нууц үг олж харан, түүний цаадах учир утгыг шинжлэн гаргаж, нууц үгэнд агуулсан ямар нэгэн юмны эрэлд явах ба олон хүчир бэрхшээл аюул түгшүүрийг даван байж, олж авч буй загвараараа адил байгааг тодруулж өгөв.

Судлаач хоёрын зохиолын хүүрнэл дэх дүр дүрслэлийн ерөнхий дүр зургийг гаргахдаа хоёр зохиолд гарч буй дүрийг “Хүн” болон “Амьтан” гэсэн хоёр хэсэгт хуваагаад, үүнийгээ дараах хүснэгтээр харуулсан нь маш тодорхой болсон байна.

Дүр Зохиол	Хүн	Амьтан
“Харанхуй хад”	“Би” Тогооч Хар хүн Эмгэн	морь нохой хэрээ
“Алтан цох”	“Би” Легранд Юпитер Лейтенант Гэ	цох нохой хэрээ

Хүснэгтээс харахад, хоёр зохиолд гардаг дүрийн төрөл зүйлд хүн, амьтан гэсэн адилхан хоёр төрлийн дүр байх ба бас хоёр зохиолд хоёуланд нь цөөхөн дүр гарч байна. Магадгүй, хоёр зохиолын дүрийн зан чанарын адилхан тал нь ч үүнд харагдаж байгаа нь сонирхолтой. Ингээд судлаач:

1. *“Д.Нацагдорж “Харанхуй хад”-г бичихээс өмнө “Алтан цох”-г уншсан байж болно.*
2. *Д.Нацагдорж “Харанхуй хад”-г бичихээс өмнө “Алтан цох”-г орчуулж байсан байж болно.*
3. *Нэг зохиолч заавал нэг зохиолыг орчуулбал сая түүний нөлөөг хүртэх биш, орчуулан хэвлэсэн цагаар нөлөө хүртсэнийг тогтоож болохгүй.*
4. *Д.Нацагдоржийн “Харанхуй хад” болон бусад уран бүтээлд Э.А.Погийн өөр уран бүтээлийн нөлөө байх эсэхийг шинжилж, Д.Нацагдорж “Харанхуй хад”-г бичихээс өмнө Э.А.Погийн зохиол бүтээлийг уншиж байсан эсэхийг шинжилж болно.”<sup>52</sup>*

гэсэн магадлал дэвшүүлж, судлаачийн хувийн үнэлэмж байр сууриа илэрхийлжээ. Энэ бүлэгт байгаа бас нэгэн анхаарууштай хэсэг бол “Харанхуй хад” ба “Хэрээ” [Е.А.Рое “The Raven”] найраглалын харьцуулсан судалгааны хэсэг болно. Энэ хэсгийн ерөнхий уур амьсгал имиж нь өрнөдийн утга соёл, нийгэм гүн ухааны үнэлэмжийн үүднээс хандсан гэж үзэж болно. Тухайлбал “Уйтгарт уур амьсгал, харанхуй ертөнцийн зураглал” буюу декадент, дистопик маягийн үнэлэмж, “Тоо үзэсгэлэнт эрдэмтэн охины дүр бүтээлт” буюу муза,

<sup>52</sup> Манухуар “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал”, Уб., Нандир дизайн хэлэлийн компани, 176-р тал

даги насуудын үйл хэрэг, “Хэрээ”-ний дүрийн өгүүлэмж буюу сөрөг, эсрэг символик маягийн өгүүлэмж, “Готик хэв маягийн илрэл” буюу өрнөдийн эгц дээшээ шовгор оройтой, элдэв хэв маягийн хэв угалзтай, сүм хэлбэрийн цонхнуудтай, гэрэл гэгээ муутай, тэгсэн атлаа ханан дээрх элдэв хүн амьтны дүрс, хөшөө нь тод харагддаг, иймэрхүү маягийн сүм юм уу байшин барилгад ороход төрдөг айдсын мэдрэмж зэргийг шингээснээрээ Э.А.По хийгээд Д.Нацагдорж хоёрын туурвил зүйн сэтгэлгээ давхцал маягтай байсан гэж үнэлсэн нь эл бүтээлийн шинэлэг талын бас нэгэн илэрхийлэл болж байна.

“Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” бүтээлийн IV бүлэг “Д.Нацагдоржийн уран бүтээлийн шинэ тайламж”-даа “Харанхуй хад”, “Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”, “Уул усны охин” зэрэг бүтээлийг Э.А.Погийн “Израфел”[Israfel]-тай туурвил зүйн сэтгэлгээний үүднээс харьцуулж, “Ламбугайн нулимс”-ын талаар өөрийн байр сууриа илэрхийлж, улмаар энэхүү бүтээлд хүүрнэл зүйн үүднээс хандан судалсан нь залуу судлаачийн өөрийгөө илэрхийлсэн шинэлэг судалгаа болсон байна.

Энэ бүхний эцэст дүгнэн үзвэл, ӨМБИС-ийн багш, доктор Манухуарын “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” бүтээл нь Харьцуулсан уран зохиол (comparative literature)-ын үүднээс үндэсний ижилсэл буюу “National identity” хэмээх ойлголтыг Э.А.Погийн болон Д.Нацагдоржийн бүтээл дээр тодруулж өгсөн байна. МУИС-ын профессор Л.Мөнх-Эрдэнэ: “*Үгийн хувьд Identity нь Identify, Identifcaton, Identical зэрэг үгс нь “мөнийг, адилыг, ижлийг таних, тогтоох”, ижил, адил байх гэсэн санааг агуулдаг бол Identity нь шинжилгээний категорийн хувьд өөртөө ижил, адил байхын дээр өрөөлөөс өөр, ондоо байх гэсэн хоёр талыг агуулсан ойлголт. Үнэндээ аливаа юмс, үзэгдлийг таних (Identify) гэдэг нь мөн чанарыг нь тогтоохын хамт, бусдаас ялгана гэсэн үг. Өөрөөр хэлбэл тухайн зүйлийг тухайн зүйл болгож байгаа чанаруудыг нь тогтоохын дээр бусдаас ялгарч, ондоорч байгааг нь ч тогтооно гэсэн хэрэг. Тиймээс үндэсний ижилсэл гэдэг ойлголт нь тухайн үндэстний гишүүдэд нийтэд нь ижил, адил, нийтлэг байгаа зүйлс буюу чанар болон тэднийг бусдаас ялгаж байгаа зүйлс, чанарыг хамарсан хоёр талтай ухагдахуун гэж ойлгож болно.*”<sup>53</sup> гэжээ. Тэгвэл доктор Манухуарын “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” нь Д.Нацагдорж ба түүний зохиолыг Э.А.По ба түүний зохиолтой ямар түвшинд, юугаараа, ямар талаараа адил төстэй атлаа ялгаатай байгааг тогтоосон, “Харанхуй хад”, “Алтан цох” хоёр нь ямар утга чанараараа ижилсэж, ямар утга чанараараа ялгаран ондоошиж, хамт зэрэгцэн оршиж буй учрыг тайлбарлан таниулж өгснөөрөө Д.Нацагдорж судлалд, манай харьцуулсан уран зохиол судлалд гарч буй шинэ амжилт болж байгаа юм. Тийм болохоор Монгол Улсын ШУА-ийн гадаад гишүүн, Монголын уран зохиол судлаач, профессор Ван Мандуга Манухуарын “Д.Нацагдоржийн орчуулга түүний туурвил зүйн харьцуулсан судлал” бүтээлийг “Залуу эрдэмтдийн шинэлэг ололт амжилт” хэмээн үнэлсэн нь аргагүй юм.

<sup>53</sup> Л.Мөнх-Эрдэнэ “Аархаж, омогшье гэсэн ч тийм юм тун хомс байна”, <http://www.baabar.mn/article/maks-plankiin-niigmiin-antropologiin-khureelengiin-zochin-sudlaach-dr-lmunkh-erdene>

**СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛСАН  
2025 ОНЫ ЗУНЫ МОРИН АЯЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ**

*Макихара Соичи  
(Соёл Эрдэм дээд сургуулийн  
Удирдах зөвлөлийн дарга)*

2025 онд Соёл Эрдэм дээд сургуулийн “Шилийн булаг” жуулчны баазын зуны морин аяллын хөтөлбөр амжилттай болж өндөрлөлөө.

Энэхүү хөтөлбөрт Соёл Эрдэм дээд сургуулийн оюутнууд болон Ахлах сургуулийн сурагчид япон хэлний дадлагын хүрээнд олон тоогоор оролцов.

Хөдөөний ахуй амьдралын талаар суурь мэдлэггүй байсан тэд, жуулчны баазад гал тогооны туслах ажил, ресторанд зөөгч, морины хөтөч хийх хүртэл ур чадвартай болсон. Мөн энэ зун Ахлах сургуулиа төгөөд, бааз дээр дадлага хийсэн Зулаа, Анужин зэрэг 8 сурагч, Япон улсад суралцахаар 9 -р сарын дундуур Япон улсыг зорилоо. Тэд одоо бааз дээр танилцсан япон аав ээжийнхээ гэрт тухтай амарч, 10 сарын 1-нээс шинэ хичээлийн жилдээ хичээлдээ явахаар бэлдэж байна.

1991 онд Хармони төв нь анх удаа Монголд морин аяллын хөтөлбөр зохион байгуулснаас хойш өдгөө 35 жил өнгөрчээ. Энэ хугацаанд томоохон осол гэмтэлгүйгээр үйл ажиллагаагаа тасралтгүй, оновчтой зохион байгуулан өрнүүлж ирсэн нь бидний бахархал юм. Энэ жил 1991 оны морин аялалд оролцож байсан Имамура Такаюки, Нагатомо Кумико нарын баг, мөн үүсгэн байгуулалтын үеэс жил бүр оролцож ирсэн Хармони төвийн хуучин захирал Ооно Юкио ахлагчтай багийнхан дахин зочлов. Тэд цар тахлын гурван жилийг эс тооцвол, Монгол орноо жил бүр ирдэг туршлагатай зочид бөгөөд ялангуяа Акимото гуай 80 нас гарсан хэдий ч “-Энэ жил Монгол явахгүй юм уу” хэмээн цар тахлын үед ч асууж байсан, эрч хүчтэй хүн бөгөөд түүний тэр сэтгэл биднийг ихэд зоригжуулсан юм.

Мөн Хиппо Фамили Клубын зохион байгуулсан “Өвсөн талын гэрийн нэйчер кэмп”-ээс гадна, Обирин их сургууль, Риккёо их сургууль, Токива их сургууль, Комазава охидын их сургууль болон Соёл Эрдэм дээд сургуулийн оюутнууд хамтран байгаль орчны судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэв.

Үүнээс гадна бид JICA Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Мияги-г урьж, Япон улсын ODA засгийн газрын бодлого болон Монгол дахь хэрэгжилтийн талаар илтгэл сонсов. Оюутнууд маш сонирхолтойгоор сонсож олон асуулт тавьж, хариултаа авсан, үр өгөөжтэй сургалтын боломж болов. Энэ завшааныг ашиглан Мияги даргад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хиппо Фамили Клуб нь морь унах дадлагаас гадна нүүдэлчдийн амьдралтай танилцах, морин хуур тоглох дадлага, уламжлалт гар урлал, эсгий урлал хийх, мөн Улаанбаатар хотод Монгол гэр бүлийн гишүүн болж хоёр хоног байрлах ... гэх мэт олон талт харилцааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Тус клуб нь олон улсын олон хэлний харилцааг хөгжүүлдэг байгууллага бөгөөд манай дунд сургуулиас зохион байгуулдаг “Японд сурагч солилцоо” хөтөлбөрийн хүрээнд Японд айлчлалын үеэр сурагчдыг гэрээр хүлээн авахад байнга туслалцаа үзүүлж ирсэн. Энэ дашрамд мөн Хиппо Фамили Клубын гишүүдэд гүн талархал илэрхийлье.

Бид морин аяллын хөтөлбөрт юуны өмнө “Аюулгүй байдлыг” нэн тэргүүнд анхаардаг билээ. *“Аюулгүй байдлыг нэгдүгээрт тавьж, бүрэн дүүрэн хөгжилтэйгөөр морь унъя”* гэсэн уриан дор, хамгийн их анхаарал болгоомжтойгоор үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Үүний үр дүнд бид энэ жилийн морин аялал болон жуулчны хөтөлбөрөө ямар нэгэн осол, гэмтэлгүйгээр амжилттай дуусгаж чадсан билээ.

Эцэст нь, энэ зуны амралтын хугацаанд Соёл эрдэм дээд сургууль, Соёл эрдэм ерөнхий боловсролын сургуулийн “Шилийн булаг” баазын зуны морин аяллын жуулчны хөтөлбөрт ирсэн Японы зочид, хөтөлбөрийн үйл ажиллагаанд зүтгэл гаргасан ажилтан ажилчид, япон хэлний дадлагын хүрээнд оролцсон оюутан сурагчдад гүн талархал илэрхийлье.

